

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖИЛЛАГАА,
АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Д.Бямбахүү

Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн ахлах багш,
цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Монгол Улсын Засгийн газраас баримталж буй бодлого, эдийн засгийн хямралт байдал, хүн амын ядууралтай холбоотойгоор сүүлийн үед гэмт хэрэг, зөрчил тэр дундаа тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт явдал цөөнгүй бүртгэгдэх боллоо. Иймд тээврийн хэрэгсэлийг эрэн сурвалжлах ажлын үр нөлөөг дээшлүүлэх, тээврийн хэрэгслийг эрэн сурвалжлахад анхаарах асуудлын талаар товч авч үзэж, өөрийн санал дүгнэлтээ дэвшүүлэв.

Түлхүүр үгс: Ажиллагаа, хулгайлах, эрэн сурвалжлах, тээврийн хэрэгсэл, хяналтын төхөөрөмж

Үндсэн хэсэг. Нийгмийн амьдралын бүхий л хүрээг хамран хэрэгжиж байгаа өөрчлөлт, шинэчлэлийн өнөөгийн нөхцөлд Цагдаагийн байгууллагын хууль сахиулах үйл ажиллагааны арга хэлбэр, эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох, тэр чиглэлийн ном, сурах бичиг, гарын авлага боловсруулж, түгээх, тодорхой төрлийн гэмт хэргийн чиглэлээр дагнан судалгаа хийж, шалтгаан нөхцлийг судалж, урьдчилан сэргийлэх шинэ арга замыг эрэлхийлэхэд сургалтын болон практик байгууллагуудын хамтын ажиллагаа чухал бөгөөд шинэ түвшинд гаргах шаардлага тулгарч байна.

Өнөөдөр цагдаагийн эрэн сурвалжлах ажлын чиглэлээр харьцангуй бага судлагдсан байх бөгөөд зарим ном зохиолд тодорхой хэмжээгээр дурдсан нь бий боловч хулгайлагдсан тээврийн хэрэгсэлийг эрэн сурвалжлах ажиллагааны онол практикийн асуудлын талаар дурдсан, тусгайлан иж бүрнээр нь авч үзсэн, судалгаа шинжилгээний ажил, нэг сэдэвт бүтээл одоогоор хараахан үгүй байна.

Монгол Улсын хэмжээнд 1198103 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас Насжилтаар нь авч үзвэл 0-3 жил 47172, 4-6 жил 4067, 7-9 жил 143657, 10 жил ба түүнээс дээш 1003207 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн байна¹.

Дээрх судалгаанаас үзэхэд хүн амын хэрэгцээнд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн тоо жил жилээс улам нэмэгдэж, тэр хэмжээгээр тээврийн хэрэгсэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчил улам нэмэгдэх хандлагатай байна.

Цагдаагийн байгууллагад иргэдээс ирж байгаа тээврийн хэрэгсэл хулгайлагдсан гэх мэдээлэлийг авч үзэхэд 2017 онд 121, 2018 онд 217, 2019 онд 311 болж жил ирэх тутам өссөн байна.

Тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн шалгаснаас 61,2% буюу 394 хэргийг илрүүлсэн байх бөгөөд 38,8% буюу 249 гэмт хэргийн эзэн холбогдогчийг нь тогтоож чадаагүй байна.

Аливаа гэмт хэргийг илрүүлэх, эзэн холбогдогчийг нь тогтооход нэн түрүүнд хийх ёстой ажлуудын нэг бол эрэн сурвалжлах ажил юм. Гэмт этгээд олж тогтоох, нотлох баримтыг олж бэхжүүлэх нь эрэн сурвалжлах ажлын гол зорилго оршино.

Техник технологийн хөгжил, дэвшил улам бүр хөгжихийн хэрээр нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт явдал улам бүр нэмэгдэж байна.

¹ Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн 2021 оны мэдээлэл

Энэ нь нэг талаас иргэд амар хялбар аргаар хөрөнгөжих, гэмт үйлдлийн мөрөө бууруулах, зугтаах, гэмт хэргийн газраас түргэн холдож зайлахын тулд тээврийн хэрэгсэл хулгайлах, ашиглах үйлдэл нэмэгдсээр байна.

Түүнээс гадна автомашины болон сэлбэг хэрэгслийн ченжүүдийн нилээд хэсэг нь тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг үйлдэгсэдтэй холбоотойгоос гадна зарим нь хулгайн эд зүйл гэдгийг мэдсээр атлаа хямд үнээр худалдан авч үнэ өсгөн худалддаг бөгөөд ченж нараас тээврийн хэрэгсэл эд анги худалдан авч байгаа зарим худалдан авагчид хулгайн эд зүйл авч байгаагаа ч мэдэж байдаг.

Өнөөдөр цагдаагийн байгууллага, алба хаагч нь хулгайлагдсан тээврийн хэрэгслийн талаарх гомдол, мэдээллийг харьяалал харгалзахгүйгээр хүлээн авч байна.

Цагдаагийн байгууллага хулгайлагдсан тээврийн хэрэгслийн талаар иргэн, албан тушаалтнаас гомдол, мэдээллийг хүлээн авахдаа дараах зүйлийг тодруулж бүртгэсэн байна. Тухайлбал:

1. Эзэмшигч иргэн ба дуудлага өгсөн нэр, хаяг, утасны дугаар;
2. Алдагдсан, тоногдсон цаг хугацаа, байршил;
3. Гэрчилгээний болон улсын дугаар; марк, загвар;
4. Хөдөлгүүр, арал, бүхээгийн дугаар;
5. Үйлдвэрлэсэн болон Монгол Улсад орж ирсэн он, сар;
6. Ачаа тээшинд байгаа эд зүйлсийн талаарх мэдээ, мэдээлэл;
7. Тээврийн хэрэгслийг авсан байж болох хүний талаарх мэдээ, мэдээлэл;

Цагдаагийн байгууллагаас хулгайлагдсан тээврийн хэрэгслийн талаарх мэдээллээс хаанаас алдагдсан, улсын дугаар; марк, загвар, өнгө зэргийг зарлан мэдээллэж алба хаагчдад эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заансаар Нийслэлийн замын цагдаагийн газрын шуурхай удирдлагын алба нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага нь мэдээллийг хүлээн авмагц үүрэг гүйцэтгэж байгаа дараах нэгжийн дарга, байцаагч, цагдаа нарт биечлэн болон холбооны техник хэрэгсэл ашиглан шуурхай мэдэгдэнэ гэж заажээ. Тухайлбал:

а/замын цагдаагийн албаны нийт бие бүрэлдэхүүн;
б/орон нутгийн цагдаагийн байгууллага, замын цагдаагийн алба хаагчид;
в/замын пост, шалган бүртгэх товчоо дээр ажиллаж байгаа алба хаагч; гэж заасан боловч ард иргэдэд хэрхэн мэдээллэж, мэдээ, мэдээлэл цуглуулахыг заагаагүй байна.

Мөн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий цагдаагийн алба хаагч мэдээллийн мөрөөр эрэн сурвалжлах ажиллагаа явуулахдаа дараах тээврийн хэрэгсэлд анхаарал хандуулна:

- а/хөдөлгөөнд оролцож байгаа;
- б/түр саатуулагдсан;
- в/тээврийн хэрэгслийн улсын үзлэгт хамрагдаж байгаа;
- г/тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон улсын дугаар шинээр авч байгаа;
- д/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд шилжилт хөдөлгөөн хийгдэж байгаа;
- е/зах, худалдааны цэгүүдэд худалдаж байгаа;
- ж/авто засварын үйлчилгээ хийлгэж байгаа;
- з/зам тээврийн осол, хэрэгт шалгагдаж байгаа;
- к/бусад гэж заасан байна.

Гэсэн хэдий ч хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийг хянахад замын цагдаагийн алба хаагчид төдийлөн хүрэлцэхгүй ихэнх цагийг хөдөлгөөн зохицуулалт хийсээр өнгөрөөж байна.

Мөн тээврийн хэрэгслийн дугаар олголт нь цагдаагийн байгууллагын хяналтанд байхгүйгээс гэмт этгээдүүд ашиглан хулгайлсан тээврийн хэрэгслийн дугаарыг ижил машины дугаараар солин замын хөдөлгөөнд оролцоход саадгүй зорчиж болохоор байна.

Түүнчлэн замын цагдаагийн алба хаагчид төдийлөн хөдөлгүүр, арал, бүхээгийн дугаарын тулгалт хийж шалгахгүй байна.

Иймд зах, худалдааны цэгүүдэд худалдаж байгаа, авто засварын үйлчилгээ үзүүлэх цэг газруудад хяналт шалгалтыг цогцоор нь хийх шаардлагатай байна.

Хулгайлагдсан тээврийн хэрэгслийн тухай нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын шуурхай удирдлагын алба нь хүлээн авсан мэдээллийг бие бүрэлдэхүүндээ шуурхай хүргэж, эрэн сурвалжлах ажиллагааг дараах тээврийн хэрэгсэлд чиглүүлнэ. Үүнд:

а/хариуцсан нутаг дэвсгэрт байрлах авто зогсоол дээр хөдөлгөөнд оролцохгүйгээр удаан хугацаагаар зогсож байгаа;

б/гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, саатуулахбайранд хүргэгдэж ирсэн хүний эзэмшлийн болон түүний сууж, эсхүл бичиг баримтгүйгээр жолоодож явсан;

в/гэмт хэрэг, зөрчлийн газар дээр байгаа;

г/эд мөрийн баримтаар хураагдсан;

д/битүүмжлэгдсэн;

е/таслан сэргийлэх арга хэмжээний дагуу барьцаанд тавигдсан;

ж/барьцаалдан зээлдүүлэх үйлчилгээ үзүүлдэг байгууллагад;

Тухайн хариуцсан нутаг дэвсгэрийнхээ авто зогсоол болон хөдөлгөөнд оролцохгүйгээр удаан хугацаагаар зогсож байгаа тээврийн хэрэгслийн бүртгэл судалгаа нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нэгж хэсэг дээр одоогоор байхгүй байна.

Мөн цагдаагийн байгууллагаас барьцаалан зээлдүүлэх газрыг хяналт хийж байгаа үйл ажиллагаа маш сул байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад гадны орнуудаас худалдаанд орж ирж байгаа тээврийн хэрэгслийн нэр төрөл олширч, үүнийг уршгаар тээврийн хэрэгслийн хөдөлгүүр, арал, бүхээгийн дугаар марк төрөл бүрт үйлдвэрлэгчээс өөр өөр газар бичигдсэн байгаа нь цагдаагийн алба хаагчийг шалгахад нилээд хүндрэл учирч байна. Иймээс цагдаагийн алба хаагчдад тээврийн хэрэгслийн хөдөлгүүр, арал, бүхээгийн дугаар хаана хаана хэвлэгдсэн байгаа талаар нэмэлт сургалт зохион байгуулах шаардлага тулгарч байна.

Мэдээллийн технологи өндөр хөгжсөн өнөө үед программ, техник хангамжийн дэвшилтэд шинэ, шилдэг бүтээгдэхүүнүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, ажлаа хөнгөвчлөх, хариуцлагатай, үр ашигтай ажиллагааг бий болгох нь цагдаагийн байгууллагын нэг зорилт болж байна.

Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ажилд нэгэн ахиц гаргах үйл ажиллагаа бол “GPS tracking system” буюу тээврийн хэрэгслийн хяналтын системийг Монгол Улсад замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэл бүрт суулгаж хэрэглэх нь ихээхэн чухал ажил байна.

Тиймээс тээврийн хэрэгслийн байрлалыг тогтоох, хянах, GPS системийг автомашинуудад суурилуулснаар онлайнаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг компьютер болон гар утаснаас шууд хянах боломжтой болно.

Энэ нь цагдаагийн байгууллагаас дан ганц хулгайлагдсан тээврийн хэрэгслийг эрэн сурвалжлаж ажилд ашиглагдахгүй түүнээс гадна бусад байдлаар эрэн сурвалжлах ажилд өргөнөөр ашиглах боломжтой. Нөгөө талаас тээврийн хэрэгслийн жолоочийн аюулгүй байдал болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хянахад давхар ач холбогдолтой байна.

Мөн камерын хяналтын системийг сайжруулснаар тээврийн хэрэгслийг эрэн сурвалжлах ажилд нилээд ахиц гарна гэж бодож байна. Тухайлбал:

Нийслэл Улаанбаатар хотод 29 уулзварт байрлуулсан 29 ширхэг хөдөлгөөнт камер 15 цэгт 34 ширхэг зөрчлийн камер, хөдөлгөөн мэдрэгч камер 52 ширхэг, Энхтайваны өргөн чөлөөний зорчих хэсгийн нэгдүгээр эгнээний 26 цэгт суурилагдсан 52 ширхэг камер болон Энхтайваны өргөн чөлөөний нийтийн тээврийн хэрэгслийн буудал дээр байрлагдсан 40 ширхэг камер нийт 155 хяналтын камер, 52 ширхэг хөдөлгөөн мэдрэгчийн тусламжтай замын хөдөлгөөнийг хянан, зохицуулж байна².

². Тээврийн цагдаагийн албаны 2019 оны тайлан мэдээ 64 дэх тал.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд камерын хяналтын систем нэвтэрснээр дараах үр дүн гарсан гэж дүгнэж байна. Үүнд:

- Улаанбаатар хотын замын хөдөлгөөний ачааллыг мэдэрч, хөдөлгөөн зохицуулалт хийгддэг болсон;
- Замын хөдөлгөөнд оролцогч жолооч нарын дүрэм баримталж, хөдөлгөөнд оролцох хариуцлага, ухамсар нэмэгдсэн;
- Зөрчлийн илрүүлэлт нэмэгдэж, нотлох баримтыг шуудангаар иргэдэд хүргэдэг соёлтой систем бий болсон;
- Зөрчилд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо нэмэгдэж, нийслэлийн төсөвт орох орлого нэмэгдснээр нэг талаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах техник технологийг нэвтрүүлэх санхүүгийн эх үүсвэр бий болсон;
- Эрэн сурвалжлах ажиллагаанд ахиц гарсан;
- Замын цагдаа болон иргэд, жолооч нарын хооронд үүсдэг байсан харилцааны зөрчил буурсан гэж судлаачийн хувьд үзэж байна.

Сүүлийн үеийн камерын системийн хувьд дэвшилтэт технологи болох нэг зэрэг 8 үйлдлийг хянах боломжтой³ камерийг Монгол Улсад нэвтрүүлж болох эсэхийг судалж байна. уг камерийг Арабын Эмират улсын нийслэл Абу-даби хотод ашиглаж байна. Энэ технологи нь дараах 8 үйлдлийг нэгэн зэрэг хийж гүйцэтгэх хүчин чадалтай юм.

- Хурд хэтрүүлэх
- Улаан гэрлэн дохио
- Эгнээ байр
- Замын ачаалал
- Зам тээврийн осол
- Тээврийн хэрэгслийн тоо
- Хөдөлгөөний хяналт
- Дугаар илрүүлэлт

Энэ үйлдэл нь эрэн сурвалжлах ажилд ихээхэн ач холбогдолтой технологи бөгөөд хулгайлагдсан тээврийн хэрэгсэл, эрэн сурвалжлагдаж байгаа автомашиныг дугаараар нь замын хөдөлгөөнд тухайн цаг үед хэрхэн оролцож байгааг шууд мэдэх давуу талтай. Нөгөө талаас, эрэн сурвалжлагдаж байгаа автомашиныг тухайн дугаараар нь маршрутыг нь тогтоох боломжтой байдаг.

Аж ахуй нэгж байгууллагын тээврийн хэрэгслийн зогсоолыг бүртгэх системийг манай улсад нэвтрүүлэх нь зүйтэй байна. Уг систем тээврийн хэрэгслийн зогсоолд байрласан цаг хугацаа, төлбөр төлөлт, зогсоолын ачааллыг тэнцвэржүүлэх гээд олон ач холбогдолтой байхаас гадна эрэн сурвалжлах ажилд өргөнөөр ашиглаж болно.

Аж ахуй нэгж байгууллагын зогсоолын хяналтын системд цагдаагийн байгууллага нэвтэрэх бүрэн боломжтой байхаар зохион байгуулах нь зүйтэй. Мөн зогсоолд сэжигтэй байдлаар олон хоног хугацаагаар тавигдсан тээврийн хэрэгслийг хянаж бүртгэхэд нэн шаардлагатай байна.

Дүгнэлт. Тээврийн хэрэгслийг эрэн сурвалжлах ажилд ашиглагдаж байгаа техник технологи тодорхой хэмжээгээр байгаа боловч нэгдсэн нэг системд холбогдож чадаагүй, тэр хэмжээгээр нутаг дэвсгэрийн хэмжээнд хангалттай түвшинд суурилагдаж чадаагүй, хоорондын уялдаа холбоо байхгүй, цагдаагийн байгууллагын хяналтын камерын системд аж ахуйн нэгж, байгууллагуудын хяналтын камерууд холбогдож чадаагүй байгаа нь эрэн сурвалжлах ажлын үр дүнг бууруулахад нөлөөлж байна гэж судлаачийн хувьд үзэж байна.

³<http://traffic.police.gov.mn/>

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Аж ахуй нэгж байгууллагуудын тээврийн хэрэгслийн зогсоолыг бүртгэх системийг манай улсад нэвтрүүлэх;
2. Сүүлийн үеийн дэвшилтэт технологи болох нэг зэрэг 8 үйлдлийг хянах боломжтой камерийн системийг Монгол Улсад нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх;
3. Аж ахуйн нэгж, байгууллагуудын хяналтын камеруудын үзүүлэлтэд стандарт тогтоож, стандартад нийцсэн хяналтын камерыг Цагдаагийн байгууллагын хяналтын камерын системд холбож нэг системээр хянах боломжийг бүрдүүлэх;
4. Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглаж байгаа хяналтын камерын системийг Шуурхай удирдлагын төвийн системд холбож, улсын хэмжээний хяналтын системийг бий болгох;
5. Монгол Улсад замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэл бүрт байршил тогтоох GPS системийг суулгаж эрэн сурвалжлах ажилд ашиглах зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД БАЙРШИЛ ТОГТООГЧ БУЮУ “GPS” АШИГЛАХ НЬ

/Баян-Өлгий аймгийн жишээ нь дээр /

Ш.Ержан

ДХИС-ийн магистрант,

цагдаагийн хошууч

Товчлол. Монгол Улсын хэмжээнд гэмт хэргийн гаралт жилээс жилд өссөн үзүүлэлттэй, буурахгүй байгаа бөгөөд тэр дундаа малын хулгайн гэмт хэрэг жилээс жилд өсөх хандлагатай байна.

Энэхүү өгүүлэлд Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэрээс малын хулгайн гэмт хэрэг үйлдэгдэж иргэдэд их хэмжээний хохирол учирч хулгайд алдагдсан малыг олж тогтоох, гэмт хэрэгтэнд хуульд заасан шийтгэл оногдуулахад хүндрэл, бэрхшээл учирч байгааг харгалзан бод малд байршил тогтоогч буюу GPS төхөөрөмжийг суулгаж малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ашиглах ач холбогдолын талаар өгүүлсэн болно.

Түлхүүр үг. Малын хулгай, гэмт хэрэг, хил дамнасан малын хулгай, байршил тогтоогч.

Үндсэн хэсэг. Баян-Өлгий аймгийн хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар 556 толгой бод мал ОХУ-ын хийлийн бүсэд хулгайлагдаж улмаар Монгол Улсын малчин бүхий иргэдэд 461.840.000 төгрөгийн хохирол учирсан ба уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө засах орны малчин иргэдийн хэрэглэж байгаа байршил тогтоогчийг Монгол Улсын хил орчимд байдаг бод малд зүүж хэрэгжүүлснээр малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, алдагдсан малыг олж тогтоох ажилд ахиц гарах юм.

Монгол оронд 1921 онд ялсан ардын хувьсгалын жилүүдэд хэдийгээр өмчийн хэлбэр янз бүрээр өөрчлөгдөж байсан ч мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах тууштай дэс дараалалтай бодлого боловсронгуй болж, мал хулгайлах, ашиглан шамшигдуулах гэмт хэргийн субъектэд оногдуулах ял шийтгэл хатуу чанд байсныг зөвхөн нэг хуулиар жишээ болгон тодорхойлж болох юм.

Монгол Улсын 1992 оны шинэ Үндсэн хуульд Эрүүгийн хуулийг нийцүүлэх зорилгоор 1993 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд уг хуулийн 123 дугаар зүйлд “Бусдын эд хөрөнгийг хулгайлж ашиглан шамшигдуулах гэмт хэргийг өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр тодорхойлон авч онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн тохиолдолд бүлэг этгээд, онц аюултай этгээд эсвэл их хэмжээтэй хулгайлсныг”⁴ заасан бөгөөд 2002 оны Монгол Улсын Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд мөн адил энэ хэлбэрээр Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт Мал хулгайлах гэмт хэргийг нэгтгэн зүйлчилж байсан. Улмаар 2015 оны эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлд Мал хулгайлах гэмт хэргийг тусад нь зүйлчлэхээр заасан нь онцлог юм.

Баян-Өлгий аймаг нь баруун талаараа Алтайн нурууны хяр дагаж БНХАУ-ын Шинжаан-Уйгурын Өөртөө засах оронтой 450 км, хойд талаараа Сийлхэмийн нуруу дагаж ОХУ-ын Алтайн Бүгд Найрамдах Улстай 225 км, зүүн талаараа Увс аймагтай 165 км, зүүн ба урд талаараа Ховд аймагтай 450 км нутгаар хиллэдэг. Эдийн засгийн гол салбар нь мал аж ахуй бөгөөд 1.4 сая толгой малтай.⁵ Малын тоо, толгой өссөнтэй холбоотой малын хулгайн гэмт хэрэг болон тэр дундаа хил дамнасан малын хулгайн гэмт хэрэг ихсэх хандлагатай байна.

Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг болон Малын хулгайн гэмт хэргийг сүүлийн 5 жилийн байдлаар хэсэгчилсэн судалгаагаар хэргийн гаралтыг судалж үзэхэд:

- 2017 онд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 101 бүртгэгдсэн бөгөөд үүний 17 буюу 16.8 хувь нь мал хулгайлах гэмт хэрэг

⁴ Төрийн мэдээлэл. 2016. №21. Эрүүгийн хууль

⁵ <http://mn.wikipedia.org>

- 2018 онд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 131 бүртгэгдсэн бөгөөд үүний 23 буюу 17.5 хувь нь мал хулгайлах гэмт хэрэг
- 2019 онд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 139 бүртгэгдсэн бөгөөд үүний 13 буюу 9.3 хувь нь мал хулгайлах гэмт хэрэг
- 2020 онд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 135 бүртгэгдсэн бөгөөд үүний 27 буюу 20 хувь нь мал хулгайлах гэмт хэрэг
- 2021 онд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 93 бүртгэгдсэн бөгөөд үүний 21 буюу 22.5 хувийг нь мал хулгайлах төрлийн гэмт хэрэг⁶ тус тус эзэлж байна.

График №1



Уг судалгаагаар аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа малын хулгайн гэмт хэрэг тогтвортой буурахгүй байгааг харуулж байна.

Малын хулгайн гэмт хэргийг амьжиргааны эх үүсвэргүй, хялбар аргаар ашиг хонжоо олох зорилгоор нутгийн иргэд үйлдэж байгаагийн зэрэгцээ тус аймгийн ОХУ-тай хиллэдэг Улаанхус, Ногооннуур сумдын нутаг дэвсгэрээс ОХУ-ын Бүгд Найрамдах Алтай, Бүгд Найрамдах Тува улсын иргэд хууль бусаар Монгол Улсын хил руу нэвтрэн орж бод мал болох адуу, үхэр зэрэг малыг олон тоогоор /сүргээр / нь хил давуулан хулгайлах гэмт хэрэг үйлдэх нь буурахгүй байна. Малын хулгайн гэмт хэрэгт ихэвчлэн тууварлахад хялбар бод мал болох адуу, үхэр зэрэг малыг хулгайлдаг нь тогтоогдож байна.

Хил орчмын малын хулгайн гэмт хэргийн улмаас тус аймгийн Улаанхус, Ногооннуур сумдын малчин иргэдийн 484 толгой адуу, 72 толгой үхэр алдагдсан бөгөөд энэ гэмт хэргийн улмаас малчин иргэдэд 461.840.000 төгрөгийн хохирол учирсан. Нийт алдагдсан 556 толгой малаас 28 толгой мал олдсоноос 13 толгой адуу нь ОХУ-аас гүйж ирсэн нь тогтоогдсон.⁷

Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд 2006 оны 12 дугаар сарын 08-ний өдөр байгуулсан “Монгол Орос улсын хилийн дэглэмийн тухай” гэрээний 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Хилийн бүрэн эрхт төлөөлөгчид нь харилцан тохиролцож, улсын хил дээрх уулзалтын байр, албан баримт бичиг хүлээлцэх болон холбооны техник хэрэгсэл ашиглах журмыг тодорхойлно.

Хоёр дахь хэсэгт Хилийн бүрэн эрхт төлөөлөгч буюу түүний даалгавараар хилийн бүрэн эрхт төлөөлөгчийн орлогч эсхүл туслагч нар саатуулагдсан этгээд, амьтад, эд зүйлс, түүнчлэн хүний цогцос хүлээлцэх ажиллагааг хэлэлцэн торирч талууд хууль тогтоомжийн дгуу хэрэгжүүлнэ. Хүлээлцэх ажиллагааг хэрэгжүүлэх газар, хугацаа болон журмыг хилийн бүрэн эрхт төлөөлөгч тухай бүр тусд нь тогтооно⁸ гэж заасан боловч Монгол Улсын хилээс Оросын Холбооны Улсын хил руу хууль бусар хулгайлагдсан малын мөрийг холбогдох хууль тогтоомжын хүрээнд нотломжын хамт ОХУ-ын эрх бүхий алба хаагч нарт хүлээлгэн өгөх, малыг эрэн сурвалжилж гэрээний хүрээнд буцаан олгох ажилд

⁶ System.police.gov.mn Цагдаагийн байгууллагын мэдээллийн сан

⁷ Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын тайлангаас авав.

⁸ Монгол улс, Оросын Холбооны Улсын хооронд 2006 оны 12 дугаар сарын 08-ний өдөр байгуулсан “Монгол Орос улсын хилийн дэглэмийн тухай” гэрээ

ОХУ-ын эрх бүхий алба хаагч нар хайхрамжгүй хандаж хэдийгээр мал ОХУ-ын нутаг дэвсгэрт байгаа нь тодорхой боловч малын мөр хүлээж авдаггүйн улмаас малын хулгайн гэмт хэрэг илэрэхгүй, нутгийн гүн руу нэвтэрч эрэн сурвалжлах ажил зохион байгуулах боломжгүй байдаг нь харамсалтай.

Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн радио, телевиз, сонин, сэтгүүл, интернет орчин болон сэрэмжлүүлэг хуудас зэргээр урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулдаг боловч мал бүхий иргэд Монгол Улсын Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэхгүй байна. Иймд хил орчмын бүс нутагт амьдардаг, хил дамнасан малын хулгайн гэмт хэрэгт өртөж болзошгүй иргэдийн судалгааг Цагдаагийн байгууллагаас гаргаж бод мал болох адуу, үхэр зэрэгт байршил тогтоогч буюу чип суулгаснаар хил дамнасан малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, алдагдсан малыг олж тогтооход хялбар болж, иргэд хохиролгүй болно гэж үзэж байна.

GPS нь (Global Positioning System) АНУ-ын Батлан Хамгаалах яамнаас хэрэгжүүлсэн цэрэг иргэний зориулалтын байршил тогтоох систем юм. Одоогоор олон нийтийн хэрэгцээнд АНУ-ын GPS ба ОХУ-ын Глонасс системүүдийг амжилттай ашиглаж байна. Эдгээр системүүд нь тус бүр 24 ширхэг хиймэл дагуулыг дэлхийгээс 20000 километр тойрог замд байрлуулж, байршлын дохиоллыг хэрэглэгчийн байршил тогтоогчид тасралтгүй дамжуулж ажилладаг.

GPS-ийн гол зарчим нь дэлхийн аль ч цэг дээр 4 ба түүнээс олон байршлын хиймэл дагуул хэрэглэгчид байршлын дохиоллыг дамжуулахад оршдог. GPS-ийг анх цэргийн зориулалттайгаар 1973 оноос эхлэн судалж хэрэгжүүлж эхэлсэн ба 90-ээд оноос бага багаар иргэний хэрэгцээнд ашиглуулж эхэлжээ.

Сүүлийн жилүүдэд GPS-ийн хэрэглээ Монгол Улсад хурдтай нэвтэрсэн. Ялангуяа ухаалаг утаснуудын GPS-ийг ашиглах ба Оллоо үйлдвэрлэгчийн GPS-ийг үндэсний хэрэглэгчид ашиглаад хэдэн жил болж байна. Дэлхийг тойроод хиймэл дагуулууд маш нарийн тойрог замаар өдөрт 2 удаа тойрдог бөгөөд дэлхий рүү дохионы мэдээллийг дамжуулж GPS хүлээн авагч нь уг мэдээллийг хүлээн аваад, гурвалсан систем ашиглан байршлыг нарийн тогтоож өгдөг. Цаг агаарын ямар ч нөхцөлд дэлхийн хаана ч 24 цагийн байнгын ажиллагаатай байдаг юм.

Энгийн байршил тогтоогч GPS төхөөрөмжүүд нь бүрэн цэнэгээрээ ажиллах хугацаа бага байдаг болохоор малд зүүхэд ихээхэн хүндрэл учруулдаг билээ. Харин нарны GPS байршил тогтоогч нь байнгын цэнэгтэй байдаг тул гэрийн тэжээвэр амьтад болон ан амьтдын байршлыг тогтооход тохиромжтой байдаг. Мөн түүнчлэн ус бороонд тэсвэртэй, өвлийн хүйтэнд тогтвортой ажилладаг болохоороо энэхүү төхөөрөмж нь Монгол оронд хэрэглэхэд тохиромжтой гэж үзлээ. Учир нь малын халуун биенээс илч авч байдаг болохоор өвлийн хүйтэнд ч тогтвортой ажилладаг юм. Энэхүү төхөөрөмж зүүсэн малын хөдөлгөөн бүрийг цаг тухайд нь хянаж болно. Мөн хурдны морьдын сунгаа болон уралдааны явцыг хянаж, уяа сойлгыг нь тааруулах, хулгайгаас хамгаалахад хэрэглэж болно.

Нарны GPS байршил тогтоогч нь сансрын сателлит төхөөрөмжөөр дамжуулан гар утас болон компьютер мэдээлэл өгч, мал амьтны байрлаж байгаа газрыг зааж өгдөг. Хэрэв түүнийг малын хүзүүнээс салгах юм бол түүний мэдрэгч төхөөрөмж холбоотой байгаа гар утас болон компьютерт ослын дохио өгнө. Мөн тухайн малын сүүлийн 90 хоногт явсан замын бичлэгийг ч үзэж болдог.

БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах орны малчид “GPS” буюу байршил тогтоох системийг 2011 оноос малд хэрэглэж мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхээс гадна мал хариулахад хялбар байгаа нь тогтоогдсон байна. Малчдад ийм ая тухтай байдлыг хөдөө аж ахуйн салбарт шинжлэх ухааны ололт амжилтыг нэвтрүүлэх зорилготой хиймэл дагуулын системийн үйл ажиллагаа олгосон байна.

Мал нь хаана бэлчиж байгааг нь байнга ажиглаж байхын тулд бод малд тусгай датчик зүүснээр датчик нь ажиглалтын хиймэл дагуулууд руу мэдээлэл өгөх ба харин хиймэл дагуулууд тэдгээрийг боловсруулан малчдын гар утсанд илгээж мэдээллээ өгдөг.

Ийм төрлийн байршил тогтоогч нь Монгол Улсын зах зээлд 150.000-300.000 төгрөгийн үнэ өртөгтэй бөгөөд Монгол Улсын малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт заасан Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар үр дүнтэй ажиллаж байгаа малчид, мал бүхий иргэдийн бүлгийг холбооны болон бусад техник хэрэгслээр хангахад төрөөс дэмжлэг үзүүлнэ⁹ гэж заасан бөгөөд шаардлагатай зардлыг мал бүхий иргэдээс, Орон нутгийн хөгжлийн сан болон төрийн бус байгууллагаас төсөл, санхүүжилт хэлбэрээр гаргуулах ажлыг судлан байршил тогтоогчийг малд зүүснээр Монгол Улсын нутаг дэвсгэрт болон Монгол Улсын хилийн гадна байгаа малын байршлыг тогтоож гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлж чадна гэж үзэж байна.

Дүгнэлт. Монгол Улсын баруун хязгаар Баян-Өлгий аймгийн Оросын Холбооны Улстай хил залгаа 2 сумын иргэдийн малаас сүүлийн 5 жилийн байдлаар 556 толгой бод мал хулгайд алдагдаж 461.840.000 төгрөгийн хохирол учирсан бөгөөд энэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, нэгэнт ОХУ-ын нутаг дэвсгэрт хулгайлагдан очсон Монгол Улсын иргэний малыг байгаа байршлыг тогтоож хоёр улсын гэрээний дагуу хүлээлгэн өгөх ажлыг эрчимжүүлэх үүднээс бод малд байршил тогтоогч буюу GPS төхөөрөмжийг байршуулснаар Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлж, таслан зогсоож, алдагдсан малыг олж тогтоох бүрэн боломжтой юм байна..

Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт заасан “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар үр дүнтэй ажиллаж байгаа малчид, мал бүхий иргэдийн бүлгийг холбооны болон бусад техник хэрэгслээр хангахад төрөөс дэмжлэг үзүүлнэ”¹⁰ гэж заасан бөгөөд шаардлагатай зардлыг мал бүхий иргэдээс, Орон нутгийн хөгжлийн сан болон төрийн бус байгууллагаас төсөл, санхүүжилт хэлбэрээр гаргуулж байршил тогтоогчийг малд зүүснээр хил орчмын малын хулгай буурч, гэмт хэргийн илрүүлэлт ахина гэж дүгнэж байна.

Санал. Мал хулгайлах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд байршил тогтоогч GPS төхөөрөмжүүдийг суулгах ажлыг тухайн аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл болон цагдаагийн газар хамтран зохион байгуулах

2. Малд байршил тогтоогч GPS төхөөрөмжүүдийг суулгах ажилтай холбоотой зардлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санд төвлөрсөн хөрөнгөөр шийдвэрлэх

3. Хамгийн хямд чанартай байршил тогтоогч GPS төхөөрөмжийн судалгааг

Ашигласан материалын жагсаалт.

Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он.
2. Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2002 он.
3. Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2015 он.
4. Монгол Улсын Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль. УБ., 2004 он

Бусад эх сурвалж

1. <https://www.google.mn>
2. <http://legalinfo.mn/>
3. System.police.gov
4. <http://criminology.blogmn.net>

⁹ Төрийн мэдээлэл. 2004. №23. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль.

¹⁰ Төрийн мэдээлэл. 2004. №23. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль.

**ОХУ ДАХЬ МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС
ЭРГЭЛТТЭЙ ТЭМЦЭХ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ**

Ж.Мөнхболд

*ДХИС-ийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн тэнхимийн эрхлэгч,
доктор, дэд профессор,
цагдаагийн хурандаа*

Товчлол: Дэлхий нийтийг хамарсан шинэ төрлийн коронавирусын халдварын цар тахал улс орнуудын хэвийн үйл ажиллагаа, гэмт хэргийн гаралтад шууд нөлөөлөхийн зэрэгцээ 2019 оноос хойш цахим технологи ашиглаж үйлдэж мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг үйлдэгдэх хандлага нэмэгдэж байгаа нь анхаарал татаж байна.

Монгол Улс дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой ерөнхий нөхцөл байдал, мансууруулах бодистой тэмцэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд, тэдгээрийн тогтолцоо, харилцан ажиллагаа, тулгамдаж буй бэрхшээлүүд, энэхүү гэмт явдлаас урьдчилан сэргийлэх бодлого, эрх зүйн орчин, чиг үүргийн давхцал, харилцан ажиллагааг боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход гадаадын туршлага, гэмт хэрэгтэй тэмцэж буй бодлого, арга хэмжээг судлах шаардлага тавигдаж байна. Тухайн өгүүлэлд ОХУ-ын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх бодлого, үйл ажиллагааны онцлогийг тусган харуулахыг зорьсон болно.

Түлхүүр үг: Эрүүгийн эрх зүйн бодлого, Мансууруулах бодистой тэмцэх бодлого, Мансууруулах бодистой тэмцэх үйл ажиллагаа, хууль бус эргэлтэд тавих төрийн хяналт, Мансууруулах бодист донтогч, Хэрэглэгчийн тоо, Хамтын ажиллагаа

Үндсэн хэсэг. ОХУ-д жил бүр хар тамхины хууль бус эргэлттэй холбоотой 200 мянга орчим гэмт хэргийг тусгай албадаас илрүүлж, бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 9.4%-н мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис тээвэрлэх /зөөвөрлөх/ чиглэлээр үйлдэгдсэн¹¹ нь анхаарал татаж байна. Тус улсын Наркологийн албанд бүртгэгдсэн мансууруулах бодистой холбоотой сэтгэцийн эмгэгтэй өвчтөнүүдийн нийт тоо 2010 онд 478.700 хүн байсан бол 2019 онд 326.000 хүн болж, 29 хувь буурсан байна.

Мансууруулах бодис хэрэглэхтэй холбоотой сэтгэцийн эмгэгтэй гэж анх удаа оношлогдсон хүмүүсийн тоо 2010 оноос хойш 38.8 хувиар буурч, 2019 онд 51.3 мянган хүн буюу 100 мянган хүн тутамд 34.9 тохиолдол болжээ¹². Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэгчдийн дунд судсаар буюу тариураар хэрэглэгчидэд онцгой анхаарал хандуулах шаардлагтай. Өөрөөр хэлбэл ихэнх тохиолдолд донтолтын хэлбэр хүндэрсэн мансуурагч судсаар хэрэглэгч болсон байдаг.

Тухайн улсад энэ төрлийн хэрэглэгчид 2015 онтой харьцуулахад 2019 онд¹³ 38.4 хувиар буурч, 207.5 мянган хүн болсон.

2010 оноос хойш шинэ, аюултай сэтгэцэд нөлөөлөх бодисоос хамааралтай, олон төрлийн бодист донтсон хүмүүсийн тоо 2010 онд - 26,4 мянган хүн, байсан бол 2019 онд - 66,7 мянган хүн болж 2,5 дахин нэмэгдсэн, сэтгэцэд нөлөөлөх эмээс хамааралтай хүний тоо 2010 онд - 7.8 мянган хүн байсан бол 2019 онд - 26.4 мянган хүн болж 3 дахин нэмэгдсэн байна. Үүний зэрэгцээ мансууруулах бодис хэрэглэснээс хордлогод орсон хүн 100 мянган хүн тутамд 12.4 тохиолдол /2019 он/, үүнээс насанд

¹¹ 2017-2018 онд -10.1 хувь

¹² Противодействие незаконному обороту наркотиков : ВИПК МВД России, 2020;

¹³ Тариураар

хүрээгүй хүмүүс - 100 мянган хүн тутамд 11.6 тохиолдол, хар тамхи хэрэглэсний улмаас нас барсан хүний тоо 2019 онд 4.6 мянган хүнээс давсан байдалтай тус тус бүртгэгдсэн байна¹⁴.

ОХУ-д хар тамхины хэрэглээний түвшинг тодорхойлох зорилгоор хүн амын дунд бий болсон хандлагыг үнэлэх зорилгоор явуулсан социологийн судалгаанаас үзэхэд хар тамхи, мансууруулах бодисыг тогтмол хэрэглэдэг хүний тоо өндөр байгааг харуулж байна¹⁵. 2019 оны социологийн судалгаанд хамрагдсан иргэдийн 21.8 орчим хувь нь хар тамхи хэрэглэж үзэх хүсэлтэй, 24.1 хувь нь хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар хэрэглэж байсан болон хэрэглэж байгаа хүмүүстэй харилцдаг гэсэн дүгнэлт гарсан байна¹⁶.

Дэлхий нийтийг хамарсан шинэ төрлийн коронавирусын халдварын цар тахал улс орнуудын хэвийн үйл ажиллагаа, гэмт хэргийн гаралтад шууд нөлөөлсөн байна. Тухайлбал, 2019 онд цахим технологи ашиглаж үйлдсэн мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг 24.7 мянга бүртгэгдсэн бол 2020 оны дүнгээр цахим технологи ашиглан үйлдэгдсэн энэ төрлийн гэмт хэрэг 47 мянга буюу 2 дахин их бүртгэгдсэн нь анхаарал татаж байна¹⁷.

1. Оросын Холбооны Улсын эрүүгийн эрх зүйн бодлого

Тус улсад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын гэмт хэрэг хүүхэд, өсвөр насныханы хувьд гэмт хэрэгт ашиглагдах, эсвэл өөрсдөө гардан гүйцэтгэх, зохион байгуулах аль ч хэлбэрээр холбогдож байна. Ихэнх тохиолдолд насан хүрэгчид тэднийг ашиглан гэмт хэрэг үйлдэх нь хариуцлагаас зайлсхийх гэсэн оролдлоготой нь холбоотой байна. Тус улсад нөхцөл байдалтай уялдуулан 2003 оны 11 сард Холбооны хар тамхитай тэмцэх хороог байгуулсан бөгөөд энэ байгууллага нь 40 000 хүний орон тоотой, жилийн 810,794 ам долларын төсөвтэй, засгийн газрын бие даасан агентлаг байгуулж ажиллаж байсан.¹⁸ Хэдийгээр 2016 онд дээрх байгууллага татан буугдаж, эрх, үүрэг нь Дотоод хэргийн яамандаа шилжсэн ч энэ нь тухайн асуудыг шийдвэрлэхэд бэрхшээл учирсаар байгааг харуулж байна.

Тус улсын судлаачдын¹⁹ үзэж байгаагаар:

- Өсвөр насныхан нь бусдын, ялангуяа насанд хүрэгчдийн үгэнд амархан ордог, тэдний дарамт шахалт, албадлага зэргийг хүлцэнгүй дагаж биелүүлдэг.
- Өсвөр насны хүүхдүүдээр хар тамхины төрлийн зүйлс заруулах нь хууль сахиулах байгууллагын хараа, анхааралд өртөхгүй байх боломжтой байдаг.
- Үе тэнгийн хүүхдүүтэйгээ нийтгч зан, байдлыг ашиглан амархан харилцаа холбоо тогтооход хялбар. Түүнчлэн өсвөр насны хүүхдүүд нь насанд хүрсэн хүмүүсийн хүрч чадахгүй, хүндрэлтэй тэр орчин, газруудад хар тамхины төрлийн зүйлсээ зарж борлуулах боломж нь илүү байдагтай холбоотой. Тухайлбал: ЕБС, тусгай дунд болон их дээд сургуулиуд, мөн оюутны дотуур байр гэх мэт шалтгаанаар энэ төрлийн бодистой холбоотой гэмт хэрэгт холбогддог, улмаар хэрэглэх сэдэл, нөхцөл байдал бүрддэг гэжээ.

Тус улсад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой дараах тохиолдлуудыг гэмт хэрэгт тооцож ял оногдуулдаг байна. Үүнд:

- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис буюу тэдгээртэй адилтгах зүйлийг хууль бусаар үйлдвэрлэх, борлуулах буюу илгээх, ашиглан шамшигдуулах, эсхүл авахаар далайлган сүрдүүлэх, хэрэглэхэд бусдыг хатгах,
- Тариалахыг хориглосон ургамлыг тарих буюу ургуулах, түүнчлэн олс, намуу цэцэг буюу мансууруулах бодис агуулсан бусад ургамлыг тариалах,
- Мансууруулах хэрэгсэл буюу сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэх байр байгуулсан, тэтгэх,

¹⁴ 2011 онд - 3.7 мянган хүн, 2018 онд - 4.4 мянган хүн

¹⁵ 1.9 сая хүн буюу хүн амын 1.3 хувь.

¹⁶ Гаджиев, Муса Абдусамадович. Борьба с незаконным оборотом наркотиков в глобальном управлении - Москва, 2020;

¹⁷ Доклад о наркоситуации в Российской Федерации в 2020 году (выдержка) Москва 2021

¹⁸ Витовская, Евгения Сергеевна. Международное сотрудничество в сфере борьбы с незаконным оборотом наркотиков : учебное пособие - Новокузнецк : Кузбасский институт ФСИН России, 2021;

¹⁹ Т.Г.Газизовийн 2016 онд хийсэн судалгаа.

- Уг бодисыг хууль бусаар олгох, жор буюу олж авах эрх олгосон бусад баримт бичгийг хуурамчаар үйлдэх,

- Тусгай хяналтад байвал зохих бусад бодис үйлдвэрлэх ба бэлтгэхэд ашиглах адитгал, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг гаалийн хилээс гадуур буюу гаалийн хяналт шалгалтаас нуун дарагдуулж, эсхүл баримт бичиг буюу гаалийн адитгалын хэрэгсэл ашиглан хууран мэхэлж, эсхүл мэдүүлээгүйгээр буюу зохиомлоор мэдүүлж, улсын хилээр нэвтрүүлэх, түүнд албан тушаалынхаа байдлыг ашиглах,

- Уг бодистой адилтгах зүйлийг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар үлэмж хэмжээгээр олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, бэлтгэсэн, дахин боловсруулах,

- Уг бодисыг бэлтгэхэд ашиглагдах багаж хэрэгсэл ба тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх, бэлтгэх, дахин боловсруулах, хадгалах, бүртгэх, борлуулах, худалдах, хуваарилах, тээвэрлэх, илгээх, олж авах, ашиглах, гаргах, оруулах, эсхүл устгах журам зөрчсөн, түүнчлэн тэдгээрийг үйлдвэрлэхэд ашиглагдах ургамлыг тариалах журмыг түүнийг мөрдөх, мөрдүүлэх үүрэг бүхий этгээд зөрчсөнөөс тэдгээр нь алдагдсан, эсвэл шунахай сэдэлтээр үйлдсэн, хүний эрүүл мэндэд гэм хор буюу өөр хүнд хор уршиг болгоомжгүй учруулах зэргийг гэмт хэрэгт тооцож, ял оногдуулахаар заасан байна.

2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр явуулж буй төрийн бодлого, эрх зүйн орчин, үйл ажиллагаа.

Үндсэн бодлогын хувьд дараах гурван чиглэлийг үндэс болгожээ.

1. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлт, хууль бус хэрэглээг бууруулах;

2. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус хэрэглээнээс гарах үр дагавраас үүдэлтэй хүндрэл, хор уршгийг бууруулах;

3. Нийгэмд мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлт, хууль бус хэрэглээний эсрэг хандлагыг бий болгох.

ОХУ-ын Мансууруулах бодистой тэмцэх бодлого нь дараахь стратегийн зорилтуудыг шийдвэрлэхээр тодорхойлогдсон байна. Үүнд:

- хар тамхины хууль бус худалдаа, хар тамхины эсрэг үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох (хар тамхины нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, шинжлэх ухааны судалгаа, боловсруулалтыг харгалзан үзэх);

- ОХУ-ын улсын хилээр мансууруулах бодисыг хууль бусаар нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хил, гаалийн хяналтын механизмыг боловсронгуй болгох;

- хар тамхины хууль бус худалдаатай холбоотой зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг сайжруулах;

- хар тамхины хууль бус худалдаанаас олсон орлогыг хууль ёсны болгох (мөнгө угаах) үйл ажиллагаатай тэмцэх;

- мансууруулах бодисыг хууль бусаар үйлдвэрлэх, тээвэрлэх, түгээх дэд бүтцийг устгах, ОХУ-ын нутаг дэвсгэрт мансууруулах бодисын хууль бус үйлдвэрлэлийн түүхий эдийн баазыг бууруулах;

- хар тамхинаас урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагааны нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх;

- Оросын уламжлалт оюун санаа, ёс суртахуун, соёлын үнэт зүйлсийг харгалзан нийгэмд хар тамхины хууль бус хэрэглээний эсрэг ухамсарт хандлагыг бий болгох нөхцлийг бүрдүүлэх;

- ОХУ-ын наркологийн албаны үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх, хар тамхинд донтсон хүмүүсийг хууль бусаар эмчлэх хэргээс урьдчилан сэргийлэх;

- мансууруулах бодис хэрэглэгчдийн халдварт өвчнөөс (ХДХВ-ийн халдвар, вирус гепатит, сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчин) урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх хүртээмжийг нэмэгдүүлэх;

- хар тамхи хэрэглэгчийг шүүхийн шийдвэрээр эмчлэх, эмнэлгийн болон нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах эрх зүйн механизмыг боловсронгуй болгох;

- хар тамхины хууль бус эргэлтийн чиглэлээр олон улсын хамтын ажиллагааны тогтолцоог цаашид хөгжүүлэх;
- хар тамхины эсрэг үйл ажиллагааны үр дүнтэй зохицуулалтыг хангах;
- эмийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, эмийн хяналтын чиглэлээрх судалгааны үр ашиг, бодитой байдлыг нэмэгдүүлэх;
- хар тамхи хэрэглэгчид, түүний дотор хорих газраас суллагдсан болон тогтмол оршин суух хаяггүй хүмүүсийг нийгэмшүүлэх боломжийг нэмэгдүүлэх.

Мансууруулах бодистой тэмцэх бодлогыг дараах чиглэлээр хэрэгжүүлж байна. Үүнд:

- хар тамхины эсрэг үйл ажиллагаа, хар тамхины хууль бус эргэлтэд тавих төрийн хяналтыг сайжруулах;
- мансууруулах бодисын хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх;
- хар тамхинд донтох, хор хөнөөлтэй (сөрөг үр дагавартай) мансууруулах бодис хэрэглэсэн гэж оношлогдсон хүмүүсийн тоог бууруулах;
- хар тамхины хууль бус худалдаатай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах;
- хар тамхины хууль бус худалдааны чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг сайжруулах.

Мансууруулах бодистой тэмцэх үйл ажиллагаа, хууль бус эргэлтэд тавих төрийн хяналт нь дараах чиглэлээр хэрэгждэг. Үүнд:

- эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
- шинэ төрлийн мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх аюултай бодисыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх төрийн хяналтын систем, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;
- соёл, амралт зугаалгын газруудад хар тамхины хууль бус худалдааг таслан зогсоох;
- мансууруулах бодисын хууль бус хэрэглээ, түгээлтийг дэмжих зорилгоор интернет эх сурвалжуудыг илрүүлэх, таслан зогсоох;
- зохион байгуулалттай бүлэглэл, гэмт хэргийн бүлэглэл, хар тамхины хууль бус худалдаатай тэмцэх ажлыг зохион байгуулах;
- хар тамхины хууль бус тариалалт, зэрлэг ургамал ургасан газар, тэдгээрийг хууль бус тариалалт, тэдгээрийг устгах аргыг сайжруулах механизмыг боловсронгуй болгох;
- эмийн болон мал эмнэлгийн зориулалтаар ашигладаг мансууруулах бодис үйлдвэрлэх, түүнчлэн эмийн үйлдвэрлэл, бусад зориулалтаар хар тамхины ургамал тариалахад төрийн хяналтыг хэрэгжүүлэх;
- Мансууруулах бодисын дагалдах бодисын эргэлт, тэдгээрийг үйлдвэрлэх, борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хууль бус үйлдвэрлэлд ашиглахаас урьдчилан сэргийлэх.

а. Мансууруулах бодисын хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

а) насанд хүрээгүй хүүхдийг сөрөг зан үйлээс урьдчилан сэргийлэх сурган хүмүүжүүлэх хөтөлбөр, хар тамхины хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх анхан шатны дэд бүтэц, хэлбэр, аргыг хөгжүүлэх. (практик сургалт, төслийн үйл ажиллагаа болон бусад аргууд);

б) урьдчилан сэргийлэх арга хэмжээг сургалтын хөтөлбөр, хичээлээс гадуурх болон бусад ажил, холбооны болон бүс нутгийн хөтөлбөр, төсөл, иргэд, ялангуяа хүүхэд, залуучуудад иргэний-эх оронч, оюун санааны болон ёс суртахууны боловсрол олгох;

в) оюутнуудын дунд хар тамхины хууль бус хэрэглээнээс татгалзах оюун санааны болон ёс суртахууны төлөвшил суулгах;

г) мансууруулах бодисын хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх үйл ажиллагааны стандартыг боловсруулж хэрэгжүүлэх, түүний үр нөлөөг үнэлэх нэгдсэн арга зүй, үнэлгээний шалгуурыг боловсруулах, олон нийтийн болон ашгийн бус байгууллагаас хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн үр дүн, үйл ажиллагааг дэмжих,

д) хар тамхины хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах хүний нөөцийг тусгайлан сургах тогтолцоог хөгжүүлэх;

е) хар тамхины эсрэг бодлогыг хэрэгжүүлэхэд сайн дурынхны (сайн дурын ажилтнууд) идэвхтэй оролцох;

ж) боловсролын байгууллагад хар тамхины хууль бус хэрэглээг эрт илрүүлэх механизмыг боловсронгуй болгох, мансууруулах бодисын хууль бус хэрэглээг эрт илрүүлэх үйл ажиллагаанд оюутнуудыг оролцуулах нөхцөлийг бүрдүүлэх;

з) хар тамхины эсрэг үйл ажиллагааны чиглэлээр гадаадын сайн туршлага, арга техникийг ашиглах зэрэг хар тамхины хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх шилдэг туршлагыг гадаад улс орнуудтай хамтран хэрэгжүүлэх туршлагыг өргөжүүлэх;

и) иргэд, насанд хүрээгүй хүүхэд, тэдний эцэг эх (хууль ёсны төлөөлөгч)-ийн хууль бус хэрэглээний эрсдэл, түүний хэрэглээний үр дагаврын талаархи мэдлэгийн түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн хар тамхины эсрэг суртал ухуулгын асуудлаар хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах;

и) хар тамхины эсрэг бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн мэдээлэл, боловсролын хөтөлбөрийг бий болгох, түүнчлэн холбогдох хөтөлбөрийн үр нөлөөг хянах, дүн шинжилгээ хийж, нотолгоонд суурилсан зөвлөмж боловсруулан олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр сурталчилах,

б. Мансууруулах бодист донтогч, хэрэглэгчийн тоог бууруулах үйл ажиллагааны хэлбэр.

а) ОХУ-д мансууруулах бодисын хэрэглээг хууль ёсны болгох, түүнчлэн мансууруулах өвдөлт намдаах эмийн хэрэглээг үндэслэлгүйгээр өргөжүүлэхгүй байх;

б) хар тамхины хууль бус хэрэглээнээс үүдэлтэй хордлогын тохиолдол, нас баралтын түвшинг бууруулах;

в) наркологийн албыг цогцоор нь хөгжүүлэх, наркологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эмнэлгийн байгууллага, салбар нэгжүүдийн материал, техникийн баазыг сайжруулах, эрүүл мэндийн нөхөн сэргээх төв, тасгийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх.

г) мансууруулах бодисыг хууль бусаар ашиглах, хар тамхинд донтох өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, түүнчлэн хар тамхинд донтсон хүмүүсийг эмчлэх арга барилыг боловсронгуй болгох,

д) мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн хууль бус хэрэглээг эрт илрүүлэх (эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний түвшинд) сайжруулах;

е) мансууруулах бодис хэрэглэгчдийн дунд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг нэвтрүүлэх;

ж) хар тамхинд донтсон хүмүүсийг нийгмийн нөхөн сэргээх тогтолцоог хөгжүүлэх, нийгэмшүүлэх, архи, мансууруулах бодис болон бусад хорт зуршилтай хүмүүсийг нийгэмшүүлэх

з) мансууруулах бодис хэрэглэгчдийг нийгэмшүүлэх тогтолцоог төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор хөгжүүлэх, үр дүнтэй ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх, механизмыг үе шаттайгаар нэвтрүүлэх.

с. Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах үйл ажиллагаа

а) ОХУ-ын хилээр дамжин өнгөрөх бараа, тээврийн дэд бүтцийн байгууламжид хяналт тавих, хил, гаалийн хяналтын механизмыг боловсронгуй болгох.

б/зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлээс үйлдэгдэж буй хар тамхины хууль бус худалдаатай холбоотой гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга зүйг боловсронгуй болгох;

в) хар тамхины хууль бус худалдаатай холбоотой зохион байгуулалттай бүлэглэл, гэмт хэргийн бүлэглэлийн үйл ажиллагаанд иргэд оролцохоос урьдчилан сэргийлэх механизмыг боловсруулах;

г) орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан зохион байгуулалттай бүлэглэл холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох механизмыг хөгжүүлэх;

д) хар тамхины хууль бус худалдаанаас олсон орлогыг хууль ёсны болгохтой тэмцэх, түүний дотор энэ чиглэлийн санхүүгийн гүйлгээг илрүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй зохион байгуулалттай бүлэг, гэмт хэргийн бүлэглэл, аж ахуйн нэгжийн гишүүдийг илрүүлэх.

е) хар тамхины гэмт хэргийн эдийн засгийн сүлжээг таслан зогсоох тактик, арга зүйг сайжруулах, хууль сахиулах байгууллагууд, санхүүгийн хяналтын алба болон төрийн бус байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх;

ж) хар тамхины хууль бус худалдаатай холбоотой гэмт хэрэг үйлдэхэд цахим төлбөрийн хэрэгслийн хэрэглээг таслан зогсооход чиглэсэн арга хэмжээг боловсронгуй болгох,

d. Хамтын ажиллагаа

Хамтын ажиллагааг дараах хэлбэрээр²⁰ явуулж байна. Үүнд:

а) Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн хууль бус эргэлттэй тэмцэх тухай олон улсын конвенцуудын хэрэгжилтэд хяналт тавих;

Мансууруулах бодисын эсрэг олон улсын бодлого, НҮБ-ын Мансууруулах бодисын хяналтын хорооны бүрэн эрхийг хэрэгжүүлэх зарчмын байр суурийг харгалзан дэлхийн хар тамхины аюулын эсрэг тэмцэх;

б) дэлхийн хар тамхины хяналтын өнөөгийн дэглэмийг сулруулах, өөрчлөхөөс урьдчилан сэргийлэх, хар тамхины хууль бус эргэлт, хэрэглээг нэмэгдүүлэхэд хүргэж болзошгүй бусад санаачлагыг хэрэгжүүлэхээс урьдчилан сэргийлэх;

в) Терроризмыг санхүүжүүлэх болон мөнгө угаах, бусад олон улсын болон бүс нутгийн байгууллага, холбоод, хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага, Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл, Шанхайн хамтын ажиллагааны байгууллага, БРИКС-ийн холбоо, Евразийн бүлгийн хүрээнд хар тамхины хууль бус худалдаатай тэмцэх чиглэлээр хоёр болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх.

г) Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсын хар тамхины эсрэг чадавхийг бэхжүүлэх, нутаг дэвсгэрээс нь ирж буй хар тамхины аюулыг нутагшуулах зорилгоор олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх;

д) Төв Ази, Ази, Номхон далайн бүс нутаг, Европ, Латин Америк, Хойд Америк, Африкийн орнуудтай хар тамхины хууль бус худалдаатай тэмцэх чиглэлээр хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх, түүнчлэн энэ чиглэлээр хамтарсан санаачилгыг дэмжих байр суурийг цаашид уялдуулах

е) тус улсын нутаг дэвсгэрт мансууруулах бодисыг хууль бусаар импортлох, үйлдвэрлэх, худалдаалах зорилгоор орчин үеийн шинэ технологийг ашиглахтай тэмцэхэд чиглэсэн гадаадын шилдэг туршлагыг судалж, хэрэгжүүлэх; түүнчлэн терроризмыг санхүүжүүлэхэд ашиглагдах хар тамхины гэмт хэргийн эдийн засгийн холбоог устгах;

ж) хар тамхины эсрэг үйл ажиллагаа явуулахад нь туслах, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын ивээл дор боловсон хүчнийг сургах, боловсон хүчин бэлтгэх асуудлаар гадаад улс орнуудтай хоёр талын болон олон талт хамтын ажиллагаанд ОХУ-ын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, хар тамхины хууль бус эргэлттэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын ур чадвар, чадавхийг хөгжүүлэх;

з) ОХУ-ын Гадаад хэргийн яам, гадаад улсын байгууллага, олон улсын байгууллагаас зохион байгуулдаг боловсрол, шинжлэх ухаан-практик арга хэмжээ, бага хурал, симпозиум, хэвлэл мэдээллийн форум болон бусад ижил төстэй арга хэмжээний хүрээнд хар тамхины хууль бус худалдаатай тэмцэхтэй

²⁰ Корнев, Андрей Анатольевич. Административно-правовые средства борьбы с незаконным оборотом наркотиков в Российской Федерации : - Санкт-Петербург, 2008;

холбоотой асуудлыг иж бүрэн судлах, холбогдох асуудлыг олон улсын болон бүс нутгийн тавцанд шийдвэрлэх хамтарсан арга хэмжээ боловсруулах..

Дунд болон урт хугацаанд үндэсний аюулгүй байдалд заналхийлэх боломжтой чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

а) мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх олон улсын эрх зүйн актуудыг зөрчиж, мансууруулах бодисыг либералчлах, хуульчлах, хууль бус эргэлттэй тэмцэх хар тамхины олон улсын хяналтын тогтолцоог тогтворгүй болгох оролдлого;

б) каннабисыг хувийн хэрэгцээнд ашиглахыг хуульчилж, шинэ төрлийн эм бий болж, тэдгээрийг борлуулах зах зээл үүссэнээр дэлхийн эмийн зах зээл өргөжиж, эрх баригчдын хяналтад байгаа, түүнчлэн зэвсэгт мөргөлдөөний бүс нутагт хар тамхины хууль бус үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэн.

в) хар тамхины хууль бус худалдаатай холбоотой зохион байгуулалттай бүлэглэл, (гэмт байгууллага), түүний дотор үндэстэн дамнасан үйл ажиллагаа;

г) зохион байгуулалттай бүлэглэлийн хууль бус үйл ажиллагааны шинэ хэлбэрүүд гарч, харилцаа холбоо болон бусад шинэ технологийг ашиглан мансууруулах бодис нийлүүлэх, борлуулах сүлжээ үүсэх;

д) Эмийн эрэлт хэрэгцээ нэмэгдсэнтэй холбоотойгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм үйлдвэрлэх, боловсруулахад ихэвчлэн ашигладаг бодисыг ашиглан ОХУ-ын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн хууль бус хэрэглээний зорилгоор синтетик эмийн зах зээл дээрх нийлүүлэлт нэмэгдэх.

е) хар тамхины хууль бус худалдаанаас олсон орлогыг хууль ёсны болгох (мөнгө угаах) зорилгоор орчин үеийн санхүүгийн хэрэгсэл, төлбөр төлөх шинэ аргыг ашиглах;

ж) мансууруулах бодисын хууль бус хэрэглээг сурталчлах зорилгоор цахим орчины хэрэглээ нэмэгдэх, ашиглах;

з) Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад хар тамхины ургамал тариалах, хар тамхины бүлгийн эмийн үйлдвэрлэл өндөр түвшинд хэвээр байгаа, тухайн нутаг дэвсгэр дээр бусад төрлийн мансууруулах бодис, түүний дотор синтетик эмийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх хандлагатай байна;

и) ОХУ-ын нутаг дэвсгэрээр дамжуулан хар тамхины тээвэрлэлт, түүнчлэн олон улсын шуудан, илгээмжийн хүргэх үйлчилгээг ашиглан мансууруулах бодисыг хууль бусаар импортлох хэмжээг нэмэгдүүлэх гэсэн үндэстэн дамнасан гэмт хэргийн байгууллагуудын оролдлого;

к) хар тамхины хууль бус худалдаанаас олсон орлогыг олон улсын террорист байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашиглах;

л) сэтгэцэд нөлөөлөх эмийг эмчийн жоргүйгээр хэрэглэх, хууль бусаар хэрэглэх зорилгоор синтетик гаралтай сэтгэцэд нөлөөлөхүйц аюултай бодис шинээр гаргаж авах, борлуулах тохиолдлын тоо нэмэгдэх,

л) мансууруулах бодисын донтолт, ХДХВ-ийн халдвар, вирус гепатитын тархалт;

м) урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, хар тамхинд донтогчдыг нийгэмшүүлэх үйл ажиллагаа хангалтгүй, хар тамхины эсрэг бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллагын чадавхи хязгаарлагдмал;

ө) хар тамхи хэрэглэгчдийг шүүхийн шийдвэрээр эмчлэх, эмнэлгийн болон нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах эрх зүйн механизмыг үр ашиггүй ашиглах зэрэг болно.

Дүгнэлт

1. Дэлхий дахинд тархаад байгаа коронавирус /COVID-19/ цар тахлын хүрээнд иргэдийн зорчих хөдөлгөөнийг хязгаарласан, хилийн боомтууд хаагдсантай холбоотой дэлхий ихэнх орнуудад нийт гэмт хэрэг, зөрчлийн тоо багасах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, эрэлт нийлүүлэлтийг хязгаарлах, борлуулалтын сүлжээ багсах, таслан зогсоох, сэжигтэй этгээд бүлэг бөөгнөрөл харьцангуй багассан эерэг үзүүлэлтүүд гарч байгаа хэдий ч цахим технологи, крипто төлбөрийн хэргэсэл хөгжихийн хирээр мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтэд хамаарах уламжлалт хандлага,

нөхцөл байдал өөрчлөгдөж, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйл ажиллагаа илүү системчлэгдсэн, нууцлагдсан, илрүүлэхэд төвөтэй болох хандлага ажиглагдаж байна.

2. Цаашид коронавирус /COVID-19/ цар тахлын хатуу дэглэм буурч, хил, гааль, иргэдийн зорчих хөдөлгөөн нээгдсэн даруйд энэ төрлийн гэмт хэрэг, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйл ажиллагаа огцом нэмэгдэх, идэвхжих магадлалтай байна.

3. ОХУ-д хар тамхины хэрэглээний түвшинг тодорхойлох зорилгоор хүн амын дунд бий болсон хандлагыг үнэлэх зорилгоор явуулсан социологийн судалгаанаас үзэхэд хар тамхи, мансууруулах бодисыг тогтмол хэрэглэдэг хүний тоо өндөр, 2019 оны социологийн судалгаанд хамрагдсан иргэдийн 21.8 орчим хувь нь хар тамхи хэрэглэж үзэх хүсэлтэй, 24.1 хувь нь хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар хэрэглэж байсан болон хэрэглэж байгаа хүмүүстэй харилцдаг гэсэн дүгнэлт гарсан нь хөрш зэргэлдээ орны хүн амын дунд хэрэглэгч их байгаа нь анхааралд татаж байна.

4. Дэлхий нийтийг хамарсан шинэ төрлийн коронавирусын халдварын цар тахал улс орнуудын хэвийн үйл ажиллагаа, гэмт хэргийн гаралтад шууд нөлөөлсөн байна. Тухайлбал, ОХУ-д 2019 онд цахим технологи ашиглаж үйлдсэн мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг 24.7 мянга бүртгэгдсэн бол 2020 оны дүнгээр цахим технологи ашиглан үйлдэгдсэн энэ төрлийн гэмт хэрэг 47 мянга буюу 2 дахин их бүртгэгдсэн байгаа нь анхаарал татаж байна.

Санал

1. Монгол Улс дахь мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх урт хугацааны төрийн бодлого боловсруулах;

2. Монгол Улс дахь мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдлыг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг батлах, нөхцөл байдлын судалгааг гаргах байгууллага, албан тушаалтныг тодорхой болгож эрх зүйн зохицуулалт хийх;

3. Монгол Улсын хилээр мансууруулах бодисыг хууль бусаар нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хил, гаалийн хяналтын механизмыг боловсронгуй болгох, сайжруулах боломжыг судлах;

4. Мансууруулах бодисыг хууль бусаар үйлдвэрлэх, тээвэрлэх, түгээх дэд бүтэц, сүлжээ үүсэхээс урьдчилан сэргийлэх;

5. Нийгэмд хар тамхины хууль бус хэрэглээний эсрэг ухамсарт хандлагыг бий болгох нөхцлийг бүрдүүлэх талаар судалгаа хийх, эрх зүйн зохицуулалт бий болгох саналуудыг дэвшүүлж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Противодействие незаконному обороту наркотиков : ВПМК МВД России, 2020;
2. Гаджиев, Муса Абдусамадович. Борьба с незаконным оборотом наркотиков в глобальном управлении - Москва, 2020;
3. О борьбе с наркотиками : регулирование деятельности в сфере оборота наркотических средств, ограничение оборота некоторых психотропных веществ, культивирование наркосодержащих растений, запрещение пересылки наркотических средств. - Москва : Профиздат, 2014;
4. Витовская, Евгения Сергеевна. Международное сотрудничество в сфере борьбы с незаконным оборотом наркотиков : учебное пособие - Новокузнецк : Кузбасский институт ФСИН России, 2021;
5. Корнев, Андрей Анатольевич. Административно-правовые средства борьбы с незаконным оборотом наркотиков в Российской Федерации : - Санкт-Петербург, 2008;

ЦААЗААР АВАХ ЯЛ БА ХҮНИЙ ЭРХ

И.Ургамал

ЭЗНУС-ийн НЭЗТ-ийн багш

Доктор (Ph.D), цагдаагийн ахлах дэслэгч

Товч агуулга. XX зууны сүүлчээс дэлхийн олон улс орны эрүүгийн эрх зүйн салбар болон ялын бодлогод хүмүүнлэгийн хандлага хүчтэй нөлөөлж цаазаар авах ялын хэрэглээ илт хязгаарлагдах болсон. Одоогийн байдлаар цаазаар авах ялыг хэрэглэхээс татгалзсан буюу халсан 145 орон, идэвхитэй хэрэглэж буй 26 орон, хязгаарлагдмал буюу түдгэлзсэн 31 орон байна. Манай Улсын хувьд 2010 оны нэгдүгээр сарын 1-нд цаазаар авах ялын гүйцэтгэлд мораториум²¹ тогтоож үүнээс хоёр жилийн дараа Улсын их хурал Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд нэгдэн орох тухай хуулийг соёрхон баталсан. Ингэснээр цаазаар авах ялыг гүйцэтгэхээс татгалзаж Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаас цаазаар авах ялыг бүрмөсөн халснаар манай улс цаазын ялгүй улс болсон билээ.

Энэхүү өгүүлэлд хүний амьд явах эрх болон цаазаар авах ялыг манай улсын хууль тогтоомжид хэрхэн тусгагдаж ирсэн эрх зүйн түүхэн хөгжил болон цаазаар авах ялаас татгалзах болсон шалтгааны талаар товч авч үзсэн болно.

Түлхүүр үг. Хүний эрх, цаазаар авах ял, хууль,

Үндсэн хэсэг. Хүний амьд явах эрх бол төрөхөөс заяамал жам ёсны эрх бөгөөд түүнийг ямарч тохиолдолд хуульчлан хөндөх нь хууль ёс болоод хүнлэг ёсноос гажуудсан асуудал. Түүнчлэн олон улсад эрүүгийн эрх зүй болон ялын бодлогод хүний халдашгүй эрх, эрх зүйт ёсны шаардлагыг хангахад чиглэгдсэн НҮБ-ын гэрээ, конвенц цөөнгүй гарсан болно²². Үүнээс заримыг дурдвал НҮБ-аас 1989 онд батлагдсан “Иргэний олон улс төрийн эрхийн тухай” Олон улсын пактын хоёрдугаар нэмэлт протокол, НҮБ-ын 2007 онд баталсан “Цаазаар авах ялыг дэмжих тухай конвенц”, Европийн холбооны зөвлөлийн 1989 оны Хүний эрхийн конвенцийн 6,13 дугаар протокол, НҮБ-ын 1984 оны “Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн эрхийг хамгаалах конвенц” зэрэг болно.

Манай улс цаазаар авах ялаас татгалзахаас өмнө 2002 оны Эрүүгийн хуулиар долоон төрлийн гэмт хэрэгт уг ялыг оноодог байсан. Үүнд, төр нийгмийн зүтгэлтний амь биед халдах, хорлон сүйтгэх, хүндрүүлэх нөхцөлтэйгөөр бусдыг санаатай алах, зандалчлах, геноцид, терроризм үйлдэх зэрэг гэмт хэрэг орно. Өөрөөр хэлбэл, бусдын амь насыг санаатай бүрэлгэсэн, бага насны хүүхдийг хүчирхийлж, ёс бусаар бэлгийн дур хүслээ хангасан этгээдийг цаазын ялаар шийтгэдэг байв.

Түүхээс харвал цаазаар авах ял нь ямагт төрийн бодлогын болон эрүүгийн эрх зүй судлаачдын анхаарлын төвд явсаар ирсэн. Манай улсад 1953 онд цаазаар авах ялыг хүчингүй болгож байсан ч уг шийдвэрээ цуцлан эргээд тус ялыг хэрэглэх болсон түүхтэй. Дэлхий дахинд явагдаж буй эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн дагуу Монгол Улсад ялын бодлогод шинэчлэлт хийх нэн шаардлага гараад байгаа нь маргаангүй. Үүнд хамгийн түрүүнд ялын бодлогод хүнлэг, энэрэнгүй ёсны зарчмын дагуу Эрүүгийн хуулинд зарчмын өөрчлөлтүүд гарсны нэг том илрэл бол цаазаар авах ялыг хассан явдал болсон.

Хүний эрхийг өндөр түвшинд хамгаалдаг хөгжингүй зарим орнуудын хувьд ч цаазын ялыг хэрэглэсээр байгаа. Гэвч тус ялыг хэрэглэж буй эрх зүйн орчин, ялын гүйцэтгэл манайхаас өөр байх жишээтэй. Өнөөгийн манай нийгэмд цаазаар авах ялыг халах цаг нь болсон, болоогүй мөн харгис хэрцгий гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цаазаар авах ял оноох нь зүйтэй талаар нийгэмд хоёрдмол байр суурь ажиглагдах болсон. Иймээс Монгол Улсад цаазын ялыг хэрэглэж ирсэн түүх болон АНУ, Хятад,

²¹ “Бүхэлд нь хойшлуулах”

²² Баярсайхан Д. Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессийн шинэтгэлийн асуудлууд. Уб. 2019. 114 дэх тал.

Япон гэсэн зарим улсын ялын бодлого, цаазаар авах ялыг хэрэглэх эрх зүйн орчин, онцлог зохицуулалтын талаар харьцуулан судлахыг хичээлээ.

1. Монгол Улсад цаазын ялыг хэрэглэж ирсэн түүх, түүний онцлог

Монгол Улс нь төр, хууль, цаазын арвин баялаг уламжлалтай. Анхны төрөлжсөн Эрүүгийн хуулийг 1926 онд гаргаж байсан түүхтэй. Үүнээс хойш эрүүгийн хуулийг нийт найман удаа шинэчлэн баталсан байдаг. (1926, 1934, 1942, 1960, 1987, 1994, 2002, 2015)²³. Эрүүгийн эрх зүйн зохицуулалтын түүхээс цаазаар авах ялтай холбоотой зарим онцлог заалтуудаас дурдвал 1942 оны эрүүгийн хуульд “энэхүү эрүүгийн хуульд шууд үл заагдсан ямар нэгэн гэмт хэрэг гарвал мөнхүү хуулийн тусгай ангийн зүйлүүдээс тэрхүү үйлдсэн гэмт хэргийн төрөл ба зүйлд хамгийн төсөөтэйг баримтлан зохих ялын хэмжээг оноовол зохино” гэжээ. Энэ нь эрүүгийн хуулийг ямар ч тохиолдолд төсөөтэй хэрэглэхийг хориглодог нийтийн жишгийг зөрчиж тэр үеийн улс төрийн хэлмэгдүүлэлтийг хуулиас гадуур “онцгой бүрэн эрхт комисс” байгуулах замаар хэрэгжүүлэх эрх зүйн үндэс болж байв.²⁴

1961 оны эрүүгийн хуульд хүний бүрэн эрхийг хасах, хуулийг төсөөтэй хэрэглэх заалтууд хасагдсан боловч нэг намын үзэл суртлыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл болж байв. Эрүүгийн хуулиар гол хамгаалах зүйлд “социалист байгуулал”, “социалист өмч” –ийг тавьж улс төржиж, үзэл сурталжсан зүйл заалтууд олноор туссан байв. Үүний тод илрэл нь 1986 оны хуулинд социалист өмчийг онц их хэмжээтэй шамшигдуулсан бол цаазаар авах ял оногдуулахаар зааж байжээ.

Хувьсгалын анхны жилүүдэд Ардын Засгийн газраас гаргасан Эрүүгийн эрх зүйн хуульчилсан актуудын гол агуулга нь:

- Манжийн болон Монголын хаант улсын үед хэрэглэж байсан эрүү шүүлийг нэн дару хэрэгсэхгүй болгох;
- Ардчилсан төрийн эрүүгийн хууль цаазны үндсэн бодлого зарчмыг тогтоосон түүнийг ард түмэнд ойлгон таниулах;
- Хуучин төрийн шүүхийн системийг устгаж шинэ төрийн шүүхийн системийг боловсруулах урьдчилсан бэлтгэл ажлыг хангах зэрэг байсан.

Энэхүү арга хэмжээг Монгол Ардын Намын Төв Хорооны удирдлагаар Ардын засгийн газар, түүний шүүх яамнаас эрхлэн явуулдаг байсан байна. Тухайн үеийн эрүүгийн эх сурвалжид: Ардын Засгийн Газрын хурлаас гаргасан хуульчилсан акт(хурлын тогтоол бичиг), Шүүх яамнаас гаргасан актууд, тушаасан бичгүүд, Улс төрд тэрсэлсэн онц ноцтой хэргийг таслуулахаар Засгийн газраас байгуулсан комиссын тогтоол зэрэг болно. Эдгээр актуудын онцлог нь төрийн бүх эрх мэдлийг Ардын Засгийн Газарт төвлөрүүлж Засгийн газрын хурлаар хууль гаргах, захиргааны бүх асуудал хэлцэгдэж Засгийн газрын үйл ажиллагаа нэлээд өргөн хүрээ, эрх мэдлийг хамарч байв.

1921 оны 11 дүгээр сарын 1-нд Ардын засгийн газар ба Богд хааны хооронд эрх хэмжээг зааглан тогтоосон “Тангаргын гэрээ” баримт бичгийг гаргасанаар Ардын Засгийн Газарт засгийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл бүгд багтжээ. 1921 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн Ардын Засгийн газрын хурлын 9 дүгээр тогтоолын 5 дугаар зүйлд Эх орноосоо урвах гэмт хэргээс бусад гэмт хэрэгт алах цөлөх дөнгөлөх ялыг өөрчилж алах ялыг 10 жил хорих, алгуурлан алах ялыг 7 жил хорих ял болгон өөрчилж ял шийтгэл оногдуулахдаа тайж ард гэж ялгаварлан гадуурхахыг хориглосон байна. Мөн Ардын Засгийн Газрын 1923 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хурлын 13 дугаар тогтоолын 1,2 дугаар зүйлээр Ардын төрд тэрсэлж гадаадаас цэргийн тусламж гуйж Ардын засгийг устгах зорилготой төрийн эсрэг гэмт хэрэг үлдсэн Дампил нарын 8 этгээд, эсэргүү хувалдаан зохион байгуулсан Мижиддорж нарын 4 этгээдэд оногдуулсан буудан алах ялыг ёсоор болгон баталжээ. Мөн Ардын Засгийн Газар 1923 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 22 дугаар тогтоолын 6 дугаар зүйлээр Эрүүгийн хуулийг боловсруулан дагаж шийтгүүлэх хүртэл зэвсэг хэрэглэж дээрэм хийсэн ашгийг хичээх буюу бусдыг санаатайгаар алсан гэмт хэрэгт цаазаар авах ялыг хэрэглэхээр тогтжээ.

²³ Баярсайхан Д. Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессийн шинэтгэлийн асуудлууд, Уб. 2019

²⁴ Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт., Уб. 1998

1924 оны 11 дүгээр сард Улсын анхдугаар Их Хурал хуралдаж улсыг “Бүгд Найрамдах Монгол Ард Улс” гэж тунхаглаж анхдугаар үндсэн хуулийг баталсан. Үндсэн хуульд “Улсын Шүүх Таслах Газрууд, хэргийн явуулах дүрэм журам, мөн иргэний ба эрүүгийн хууль зүйлийг тогтооно” гэж заасан. (1924 оны Үндсэн хууль 4 дүгээр зүйл)

Тухайн үеийн эрүүгийн эрх зүйн үндсэн зорилго, ялын бодлого нь ардын хувьсгалаар олсон эрх чөлөөг хамгаалах зорилготой тул ардчилсан эрх эрх чөлөөг устгах гэсэн ардын дайсныг хатуу чанд цээрлүүлэн шийтгэх бодлоготой байв. Мөн Улсын бага хурлын тэргүүлэгчдын 1926 оны 1 дүгээр сарын 15-ны 1 дүгээр хурлаар 20 зүйл бүхий “Улс төрийн явдалд холбогдох хэргийг таслан шийтгэх газрын түр дагаж явах газрын дүрэм” 4 бүлэг, 64 зүйл бүхий “Улс төрийн хэрэгт холбогдох этгээдийг шүүн таслах түр хурлын дагаж явах журмыг” тус тус батлан мөрдүүлсний дүрмийн нэгдүгээр зүйлд “БНМАУ-ын засаг төрийн явдалд хортой санаа агуулж хувьсгалд тэрслэгсэд ба мөн улс ардын аж ахуйн явдалд онц аюултай хэрэг үйлдсэн... зэрэг явдалд холбогдогчийн тухай хэргийг таслах тусгай газар байгуулна” гэжээ.

Цаг зуурын шүүх таслах газар улс төрийн гэмт хэргийг таслан шийтгэхдээ ямар ч хэмжээний ял шийтгэл өөрөөр хэлбэл цаазаар авах ял оногдуулах онцгой эрхтэй байв. Дээрх шүүхэд харьяалагдан таслагдах гэмт хэрэгт:

1. Зэвсэг барьж урвах явдлыг зохион байгуулах, төв ба орон нутагт засгийн эрхийг булаан авах буюу БНМАУ-ын нутаг дэвсгэрээс таслан авч улсын мэдлээс гаргахыг оролдох
2. БНМАУ-д гадаадын зэвсэгт цэргийг оруулахыг хичээхгадаад улс болон түүний төлөөлөгчидтэй хуйвалдан харилцах
3. Ард түмний сэтгэл санааг урвуулж албан татва гаргахгүй, цэргийн албанаас зайлсхийх, хувьсгалд тэрслэх
4. Хувьсгалын эсэргүү зорилгоор Ардын засгийн эх баригчид, хувьсгалын удирдагчдын амийг хороох
5. Дайсан этгээдийн өмнөөс тагнуул хийх улс төрийн нууцыг хулгайлах ба мэдээ хураах, ялангуяа цэргийн нууц чухал зүйлүүдийг хувьсгалтай тэрслэх анги намд мэдэгдэж хувьдаа ашиг олох
6. Хувьсгалын явдалд хортой бичиг сэтгүүлийг зохион үйлдэх тараахаар хадгалах буюу тараах үйлдлүүд багтдаг байжээ.

Үүнээс хойш Засгийн газрын 1927 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 8 дугаар хурлаар “Цаг зуурын шүүх таслах газар”-н онцгой эрхийг өөрчилж гэмт хэрэгт БНМАУ-ын шүүх цаазын бичгийг баримтлан ял оногдуулж байхаар болжээ. 1926 оны БНМАУ-ын шүүх цаазын бичгийн 5 дугаар зүйлд Ял ба засан сайжруулах арга хийгээд ард олныг арчлан хамгаалах аргад цаазаар авах ялыг “алах ял” гэж тусгасан байдаг. Тус ялыг нийт 4 төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ялыг хэрэглэхээр тусгасан. Үүнд:

- Улс төр дор тэрслэх нь гэсэн 8 дугаар бүлгийн 41-44 дүгээр зүйл
- Улс төрөөс урвах нь 49,50 дугаар зүйл
- Улсын гадаад харилцаа найрамдалд дор хор хүргэх нь 52 дугаар зүйл
- Хүний аминд хор хүргэх зэрэг болно. 169, 170 дугаар зүйл зэрэг нийт 9 зүйлийн гэмт хэрэгт цаазын ял оноож байв.

1929 он шүүх цаазны бичигт нэмэлтээр (20 дугаар бүлэг) “Аливаа албаны хүн гэмт явдлаар явах нь” бүлгийг нэмж тус бүлгийн 157 дугаар зүйлд “Аливаа албан тушаалтан буюу албаны болон ард олноос байгуулсан газраас тусгай тушаасан ёсоор хэрэг явдлыг гүйцэтгэж буй этгээд онц эрх бүхий этгээд улсын үнэ бүхий онц чухал зүйлийг ашиглах зэргээр сүйтгэвээс онц хүндэтгэх учир шалтгаан буй аваас буудан ална” гэж заажээ. Тус Шүүх цаазын бичигт хувьсгалын эсэргүү улс төрийн гэмт хэргүүдийг олон бүлэгт тарааж хуульчилсан мөн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт харьцангуй хөнгөн ял оноохоор зааж байсан нь учир дуталтай байв.

1934 оны шүүх цаазын бичигт Сайд нарын зөвлөлийн 1936 оны 8 дугаар сарын 10-ны 35 дугаар хурал, Улсын бага хурлын тэргүүлэгчдийн хурлын 19 дүгээр хурлаар Шүүх цаазны бичгийн тусгай

ангид Цэргийн гэмт хэргийн тухай 9 дүгээр бүлгийг шинээр нэмж оруулсан. Ялын дээд хэмжээ нь буудан алах ял. Тус ялыг Хувьсгалын эсэргүү гэмт хэргүүд бүлгийн Зэвсэг барин эсэргүүцсэн, засгийн эрхийг булаан эзэлсэн мөн тус хөдөлгөөнийг бэлтгэсэн зохион байгуулсан оролцуулахыг татан оролцуулсан, гадаад улсын хилийн гадна буй этгээдүүдтэй харилцсан бол буудан алах ялаар шийтгэх, улсын нууц мэдээг гадаад улсад ба хувьсгалын эсэргүү нарт өгсөн, Улсын болон үйлдвэрийн газруудыг үйл ажиллагааг муутгасан, гарз хохирлыг санаатайгаар учруулсан, улсын болон олон нийтийн үйлдвэрийн газруудын ардын харилцан нэвтрэлцэх холбооны хэрэгсэл бусад барьж байгуулсан зүйлийг дэлбэлэх тэсэргэхгал тавих санаатайгаар эвдэн сүйтгэсэн бол, Ардын хувьсгалт засгийн төлөөлөх этгээд болон хувьсгалын байгууллагын ажилчид тэднийг ажил үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан амь насыг нь хороох, тахир дутуу болгох зэрэгт цаазаар авах ял оноор заажээ.

Мөн Ардын хувьсгалт засгийг эсэргүүцэх зорилгоор ард олны санаа үймсэн болон дайны цаг үест суртал ухуулга ном хэвлэмэл тараавал буудан хороохоор зааж байжээ. Мөн хоёрдугаар бүлгийн Засаг захиргааны цурмыг эсэргүүцэх онц аюултай гэмт хэргүүд бүлэгт Аливаа хүмүүс олноор журмыг алдаж самууран хөдлөх хүмүүсийг алах болон шатаах эвдэх сүйтгэх хамгаалах цэрэгт эсэргүүцсэн бол буудан алж хөрөнгийг хураах ял онооно. Мөн үүтэй төстэй 52, 54 дүгээр зүйлүүдэд буудан алах ялаар шийтгэхээр зааж байжээ.

Зургаадугаар бүлэг Хүний амь бие эрүүл мэнд эрх чөлөө нэр алдарт харшлах гэмт хэргүүд бүлгийн Хүнийг санаатай алсан бол мөн хүндрүүлэн шалгаантай бол буудан алах ял оноож байсан. Мөн шинээр есдүгээр бүлгийг Цэргийн албаны хүмүүсээс өдүүлсэн гэмт явдлыг шийтгэх тухай “Эх орноосоо урвагсдын тухай” хэсгийн Эсэргүү бүлгэм байгуулсан, тагнуул хийсэн, нууц задалсан этгээдүүдэд цаазын ялаар цээрлүүлнэ хэмээсэн. Мөн эрүүгийн хэрэгт хориотой бусад гэмт явдлын тухай хэсэгт 156, 159, 157, 160, 162, 167, 169, 171, 172, 174 дугаар зүйлд заасан гэмт хэргүүдэд “шууд буудан алах” ял оноохоор заасан байжээ.

1934 оны Шүүх цаазны бичгийн онцлог зүйл нь тухайн үеийн нийгмийн байдал нэг намын үзэл суртал хуулинд тусаж гэмт хэрэгт хомрогolon шийтгэх мөн ижил төрлийн олон гэмт хэрэгт цаазын ялыг оноохоор заасан байжээ. Мөн Цэргийн албаны хүмүүсээс өдүүлсэн гэмт явдлын тухай хэсэгт буудан алах ялыг “шууд буудан ална” гэж заасан нь хэт хүнлэг бус шудрага ёсны зарчимд үл нийцэх харгис заалт байв.

1942 оны Эрүүгийн хуулинд шинэ Үндсэн хуулийн дагуу шүүх цаазын бичгийг шинэчлэн боловсруулах жил явагдаж 1942 оны 1 дүгээр сарын 17 нд Улсын 25 дугаар бага хурлаар Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн түүхэнд анх удаа “БНМАУ-ын эрүүгийн хууль” нэртэй гаргажээ. 1953 оны 8 дугаар сарын 5-нд БНМАУ-ын Их Хурлын тэргүүлэгчдээс гаргасан “Алах ялыг өөрчлөх тухай” зарлиг, 1954 оны 6 дугаар сарын 9-ний өөрчлөлт нь Эрүүгийн хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилж байв.

Тус хуулийн 4 дүгээр бүлэг Ялын тухай хэсгийн 20 дахь хэсэгт “Хувьсгалт төр засаг хийгээд улс нийтэд онц аюул бүхий хүнд гэмт хэргүүдтэй хатуугар тэмцэхийн тулд энэхүү хуулийн зүйлүүдэд тусгайлан заасан байвал улс нийтийг хамгаалахын тулд туйлын арга болох буудан алах ялыг хэрэглэнэ.” , “уул гэмт хэргийн үйлдэх үед 18 насанд хүрээгүй байсан хүмүүс жирэмсэн хөхүүл хүүхэдтэй хүмүүст буудан алах ял оногдуулж үл болно ” гэж тус тус заасан байв. 1953 оны Алах ялыг өөрчлөх тухай зарлигаар эх орноос урвах, тагнуул хийх, хорлон сүйтгэх, тэсэлж дэлбэлэх зэрэг гэмт хэрэг үйлдэгчдэд 25 жил хүртэл хорьж шийтгэхээр заасан боловч 1954 оноос тус хуулийн нэгдүгээр бүлэгт заасан “Хувьсгалын эсэргүү гэмт хэргүүд буюу нийт 15 төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ял оноохоор заажээ. Үүнд жишээлбэл ”БНМАУ-ын цэргийн сүр хүч тусгаар тогтнол халдашгүй байдалд хор хохирлыг хүргэж тагнуул хийх, цэргийн болон улсын нууцыг дайсанд шилжүүлэн өгөх, дайсны талд урвах зэрэг гэмт хэргүүдийг эх орноосоо урвах гэмт хэрэг гэж үзэн цаазаар авах ял оноож бүх хөрөнгийг хураахаар заажээ. Мөн эх орноосоо урвах гэмт хэргийг мэдсээр атал мэдээлээгүй гэр бүлийхний бүх хөрөнгийг хурааж, 5 жил хорих албан хаагчдыг хүндрүүлэх шалтгаан байвал буудан алж бүх хөрөнгийг хураахаар

заасан байв. Ийнхүү тус бүлэгт 15 төрлийн гэмт хэргийг зүйлчлэн заасан бөгөөд бүгд цаазаар авах ялтай байсны дээр тус ялыг бүх хөрөнгийг хураах ялтай хамтатган хэрэглэдэг байв.

Хоёрдугаар бүлгийн Засаг захиргааны эсэргүүцсэн бөгөөд БНМАУ-д онц аюул бүхий гэмт хэргүүд бүлгийн үймээн самуун үүсгэсэн, галдан шатаасан эвдэн сүйтгэсэн явдал нь хүндрүүлэх шалтгаантай бол, бандитизм үйлдсэн бол, буу зэвсэг хулгайлан авсан, замтээврийн ажилчдаас хөдөлмөрийн сахилга бат, журмыг зөрчиж эвдрэл сүйтгэл болон хүмүүст хор хохирол учруулсан бол дайн айлдааны үест албан татвар өгөхөөс зайлсхийх, яс үндэс шашин шүтлэгийн зөрчлийг гаргаж ухуулга сурталчилгаа хийсэн бол хар тамхи үлэмж их хэмжээгээр хууль бусаар хил давуулсан оруулж ирсэн үйлдлүүдийг хүндрүүлэн үзэх шалтгаантай үйлдсэн бол цаазлан хороож бүх хөрөнгийг хураахаар заажээ.

“Албан тушаалын гэм хэргүүд бүлгийн” албан тушаалтнаас засгийн эрх буюу албан тушаалын эрхээ хувийн ашгийг хичээн илт хэтрүүлсэн, хүний амь бие эрүүл мэнд эрх чөлөө хийгээд нэр алдарт харшлах гэмт хэргүүд, хүнийг санаатай хүндрүүлэн үзэх шалтгаантай алвал, бие бэлэгс боловсроогүй эмэгтэйчүүдийг хүчирхийлвэл буудан алах ялаар шийтгэж байсны дээр цэргийн 23 төрлийн гэмт хэргүүдэд цаазаар авах ял оноохоор хуульчилсан байна. Тухайн үед цаазаар авах ялаас татгалзаж байсан түүхэн ач холбогдол байсан боловч удалгүй буцаан сэргээсэн мөн маш олон төрлийн хэрэгт цаазаар авах ялыг бүх хөрөнгийг хураах ялтай хамтатган хэрэглэж байсан байна. Мөн тухайн үеийн дэлхийн 2 дугаар дайн болон манай улсын онцгой нөхцөл байдлын улмаас цэргийн гэмт хэргийн ялыг чангаар тогтоосон нь харагдаж байна.

1961 оны Эрүүгийн хуулийг мөн оны 1 дүгээр сарын 31-ний Ардын их хурлын 2 дугаар чуулганаар баталж 4 дүгээр сарын нэгнээс эхэлж мөрдсөн. Ял шийтгэх явдал нь хүний бие махбодийг зовоох хүн гэсэн нэрийг доромжлон гутаах зориллогүй гэж үзсэн. Ийнхүү ялын үндсэн төрлүүдэд цаазаар авах ялыг оруулаагүй бөгөөд 18 дугаар зүйлд “Онцгой ял-Цаазаар авах” гэж тусгажээ. Цаазаар авах ялыг Эх орноосоо урвах, тагнуул хийх, хорлон сүйтгэх, алан хядах, хүндрүүлэх шалтгаантай будыг санаатай алах, улс олон нийтийн хөрөнгийг ашиглан шамшигдуулах, иргэдийн амины хөрөнгийг хулгайлах, дээрэм хийх эдгээр гэмт хэргийн талаар хульд тусгайлан заасан бол онцгой ял-цаазаар авах ялыг оногдуулж болохоор заажээ. Харин эмэгтэйчүүд ба 60-аас дээш насны эрэгтэйчүүд, уг гэмт хэрэг үйлдэх үед 18 нас хүрээгүй этгээдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй гэж заажээ.

Тухайн үеийн нийгмийн байгуулал үзэл суртлаас хамааран “Социалист өмчийн эсрэг гэмт хэрэг” бүлгийн 63-в-д Улс олон нийтийн хөрөнгийг их хэмжээгээр ашиглан шамшигдуулсан бол цаазаар авч бүх хөрөнгийг хураана гэж заажээ. Мөн цэргийн гэмт хэрэгт цаазын ял оногдуулахгүйгээр хуульчилжээ. Түүхийн явцаас харахад эрүүгийн хууль тогтоомжид ялыг тухайн үеийн нийгмийн байдал, улс төр, төр засгийн бодлого, дэглэмээс хамааралтайгаар хуульчилж иржээ. Гэвч манай улс НҮБ-д гишүүн улсаар орсон мөн олон улсын гэрээ, конвенцод нэгдэж соёрхон баталсан зэрэг болон нийгмийн бусад шаардалгаас хамааран цаазын ялын хэрэглээг хумих бодлого барьж иржээ. Энэ нь хүнлэг энэрэнгүй ардчилсан төрт ёсны үзэл зарчимтай нийцсэн явдал юм. Гэвч түүхийн явцад шүүх цаазын бичиг, эрүүгийн хуулийг зөвхөн тухайн төр засгийн бодлогоор боловсруулж улс төрийн үзэл суртал шингээж, хоморголон хэлмэгдүүлж цаазын ялыг оноож байсан гашуун туршлага бидэнд байдаг бөгөөд хүний амь насыг хороох нь сэргээж болошгүй алдаа болохыг түүх бидэнд харуулсан юм.

2. Зарим улс орнуудад цаазаар авах ялын хэрэглээ, гүйцэтгэлийн зарим асуудал, онцлог шинжүүд

АНУ, Хятад, Япон улс нь эрүүгийн эрх зүйн түүхэн уламжлалын хувьд олон жилийн баялаг түүхтэй эдийн засаг, нийгмийн хөгжлөөрөө дэлхийд тэргүүлэгч хөгжингүй улсууд юм. АНУ бол 50 муж улсыг нэгтгэсэн холбооны төрийн байгууламжтай улс бөгөөд Английн нийтлэг эрх зүйн уламжламжлал

нөлөөнд тулгуурлан хөгжиж иржээ²⁵. АНУ-д 2000 он хүртэл жилд 295 цаазын ял оноодог байсан бол 2018 оны байдлаар 43 болж буурсан байна.

АНУ-ын Үндсэн хуульд “Цаазаар авах ял шийтгүүлэх гэмт хэрэгт Их суудлын тангарагтны шүүхийн мэдүүлэг, яллах дүгнэлтгүйгээр хэнийг ч хариуцлагад татаж болохгүй. Энэ нь дайны үед буюу нийгэмд аюул заналхийлсэнтэй холбоотойгоор цэргийн жинхэнэ албанд татагдсан хуурай болон тэнгисийн цэргийн хүчний буюу цагдаагийн анги, нэгтгэлд алба хаагчдад үл хамаарна. Үйлдсэн эрх зүйн нэг зөрчлийн төлөө хэний ч амь насыг хохироох, бие махбодийг зовоох ял ноогдуулахаар заналхийлж, хоёр удаа шийтгэж болохгүй. Хэн ч ямар нэгэн эрүүгийн хэрэгт өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх ёсгүй. Зохих ёсны эрх зүйн байцаан шийтгэх ажиллагааны журамгүйгээр хүний амь насыг бусниулж, эрх чөлөөг нь хасаж, өмчийг нь хурааж болохгүй. Хувийн өмчийг шударга нөхөн олговор, үнээгүйгээр нийгмийн хэрэгцээнд хураан авч болохгүй.” гэж заажээ.

Холбооны нэгдсэн улсын эрүүгийн хуулинд тагнуул хийх, эх орноосоо урвах, онгоц барьцаалж аллага үйлдэх, хар тамхи, террорист аллага, хүн хулгайлж аллага үйлдэх, хөлсөөр аллага үйлдэх болон төрлөөр устгах гэх мэтийн 41 төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ялыг оноож байна.²⁶

Холбооны түвшинд болон ихэнх муж улсад ялыг зөвхөн шүүгч оногдуулдаг. Гэхдээ зарим муж улсад шүүгдэгч шүүгч эсвэл тангарагтны аль нэгээр ял заалгахыг сонгож болох бөгөөд цаазаар авах ялтай хэргүүдэд 12 тангарагтан бүгд нэгэн саналаар шийдээгүй бол цаазаар авах ял оногдуулдаггүй. Зарим муж улсад тангарагтан шүүгдэгчийг буруутай гэж үзсэний дараа тангарагтны шүүх заах ялыг шийдвэрлэхээр дахин цугладаг байна. Зарим муж улсад ял оногдуулах зорилгоор тангарагтны шинэ шүүх бүрэлдүүлдэг.

Муж улсууд цаазаар авах ялын тухайд хоорондоо ихээхэн зөрөлдөөнтэй хуулиудыг батлах явдал гардаг байна. АНУ-ын 50 муж улсын 29 муж нь цаазаар авах ялыг хэрэглэж 21 муж улс нь цаазын ялаас татгалзсан буюу хэрэглэдэггүй байна. Цаазын ялыг хэрэглэж байгаа мужуудад “Alabama, Arizona, Arkansas, California*, Colorado, Florida, Georgia, Idaho, Indiana, Kansas, Kentucky, Louisiana, Mississippi, Missouri, Montana, Nebraska, Nevada, North Carolina, Ohio, Oklahoma, Oregon*, Pennsylvania*, South Carolina, South Dakota, Tennessee, Texas, Utah, Virginia, Wyoming”²⁷ зэрэг багтана.²⁸Тус улсын их сургуулийн эрдэмтдийн 2014 онд хийсэн судалгаагаар Америкт цаазын ял сонссон хоригдлуудын 4.1 хувь нь гэм буруугүй байдаг бөгөөд АНУ-д цаазын ял нь гэм буруугүй хүнийг цаазлах томоохон эрсдлийг дагуулж байгааг хүлээн зөвшөөрөөд байгаа бөгөөд 1973 оноос хойш гэм буруугүй 165 хүнд цаазын ял оноосон байсныг цагаатгажээ.

Япон улс. Япон улс үндсэн хуулиар хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлээ баталгаажуулсан үндсэн с. хуульт хаант засагтай улс бөгөөд эзэн хаан нь төрийн тэргүүн юм.

Япон нь эдийн засгийн чадавхаараа дэлхийд АНУ, Хятадын дараа гуравдугаарт ордог их наймын гишүүн улс юм. Японы эрүүгийн хууль (45 дугаар кодекс) 1907онд батлагдсан.

Үндсэн ялын төрөлд цаазаар авах ял, энгийн болон чанга дэглэмтэй хорих ял, торгох ял, (misdemeanor) бага хэмжээний торгох ял болон эд хөрөнгө хураах ялыг нэмэлтээр хэрэглэдэг байна. Мөн цаазын ялыг оноосон тохиолдолд эд хөрөнгө хураахаас өөр төрлийн ял давхар оногдуулахыг хориглодог байна. Цаазаар авах ял оноох гэмт хэргүүдэд гадаадын түрэмгийлэлтэй холбоотой гэмт хэргүүд, галдан шатааж аллага үйлдэх, үерт авхуулж аллага үйлдэх, галт тэрэгний ослоор амь насыг хохироох, усан хангамжийг хордуулж үхэлд хүргэх, хүн амины гэмт хэргүүд, дээрэмдэх зорилгоор алах төрлийн гэмт хэргүүдэд цаазын ял оноодог байна. Цаазын ялыг гүйцэтгэдэг долоон шорон байдаг. Цаазаар авах ялыг дүүжлэн хороож гүйцэтгэдэг.

²⁵ Баярсайхан Должин, *Харьцуулсан эрүүгийн эрх зүй* (Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК, 2017), 236, 244

²⁶ <https://deathpenalty.procon.org/>

²⁷ “Oregon, Pennsylvania, Wyoming” мужуудад цаазаар авах ялд мораториум тогтоосон.

²⁸ <https://www.amnesty.org/en>

Мөн цаазын ялын нэг нөхцөл нь ялын дээд хэмжээгээр шийтгүүлсэн гэмт этгээдүүдийн ялыг гүйцэтгэхээс өмнө зургаан жилийн турш шоронд хорьдог байна. Учир нь энэ хугацаанд түүний үйлдсэн гэмт хэрэгтэй холбоотой шинэ баримт, нөхцөл байдал үүсч болзошгүй гэж үздэг ажээ. Энэ хугацаанд хэрэгтэн 10м² талбай бүхий өрөөнд хоригдоно. Өрөөний гэрэл тогтмол асаалттай байж, байнгын хяналттай байдаг байна.

Ялтанд ялыг гүйцэтгэхээс хагас цагийн өмнө сонсгох бөгөөд энэ хугацаанд тэр мөргөл үйлдэх, эсвэл лам дуудуулах эрхтэй. Ялыг тусгайлан зассан өрөөнд дүүжлэх аргаар гүйцэтгэдэг. Зэргэлдээ өрөөнд нь тэр нүхийг онгойлгох гурван товчлуур байх бөгөөд тэдний нэг нь л ажиллагаатай, товчлуурыг дарсан харгалзлагч гурван хүний хэн нь ялыг гүйцэтгэснээ мэдэхгүй байхаар зохицуулдаг байна.


Цаазаар авах ялыг хөнгөрүүлсэн тохиолдолд 10-аас доошгүй жилээр хорих ял оноодог байна. Статистикийн мэдээгээр япон иргэдийн 86 хувь нь цаазаар авах ялыг хэвээр үлдээх нь зүйтэй гэж үзсэн байна.

Хятад улс. Хятад улсад цаазаар авах ялыг эх орноосоо урвах, салан тусгаарлах, тагнуул хийх, галдан шатаах, аллага, хүчин,хулгай, хар тамхи, хүний наймааны гэмт хэргүүдэд оноодог байна. Цаазар авах ялыг онцгой нөхцөлтэй биш бол ялын тогтоол үйлдсэнээс 2 жилийн дараа гүйцэтгэдэг. Цаазаар авах ялыг Ардын дээд шүүхээс баталгаажуулж оноодог. Мөн 18 нас хүрээгүй болон жирэмсэн эмэгтэйд тус ялыг гүйцэтгэдэггүй. Цаазаар авах ялыг Ардын дээд шүүхээс хөнгөрүүлсэн болон өршөөгдсөн тохиолдолд 15 жилээс багагүй хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

Цаазын ялыг гүйцэтгэсэн тоо мэдээлэл нь улсын нууцад хамаардаг ба энэ нь олон улсын болон хүний эрхийн байгууллгуудын шүүмжлэлийг ихээр дагуулаг байна. Зарим олон улсын байгууллагаас мэдээлсэн тооноос дурдвал Хятад улсад цаазын гүйцэтгэл 1983 онд 24000 –д хүрч байжээ.

Хүснэгт. АНУ, Япон Хятад улсын цаазын ялын гүйцэтгэл 2010-2018 он

Он	Япон	АНУ	Хятад
2018	15	25	Улсын нууцад хамаардаг
2017	4	23	
2016	3	20	
2015	3	28	
2014	3	35	
2013	8	39	
2012	7	43	
2011	-	43	
2010	2	-	
Нийт	45	230	



3. Монгол Улсад цаазаар авах ялыг хэрэглэхээс татгалзах шалтгаан, ач холбогдол, дэлхий нийтийн чиг хандлага

Цаазаар авах ял бол хүний жам ёсны эрхийг үгүйсгэсэн харгис чанартай бөгөөд төрөөс хүчирхийллийг хуульчилсан явдал юм. Цаазаар авах ялаас татгалзах олон шалтгаан байгаатай олон улсын хүний эрхийн байгууллагууд, судлаач эрдэмтэд болон жирийн иргэд хүртэл санал нийлдэг.

- *Эргэж залруулж болшгүй алдаа гаргах шалтгаан болдог.* Жишээ нь АНУ-д 1973 оноос хойш цаазаар авах ял оноосон 165 иргэний гэм буруугүй болохыг тогтоож цагаатгасан байна. Өөрөөр хэлбэл энэ нь цаазын ял сонссон 9 хүний нэг нь цагаатгагдаж байна гэсэн үг юм. Хятадад одоогоос 30 жилийн өмнө Тэнг Шиншан гэж хүнийг цаазалжээ. Түүнийг сураггүй болсон нэг эмэгтэйг хүчирхийлж, улмаар амь насыг нь хороосон гэж гэрчийн мэдүүлэгт үндэслэн цаазалжээ. Гэвч цаазын ялыг гүйцэтгэснээс хойш гурван жилийн дараа тэр хүчирхийлүүлж алагдсан, сураггүй болсон гэх эмэгтэй амьд мэнд байсан. Харин цаазлуулсан эр шороон дор. Егүүтгэсэн амийг сэргээх аргагүйг энэ түүх харуулж байна. 29

Манай Монгол Улсад цаазын ялаар шийтгүүлсэн хүмүүсийн гурван хүн тутмынх нь нэгний шийтгэл эргэлзээтэй байсан тухай Эмнести Интернэйшнл мэдээлсэн байдаг. Энэ нь ч шүүхийн шийдвэрээр нотлогддог. Анхан шатанд цааз авсан 3 хүний нэгнийх нь ял давах шатанд өөрчлөгдөж байсан. Цааз аваад хэрэг нь хэрэгсэхгүй болж цагаадсан тохиолдол ч бий. Зургаан удаа яллуулж, шүүхээс 3 удаа цаазлах ялаар шийтгүүлж, энэ хооронд 7 жил хоригдоод шүүхийн магадлангаар хэрэг нь хэрэгсэхгүй болж байсан нэг тохиолдол бий. 2009 он хүртэл цааз авсан иргэдийн 67 хувь нь анх удаа гэмт хэрэг үйлдсэн, 20-40 насны хүмүүс байсан.

- *Гэмт хэргийн гаралтад нөлөө үзүүлдэггүй.* Дэлхийн улс орнууд цаазын ялын гүйцэтгэлийн мэдээллийг нийтэд нээлттэйгээр цахим хуудсуудад байршуулдаг. Харин судлаачид энэ тоо баримтад хүчин зүйлийн шинжилгээ хийж үзэхэд цаазын ялын гүйцэтгэл, гэмт хэргийн тоо хоорондын хамаарал байхгүй болох нь тогтоогджээ. 30

- *Нийгмийн эмзэг бүлгийг илүү хамрах эрсдэлтэй.* Ядуу, боловсролгүй, өөрийгөө хамгаалах чадваргүй, өмгөөлөгчөөр эрхээ хамгаалуулж чадахгүй нэгэнд энэ ял илүү тусах нь тодорхой. Үүгээрээ нийгэмд шудрага ёсыг алдагдуулахад хүргэх аюултай.

- *Улс төрийн хэрэгсэл болох эрсдэлтэй.* Зарим улс оронд тус ялыг улс төрийн эсрэг хүчийг дарахад ашигладаг. Манай улсад ч ийм гашуун түүх байдаг. (1937 оны хэлмэгдүүлэлт)

- *Цаазаар авах ял бол хүчирхийлэл.* Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг төрийн нэрийн өмнөөс алах нь нийгэмд шударга ёсыг тогтоох бус хүчирхийлэл, өшөө авалтыг нийгэмд түгээж буй явдал юм. Мөн төр ард иргэдийнхээ амьд явах эрхийг хамгаалах үүрэг хүлээсэн бөгөөд үүргээ биелүүлээгүйн төлөө хүнийг гэмт хэргийн золиос болгох эсвэл цаазлах нь хууль бус шудрага ёсноос гажуудсан үзэгдэл болно.

Цаазын ялаас дэлхий нийт хэдийн эрчимтэй татгалзаж эхлээд байна. Хандлагаас ажиглахад эдийн засгийн хөгжил өндөр, ардчилал шудрага ёс хөгжсөн, хүний эрхийг дээдлэгч улс орнууд тус ялаас эрчимтэй татгалзаж байгаа нь ажиглагдаж байна. АНУ, Япон, Хятад улсуудын хувьд ч мөн цаазын ялаас татгалзах алхмуудаа хэдийн хийж эхэлсэн. Жишээлбэл АНУ-д цаазын ялын эсрэг хөдөлгөөн хамгийн анх үүссэн, 1846 онд Америкийн Мичиган мужид цаазын ялыг халсан байдаг. Мөн АНУ-д цаазын ялаар шийтгүүлсэн ялтны ялыг гүйцэтгэхгүй олон жил хорьдог. 2018 онд ялыг нь гүйцэтгэсэн 25 хоригдлын шоронд ялаа гүйцэтгэхийг хүлээсэн хугацаа 8 - 41 жил байсан. Японд 6-аас дээш жил. Хүлээлтийн дундаж хугацаа 24 жил хүртэл байсан гол утга учир нь гэм зэмгүй хүнийг цаазлах эрсдэлийг багасгахад оршдог байна. АНУ, Япон улсууд нь цаазын ялыг гүйцэтгэсэн тоо мэдээллийг дэлхий нийтэд ил тод өгдөг байна. Харин Хятад улсын хувьд цаазын ялын гүйцэтгэлийн жинхэнэ тоо мэдээг олон улсад нууцалдаг өмнөд хятадад олны өмнө цаазлах явдал одоог хортөл байдаг мөн салан тусгаарлах үйл ажиллагаа явуулсан Шинжан аймгийн Уйгар иргэдэд цаазаар авах ялыг олноор хэрэглэдэг талаар

²⁹ Цааз ба Дэлхий, “Baabar.mn”-ний нийтлэл, Цахиагийн Элбэгдорж, 2019 он

³⁰ <https://www.amnesty.org>

шүүмжлэл ихээр дагуулдаг юм. Гэвч Хятадын хууль зүйн салбарын эрдэмтэд, Хуульчдын холбооноос 2020 он гэхэд цаазын ялын гүйцэтгэлийг багасгах, улмаар ил тод, хүнлэг энэрэнгүй байх талаар аль хэдийн дуу хоолойгоо нэгтгээд эхэлсэн юм. 31

Дүгнэлт. Дэлхий даяар цаазаар авах ялын гүйцэтгэл 2018 онд 31 хувиар буурч, сүүлийн 10 жилийн хугацаан дахь хамгийн доод үзүүлэлтэд хүрсэн тухай “Amnesty International” төрийн бус байгууллагын тайлан мэдээнд дурджээ. Тус байгууллагын жил тутмын судалгаанаас үзвэл, 2018 онд 690 хүнийг цаазалсан байна. 2017 онд энэ тоо 993 байжээ. Үүнээс харахад улс орнууд ерөнхийдөө цаазын ял хэрэглэх нь багасаж, харгис, хүнлэг бус энэ шийтгэлийг халахад үр дүнтэй алхам хийж байгаа нь харагдаж байна. Монгол Улс цаазын ялыг түүхэндээ халж хүнлэг энэрэнгүй ёсны зоригтой алхам хийж байсан удаатай бөгөөд үүгээрээ бие даасан, нийгмийн шаардлагад суурилсан төрийн бодлоготой улс болохоо дэлхий дахинд харуулж байсан удаатай. Энэ мэт олон оролдлогын үр дүнд Монгол Улс Эрүүгийн хуульд шинэчлэлт хийж 2017 оны 07 сарын нэгнээс үйлчилж эхэлсэн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад цаазаар авах ялыг 93 жил хэрэглэсний эцэст халсан. Энэ үйлдэл нь манай улсын хувьд олон улсад хүнлэг энэрэнгүй ардчилсан улс болохоо нотлон харуулсан алхам болсон юм.

Манай улс цаазын ялыг хэрэглэж байх үед практикт маш олон алдаатай хүний эрхийг доройтуулсан, шудрага ёсыг алдагдуулсан явдал гарч байсан бөгөөд үүнийг бид 1937 оны улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршгаар мэдэх билээ. Мөн цаазын ялыг гүйцэтгэх хууль эрх зүйн орчин тодорхой бишээс болж одоог хүртэл статистикийн тоо мэдээлэл алдаатай, цаазлуулсан иргэний цогцсыг ар гэрт нь хүлээлгэж өгдөггүй, нууц байдалд үйлддэг зэрэг хүний эрхийн эсрэг үйлдлүүд гарах үндэс болж байсан юм. Цаазаар авах ял нь гэмт хэрэгтний амь насыг бүрэлгээд зогсохгүй түүний ар гэр, гэр бүлд нь сэтгэл санааны шийтгэл давхар амсуулдаг хортой юм.

Цаазаар авах ял нь төрийн нэрийн өмнөөс үйлдэж буй аллага бөгөөд нийгэмд хүчирхийлэл, өшөө авалтыг харуулсан үйлдэл юм. Хэрвээ алдаатай шидвэр гаргасан тохиолдолд хэзээ ч засаж болшгүй алдаа гарах эх үндэс бөгөөд энэ нийгэмд айдсыг төрүүлэх хор уршигтай. Төр иргэдийнхээ амьд явах эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах үүрэгтэй бөгөөд үүнийхээ төлөө өндөр хариуцлага хүлээх ёстой болохоос гэмтэй иргэнийг цаазын тавцанд гаргаж асуудлыг шийдэх ёсгүй юм. Хатуу чанга харгис ял оноосноор шудрага ёсыг тогтоох бус харин гэмт хэрэг бүрт хариуцлага гарцаагүй, хариуцлага нь нийгэмд учруулсан гэм хорыг арилгадаг байх нь хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийн гол тулгуур ойлголт юм.

Ашигласан материал

Ном, сурах бичиг, гарын авлага:

1. Жанцан Суурь, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүй*. Улаанбаатар: 2004.
2. Нарангэрэл Содовсүрэн, *Монгол Улсын эрүүгийн эрх зүй Ерөнхий анги*. Улаанбаатар: 1999.
3. Эрдэнэбат Б, *Эрүүгийн эрх зүйн харьцуулсан судлал* Улаанбаатар:2008.
4. Баярсайхан Должин, *Харьцуулсан эрүүгийн эрх зүй* Улаанбаатар: Соёмбо Принтинг, 2017.
5. Баярсайхан Должин, *Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн процессийн шинэтгэлийн асуудлууд*.Улаанбаатар: Соёмбо Принтинг, 2019.
6. Адъяабазар Д, *Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт* Улаанбаатар:1998.
7. Эмнэсти Интернэшнл, *Цаазаар авах ял ба Хүний эрх*. Улаанбаатар: 2006.

Цахим эх сурвалж:

1. <https://deathpenalty.procon.org/>
2. <https://deathpenaltyinfo.org>)
3. <https://www.amnesty.org>
4. <https://president.mn/2931/> 2019.11.20

³¹ China Reconsiders Broad Use of Death Penalty, Washington Post, January 18, 2004 (<https://deathpenaltyinfo.org>)

ХОХИРОГЧТОЙ ЭВЛЭРСЭН ҮНДЭСЛЭЛЭЭР ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН УЛАМЖЛАЛ

Магистр Л.Мандах

Товч агуулга. Монгол улсын Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх нэг төрөл болох хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай асуудлыг авч үзэхийн өмнө эрүүгийн хариуцлага, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай онолын ойлголтыг тодорхойлох зайлшгүй шаардлагатай.

Учир нь дээрхи ойлголтуудыг авч үзэх нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх уг төрлийг судлах онолын үндэс болохын зэрэгцээ түүний хууль цаазын агуулга, онцлог, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх институтэд түүний эзлэх байр суурь, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх бусад төрлүүдээс ялгагдах онцлогийг танин мэдэх боломжийг олгоно.

Энэхүү өгүүлэлд хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай ойлголт, мөн чанар, үндэслэл журмын талаар өмнөх Эрүүгийн хууль тогтоомжид хэрхэн тусгагдаж байсан талаар товч авч үзсэн болно.

Түлхүүр үг. Эрүүгийн хариуцлага, эрх бүхий албан тушаалтан, хохирогч, өмгөөлөгч,

Үндсэн хэсэг. Монгол Улсын ЭЭЗүйн гол тулгуур асуудал бол гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын тухай асуудал билээ.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энхтайван, хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалахад орших бөгөөд энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хүн, төр, нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнийг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг хуульчилдаг./Эрүүгийн хуулийн 1-р зүйл/

Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага, оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг зөвхөн Эрүүгийн хуулиар тогтооно./Эрүүгийн хуулийн 3-р зүйлийн 3.1/

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын тухай асуудлыг хуульчлах нь ЭЭЗүйн зорилтыг хэрэгжүүлэх нэг арга хэрэгсэл мөн. Учир нь Монгол Улсын ЭЭЗүйн зорилт нь хууль тогтоогчоос Эрүүгийн хуулиар хамгаалагдсан нийгмийн харилцаа /эрх ашиг, сонирхол, үнэт зүйл/-нд халдсан ямар нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохын зэрэгцээ уг гэмт хэргийг үйлдсэн гэм буруутай этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын ойлголт, түүний үндэслэл, төрөл, хэмжээг Эрүүгийн хуульд хуульчилсан тохиолдолд л хэрэгжих үндэстэй юм.

Эрүүгийн хариуцлагын тухай ухагдахуун нь Эрүүгийн хуульд хуульчлагдсан эрх зүйн ухагдхуун бөгөөд эрүүгийн хариуцлагын ойлголт, зорилго, үндэслэл, төрөл, хэлбэр, болон түүнтэй холбоотой эрх зүйн нийтлэг хэмжээ нь Эрүүгийн хуулийн Ерөнхий ангид тухайлбал: Эрүүгийн хуулийн 1, 3, 4, 8, 10-р зүйл, Эрүүгийн хуулийн III-IV хэсэг IX-XIII бүлэгт хуульчилагдсан байна. Тухайлбал: Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 45-р зүйлийн 45.1-д “...Эрүүгийн хариуцлага нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийн эрх, эрх чөлөөнд энэ хуульд заасны дагуу шүүхийн шийтгэх тогтоолоор хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын арга хэмжээ мөн...” гэж тодорхойлжээ.

Эрүүгийн хариуцлагын тухай ухагдахуун нь онолын ойлголт бөгөөд ЭЭЗүйн Ерөнхий ангийн шинжлэх ухааны судлах зүйл болно.

Эрүүгийн хариуцлага нь хууль зүйн хариуцлагын нэг төрөл, түүний хамгийн хүнд хэлбэр мөн.

Эрүүгийн хариуцлага нь Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэж буй хууль зүйн хариуцлагын нэг төрөл болно.

ЭЭЗүйн шинжлэх ухаанд эрүүгийн хариуцлагын тухай асуудал хамгийн маргаантай асуудлуудын нэг хэвээр байсаар байгаа ба одоо хүртэл нэгдсэн ойлголт тогтоогүй байна.

Энэ талаар ОХУ-ын профессор И.Э.Звечаровский “...ЭЭЗүйн онолд эрүүгийн хариуцлагын асуудал шиг эрдэмтэд, судлаачдын анхаарлыг татаж байсан, татсаар байгаа асуудал орчин үед байхгүй нь тохиолдлын зүйл биш бөгөөд эрүүгийн хариуцлагын тухай асуудал нь ЭЭЗүйн шинжлэх ухааны хамгийн тулгуур ухагдхуун болдог...” гэж дүгнэжээ.³²

Сүүлийн үед ЭЭЗүйн шинжлэх ухаанд эрүүгийн хариуцлагын ухагдхууны талаар дараах гурван үзэл бодол зонхилж байна. Үүнд:

1. Эрүүгийн хариуцлага нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төрөөс гэмт хэрэг үйлдсэний төлөө хүлээлгэж буй Эрүүгийн хуульд заасан төрийн албадлагын арга хэмжээг хүлээх үүрэг;

2. Эрүүгийн хариуцлага нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төрөөс хүлээлгэж буй төрийн албадлагын арга хэмжээг биечлэн хүлээх /эдлэх/ үүргийг хэрэгжүүлэх явдал;

3. Эрүүгийн хариуцлагыг эерэг утгаар нь буюу Эрүүгийн хуульд заасан зан үйлийн горим журмыг /хориглолтыг зөрчихгүй байх, хүлээлгэсэн үүргийг биелүүлэх/ дагаж мөрдөх өөрийн үүргийг хэрхэн ухамсарласан байдлаар илэрхийлэгдэх, хууль ёсонд нийцсэн зан үйлийн эцэст бий болох эерэг үр дагавар гэсэн утгаар тайлбарлах болжээ.³³

Монгол Улсын ЭЭЗүйн онолд эрүүгийн хариуцлагын ойлголтыг тодорхойлох асуудал маргаантай хэвээр бөгөөд энэ талаар эрдэмтэд, судлаачид өөрсдийн байр суурийг илэрхийлжээ. Хуульч Т.Дэндэв “...эрүүгийн хариуцлага гэдэг нь тус улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрүүгийн эрхийн хэм хэмжээнд үндэслэсэн хэрэг хариуцах үүргийг хэлнэ...”³⁴ гэж тодорхойлсон бол доктор /Sc. D/, профессор Г.Совд “...Эрүүгийн хариуцлагыг өргөн утгаар авч үзвэл Эрүүгийн хуулийн үйлчилгээний үндсэн зарчим бөгөөд төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх олон талт ажиллагааны хамгийн хүнд, тусгай арга хэмжээ, тодорхой субъектын хувьд эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ зөрчсөний үр дагавар болгон эрхийн байдалд нь урт хугацаагаар нийгмээс тусгаарлах, түүгээр ч барахгүй амьд явах эрхэнд нь халдах хүртэл хязгаарлалт тогтоож байгаа явдал юм...”³⁵ гэж дүгнэсэн байна.

Харин доктор /Sc. D/, профессор С.Жанцан “...Эрүүгийн хариуцлага нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийн эрх, эрх чөлөөнд энэ хуульд заасны дагуу шүүхийн шийтгэх тогтоолоор хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын арга хэмжээг юм...”³⁶ гэж үзжээ.

Хууль зүйн тайлбар номын зохиогчид “...Гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай этгээдийн эрх, эрх чөлөөг хязгаарлахаар эрүүгийн хуульд заасан хууль зүйн хариуцлагын төрөл юм...”³⁷ гэж тодорхойлжээ.

Бидний үзэж байгаагаар **эрүүгийн хариуцлага** гэдэг нь Эрүүгийн хуулийн Тусгай ангид заасан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутай этгээдийн төрөөс /шүүхээс/ түүнд гэмт хэрэг үйлдсэний төлөө хүлээлгэж байгаа, Эрүүгийн хуульд заасан эрүүгийн ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээгээр хэрэгжиж буй төрийн албадлагын арга хэмжээг ЭБШХууль, ШШГТХуульд заасан /процессын/ журмын дагуу эдлэх, хүлээх үүрэг мөн.

Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх ойлголт, үндэслэл, төрөл

³² И.Э.Звечаровский. Уголовная ответственность: понятие, виды, формы реализации.г.Иркутск.изд Иркут.гос ун-т 1992 г. стр 15

³³ Российское уголовное право /под ред. В.Н.Кудрявцева и А.В.Наумова/. М.изд Спарк. 2000 г. стр 177, С.Нарангэрэл.Монгол Улсын ЭЭЗий.Ерөнхий анги.УБ.1999 он. 100 дах тал

³⁴ Т.Дэндэв.БНМАУ-ын ЭЭЗий дэхь ял шийтгэлийн тухай асуудал. УБ. 1975 он. 4 дэх тал

³⁵ Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ. 2002 он. 59дэх тал

³⁶ С.Жанцан.Монгол Улсын ЭЭЗий /Альбом схем,зүйлчлэлийн асуудал/. УБ.2004 он. 27 дах тал

³⁷ Хууль зүйн тайлбар толь. УБ. 2003 он. 369 дэх тал

Монгол Улсын ЭЭЗүйд эрүүгийн хариуцлагын тухай асуудлын хүрээнд зайлшгүй авч үзэх, эрүүгийн хариуцлагын асуудалтай салшгүй холбоотой нэг институт бол эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх асуудал билээ.

Монгол Улсын ЭЭЗүйн нэг чухал зарчим бол эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим бөгөөд Эрүүгийн хуулийн 9-р зүйлийн 9.1-д “...Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага заавал хүлээлгэнэ...” гэж заажээ.

Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмын үүднээс нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн этгээд бүрт эрүүгийн хариуцлагыг зайлшгүй хүлээлгэх, эрүүгийн хариуцлагыг гарцаагүй байх үүргийг төр хариуцан хүлээлгэж байх ёстой боловч

1-рт: Төрийн ЭЭЗүйн бодлогын хүрээнд эрүүгийн зүйн арга хэрэгслийг хэмнэлттэй хэрэглэх; /экономика уголовных репрессий /

2-рт: Төрийн ЭЭЗүйн бодлогын хэлбэр болох депенализацийг³⁸ /гэмт хэрэгт оногдуулах эрүүгийн хариуцлага, ялыг хөнгөрүүлэх, эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх арга зам тодорхойлох/ зүй зохистой хэрэглэх;

3-рт: ЭЭЗүйн энэрэнгүй ёсны зарчмыг удирдлага болгон гэмт хэрэг үйлдсэн этгээдийг түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх асуудлыг / институт/ Эрүүгийн хуульд хуульчилдаг байна³⁹.

Манай өмнөх Эрүүгийн хуулиудад эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх эрх зүйн үндэслэл, төрөл, журмыг нарийвчлан хуульчилаагүй, зөвхөн зарим нэг төрлийг хуульчилсан, эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх тодорхой төрлүүд нь Эрүүгийн хуульд бус, бусад хууль тогтоомжид тухайлбал Үндсэн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх тухай хуульд хуульчлагдсан эсвэл огт хуульчлагдаагүй явж ирсэн нь түүний хууль цаазны мөн чанар, учир холбогдлыг ямар нэгэн хэмжээгээр алдагдуулж байсан гэж үзэх бүрэн үндэстэй.

Эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх нь ЭЭЗүйн Ерөнхий ангийн нэг институт болохын хувьд түүний эрх зүйн үндсийг Эрүүгийн хуульд хуульчилсан байх ёстой.

Эрүүгийн хуулийн 9-р зүйлийн 9.2-д “...Ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээнээс чөлөөлөх үндэслэл, журмыг гагцхүү энэ хуулиар тогтооно...” гэж эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх эрх зүйн үндсийг хуульчилжээ.

Түүнчлэн хууль тогтоогч Монгол Улсын 2002 оны Эрүүгийн шинэ хуульд эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх асуудлыг жинхэнэ хууль цаазын агуулгаар нь, ЭЭЗүйн бие даасан институтын хувьд Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн IV хэсэгт бие даасан бүлгүүдэд /XII-XIII бүлэг/ нарийвчлан хуульчилж өгсөн нь түүний өмнөх Эрүүгийн хуулиудаас ялгагдах дэвшилттэй ололтой тал болсон юм.

Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх гэдэг нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд /шүүхийн шийтгэх тогтоол гарахаас өмнөх үе шатанд/ ЭБШХуулиар эрх олгогдсон этгээдээс /хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч/ Эрүүгийн хуулийн Тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдийг Эрүүгийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу төрөөс түүнд хүлээлгэж байгаа төрийн албадлагаас /төрийн өмнөөс шүүн хэлэлцэх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцох, шүүхийн шийтгэх тогтоолоор ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг оногдуулах, оногдуулсан ялыг биечлэн эдлүүлэх/ чөлөөлж буй ажиллагааг хэлнэ⁴⁰.

Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тодорхой төрөл, тэдгээрийг хэрэгжүүлэх үндэслэл, журмыг Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн XII бүлэгт хуульчилжээ. Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн XII бүлэгт эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх дор дурьдсан төрлийг хуульчилжээ. Үүнд:

³⁸ Доктор, профессор С.Жанцан түүнийг ялгүй болгох гэж томъёолжээ.”Монголын төрийн эрүүгийн бодлогын тулгамдсан асуудал”. Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгэл. 2004 он. №4. 15 дах тал

³⁹ Д.Адъяабазар, Б.Батдэлгэр, Г.Гантөмөр. Эрүүгийн хариуцлага. УБ.2006 он. дах тал

⁴⁰ Г.Гантөмөр. Эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх /Д.Адъяабазар, Б.Батдэлгэр, Г.Гантөмөр. Эрүүгийн хариуцлага. УБ. 2006 он. 104 дэх тал

1. Үйлдсэн хэргээ илчилж ирсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, /ЭХ-ийн 70-р зүйл/
2. Хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, /ЭХ-ийн 71-р зүйл/
3. Эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа өнгөрсөн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, /ЭХ-ийн 72-р зүйл/
4. Цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбоотойгоор эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, /ЭХ-ийн 73-р зүйл/
5. Өршөөл үзүүлж эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, /ЭХ-ийн 77-р зүйл/ зэрэг болно.

Хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх гэдэг нь анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг Эрүүгийн хуулийн 71-р зүйлд заасан үндэслэлээр хохирогчтой эвлэрсэнээр ЭБШХуулийн 25-р зүйлд заасан журмын дагуу хэргийг хэрэгсэхгүй болгох замаар эрүүгийн хариуцлагын хүрээнд түүнд хүлээлгэх төрийн албадлагаас /төрийн өмнөөс шүүн хэлэлцэх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцох, шүүхийн шийтгэх тогтоолоор ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг оногдуулах, оногдуулсан ялыг биечлэн эдлүүлэх/ чөлөөлж буй ажиллагааг хэлнэ.

Хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл

Хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн гэм буруутай этгээд хохирогчтой сайн дураараа эвлэрсэн бөгөөд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно. /ЭХ-ийн 71-р зүйлийн 71.1/

Хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхөд дараах 3 үндэслэлүүдийн нийлбэр байх ёстой. Үүнд:

1. Хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн байх,
2. Хохирогчтой сайн дураар эвлэрсэн байх,
3. Гэмт хэргийнхээ улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн, гэм хорыг арилгасан байх зэрэг болно.

Хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн байх

Хууль тогтоогч хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн гэж заасан нь хууль зүйн нэр томъёоны хувьд төдий л оновчтой бус бөгөөд түүнийг өөрөөр тайлбарлах боломжийг олгож байгаа нь түүний муу тал гэлтэй. “Анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн” гэж хуульчилсан бол илүү оновчтой байх байсан болов уу. Учир нь хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн гэдэг нь урьд хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн байж болох бөгөөд хөнгөн гэмт хэрэг л анх удаа үйлдсэн байх гэсэн санааг өөртөө давхар агуулах, тэгж тайлбарлах боломжийг бас давхар бий болгож байгаа юм.

Хөнгөн гэмт хэрэг гэдэг нь Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 17-р зүйлийн 17.2-д зааснаар Эрүүгийн хуулийн тусгай ангид нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэхээр заасан гэмт хэргийг хэлнэ.

“Хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн” гэдгийг доктор /Sc.D/, профессор Г.Совд зөвхөн хөнгөн гэмт хэргийг анх удаа биш амьдралдаа анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэнийг ойлгоно гэж тайлбарлажээ.⁴¹ Харин доктор /Sc.D/, профессор Ж.Авхиа, судлаач Б.Ганболд нарын бичсэн Эрүүгийн хуулийн тайлбарт “хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн” гэдгийг анх удаа гэмт хэрэг үйлдсэн байх, уг хэрэг нь хөнгөн гэмт хэрэг байх гэж тус тусдаа үндэслэл болгон үзжээ.⁴²

Бидний үзэж байгаагаар **“хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн”** гэдэгт

1-рт: урьд нь гэмт хэрэг үйлдэж байгаагүй этгээд анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэнийг,

⁴¹ Г.Совд .Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар.УБхот. 2002 он.112 дах тал

⁴² Ж.Авхиа, Б.Ганболд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар./Ерөнхий анги. Тэргүүн дэвтэр/.УБ хот. 2002 он. 218 дах тал

2-рт: урьд нь гэмт хэрэг үйлдэж /үйлдсэн гэмт хэргийн ангилал хамаарахгүй/ ял шийтгүүлсэн этгээд ялаа эдэлж дууссаны дараа Эрүүгийн хуулийн 78-р зүйлд заасны дагуу уг хэрэгтээ ялгүй болсон буюу ялгүйд тооцогдсоны дараа хөнгөн гэмт хэрэг үйлдсэнийг аль алиныг ойлгоно гэж тайлбарлах нь зүйтэй бөгөөд ЭЭЗүйн онолд илүү нийцнэ гэж үзэж байна.

2002 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн батлахад “*хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн*” гэж анх оруулсан ба 2004 оны 4-р сарын 15-ны “Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулиар “*Бусдын эд хөрөнгийн хулгайлах \Эрүүгийн хуулийн 145-р зүйл\ гэмт хэргээс бусад хөнгөн хэргийн анх удаа үйлдсэн*” гэж өөрчилж 2008 оны 2-р сарын 1-ний өөрчлөлтөөр “Бусдын эд хөрөнгийн хулгайлах \Эрүүгийн хуулийн 145-р зүйл\ гэмт хэргээс бусад” гэснийг хүчингүй болгосон билээ.

Хохирогчтой сайн дураар эвлэрсэн байх

Хохирогчтой эвлэрсэн гэдэг нь гэмт этгээд өөрийнх нь эрх ашиг сонирхолд гэм хор учруулсан хохирогчийн өмнө гэм буруугаа хүлээн, өөрийн үйлдлээр учруулсан хохиролыг нөхөн төлж, гэм хорыг арилгасан, хохирогч гэмт хэргийн талаар ямар нэгэн гомдол, саналгүй болсон, сайн дураар эвлэрсэн талаар хууль хамгаалах байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд хамтран сайн дурын үндсэн дээр мэдээлснийг хэлнэ.

Хохирогч гэдэг нь ЭБШХуулийн 42-р зүйлийн 42.1-д зааснаар гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хэлнэ.

Иргэн, хуулийн этгээдийг хохирогчоор тогтоохдоо хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана. \ЭБШХуулийн 42-р зүйлийн 42.2\

Гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн этгээд гэдэгт гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн иргэн, хуулийн этгээдийг ойлгохыг ЭБШХуулийн дээрхи заалтаас харж болно.

“Хохирогчтой сайн дураар эвлэрсэн байх” гэдгийг доктор/ Sc.D/, профессор Г.Совд “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар” бүтээлдээ илүү оновчтой тайлбарлажээ.

Хохирогчтой сайн дураар эвлэрсэн байх гол шалгуур нь:

1-рт: хохирогч нь гэмт хэрэг үйлдсэн этгээдтэй эвлэрэх эрх зүйн бүрэн чадамжтай байх,

2-рт: Хохирогчтой сайн дураар эвлэрсэн байх,

3-рт: Хохирогчийг хуурч мэхлээгүй, төөрөгдүүлээгүй, айлган сүрдүүлэх, заналхийлэх дарамтлах зэрэг хууль бус арга хэрэглэн эвлэрэхэд хүргээгүй, хохирогчтой бодитойгоор эвлэрсэн байх,

4-рт: Хохирогчийн зөвшөөрөл нь төр, нийгэм, иргэдийн эрх ашиг сонирхолд хор уршиг учруулахааргүй байх явдал болно.⁴³

Хохирогч нь гэмт хэрэг үйлдсэн этгээдтэй эвлэрэх эрх зүйн бүрэн чадамжтай байх гэдэг нь хохирогч нь сэтгэцийн хувьд эрүүл, эрх зүйн бүрэн чадвар чадамжтай, өөрийг төлөөлж бие даан нийгмийн харилцаанд оролцож хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэх, эдлэх, өөрийнхөө эрхийг хамгаалах бүрэн чадвартай байхыг хэлнэ.

Хохирогч хэн нэгний биеийн хүчний болон сэтгэл санааны албадлага, шахалтгүйгээр, өөрийн үйлдлийг өөрийн хүсэл зоригоор бие даан хэрэгжүүлэх боломжтой нөхцөлд сайн дураар өөрийн идэвхтэй үйлдлээр эвлэрсэнийг *сайн дураар эвлэрсэн* гэж үзнэ.

Тиймээс хууль тогтоогч ЭБШХуулийн 25-р зүйлийн 25.2-д “..Энэ хуулийн 25.1-д заасан хэргийн хохирогч нь яллагдагчийн эрхшээлд байгаагаас, эсхүл бусад шалтгааны улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгож болохгүй ба энэ тохиолдолд хэргийг шүүхэд шилжүүлж шүүх ердийн журмаар хянан шийдвэрлэнэ...” гэж заасан үүний нэг баталгаа болж байна.

Хохирогчийн зөвшөөрөл нь төр, нийгэм, иргэдийн эрх ашиг сонирхолд хор уршиг учруулахааргүй байх нь хохирогчийн яллагдагч, шүүгдэгчтэй эвлэрсэн явдал нь эрүүгийн хууль болон

⁴³ Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ.2002 он. 113 дах тал

бусад хууль тогтоомжоор хамгаалагдаж, зохицуулагдаж байгаа төр, нийгэм, иргэдийн хууль ёсны эрх ашиг сонирхолд харшлаагүй, тэдгээрт хор уршиг учруулаагүй, учруулах боломжгүй байхыг хэлнэ.

Гэмт хэргийнхээ улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн, гэм хорыг арилгасан байх

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалт нь Монгол Улсын Эрүүгийн болон ЭБШХууль, Иргэний ба Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан эрхийн актуудаас бүрдэх ба тэдгээрийн дотор Эрүүгийн хууль чухал үүрэгтэй.

Өмнөх Эрүүгийн хуульд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх, гэмт хорыг арилгах асуудлыг ял оногдуулахад хөнгөрүүлэх нөхцөл байдал болгох төдийхнээр хуульчилж Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний процессын хуулиудын хүрээнд голчлон авч үзэж байв.

Харин энэ байдлыг 2002 оны эрүүгийн шинэ хуулиар засаж чадсан юм. 2002 оны Монгол Улсын эрүүгийн шинэ хуулийг боловсруулсан үзэл баримтлалын нэг онцлог нь гэмт хэргийн улмаас хохирсон иргэн, төр, нийгмийн эрх ашиг сонирлыг хамгаалахад илүү ач холбогдол өгч, гэмт хэргийн улмаас тэдгээрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм хорыг арилгуулах талаар зарчмын ач холбогдол бүхий шинэлэг хэм хэмжээг олноор хуульчилсан нь түүний дэвшилттэй тал гэж үзэж болно⁴⁴.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх, гэм хорыг арилгах нь ЭЭЗүйд дараахь хууль цаазны мөн чанарыг илэрхийлнэ.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх, гэм хорыг арилгах нь ЭЭЗүйн чиг үүрэгтэй шууд холбогдоно.ЭЭЗүй нь нийгмийн харилцааг гэмт халдагаас хамгаалах (охранительная функция), гэмт хэргийн улмаас үүссэн нийгмийн харилцааг зохицуулах (регулитивная функция) чиг үүргээс гадна гэмт хэргийн улмаас зөрчигдсөн нийгмийн харилцаа, эрх ашиг, сонирхлыг нөхөн сэргээх (восстановительная функция) чиг үүргийг хэрэгжүүлдэг. ЭЭЗүйн нөхөн сэргээх чиг үүрэг нь гэмт хэргийн улмаас зөрчигдсөн нийгмийн харилцааг нөхөн сэргээх, гэмт хэргийн улмаас өртөгдөхөөс өмнөх хэвийн байдалд оруулах, сэргээх, түүнд учирсан хохирлыг нөхөн төлөх, гэмт хорыг арилгах явдлаар хэрэгжинэ.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх, гэм хорыг арилгах нь Эрүүгийн хариуцлагын нэг зорилго болдог. 2002 оны Монгол Улсын Эрүүгийн шинэ хуулийн 46-р зүйлийн 46.1-д гэмт хэргийн хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээхийг эрүүгийн хариуцлагын нэг зорилго болгон шинээр тодорхойлсон билээ. Хууль тогтоогч гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх явдлыг эрүүгийн хариуцлагын зорилго болгон заагаад зогсохгүй түүнийг хэрэгжүүлэх механизм хэрэгжих нөхцөл, журмыг материаллаг болон процессын хуулиудад хуульчилсан байдаг.

Гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэм хорыг арилгах нь ЭЭЗүйн зарчмуудтай шууд холбогдож байдаг. Гэмт хэргийн улмаас улс, нийгэм, иргэдийн эрх ашиг, сонирхолд учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, гэм хорыг арилгуулах замаар нийгмийн шударга ёсыг сэргээн тогтоож байгаа нь ЭЭЗүйн шударга ёсны, төр хохирсон иргэддээ энэрэнгүй хандаж буй нь ЭЭЗүйн энэрэнгүй ёсны зарчмын нэг илрэл болдог.

ЭЭЗүйд гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлөх, гэм хорыг арилгах нь гэмт хэрэг үйлдсэний дараахь гэмт этгээдийн хувийн зан байдал /посткриминальное поведение/-д хамаарах зан үйл юм. Гэхдээ түүнийг гэмт хэрэг үйлдэх үеийн гэмт этгээдийн зан байдлаас салган авч үзэх ёстой.Тухайлбал: гэмт хэрэг үйлдэж эхэлсэн этгээд өөрийн үйлдлийн нийгмийн хор аюулыг ойлгон учирч болох байсан хор аюулыг урьдчилан зайлуулсан нь энэ ойлголтод хамаарахгүй бөгөөд энэ ч утгаар нь түүнийг хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 55-р зүйлийн 55.2-д гэмт хэргийн улмаас учирах хор уршгийг зайлуулсан бол ялыг хөнгөрүүлэх бие даасан нөхцөл байдал болгон хуульчилжээ.

⁴⁴ Г.Гантөмөр.Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх, гэм хорыг арилгахын ЭЭЗүйн учир холбогдол “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл.2006 он. № 4. дах тал

Өөрийн үйлдсэн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөх, гэм хорыг арилгах нь уг гэмт этгээд (ялтан) хувийн зан байдлын хувьд нийгмийн хор аюулаар бага болохыг илэрхийлэх, түүний нийгэмд аюултай хувийн зан байдлыг хөнгөрүүлэх нэг нөхцөл, нийгмийн ашиг сонирхолд нийцсэн Эрүүгийн хуулиар хөхүүлэн дэмжигдэх үйл ажиллагаа мөн. Гэмт хэрэг үйлдсэний дараахь гэмт этгээдийн энэхүү зан үйл нь тухайн этгээдэд эерэг үр дагаварыг бий болгох ба энэ нь түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, ял оногдуулах, эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөхөд бусад ялтнаас илүү хөнгөлөлттэй нөхцөл, журмыг хуульчлах явдлаар Эрүүгийн хуулийн урамшуулсан хэм хэмжээнд илрэлээ олдог.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх, гэм хорыг арилгахын ЭЭЗүйн учир холбогдлыг авч үзэхийн өмнө гэмт хэргийн улмаас учирсан хор уршиг, хохирол, гэм хор гэж юу болох, тэдгээрийг нөхөн төлөх, арилгах гэдэгт юуг ойлгох талаар авч үзэх нь уг асуудлын мөн чанарыг нээн харуулах, зөв таньж мэдэх боломжийг олгоно.

Хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн болон ЭБШХуульд гэмт хэргийн хохирол гэм хорын ойлголтыг хуульчлаагүй боловч “хохирол”, “гэм хор” гэсэн нэр томъёог хэрэглэсэн байна. Эрүүгийн хуулийн 28-р зүйлд гэм буруугүйгээр хор уршиг учруулах, 29-р зүйлд хохирлын хэмжээг тодорхойлох, 55, 70, 71-р зүйлд хохирлоо нөхөн төлөх тухай заажээ. Харин ЭБШХуулийн 42-р зүйлийн 42.1-д гэмт хэргийн хохирогч, түүний эрх, үүргийг, 115-р зүйлийн 115.1-д эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэл гаргах, түүнийг хангах, иргэний нэхэмжлэгчийн эрх үүргийг хуульчилсан байдаг.

Монгол Улсын Иргэний хуулийн 497-р зүйлийн 497.1-д “...бусдын эрх, амь нас эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөнд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулах...”, 499-р зүйлийн 499.1-д “...бусдын амь нас эрүүл мэндэд хохирол учирсан...”, 500-р зүйлийн 500.1-д “...байшин барилга бүтэн буюу хэсэгчлэн нурсны улмаас гэм хор учрах...” гэх мэт нэр томъёог хэрэглэжээ.

Иймд хуулиудын дээрхи нэр томъёо, хууль зүйн салбар шинжлэх ухааны ойлголтонд харьцуулсан шинжилгээ хийх шаардлагатай бөгөөд манай зарим эрдэмтэд энэ талаар нэгдсэн ойлголтонд хүрээгүй байна.⁴⁵

Бидний үзэж байгаагаар Иргэний хуульд хууль бус бүх үйлдлийн (гэмт хэрэг ба гэмт хэргийн бус эрх зүйн бусад зөрчлийн) улмаас учирсан гэм хорын ойлголтыг тодорхойлсон ба тэдгээрийг ЭЭЗүйд шууд буулган хэрэглэх нь учир дутагдалтай. ЭЭЗүйд чухамхүү гэмт хэргийн улмаас учирсан хор уршиг, хохирлын суудлыг тодорхойлоно. Гэмт хэргийн улмаас учирсан хор уршиг, хохирол нь тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүнд өөрийн онцлогтойгоор (хор уршиг, түүний төрөл, хохирлын шинж чанар, хэмжээ, түүнийг тодорхойлох, тайлбарлах, хор уршиг учрах механизм, хор уршгийн гэмт хэргийн зүйчлэлд нөлөөлөх байдал) Эрүүгийн хуулийн Тусгай ангид харилцан адилгүй хуульчилагдсан байдаг.

Иймээс гэмт хэргийн улмаас учирсан хор уршиг, хохирол, гэм хорын тухай асуудлыг материаллаг эрх зүй болох ЭЭЗүйд гэмт хэрэгт тусгайлан авч үзэх ёстой ба гэмт хэргийн хор уршгийн тухай асуудал Монгол Улсын ЭЭЗүйд онолын түвшинд нэгэнт судлагдсан билээ.⁴⁶

Гэмт хэргийн улмаас учирсан үр дагавар, хор уршгийг арилгах нь хохирол нөхөн төлөх, гэм хорыг арилгах гэсэн хоёр хэлбэртэй болох нь Эрүүгийн хуулийн 55, 70, 71, 74-р зүйлүүдээс тодорхой болж байна.

ЭЭЗүйд *гэмт хэргийн хохирлыг нөхөн төлөх* гэдэгт Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тодорхой гэмт хэргийн улмаас бусдын өмчлөх эрх болон хуулиар хамгаалагдсан бусад эрх, ашиг

⁴⁵ Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи. УБ. 2005 он. 175 дах тал

⁴⁶ Г.Совд. БНМАУ-ын ЭЭЗүйн курс. Ерөнхий анги. УБ. УХГ. 1973 он. 207-211 дах тал, С. Нарангэрэл. Монгол Улсын ЭЭЗүй. Ерөнхий анги. УБ. 1999 он. 135-143 дах тал, С. Жанцан. Монгол Улсын ЭЭЗүй. Ерөнхий ба Тусгай анги. Схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал. УБ. 2004 он. 78-79 дах тал, Г. Гантөмөр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. УБ. 2003 он. 75-92 дах тал

сонирхолд шууд учирсан, мөнгөн илэрхийллээр хэмжигдэх эд хөрөнгийн хор уршгийг нөхөн төлөх, шилжүүлэн өгөх, арилгахыг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол гэдэгт бусдын өмчлөх эрхэнд шууд учирсан эд материалын хохирлоос гадна гэмт хэргийн хор уршгийг арилгахад шууд гарсан зардал, гэмт хэргийн улмаас хүлээсэн эд хөрөнгийн алдагдал, алдагдсан ашиг, орлого хамаардаг. Гэмт хэргийн улмаас хохирогчийн бие махбодид гэмтэл учруулсан бол эмчилгээ сувилгаатай холбогдон гарсан шууд зардлыг болон хиймэл эрхтэн, түүнийг тавиулахтай холбогдон гарсан бусад зардал, хэрэв хохирогч нас барсан бол оршуулах ажиллагаатай холбогдон гарсан шууд зардлыг шаардлагатай нотлох баримтуудыг үндэслэн тогтоож гэм буруутай этгээдээс гаргуулна. Гэмт хэргийн улмаас нэр төр алдар хүнд, сэтгэл санааны хувьд хохирол хүлээсэн хохирогч түүнтэй холбогдон эд материалын хохирол хүлээснээ шаардлагатай нотлох баримтаар нотолж хохирсон тухай тооцоогоо мөнгөн илэрхийллээр гаргаж ирсэн тохиолдолд шүүх түүнийг нийтлэг журмаар шийдвэрлэх үүрэгтэй.⁴⁷

Манай улсад гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг мөнгөн илэрхийлээр тооцох талаар тогтоосон журам, жишиг одоогоор байхгүй байна. Харин дэлхийн зарим орнуудад гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг гэмт хэргийн ангилалт, бусад онцлогоос хамаарч тогтоосон жишиг үнэлгээг баримтлан нөхөн төлүүлдэг практик бий.

Гэмт хэргийн улмаас учирсан гэм хорыг арилгах гэдэг нь гэмт хэргийн улмаас Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхолд учирсан хохирлоос бусад шууд учирсан хор уршиг, үр дагаварыг арилгахыг хэлнэ. Гэмт хэргийн улмаас учирсан гэм хорыг арилгах нь гэмт хэргийн зүйлийг сайн дураар улсад болон эзэнд нь эргүүлэн өгөх, гэмт хэргийн зүйлийг нуун дарагдуулсан газраа сайн дураар зааж өгөх, хохирлын мөнгөн хэмжээнд хэмжээнд нийцэх эд зүйл, хөрөнгийг сайн дураар өгөх, гэмт хэргийн улмаас эвдэрч гэмтсэн зүйлийг гэмт хэрэг үйлдэхээс өмнөх хэвийн байдалд оруулах, засварлах бусдын нэр төр, алдар хүндэд гэм хор учруулсан этгээд хохирогч, бусдын өмнө болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр уучлал гуйх, залруулга хийх зэрэг хэлбэртэй байж болно.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг **сайн дураар** нөхөн төлөх, гэм хорыг арилгах гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн этгээд гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд буюу шүүхийн шийтгэх тогтоол гарахаас өмнө сайн дураар өөрөөр хэлбэл өөрийн хүсэл зоригор, бусдын албадлага, шахалт нөлөөгөөр бус, өөрийн үйл ажиллагааг чөлөөтэй хэрэгжүүлэх боломжтой тохиолдолд үйлдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлснийг, гэм хорыг арилгасныг хэлнэ.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг сайн дураар нөхөн төлөх, гэм хорыг арилгахын хууль цаазын ач хобогдол нь гэмт хэрэг үйлдсэн этгээд Эрүүгийн байцаан шийтгэх болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд заасан журмын дагуу төрийн албадлагагүйгээр төрийн ямар нэгэн оролцоогүйгээр, түүнийг хэрэглэхээс цаг хугацааны өмнө, ямар нэгэн нэмэгдэл зардал чирэгдэл гаргалгүйгээр өөрийн үйлдсэн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлөх, гэм хорыг арилгах замаар нийгмийн зөрчигдсөн харилцаа (эрх, ашиг сонирхол)-г хэвийн байдалд буцаан оруулж байгаад оршдог.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг бүрэн төлсөн, гэм хорыг бүрэн арилгасан гэдэгт гэмт хэрэг үйлдсэн этгээд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон шийтгэх тогтоол гарахаас өмнөх шүүхийн шатанд хохирогч, болон иргэний нэхэмжлэгчид учруулсан хохирол, гэм хорыг нэхэмжлэлийн шаардлагын хэмжээнд бүрэн төлсөн, бүрэн барагдуулсан явдал хамаарна.

Хэрэв хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд дээр дурьдсан 3 үндэслэлүүд бүгд тогтоогдвол прокурор, шүүхийн шатанд ийм нөхцөл илэрвэл шүүгч ЭБШХ-ийн 25-р зүйлд заасны дагуу хэргийг хэрэгсэхгүй болгох замаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

⁴⁷ “Гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх тухай” УДШ-ийн 2000 оны 1-р сарын 19-ний өдрийн 3-р тогтоол. Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолуудын эмхэтгэл. УБ.2001 он. 209 дэх тал.

Дүгнэлт. Өмнөх Эрүүгийн хуулийн 70,71-р зүйлүүдэд хууль тогтоогч гагцхүү үйлдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо сайн дураар нөхөн төлсөн, гэм хорыг арилгасан нөхцөлд дээрх үр дагавар үүсэхээр заасан нь тодорхой харагдаж байна.

Гэмт хэргийн хохирлыг нөхөн төлөх асуудал гэмт хэргийн улмаас материаллаг хохирол бодитойгоор учирсан, эсвэл гэмт хэргийн улмаас учирсан бусад хор уршгийг мөнгөн илэрхийллээр илэрхийлж бодитойгоор төлж барагдуулж болох тохиолдолд яригдана.

Ашигласан материал

Ном, сурах бичиг, гарын авлага:

1. С.Нарангэрэл.Монгол Улсын ЭЭЗүй.Ерөнхий анги.Уб.1999
2. Т.Дэндэв.БНМАУ-ын ЭЭЗүй дэхь ял шийтгэлийн тухай асуудал. Уб. 1975
3. Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. Уб. 2002
4. С.Жанцан.Монгол Улсын ЭЭЗүй /Альбом схем,зүйлчлэлийн асуудал/. Уб.2004
5. Хууль зүйн тайлбар толь. Уб. 2003
6. Д.Адъяабазар, Б.Батдэлгэр, Г.Гантөмөр.Эрүүгийн хариуцлага. Уб.2006
7. Ж.Авхиа, Б.Ганболд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар./Ерөнхий анги. Тэргүүн дэвтэр/.Уб. 2002
8. Ч.Нямсүрэн.Гэмт хэргийн виктимологи.Уб.2005

Гадаад эх сурвалж:

9. И.Э.Звечаровский. Уголовная ответственность: понятие, виды, формы реализации.г.Иркутск.изд Иркут.гос ун-т 1992 г.
10. Российское уголовное право /под ред. В.Н.Кудрявцева и А.В.Наумова/. М.изд Спарк. 2000 г.

Сонин, сэтгүүл:

11. Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2004. №4.
12. Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2006. № 4.

**ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ ГЭМТ ХЭРГИЙН
КРИМИНОЛОГИЙН ЗАРИМ АСУУДЛУУД**
CRIMINAL DISTRIBUTION SOME CRIMINAL PROBLEMS

Д.Отгонсүрэн
*ДХИС-ийн ЭЗНУС-ийн
НЭЗТ-ийн багш, цагдаагийн дэслэгч,
Хууль зүйн магистр*

D.Otgonsuren
Lecturer, Police Lieutenant,
Department of Public Law,
School of Law and Social Sciences,
University of Internal Affairs
/ Master of Law /

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд худал мэдээлэл тараах гэмт хэргийг ихэвчлэн сэтгэхүйд нь зан суртахууны доголдол давамгайлсан, нийгэмд дадал хэвшил тогтсон, тэдгээр нь бие хүний ёс суртахуун бүрэлдэж тогтох тааламжгүй нөхцөлөөс шалтгаалсан тодорхой этгээдүүд үйлдэж байгаа талаар товч авч үзсэн болно..

Abstract: The crime of disseminating false information is often committed by certain individuals whose minds are dominated by moral defects, who have established social habits, and who are exposed to unfavorable conditions for the formation of personal morals.

Түлхүүр үг: зөрчил, гэмт хэрэг, шалтгаан нөхцөл, худал мэдээлэл тараах, хариуцлага

Keywords: violations, crimes, causes and conditions, dissemination of false information, liability

Оршил. Худал мэдээлэл тараахын эсрэг хуулийн хэд хэдэн үзэл баримтлал байдаг байна. Эдгээрээс хамгийн эртний бөгөөд анхны үзэл баримтлал бол хаадад бурхнаас заяасан эрхийн тухай үзэл баримтлал буюу хаад буруу зүйл хийхгүй гэсэн үзэл юм. Энэ үзэл баримтлалын дагуу худал мэдээлэл тараахын эсрэг анхны хууль нь анх эзэн хааны эрх мэдлийн бэлэг тэмдгийг хамгаалж гарч ирсэн гэж үздэг. Ийм учраас хаан, хааны бэлэг тэмдгийг доромжилсон тохиолдолд Lese mageste буюу хааны эрхэм зориг, нэр хүндэд халдсан гэмт хэрэг гэж үзэж цаазаар авах, шоронд хорих шийтгэл ноогдуулдаг байжээ.

Гадаадын зарим улс орны хууль тогтоомжид худал мэдээлэл тараах гэмт хэргийн тухай хуулийн уг үндэс нь МЭӨ V дугаар зуунд үйлчилж байсан Ромын “Арван хоёр таблиц”-ийн хуулиас гаралтай гэж үздэг байна. Уг хуульд “iniuria”-ийн тухай ойлголт орсон байдаг бөгөөд энэ нь ерөнхийдөө “доромжлол, гэмтэл” гэж орчуулагдах заалт ажээ. Ромын их гүрний үед хэд хэдэн цуврал нэмэлт өөрчлөлт орсон ба үүгээр “iniuria”-ийн үзэл баримтлал өргөжин, түүнд хэл амаар дайрч довтлох, гүтгэн доромжлох болон эгдүүрхэхийг багтаасан байна⁴⁸.

Эртний Ромын “iniuria”-ийн тухай хууль нь бүх иргэний алдар нэрийг хамгаалахад чиглэсэн байдаг ч, түүн дотор өндөр албан тушаалтан ордог байжээ.¹ Эрх зүй өндөр хөгжсөн зарим улс орнуудад гэм буруутай этгээдээс сэтгэл санааны хохирол гаргуулах, гэм буруутай этгээд тогтоогдоогүй бол эд

⁴⁸ ОХУ-ын хуульч Галина Араповын “Нэр төр сэргээх талаархи хууль тогтоомж европын шүүхийн хууль цааз” өгуулэл. Нэр төр гүтгэлэг. Уб. 2002. 40 дэх тал

хөрөнгө бие эрхтэнд учирсан хохирлоос гадна сэтгэл санаанд учирсан хохирлыг төрөөс нөхөн төлж барагдуулдаг тогтолцоо байдаг байна.

Үндсэн хэсэг. Монгол улс гүтгэх, доромжлох үйлдлийг олон жил гэмт хэрэгт тооцож ирсэн харин 2015 оны Эрүүгийн хуулиар хүчингүй болгож, Зөрчлийн хуулиар зохицуулж байгаад 2020 онд Зөрчлийн тухай хуульд заасан гүтгэх зөрчлийг хүчингүй болгож, эгүүлэн Эрүүгийн хуулиар худал мэдээлэл тараах гэмт хэрэг болгон хуульчилсан байна. Эрүүгийн хуулийн 13.14-т заасан худал мэдээлэл тараах гэмт хэрэг нь хүний нэр, төр, алдар хүндийг хамгаалсан зохицуулалт болсон байна.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл⁴⁹д заасан Худал мэдээлэл тараах гэмт хэрэгт хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан худал мэдээллийн хэлбэрүүд болох 1.Хуурамч мэдээлэл (Disinformation), 2.Алдаатай мэдээлэл (Misinformation), 3.Буруу сэдэлтэй мэдээлэл (Mal-information) тараасан үйлдлийг хамруулан хуулийг хэрэглэх боломжтой байна. Учир нь бусдыг гутаах зорилгоор тараасан байх шаардлага хуулиар тавигдаагүй тул ямар нэг байдлаар тараасан буюу нэр төрд халдсан бол “Худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт шалгагдах, хариуцлагад татагдах эрсдэлтэй байна.

Илт худал мэдээллийг тараасан бол хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилго шаардахгүй бөгөөд тараасан буюу халдсан бол гэмт хэрэгт тооцогдох боломжтой гэсэн үг. Хуульд заасан халдсан байх гэсэн энэ ойлголт бол өргөн хүрээг хамрах бөгөөд үүнд хүний нэр нь эерэг, сөрөг ямар ч байдлаар нь нийтлэлд гарах, дурдагдах явдал гарч болно. Тухайн мэдээлэл нь илт худал боловч хүний нэр төрийг гутаасан агуулга байхгүй байсан ч, мөн мэдээллийг гутаах санаа зорилго агуулахгүйгээр тараасан, дамжуулсан байсан ч “нэр төрд халдсан” гэж худал мэдээлэл тараасан гэмт хэрэгт тооцогдохоор байна. Гадаадын зарим улс орнууд тухайн гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг хэрхэн хийж, хүний нэр төр алдар хүндийг хуулиар хамгаалсан талаар авч үзье.

ОХУ-ын хэмжээнд жил ирэх тусам 30 орчим хувиар байнга өсөж байгаа ба эдүгээ жилд 4000 орчим худал мэдээлэлтэй холбоотой нэр төр, алдар хүндийн тухай маргаан гардаг" нь энэ төрлийн хэрэг маргаан олон улсын шинж чанартайг харуулж байна.

ОХУ-н Иргэний хуульд "Сэтгэл санааны хохирол гэдэг нь иргэний хувийн эдийн бус түүнд хамааралтай эдийн бус баялгийг зөрчсөн үйлдлийн улмаас учирсан болон бусад хуульд заасан тохиолдолд биеийн болон сэтгэл санааны зовлон шаналал байна"⁵⁰.

Сэтгэл санааны хохирол нь гэм буруутай этгээдийн гэм буруугаас үл харгалзан аюул ихтэй зүйлсийн улмаас иргэний амьдрал, эрүүл мэндэд учирсан хохирол, иргэнийг хууль бусаар шүүсэн, таслан сэргийлэх арга хэмжээг хууль бусаар хэрэглэсэн, баривчлах болон засан хүмүүжүүлэх хэлбэрээр захиргааны шийтгэлийг хууль бусаар ногдуулснаас учирсан хохирол, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээлэл тарааснаас учирсан хохирол, хуульд заасан бусад тохиолдолд” гэж заасан байна. Мөн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр төлөх ба хохирогчид учирсан биеийн болон сэтгэл санааны зовлон шаналалын шинж чанар, хохирол учруулсан нөхцөл байдал зэргийг харгалзан мөнгөний хэмжээг шүүх тогтоож байхаар хуульчилсан байна.

ХБНГУ-н Иргэний хуулийн 253 дугаар зүйлийн 1-д "зөвхөн хуульд заасан тохиолдолд аливаа хохирлын нөхөн төлбөрт мөнгөн торгууль ногдуулж болно", мөн хуулийн 847 дугаар зүйлд сэтгэл санааны гэм хорыг мөнгөөр нөхөн төлүүлэхээр заасан бөгөөд тийнхүү нөхөн төлүүлэх үндэслэл нь хохирогчийн эрх, эрх чөлөөг хууль бусаар хязгаарласан, бие эрхтэн, эрүүл мэндийг гэмтээж хохирол учруулсан" байхыг шаардсан байна. Эдийн бус хохирлын хэмжээг тодорхойлохдоо хариуцагчийн гэм буруу, хохирогчид бий болсон сөрөг үр дагавар, хариуцагчийн эд хөрөнгийн байдал зэргийг харгалзан үздэг байна. Сэтгэл санааны гэм хорыг арилгахад тусгай аргачлал боловсруулсан бөгөөд үүнийг шүүх шийдвэр гаргахдаа мөрдлөг болгодог байна.

⁴⁹ Төрийн мэдээлэл. 2015. №18. Эрүүгийн хууль

⁵⁰ ОХУ-ын хуульч Галина Араповын “Нэр төр сэргээх талаархи хууль тогтоомж европын шүүхийн хууль цааз” өгуулэл. Нэр төр гүтгэлэг.УБ2002 он 40 дэх тал

БНХАУ-д эдийн бус гэм хорыг тооцох аргачлалгүй харин тухайн хэргийн нөхцөл байдлыг харгалзан шүүхээс тогтоодог байна.

Австралид эдийн бус гэм хорын ойлголт өргөн хүрээтэй бөгөөд түүнийг үнэлэх, арилгах журмыг буюу эдийн бус гэм хорын нөхөн төлбөрийн хэмжээг хуульчилсан байна. Тухайлбал: Дотоодийн нийт бүтээгдэхүүний нэг хүнд ногдох хэмжээгээр тооцон хохиролыг барагдуулах дэлхий нийтийн жишгээс авч үзвэл худал мэдээлэл тараах нь гэмт хэрэгт тооцогдохгүй байх хандлага түгээмэл болжээ. Хэрэв тухайн иргэн худал мэдээлэл тараах гэмт хэргийн хохирогч болсон хэмээн үзэж нэр төрөө сэргээлгэхийг хүсвэл иргэний журмаар шүүхийн хамгаалалт авах нь илүү зохимжтой гэж үздэг болсон байна. Улс орнуудын хууль тогтоомжинд энэ талаар хэрхэн тусгагдсан байдлыг судалж үзэхэд 3 бүлэгт хувааж болохоор байна.

а. Хүний нэр төр, алдар хүндийг эрүүгийн болон иргэний хуулиар хамгаалдаг улсууд Энэ ангилалд ихэвчлэн тоталитар дэглэмтэй байсан улсууд болох ОХУ, Украин, Беларусь зэрэг ЗХУ-н бүрэлдэхүүнд байсан улсууд, мөн БНХАУ, БНАСАУ, Куба, Вьетнам зэргийг хамааруулж болно. Эдгээр оронд хувь хүн өөрийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжиллоо гүтгэгдлээ гэж үзвэл эрүүгийн болон иргэний журмаар алинаар нь хандахаа өөрөө шийдвэрлэнэ.

б. Зөвхөн хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан гүтгэхээс бусад үйлдлийг гэмт хэрэгт тооцдоггүй улсууд. Энэ ангилалд Европын холбооны улсууд буюу эх газрын эрх зүйн тогтолцоотой орнуудыг хамааруулж болно.

в. Нэр төр, алдар хүндийг Эрүүгийн хуулиар хамгаалдаггүй, иргэний шүүхээр асуудлыг шийдвэрлэдэг улсууд. колони байсан буюу ангилалд хамааруулж болох юм. Манай улсын хувьд эхний ангилалд буюу Эрүүгийн хуулиар хүний нэр төр, алдар хүндийг хамгаалдаг улсуудын тоонд орно. АНУ, Их Британи тэдгээрийн Англо-Саксоны эрх зүйн системтэй орнуудыг энэ бүлэгт хамааруулж болохоор харагдаж байна. Гадаад орнуудын хууль тогтоомжид худал мэдээлэл тараах гэмт хэргийн талаар тусгасаныг үзэхэд сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудын ихэнх нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар олон улсын хамтын ажиллагааны хүрээнд идэвхтэй ажиллах болсон нь эрүүгийн эрх зүйн салбарын глобалчлал, интеграцчиллын орчин, хандлагыг тодорхойлоход чухал хүчин зүйл болж байна.

Эрүүгийн хуулийг 1926 онд "Шүүх цаазын бичиг" хэмээх нэртэйгээр гаргасан гэж судлаачид үздэг. Уг хуульд "хүнд гэмт хэрэгт холбогдуулан гүтгэх" гэж анх хуульчлагдсан байдаг. Харин 1934 он гэхэд манай улсын бүх хуулиуд ЗХУ-ын ижил төрлийн хуулийн хэв загварыг хуулбарлан авсан байна. Эрүүгийн хуулийг 1926 онд анх батлан гаргаснаас хойш 1929,1942, 1951, 1961, 1986, 1993, 2002, 2016,2020 онуудад өөрчлөн шинэчилж байжээ⁵¹.

Худал мэдээлэл тараах гэмт хэргийн талаархи хуучин, шинэ Эрүүгийн хуулийн үзэл баримтлалын ялгаа нь 1986 оны БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд заасан "Гүтгэх" гэмт хэргийг "бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан илт худал гүжирдлэг тараасан бол" гэж объектив талын шинжээр нь тодорхойлож байсан. Харин 2002 оны Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлд "Гүтгэх" гэмт хэргийн субъектив болон объектив талын шинжээр нь тодорхойлсон байна. Тухайлбал, "хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор", "илт худал гүжирдлэг тараасан бол" гэмт хэрэгт тооцохоор заасан.

Хуучин Эрүүгийн хуулиар "хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилго байсан эсэхийг тогтоох шаардлага байгаагүй, зөвхөн хүний нэр төр, алдар хүндийг гутаасан илт худал Гүжирдлэг тараасан бол гэмт хэрэг гэж үзэж байсан. Хэрвээ зорилго нь тогтоогдохгүй бол гүтгэх гэмт хэргээр зүйлчлэхгүй. Энэ хэрэг нь иргэний хэргийн журмаар шийдвэрлэгдэнэ. Гүтгэх гэмт хэрэг нь өс хонзон, үзэн ядалт, хардалт зэрэг сэдэлтээр гол төлөв үйлдэгддэг.

Хүн төрөхөөс гэмт хэрэгтэн болж төрдөггүй ч тодорхой орчин, нөхцөл бүрдэхэд гэмт хэрэг үйлдэх зан төлөвүүд илрэн гарч эхэлдэг. Энэхүү эрсдэл бүхий орчинд ажиллаж, амьдарч буй хүмүүсийг

⁵¹ БНМАУ-ын Түүх III дах хэвлэл У6,1984. 574 дэх тал

гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй бие хүн гэдэг. Гэмт хэрэг үйлдэгдмэгц л нэгдүгээр асуулт нь “гэмт хэрэгтэн гэж хэн бэ?” гэж эхэлдэг. Бусад тохиолдолд уг этгээд бидний дунд, хажууд, эргэн тойронд маань ажиллаж амьдарч буй жирийн бие хүн байдаг. Тиймээс “бие хүний ерөнхий ойлголтоос гэмт хэрэгтэн хэмээх бие хүний онцлогийг гаргаж ирэх нь зүйтэй. “Бие хүн гэдэг нь нийгмийн харилцаанд орж тодорхой нэг бүлэг, давхаргад хамаарагдаж буй этгээд. Өөрөөр хэлбэл, өөрийн үйлдлээ ойлгож, түүнийгээ удирах чадвартай, өөрийн үзэл бодол итгэл үнэмшил бүхий, аливаа нийгмийн харилцаанд хүслээрээ оролцож үр дагавар бий болгогч юм.

Мөн нийгмийн харилцааны бүтээгдэхүүн болохын хирээр бие бялдар, оюун санааны талаар өсөж боловсронгуй болж өөрийн гэсэн хүмүүжил, үзэл бодол, авир араншинтай, хувийн онцлогтой болж байдаг байна. Худал мэдээлэл тараах гэмт хэргийг ихэвчлэн сэтгэхүйд нь зан суртахууны доголдол давамгайлсан, нийгэмд дадал хэвшил тогтсон, тэдгээр нь бие хүний ёс суртахуун бүрэлдэж тогтох тааламжгүй нөхцөлөөс шалтгаалсан тодорхой этгээдүүд үйлдэж байна⁵².

”Ер нь гэмт зан төлөвийн шалтгааныг ойлгохын тулд тэр нь зөвхөн бие хүнээс болон гадаад нөхцөл байдлуудаар тодорхойлогддоггүй гэдгийг анхааралдаа авах нь зайлшгүй юм⁵³. Хэрвээ энэ нь тийм байсан бол дурын хүн тааламжгүй сөрөг нөлөөлөл мэдэрсэн үедээ л худал мэдээлэл тараах гэмт хэргийг үйлдэж чадах юм. Гэвч яг адил нөхцөл байдалд янз бүрийн хүмүүс янз бүрээр биеэ авч явдаг нь тодорхой юм. Яг ижил нөхцөлд бусад гүтгүүлсэн хоёр хүний нэг нь шууд хүч хэрэглэх юм уу хариу үзүүлж байхад нөгөө нь юу ч болоогүй юм шиг байх гэх мэт. Худал мэдээлэл тараах бие хүний гол зонхилох шинж чанар нь амьдрал дахь байр сууриа хамгаалсан, өөрийгөө хамгаалах, өөрийгөө зөвтгөх, аминчхан үзэлтэй, бусдыг үл сонсох араншинтай байх ба ирээдүйд болох үйл явдлыг дутуу бодож өөртөө хор хохирол учруулдагт учир зүйн холбоо нь оршдог. Худал мэдээлэл тараах үйлдсэн гэмт хэрэгтэн бие хүний криминологи шинж:” Нийгэм хүн ам зүйн шинж (нас, хүйс, боловсрол, гэр бүлийн байдал гэх мэт) Нийгмийн амьдралын янз бүрийн хүрээн дэх харилцаа холбоо, үүрэгтэй холбоотой шинж (сургууль хамт олноосоо хөндийрсөн, нийгэм болон өөрт ашигтай харилцаа нь суларсан, үл бүтэх хүмүүстэй нийлж дарвих, өөрийн гэсэн хүсэл эрмэлзэлгүй урсгалаар байх гэх мэт) Зан төлөв, сэтгэл зүйн шинж (ёс суртахуун, улс төрийн үзэл баримтлал, ертөнцийг үзэх үзэл бодол, итгэл үнэмшил, төсөөлөл, сэтгэхүйн үйл ажиллагаа, авир араншин) гэх мэт талаас нь авч үздэг.

Нийгэм эдийн засгийн тэгш бус байдал, хүмүүсийн ахуй амьдрал зан харилцаа, сэтгэл санаанд нөлөөлж улмаар улс төрийн эрх, өмч хөрөнгийг завших зэрэг зорилгод хүрэхийн тулд иргэд болон сэтгүүлчид, тодорхой бүлэглэлүүд зарим тохиолдолд зохион байгуулалттайгаар худал мэдээлэл тараах гэмт хэргийг үйлдэх болжээ. Зарим судалгаанаас үзэхэд сонгууль болох жил худал мэдээлэл тараах гэмт хэрэг эрс ихэсдэг байна. Энэ нь улс төрчид өрсөлдөгчөө ялахын тулд, улс төрөөс татан унагаж өөрийн хүсэл зорилгоо ямар ч аргаар хамаагүй биелүүлэхийн тулд хууль зөрчин зүтгэгдгээс хамааралтай юм.

Улс төрчид, олны танил хүмүүс худал мэдээлэл тараах гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр тархаж байдгаараа жирийн иргэдийн энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсоноос ялгаатай байдаг байна. Иргэдийн хуулийн мэдлэг дутуу дулимаг байдаг зэрэг нь худал мэдээлэл тараах гэмт хэргийг үйлдэх хүчин зүйлийн нэг болдог.


Энэ төрлийн мэдээлэл сурталчилгаа хомс байдаг нь хүний нэр төр, алдар хүнд эрх эрх чөлөөг хулиар хамгаалдаг, хэрвээ зөрчигдвөл хуулийн хариуцлага хүлээлэгдэг гэдгийг нэг хэсэг нь мэддэггүй байхад мэдсээр байж санаатай үйлддэг хүмүүс ч байдаг. Ихэнх гэмт хэргийн шалтгаан нь хэрэгцээний дутагдал байх ба ердийн, олон нийтийн хүлээн зөвшөөрсөн арга хэрэгслээр хангах боломжгүй болмогц бусад арга замыг ашигладаг гэж үзэж болно. Жишээ нь, өлсөх, даарах, ичих, нэр төр нь гутаагдах гэх мэт. Доромжлох, гүтгэх гэмт хэргийг Эрүүгийн хуулиас халахыг НҮБ-ын Хүний эрхийн хорооны Ерөнхий тайлбарт зөвлөсөн. Түүнчлэн НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс 2015 онд Хүний эрхийн төлөв

⁵² www.criminology.mn

⁵³ Н.Жанцан “Криминологи” УБ.2004 77 дахь тал

байдлын ээлжит хэлэлцүүлэг явуулах үед найман улсад “нэр төр гутаахтай холбоотой заалтыг Эрүүгийн хуулиас халах”-ыг зөвлөсөн бөгөөд тухайн улсуудын нэг нь Монгол Улс байсан байна.

2015 онд Эрүүгийн хуулийн 111.2-т заасан гэмт хэрэг үйлдэж шийтгэл хүлээсэн байдал



Доктор О.Мөнхсайхан: Эрүүгийн хуулиар эсхүл Зөрчлийн тухай хуулиар доромжлол, гүтгэлгийг гэмт хэрэгт тооцож шийтгэх зохицуулалт нь үндсэн эрхийг хязгаарлахад тавигдах дээрх зургаан гол нөхцөлийн нэг болох тохирсон (зайлшгүй) байх зарчмыг зөрчдөг учраас үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөрчдөг гэж байр сууриа илэрхийлжээ. Гэвч хэдийгээр тийм боловч гүтгэгдэж, доромжлогдож байгаа хүнд мөн хүн байхынхаа тухайд заяагдсан жам ёсны эрх бий тухайн хүний энэ салшгүй эрхийг Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалахаар заасаныг дурдахад илүүц биз ээ. Мөн Жон Стюарт Милль: үзэл бодлоо илэрхийлэх эрхийг нухчин дарахын онцгой хор уршиг гэдэг хүн төрөлхтнийг тэр чигээр нь дээрэмдэхтэй адил юм. Өөрөөр хэлбэл, төөрөгдлийнхөө учрыг олох явцад үнэн зөвийг илүү тодорхой олж харах, мэдрэх боломжийг нь алдагдуулдаг байна гэж хэлсэн.⁵⁴

Худал мэдээлэл тараах нь хүний нэр төр, алдар хүндийг гутаасан худал мэдээг амаар, бичгээр, элдэв дүрс бичлэг, хуурцаг болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараасан байхыг тодорхойлсон байна. Энэ нь уг хүний нийгэмд үнэлэгдэх зүй ёсны бодит үнэлгээг доройтуулан, гажуудуулсан ойлголтыг олон нийтэд тараахад чиглэгдсэн мэдээлэл байх бөгөөд тарааж байгаа мэдээ нь уг хүний зан төлөв, үйл ажиллагааны үнэн бодит байдалд нийцэхгүй байхыг ойлгоно.

Энэ гэмт хэргийн онцлог шинж нь бусдын нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тарааснаар тодорхойлогддог. Энэ төрлийн гэмт хэрэг нь хүний нэр төр, алдар хүндийг гутаах гэсэн шууд санаатай, сэдэлт нь өш хонзон санах, үзэн ядах, атаархах явдал байдаг. Худал мэдээллийг заавал олон хүнд тараасан байхыг шаардахгүй зөвхөн анхны хүнд мэдээлснээр төгсдөг нь тус эрх зүйн харилцааны онцлог юм.

Эрүүгийн хуулийн 13.14-т Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. гэж заажээ “...олон нийт...” гэдэг нь нийгмийн нэг хэсгийг тодорхойлсон ойлголт учир тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг бий болгох нөхцлийн хувьд заавал хоёр буюу түүнээс олон хүний дэргэд доромжилсон байхыг шаардахгүй бөгөөд бусдын нэр төр, алдар хүндийг нэг хүний ч дэргэд гутаасан байж болно. УДШ-ийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний 40 дугаар тогтоолд ийнхүү тайлбарласан байна⁵⁵.

⁵⁴ orosoo@baabar.mn


⁵⁵ Улсын Дээд Шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний 40 дугаар тогтоол

Нөгөөтэйгүүр худал мэдээлэл тараах гэмт хэргийн хамгийн аюултай төрөл нь хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахад чиглэн гүтгэсэн явдал байдаг. Энэ төрлийн гэмт хэргийг зориуд, худал мэдээлэх гэмт хэргээс ялгах явдал зайлшгүй чухал юм. Зориуд худал мэдээлэхэд гэм буруутай этгээдийн санаа нь хохирогчийг эрүүгийн хариуцлагад татуулах, харин гүтгэхэд хохирогчийн нэр төр, алдар хүндийг гутаахад чиглэгддэг байна.

“Худал мэдээлэл тараах” гэмт хэргийг УИХ-аас 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлтээр оруулжээ. “Худал мэдээлэл тараах” гэмт хэрэг, уг гэмт хэргийн үндсэн ухагдахуун болох “Илт худал мэдээлэл” гэх ойлголтыг шинжлэн судлах ажлын хүрээнд Засгийн газраас 2019 онд Эрүүгийн хуульд уг зүйлийг нэмэлтээр оруулахаар өргөн мэдүүлсэн хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлал, хэлэлцүүлгийн тэмдэглэл, хуулийн төсөлтэй танилцаж, хууль санаачлагч, тогтоогчийн анхны хүсэл зориг, байр суурийг шинжлэн судлан авч үзэхэд, төслийн “Гүтгэх” гэснийг “Худал мэдээлэл тараах” гэж өөрчлөн, “хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдаж илт худал мэдээллийг” нийтийн сүлжээгээр тараах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараах гэж ялгамжтай авч үзсэн байсныг нэгтгэн уг гэмт хэргийг “олон нийтэд тараасан бол” хэмээн объектив талын шинжээр нь тодорхойлж, субъектив талын шинжийг “бүрхэгдүүлсэн” (уг гэмт хэргийн объектив, субъектив шинжийг тэнцвэргүй тодорхойлсон), худал мэдээлэл нь “гутаасан, гутаах” агуулга, шинжтэй байх эсэхийг бүрэн тодорхойлоогүй, “халдсан” гэсэн хэт ерөнхий нэр томъёог хэрэглэсэн явдал нь хууль бүтээх ажиллагааны алдаа болж, хууль хэрэглээ, шүүхийн практикт сөрөг үр дагавар үүсгэж буй гол шалтгаан болсон гэж үзэх үндэстэй юм.⁵⁶


Мөн уг зүйлийн тайлбар болох “Энэ гэмт хэргийн хохирогчид төрийн байгууллага хамаарахгүй. Үзэл бодлоо илэрхийлэхдээ улс төрд нөлөө бүхий этгээдийг гэмт хэрэгт хардсан, сэрдсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй.” гэснийг хассан байна. Уг тайлбарыг хэлэлцүүлгийн явцад хассан явдал нь мөн хууль зүйн техникийг бүрэн бүрдүүлэх шаардлагыг алдагдуулан, хуулийн төсөлд тусгагдсан “томъёолол” нь хэлэлцүүлгийн явцад дэмжигдэхгүй хасагдаж батлагдсаны улмаас эрх зүйн хийдэл, давхардал үүсгэж, үг хэлэх эрх, мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн байдлыг дордуулах үндэс болжээ.

2015 онд Эрүүгийн хуулийн 11.2-т заасан “Гүтгэх” гэмт хэрэгт шалгагдсан иргэдийн нас, хүйс, боловсролын байдал




2020 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14-т заасан “Худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт шалгагдсан байдал

⁵⁶ orosoo@baabar.mn



Нэр төр, алдар хүндээ сэргээлгэхээр нэхэмжлэгчид дунджаар 5-30 сая төгрөг, дээд хэмжээ нь 450 сая төгрөг 1995-2002 онд нэхэмжилсэн байсан ба шүүх хохиролын дундаж хэмжээг 200,0-500,0 мянган төгрөгөөр тооцож нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн байна. "2020 оны 1-9 сар хүртэлх хугацаанд цагдаагийн байгууллагаас хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчтэй холбоотой "худал мэдээлэл тараах" гэмт хэргийн шинжтэй 24 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан. Үүнээс 20-д нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг прокурорт хүргүүлсэн бол дөрвийг нь харъяаллын дагуу шилжүүлсэн байна. Энэ гэмт хэргээр сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтныг шийтгэх саналыг цагдаагийн байгууллага буюу мөрдөгч гаргаагүй байна. Улмаар Зөрчлийн тухай хуулийн Гүтгэх заалт хэрэгжиж эхэлснээс хойш 32 сарын дараа хүчингүй болсон юм.

Зөрчилийн тухай хуулийн "Гүтгэх" зүйл ангиар 2017-2020 онд шийтгэл хүлээсэн иргэн ба сэтгүүлч нарын тоон үзүүлэлт



Дээрх графикаас харахад 2017 онд сэтгүүлч 4 иргэн 28, 2018 онд сэтгүүлч 17 иргэн 486, 2019 онд сэтгүүлч 4 иргэн 355, 2020 онд сэтгүүлч байхгүй 20 иргэн шийтгэл хүлээсэн байна. Зөрчлийн нийт тоотойгоо харьцуулахад, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой шийтгэгдсэн тохиолдол бага хувийг эзэлж байна⁵⁷. 2021 оны эхний 4 сарын байдлаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлд заасан "Худал мэдээлэл тараах" өмнөх оны үлдэгдэл 105, шинээр нээсэн 119, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 6, нийт 230 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт

⁵⁷ "Глоб интернэшнл" ТББ

явуулснаас 89-ийг хааж, 4 хэргийг нэгтгэж, 1 хэргийг хэрэгсэхгүй болгож, 8 хэрэгт яллах дүгнэлт үйлдсэн байдаг. Харин 2020 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан Худал мэдээлэл тараах 10 гэмт хэрэг хянан шийдвэрлэгдсэн байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд энэ төрлийн гэмт хэргийн гаралт болон шийтгэл хүлээж ялагдсан тохиолдлууд нэмэгдсэн байгаа нь энэ бол зөрчил биш улс орны нийгэм эдийн засгийн хөгжил дэвшилттэй уялдан иргэдийн цахим хэрэглээ, мэдээ мэдээлэл түгээх, олж авах арга хэрэгсэл, хүний нэр төр алдар хүндийг хуулиар хамгаалах зэрэг маш олон шалтгаант нөхцөлүүдийг нарийвчлан судлан үзэхийн зэрэгцээ түүнээс урьдчилан сэргийлэх, хохирлын хэмжээг тооцох аргачлалыг тодорхой болгох зайлшгүй шаардлага тулгарч байгаа нь “Гэмт хэрэг” гэдгийг хүлээн зөвшөөрөх гарцаагүй дүгнэлтэд хүргэсэн гэж харагдаж байна.

Дүгнэлт: Хүний салшгүй байх жам ёсны эрхтэй шууд холбогддог сүүлийн жилүүдэд өсвөр насны сургуулийн сурагчид хууль эрх зүйн мэдлэг дутмаг байгаагаас шалтгаалан нэг нэгнийхээ нэр хүндийг гутаан доромжилж худал мэдээлэл тараах болсон нь зарим тохиолдолд амиа хорлох үйлдэл хийхэд хүргэж байгаа нь нэн харамсалтай. Иргэдийн эрх зүйн боловсролыг сайжруулах хууль эрх зүйн ухуулга сурталчилгаа, таниулгыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулалттайгаар явуулах зүйлшгүй шаардлага бий болжээ. Цахим мэдээллийн сүлжээгээр бид өдөр тутамд хүний нэр төр алдар хүндэд халдсан мэдээ мэдээлэлтэй таардаг ч үнэн худал эсэх асуудалд төдийлөн ач холбогдол өгдөггүй амаас ам дамжин ярьдаг нь “худлыг мянгантай ярихад үнэн болдог” гэдгийг давтан үйлдэж, энэ төрлийн гэмт хэргийг нийгэмд түгэхэд хувь нэмрээ оруулсаар байдаг.

Хүнлэг ардчилсан нийгэмд хүний нэр төр, алдар хүнд гэдэг эрх, эрх чөлөөгөө эдлэх эхний бөгөөд хамгийн том боломж гэдгийг авч үзэх ёстой. Монгол хүний хэнэггүй гүндүүгүй зан энэ байдаг л асуудал гэмт хэрэг гэж бодохгүй хөнгөмсөгөөр хандаж тахал мэт тархахад нөлөөлж байна. Жил бүрийн гаралт төдийлөн өндөр хувьтай биш мэт харагдавч хууль шүүхийн байгууллагт гомдол гаргалгүй чимээгүй хохирогсод бий гэдгийг бид мартах учиргүй юм. Мөн аливаа хуулийн шинэчлэл өөрчлөлт нь хэрэглээний явцад нийгэм ард иргэд, цаашлаад хууль зүйн салбарын хүрээнд нөлөөлөх үр дүн, шалтгаант нөхцлөөс хамааран шинэчлэгдэж өөрчлөгдөж байдаг зарчмын дагуу “Худал мэдээллэх” гэмт хэргийн зүйл заалтад ахиц дэвшил гарч хуулиар хамгаалагдсан хүний нэр төр алдар хүндэд нийгэмээрээ эерэг хандлагаар хандаж, цахим сүлжээний хар давалгааг саринуулах зайлшгүй шаардлагатайг хүний эрх, эрх чөлөө биднээс шаардаж байна.

Санал: дээрхи дүгнэлтийг үндэслээд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. ЭХ-н 13.14 “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ”. гэж заасан нь “халдсан” гэдэгт ямар үйлдэлийг хамааруулан ойлгохыг тодорхой заагаагүй мөн хохирогчид учруулах хор аюулыг бодитоор тусгаагүй, “тараасан” гэдэгт субъектив талын шинжийг салгаж тусгаарлаж бодитоор хандаагүй байх тул нэмэлт өөрчлөлт оруулан эрдэмтэн судлаач, хүний эрхийн хуульчдын санал бодлыг тусгаж, хууль төгс, салаа утга агуулаагүй байх зарчмыг хангах нь зүйтэй гэсэн санал

2. ЕБС-ийн суралцагчдад тодорхой хүрээнд шаталсан хэлбэрээр бага дунд ангид зан заншил, ёс суртахууны хэмжээнд ахлах ангид хууль эрх зүйн хүрээнд тодорхой мэдлэг олгож Монгол хүнд удамшиж тогтсон хэнэггүй гүндүүгүй зангаар чимээгүй гэмт хэрэг үйлдэгч болон хохирогч болсоор байдаг зан суртахууны хэм хэмжээг өөрчлөхөд ухуулга сурталчилгааны аргаар хууль зүйн үр дагаварыг таниулах цаг үе ирсэн гэдэг саналуудыг тус тус дэвшүүлж байна.

Ашигласан материал

Хууль, тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1924, 1992 он
2. Монгол Улсын Эрүүгийн хууль 2002, 2016 он
3. БНМАУ-ын Үндсэн хууль, түүнд холбогдох зарим актын эмхэтгэл, УБ 1972он
4. БНМАУ-ын Шүүх цаазын бичиг, УБ 1926,1934 он
5. Н.Жанцан “Криминологи” УБ 2004 он
6. Г.Совд “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар” УБ. 2000 он
7. Ц.Цэлмэг “Криминологи” УБ. 2005 он

Ашигласан бусад материал:

1. БНМАУ-ын түүх III дах хэвлэл. УБ., 1984 он
2. Төрийн мэдээлэл сэтгүүл
3. Улсын Дээд Шүүхийн Мэдээлэл судалгааны төвийн судалгаа 2015 он
4. ЦЕГ-ын мэдээлэл судалгааны төв, "Гэмт хэргийн нөхцөл байдлын судалгаа". 2005-2015 он
5. “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын хуульчдын хийсэн судалгаа
6. Галина Араповын “Нэр төр, гүтгэлэг.” өгүүлэл УБ 2002 он. 40 дэх тал.

Цахим эх сурвалж:

1. www.legalinfo.mn
2. www.criminology.mn
3. www.consultant.ru
4. orosoo@baabar.mn

**ТӨСВИЙН ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН БУСААР ЗАРЦУУЛАХ
ГЭМТ ХЭРГИЙГ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРҮҮГИЙН
ХУУЛЬ ТОГТОМЖТОЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**
/ОХУ, БНХАУ, Энэтхэг улсын жишээн дээр/

*Э.Золбоо
ДХИС-ийн ЭЗНУС-ийн
НЭЗТ-ийн багш,
цагдаагийн ахмад,*

Товч агуулга: Монгол Улсын нийгэм, эдийн засгийн үсрэнгүй хөгжилтэй холбоотойгоор гэмт хэргийн арга хэлбэр улам нарийсч, төрийн албан хаагчид албан тушаалын байдлаа ашиглан гэмт хэрэг үйлдэх явдал багагүй бий болж, үүний дотор Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж байгаа гэмт хэрэг нь иргэдийн татварын мөнгөөр бүрдсэн төсвийн хөрөнгийг явцуу хувийн ашиг сонирхолоор зарцуулагдах, мөн иргэдэд хүрэх төрийн үйлчилгээг тасалдуулах, нийгмийн зүгээс төрийн үйл ажиллагаанд итгэх итгэл, үнэмшилийг сулруулж улмаар төрийн үйлчилгээний нэр хүнд унах магадлалтай.

Нөгөө талаас Монгол Улсын Сангийн яамнаас Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулж, ил тод байдлыг хангах зорилгоор “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем”-ийг боловсруулан, “publicinvestment.gov.mn” цахим хуудас болон “төсвийн хөрөнгө оруулалт” гар утасны аппликейшнийг ажиллуулж эхэлсэн. Уг системийг нэвтрүүлснээр, санхүүжилтийн үйл ажиллагааг онлайн байдлаар түргэн шуурхай бэлтгэх, төсөл бүрээр нарийн мэдээлэл авах, орон нутаг болон салбарт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээтэй танилцах, хөрөнгө оруулалттай холбоотой хууль эрх зүй, тоон мэдээлэл болон цаг үеийн мэдээллийг авах боломж бүрдсэн байна. Системд төсвийн хөрөнгө оруулалтын аргачлалд суурилсан төлөвлөлт, санхүүжилтийн үйл ажиллагаа хэрэгжихээс гадна хөрөнгө оруулалтын мэдээллийн нэгдсэн сан төвлөрч бий болсон. Энэ нь татварын систем ил тод, нээлттэй, иргэд төсвийн хөрөнгийг хянах боломж бүрдэж байгаа эхний алхмууд гэж харж байна.

Түлхүүр үгс: Эдийн засаг, гэмт хэрэг, хөрөнгө, албан тушаалтан

Үндсэн хэсэг. Аливаа улсын цэцэглэн хөгжих, эдийн засгийн тогтвортой байдал нь иргэдийн төлж буй татвараас шууд хамааралтай байдаг. Улсын төсвийг бүрдүүлж буй гол хүчин зүйл нь татвар юм. Монгол Улсын Үндсэн хуульд заасан татвар төлөх үүргээ ёсчлон биелүүлж, эх орныхоо хөгжил, дэвшилд хувь нэмрээ оруулж буй татвар төлөгч, шинэ үеийн татварын тогтолцоог бүрдүүлэхэд иргэн бүр хувь нэмрээ оруулдаг.

Гэвч ийм эерэг хандлагаар бүрдүүлж буй улсын төсвийг дур мэдэн, зохион байгуулалттайгаар хууль бус үйлдэл ашиглан авах нь улс эх орноо төдийгүй бүх ард иргэдийг мэхэлсэн гэмт үйлдэл болохыг улс орон бүр өөрийн эрх зүйн орчноор хамгаалах, урьдчилан сэргийлэх, зохицуулах чиг үүргийг хангаж өгөөд байна.

Тиймээс гадаадын зарим улс орнуудын “Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг”-ийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг авч үзэхдээ хөрш зэргэлдээ, манай орны нийгэм-эдийн засгийн өмнөх тогтолцоотой адил, албан тушаалын гэмт хэрэгтэй хатуу тэмцэж байгаа туршлагыг нь харгалзан үзэж ОХУ, БНХАУ-ын Эрүүгийн эрх зүйн зохицуулалт, мөн хөгжиж буй орнуудын жишиг болон англо-саксоны эрх зүйн бүлийн орны төлөөлөл Энэтхэг улсын Эрүүгийн эрх зүйн зохицуулалтын сонгон авч үзлээ.

Оросын Холбооны Улсын /ОХУ/ Эрүүгийн хууль: Монгол болон Оросын Холбооны Улс /ОХУ/ социалист системээс ардчилал зах зээлийн тогтолцоонд шилжсэн сүүлийн 20 жилд аль алинд нь

нийгэм, эдийн засаг, улс төр оюун санаа, хууль эрх зүйн гүн гүнзгий өөрчлөлтүүд явагдаж хямрал шилжилтийн он жилүүдийг туулж буй өнөө үед төсвийн хөрөнгө, хувийн өмч гэх мэт өмч хөрөнгөд халдах гэмт этгээдийн тодорхой сөрөг үзэгдлийн түвшин тогтвортой өсөн нэмэгдэх хандлагатай байгааг анхааран үзэж тус тусын эрүүгийн хуульдаа Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэргийг тусгайлан хуульчилсан байна.

ОХУ-ын Эрүүгийн хууль 1996 онд батлагдан, одоог хүртэл тогтвортой хүчин төгөлдөр үйлчилж байна. 2011 онд болон 2021 онд нилээд том нэмэлт, өөрчлөлт орсон харагдаж байна. Тэр дундаа 2021 оны 08 дугаар сарын 22-нд миний судалж буй Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэгт нэмэлт өөрчлөлт орсон байна.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 30 дугаар бүлэг “Төрийн засаглал, төрийн албаны ашиг сонирхол, нутгийн өөрөө удирдлагын эсрэг гэмт хэрэг”⁵⁸ 285-293 дугаар зүйлд хуульчилж өгсөн байна.

Тус бүлгийн 285 дугаар зүйлд “Албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэрэг хуульчилсан ба 285.1-т “Төсвийн хөрөнгийг зүй зохисгүй зарцуулах гэмт хэрэг”, 285.2-т “Улсын төсвөөс гадуурх фондыг зүй бусаар зарцуулах гэмт хэрэг”, 285.3-т “Улсын бүртгэлийн санд хуурамч мэдээлэл оруулах”-ийг тус тус хуульчилан, дагаж мөрдөж байна.

285.1-т “Төсвийн хөрөнгийг зүй зохисгүй зарцуулах гэмт хэрэг”-т “Төсвийн хөрөнгө хүлээн авагч нь батлагдсан төсөв, төсвийн хуваарьлалтын мэдэгдэл, орлого, зарлагын тооцоо болон бусад баримт бичгээр тогтоосон нөхцөлийг хангахгүйгээр төсвийн хөрөнгийг зарцуулсан, их хэмжээний төсвийн хөрөнгийг хүлээн авсан бол 100 000-300 000 рубль-ээр торгох, 1-2 жилийн хугацаатайгаар цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, албадан ажил хийлгэх, 3 жил хүртэлх хугацаагаар тодорхой ажил хийлгэх эрх хасах, 6 сар хүртэлх хугацаагаар баривчлах, эсхүл 2 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэнэ” гэж хуульчилна.

“Их хэмжээний мөнгө” гэдэгт захиран зарцуулсан нийт хэмжээ нь 1500 000 рубль-ээс дээш, “онц их хэмжээ” гэдэг нь 7500 000 рубль-ээс дээш байхаар тогтоожээ.

Энэ гэмт хэргийг онц их хэмжээний хохирол учруулсан эсхүл урьдчилан тохирсон бүлэг хүмүүс үйлдсэн бол хүндрүүлж 200 000-500 000 рубль-ээр торгох, 1-3 жилийн хугацаатай цалин хөлс, бусад орлогоор торгох, албадан ажил хийлгэх, эд хөрөнгө эзэмших эрхээ тодорхой хугацаагаар хасах тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг 5 жил хүртэлх хугацаагаар эрх хасах, эсхүл 10 жил хүртэл хугацаагаар хорих”⁵⁹ ял, шийтгэл оногдуулахаар хуульчилсан байна. Энэ нь 2021 онд шинээр орсон нэмэлт өөрчлөлт юм.

Хүснэгт №1

	ОХУ-ын Эрүүгийн хуулийн 285.1-р зүйл Төсвийн хөрөнгийг зүй зохисгүй зарцуулах гэмт хэрэг	Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22.8-р зүйл Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
Объект	Төсвийн хөрөнгийг зарцуулах талаар хууль, дүрэм, журам байна.	Төсвийн хөрөнгийг зарцуулах талаар хуулиар тогтоосон журам байна.
Халдлагын зүйл	Төсвийн хөрөнгө	Төсвийн хөрөнгө
Объектив тал	1. Төсвийн хөрөнгө хүлээн авагч нь батлагдсан төсөв, төсвийн хуваарьлалтын мэдэгдэл, орлого, зарлагын тооцоо болон бусад баримт бичгээр тогтоосон нөхцөлийг хангахгүйгээр төсвийн хөрөнгийг зарцуулсан, 2. Их хэмжээний төсвийн хөрөнгийг хүлээн авсан	1. Зориулалтын бусаар зарцуулсан 2. Зах зээлийн дунджаас дээгүүр үнээр эд хөрөнгө худалдан авсан 3. Нөөцлөх нэрээр хэрэгцээнээс илүү хэмжээгээр бараа бүтээгдэхүүн худалдан авч, мөнгөний эрэлтийг саатуулсан 4. Зохиомол хомсдол бий болгох замаар бараа бүтээгдэхүүн бэлтгэн

⁵⁸ http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/

⁵⁹ http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/, ОХУ-ын Эрүүгийн хууль, 1996 он.

		нийлүүлэх үнийг зориудаар өсгөсөн 5. Төрийн өмч болон төсөвт байгууллагын эд хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнээр борлуулсан 6. Улсын төсвийн болон өөрийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтад шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүн ашиглах замаар төсөвт өртгийг бүрдүүлж хөрөнгө завшсан идэвхитэй үйлдэл байна.
Хохирлын хэмжээ	“Их хэмжээний мөнгө” гэдэгт захиран зарцуулсан нийт хэмжээ нь 1500 000 рубль-ээс дээш хохирол учирсан байх	300 000 төгрөгнөөс дээш хохирол учирсан байх
Субъектив тал	Гэм буруугийн санаатай хэлбэр	Гэм буруугийн санаатай хэлбэрээр, шунахайн сэдэлттэй үйлдэгдэнэ.
Субъект	Төсвийн хөрөнгө хүлээн авагч байна.	Төсөв захирагч байна.
Санкц	100 000-300 000 рубль-ээр торгох, 1-2 жилийн хугацаатайгаар цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, албадан ажил хийлгах, 3 жил хүртэлх хугацаагаар тодорхой ажил хийлгэх эрх хасах, 6 сар хүртэлх хугацаагаар баривчлах, эсхүл 2 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэнэ	нийтийн албанд томилогдох эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасаж 5400 нэгжээс 27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Хүндрүүлэх нөхцөл байдал	- “Онц их хэмжээ” гэдэг нь 7500 000 рубль-ээс дээш хохирол учирүүлсан. - Урьдчилан тохирсон бүлэг хүмүүс үйлдсэн	Их хэмжээний хохирол учирсан /50,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг/
Санкц	200,000-500,000 рубль-ээр торгох, 1-3 жилийн хугацаатай цалин хөлс, бусад орлогоор торгох, албадан ажил хийлгэх, эд хөрөнгө эзэмших эрхээ тодорхой хугацаагаар хасах тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг 5 жил хүртэлх хугацаагаар эрх хасах, эсхүл 10 жил хүртэл хугацаагаар хорих	2-8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 285.2 дугаар зүйлд “Улсын төсвөөс гадуурх фондыг зүй бусаар зарцуулах гэмт хэрэг”-ийг “ОХУ-ын холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын төсвийг захиран зарцуулаагүй, улсын төсвөөс гадуурх сангийн хөрөнгийг дур мэдэн их хэмжээгээр захиран зарцуулсан бол 100,000-300,000 рубль-ээр торгох, 3 жил хүртэлх хугацаагаар хорих, 6 сар хүртэлх хугацаагаар баривчлах, эсхүл 2 жил хүртэл хугацаагаар хорих ял эдлүүлэхээр ял шийтгэх оногдуулна.” гэж хуульчилсан байна.

Мөн хүндрүүлэх бүрэлдэхүүнд “энэ гэмт хэргийг онц их хэмжээний хохирол учруулсан эсхүл урьдчилан тохирсон бүлэг хүмүүс үйлдсэн бол хүндрүүлж 200,000-500,000 рубль-ээр торгох, 1-3 жилийн хугацаатай цалин хөлс, бусад орлогоор торгох, албадан ажил хийлгэх, эд хөрөнгө эзэмших эрхээ тодорхой хугацаагаар хасах тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг 5 жил хүртэлх хугацаагаар эрх хасах, эсхүл 10 жил хүртэл хугацаагаар хорих”⁶⁰ ял, шийтгэл оногдуулахаар хуульчилсан байна. Энэ нь 2011 оны 7 сарын 11-нд нэмэлт өөрчлөлт оруулж энэ хүндрүүлэх нөхцөл байдлыг нэмсэн байна.

Хүснэгт №2

	ОХУ-ын Эрүүгийн хуулийн 285.2-р зүйл Улсын төсвөөс гадуурх фондыг зүй бусаар зарцуулах гэмт хэрэг	Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22.8-р зүйл Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
Объект	Улсын төсвөөс гадуурх сангийн хөрөнгийг зарцуулах талаар хууль, дүрэм, журам байна.	Төсвийн хөрөнгийг зарцуулах талаар хуулиар тогтоосон журам байна.
Халдлагын зүйл	Улсын төсвөөс гадуурх сангийн хөрөнгө	Төсвийн хөрөнгө
Объектив тал	ОХУ-ын холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын төсвийг захиран зарцуулаагүй, улсын төсвөөс гадуурх сангийн хөрөнгийг дур мэдэн их хэмжээгээр захиран зарцуулсан	- Зориулалтын бусаар зарцуулсан - Зах зээлийн дунджаас дээгүүр үнээр эд хөрөнгө худалдан авсан - Нөөцлөх нэрээр хэрэгцээнээс илүү хэмжээгээр бараа бүтээгдэхүүн худалдан авч, мөнгөний эрэлтийг саатуулсан - Зохиомол хомсдол бий болгох замаар бараа бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үнийг зориудаар өсгөсөн - Төрийн өмч болон төсөвт байгууллагын эд хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнээр борлуулсан - Улсын төсвийн болон өөрийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтад шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүн ашиглах замаар төсөвт өртгийг бүрдүүлж
Хохирлын хэмжээ	“Их хэмжээний мөнгө” гэдэгт захиран зарцуулсан нийт хэмжээ нь 1500 000 рубль-ээс дээш хохирол учирсан байх	300 000 төгрөгнөөс дээш хохирол учирсан байх
Субъектив тал	Гэм буруугийн санаатай хэлбэр	Гэм буруугийн санаатай хэлбэрээр, шунахайн сэдэлтэй үйлдэгдэнэ.
Субъект	Улсын төсвөөс гадуурх төсвийн хөрөнгө хүлээн авагч байна.	Төсөв захирагч байна.
Санц	бол 100,000-300,000 рубль-ээр торгох, 3 жил хүртэлх хугацаагаар хорих, 6 сар хүртэлх хугацаагаар баривчлах, эсхүл 2 жил хүртэл	нийтийн албанд томилогдох эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасаж 5400 нэгжээс 27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1-

⁶⁰ http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/, ОХУ-ын Эрүүгийн хууль., 1996 он.

	хугацаагаар хорих ял эдлүүлэхээр ял шийтгэх оногдуулна.	5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Хүндрүүлэх нөхцөл байдал	- “Онц их хэмжээ” гэдэг нь 7500 000 рубль-ээс дээш хохирол учирруулсан. - Урьдчилан тохирсон бүлэг хүмүүс үйлдсэн	Их хэмжээний хохирол учирсан /50,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг/
Санхц	200,000-500,000 рубль-ээр торгох, 1-3 жилийн хугацаатай цалин хөлс, бусад орлогоор торгох, албадан ажил хийлгэх, эд хөрөнгө эзэмших эрхээ тодорхой хугацаагаар хасах тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг 5 жил хүртэлх хугацаагаар эрх хасах, эсхүл 10 жил хүртэл хугацаагаар хорих	2-8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 285.3-т “Улсын бүртгэлийн санд санаатайгаар хуурамч мэдээлэл оруулах” гэмт хэргийг хуульчилсан байна. Үүнд “Улсын бүртгэлийн санд санаатайгаар хуурамч мэдээлэл оруулах, түүнчлэн баримт бичгийг санаатайгаар устгах, үйлдэх, хадгалах талаарх ОХУ-ын хууль тогтоомжийг зөрчсөн бол 80 000 рубль хүртэл торгох, 6 сар хүртэл хугацаагаар баривчлах, 5 жил хүртэлх хугацаагаар эрх хасах, 4 жил хүртэлх хугацаагаар албадан ажил хийлгэх, 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан.

Хүндрүүлэх нөхцөлд нь “урьдчилан тохирсон бүлэг байвал 6 жил хүртэлх хугацаагаар хорих ба ноцтой үр дагаварт хүрвэл 10 жил хүртэлх хугацаагаар хорино” гэж хуульчилсан байна. Энэ нь 2021 онд шинээр орсон нэмэлт өөрчлөлт юм.

Хүснэгт №3

	ОХУ-ын Эрүүгийн хуулийн 285.3-р зүйл Улсын бүртгэлийн санд санаатайгаар хуурамч мэдээлэл оруулах	Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22.8-р зүйл Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
Объект	Улсын төсвөөс гадуурх сангийн хөрөнгийг зарцуулах талаар хууль, дүрэм, журам байна.	Төсвийн хөрөнгийг зарцуулах талаар хуулиар тогтоосон журам байна.
Халдлагын зүйл	Улсын бүртгэлийн сангийн ОХУ-ын хууль тогтоомж	Төсвийн хөрөнгө
Объектив тал	Улсын бүртгэлийн санд санаатайгаар хуурамч мэдээлэл оруулах, түүнчлэн баримт бичгийг санаатайгаар устгах, үйлдэх, хадгалах талаарх ОХУ-ын хууль тогтоомжийг зөрчсөн	- Зориулалтын бусаар зарцуулсан - Зах зээлийн дунджаас дээгүүр үнээр эд хөрөнгө худалдан авсан - Нөөцлөх нэрээр хэрэгцээнээс илүү хэмжээгээр бараа бүтээгдэхүүн худалдан авч, мөнгөний эрэлтийг саатуулсан - Зохиомол хомсдол бий болгох замаар бараа бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үнийг зориудаар өсгөсөн - Төрийн өмч болон төсөвт байгууллагын эд хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнээр борлуулсан - Улсын төсвийн болон өөрийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга

		байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтад шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүн ашиглах замаар төсөвт өртгийг бүрдүүлж хөрөнгө завшсан идэвхитэй үйлдэл байна.
Хохирлын хэмжээ	Хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг.	300 000 төгрөгнөөс дээш хохирол учирсан байх
Субъектив тал	Гэм буруугийн санаатай хэлбэр	Гэм буруугийн санаатай хэлбэрээр, шунахайн сэдэлттэй үйлдэгдэнэ.
Субъект	Улсын төсвөөс гадуурх төсвийн хөрөнгө хүлээн авагч байна.	Төсөв захирагч байна.
Санкц	80,000 рубль хүртэл торгох, 6 сар хүртэл хугацаагаар баривчлах, 5 жил хүртэлх хугацаагаар эрх хасах, 4 жил хүртэлх хугацаагаар албадан ажил хийлгэх, 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ	Нийтийн албанд томилогдох эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасаж 5400 нэгжээс 27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Хүндрүүлэх нөхцөл байдал	- Урьдчилан тохирсон бүлэг хүмүүс үйлдсэн - Ноцтой үр дагавар үүссэн байх	Их хэмжээний хохирол учирсан /50,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг/
Санкц	Урьдчилан тохирсон бүлэг байвал 6 жил хүртэлх хугацаагаар хорих ба ноцтой үр дагаварт хүрвэл 10 жил хүртэлх хугацаагаар хорино	2-8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

Дээрхээс үзвэл ОХУ-ын Эрүүгийн хуульд заасан тус гэмт хэргийг нарийвчлан үйлдэл тус бүрээр хуульчилж, ялыг оновчтой байдлаар шийдсэн байна. Тухайлбал, ОХУ-ын Эрүүгийн хуульд 285.1-т “Төсвийн хөрөнгийг зүй зохисгүй зарцуулах гэмт хэрэг”, 285.2-т “Улсын төсвөөс гадуурх фондыг зүй бусаар зарцуулах гэмт хэрэг”, 285.3-т “Улсын бүртгэлийн санд хуурамч мэдээлэл оруулах” гэмт хэргүүдийг тус тусд нь хуульчилсан байна.

Төсвийн хөрөнгийг зүй зохисгүй зарцуулах гэмт хэрэгт төсвийн хөрөнгө хүлээн авагч нь батлагдсан төсөв, төсвийн хуваарьлалтын мэдэгдэл, орлого, зарлагын тооцоо болон бусад баримт бичгээр тогтоосон нөхцөлийг хангахгүйгээр төсвийн хөрөнгийг зарцуулсан үйлдлээр гэмт хэрэг төгсөхөөр хуульчилснаас гадна төсөв хөрөнгийг хүлээн авсан этгээдийн үйлдэл хийгдээгүй ч “их хэмжээний төсвийн хөрөнгийг хүлээн авсан бол” гэсэн нь уг гэмт хэргийг үйлдэл хийхээс өмнө урьдчилан сэргийлж байгаа эрх зүйн орчин бүрдүүлж өгсөн нь давуу талтай байна.

Мөн ОХУ-ын Эрүүгийн хуулийн 285.3-т “Улсын бүртгэлийн санд хуурамч мэдээлэл оруулах” гэмт хэргийг хуульчилсан байх ба үүнийг үйлдлийн аргаар нь тусд нь оруулж, “улсын бүртгэлийн санд санаатайгаар хуурамч мэдээлэл оруулах, түүнчлэн баримт бичгийг санаатайгаар устгах, үйлдэх, хадгалах талаарх ОХУ-ын хууль тогтоомжийг зөрчсөн” үйлдлийг тусд нь хуульчилж ялыг ялгамжтай оногдуулсан байна.

Энэ гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд “урьдчилан тохиролцсон бүлэг үйлдсэн” бол хүндрүүлж үзэхээр хуульчилсан нь эрүүгийн бодлогын чиг үүргийг оновчтой шийдсэн гэж харж байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын /БНХАУ/ Эрүүгийн хууль: Хятад улсын эдийн засгийн тогтвортой өсөлт болон үйлдвэржилтээс шалтгаалан эрчим хүч, түүхий эдийн эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдсээр байна. Хүн ам хамгийн олонтой Хятад улс нь дэлхийн хамгийн том эрчим хүч хэрэглэгч, мөн 2 дахь том газрын тос хэрэглэгч орон гэдэг ба мөн татварын систем, хэрэгжүүлэх механизм нь чанга орон. Өөрчлөлт, шинэчлэлтийн бодлогыг хэрэгжүүлсэн сүүлийн 30-аад жилийн турш Хятадын ДНБ жилд дунджаар 10 орчим хувиар тогтмол өсч, газрын тосны хэрэглээ нь жилд дунджаар 7,5 хувиар нэмэгдсээр, төсвийн хөрөнгө ч энэ хэрээр тогтмол өсөн нэмэгдэж байна.

Бээжин хотод болж буй Хятадын “Хоёрдугаар хурал”-ын үеэр Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Көцян Засгийн газрын ажлын тайланг танилцуулахдаа “Хятад улс энэ онд төсвийн алдагдлыг 3.2 хувь болгон бууруулж, батлан хамгаалах зардлаа 6.8 хувь болгон нэмэгдүүлж байгаа” талаар Ли Көцян Ерөнхий сайд мэдээлсэн байдаг. Энэ нь мэдээжийн хэрэг цар тахлыг амжилттайгаар хяналтад авч, үр дүнтэй хязгаарлаж байгаа болон эдийн засаг аажмаар сэргэж байгаатай холбоотой. Нөгөө талаасаа энэ нь хууль, эрх зүйн бодлого чанга хатуу байдаг нь нөлөөлдөг.

Эрүүгийн бодлогын хувьд ял шийтгэл болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс гэмт хэргийн нөхцөл байдлын үндсэн дээр гэмт үйлдэл, гэмт этгээдийн хариуцлага, холбогдох арга хэмжээг хэрэглэх эрх баригч намын төрийн хувьд стратеги юм. БНХАУ-ын эрүүгийн бодлого өөрчлөн байгуулах, хувийн хэвшлийн эрх ашгийг хамгаалах, ач холбогдол эхэлсны дараа 1992 онд төрийн эрх мэдлийг хамгаалах, Монгол Улсын эрүүгийн бодлого чиглэсэн.

Монгол, Хятад нь сайн хөршийн, найрсаг улс орон байдаг нийтлэг түүх, соёл, мөн улс төрийн системтэй байсан гэдэг ч сүүлийн 30 жилд хоёр орны улс төр, эдийн засаг, хууль эрх зүйн, соёлын салбарт чухал өөрчлөлтүүд гарч байна.

Тухайлбал, хууль эрх зүйн системийн байгууллагын ялгаа нь илүү их, илүү ач холбогдолтой болж байна.

Улсын өмчлөлийн үйлдвэр аж ахуйн ажил үйлсийн нэгж /Төсвийн байгууллага/-ийн үйл ажиллагааны ашиг сонирхолыг зөрчсөн гэмт хэргийн Эрүүгийн хуулийн 165-169-р зүйлд таван гэмт хэргийг тодорхойлсон байдаг ба үүнээс Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22.8-р зүйлд заасан “Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах” гэмт хэргийн олон шинжийг агуулсан зүйлийг харьцуулбал гэмт хэргийг үйлдэх аргуудыг тодорхой заасан байдаг.

Хүснэгт №4

	БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 166-р зүйл	Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22.8-р зүйл Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
Объект	Улсын өмчийн компани, аж ахуйдал, ажил үйлсийн нэгжийн хэвийн үйл ажиллагаа, улс орны ашиг сонирхол, халдлагын зүйл нь улсын өмчлөлийн компани, аж ахуйдал, байгууллагын нэгжийн ажил, таваар	Төсвийн хөрөнгийг зарцуулах талаар хуулиар тогтоосон журам байна.
Халдлагын зүйл		Төсвийн хөрөнгө
Объектив тал	1. Өөрийн нэгжийнхээ олзвортой тухайлсан ажлыг өөрийн дотны найздаа өгч эзэгнүүлсэн байвал 2. Зах зээлийн үнээс илт дээгүүр үнээр өөрийн дотны найзынхаа эзэгнэн хамаарч байгаа нэгжээс таваар худалдан авсан буюу зах дэлгүүрийн доогуур үнээр дотны найзынхаа эзэгнэн байгаа нэгжид таваар борлуулсан 3. Өөрийн дотны найзынхаа эзэгнэн хамаарч байгаа нэгжээс хэр тэнцэхгүй таваар худалдаж авсан байвал	- Зориулалтын бусаар зарцуулсан - Зах зээлийн дунджаас дээгүүр үнээр эд хөрөнгө худалдан авсан - Нөөцлөх нэрээр хэрэгцээнээс илүү хэмжээгээр бараа бүтээгдэхүүн худалдан авч, мөнгөний эрэлтийг саатуулсан - Зохиомол хомсдол бий болгох замаар бараа бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үнийг зориудаар өсгөсөн - Төрийн өмч болон төсөвт байгууллагын эд хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнээр борлуулсан - Улсын төсвийн болон өөрийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтад шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүн ашиглах замаар төсөвт

		өртгийг бүрдүүлж хөрөнгө завшсан идэвхитэй үйлдэл байна.
Хохирлын хэмжээ	Улс орны ашиг тусад их хохирол учруулсан байвал	300 000 төгрөгнөөс дээш хохирол учирсан байх
Субъектив тал	Гэм буруугийн санаатай хэлбэрээр, шунахайн сэдэлттэй үйлдэгдэнэ.	Гэм буруугийн санаатай хэлбэрээр, шунахайн сэдэлттэй үйлдэгдэнэ.
Субъект	Улс үндэслэлийн компани, аж ахуйдал, ажил үйлсийн нэгжийн ажилтан үүрэг тушаалын байдлаа ашиглан	Төсөв захирагч байна.
Санки	3 жилээс дээш хугацаатай хорих буюу хорьж хөдөлмөрлүүлэхээр шийтгээд зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэх буюу дангаар шийтгэнэ.	Нийтийн албанд томилогдох эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасаж 5400 нэгжээс 27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Хүндрүүлэх нөхцөл байдал	Улс орны ашиг тусад онцгой их хохирол учруулсан байвал	Их хэмжээний хохирол учирсан /50,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг/
Санки	3 жилээс дээш 7 жилээс доош хугацаатай хорих буюу хорихоор шийтгээд, зоосоор яллахад нийлүүлэн шийтгэнэ.	2-8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

Дээрхээс үзвэл БНХАУ-ын Эрүүгийн хуульд улс орны эд хөрөнгийг үрэгдүүлэх шинжийг тодорхой заасан ба МУ-ын Эрүүгийн хуульд завшсанаас гэж заасан байгаа боловч үрэгдүүлэх шинжийг заасан үйлдлүүдийг хуульчилсан байгаа нь харагдаж байна. Төсвийн хөрөнгө, төрийн өмч нь өмчлөлийн хэлбэрийн хувьд үл хамаарах төсөв захирагчийн үйл ажиллагаанаас хохирол учирч байгаа учир нь энэ нь үрэгдүүлж байгаа хэлбэр юм.

Гэвч БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 166-р зүйлд өөрийн дотны найзынхаа эрх ашгийн төлөө уг үйлдлийг хийсэн байхаар хуульчилсан нь учир дутагдалтай байгаа ба энэ нь гагцхүү найз нөхөдийн хүрээлэлийн бус бусад харилцааны этгээдүүдийн эрх ашгийн төлөө дээрх аргуудаар улсад хохирол учруулсан байж болохыг хуульчилж өгөөгүйд оршино.

Санкцын хувьд БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 166-р зүйлд заасан хариуцлага нь хүнд бөгөөд торгох ялыг нэмэгдэл шинжтэйгээр заавал хэрэглэсэн байхаар заасан байна.

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 167-р зүйлд улсын өмчлөлийн компани аж ахуй, ажил үйлсийн нэгжийн шууд хариуцлагатай эрхлэн хамаарагч гэрээ тогтоох, гэрээг гүйцэтгэх явцад хариуцлагаа хүнд ноцтой алдсанаас болж мэхлэгдээд улсын ашиг тусад хүнд их хохирол учруулсан байвал мөн адил хариуцлага хүлээлгэхээр заасан. Мөн 168-р зүйлд: дээрхи субъект нь хувийн найраар гэм үйлдэж улсын өмчлөлийн компани, аж ахуйллыг дампууруулсан буюу хүнд ноцтой алдагдалтай болгоод улсын ашиг тусад хүнд их хохирол учруулсан⁶¹ бол Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилж гэмт хэрэгт тооцсон байдаг нь албан тушаалтан илтэд хохирол учруулах гэрээг байгуулсны улмаас хохирол учрах үйлдлийг гэмт хэрэгт тооцсоноороо дэвшилттэй ба МУ-ын Үндэсний аудитын газрын аудитын дүгнэлтэд гэрээний нөхцлийг улсын байгууллага, төрийн өмчит аж ахуй нэгжийн зүйгээс илэрхий хохирол хүлэхээр байгуулсан зөрчил дурьдаж зөвлөмж өгсөн байдаг зэргээс үзвэл ийм үйлдэл гарч байгааг харуулж байна.

Мөн БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 8-р бүлэгт “Шамшсан хээл хахууль идсэн ял” хэрэгт 384-р зүйл. Төрийн ажилтан үүрэг тушаалын байдлыг ашиглан албаны зоосыг аминдаа нүүлгэж хэрэглэж хууль бус ажиллагаа хийсэн, эсхүл албаны зоосыг нүүлгэж хэрэглэсэн тоо нь нилээд их буюу бүгд 3 сар

⁶¹ Батзориг.Б Зууннасан.Э “БНХАУ-н Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль” орчуулга УБ.2006. 46 дахь тал

хэтэртэл үйл буцаасан байвал албаны зоосыг нүүлгэн хэрэглэсэн ялд тооцож, 5 жилээс доош хугацаатай хорих буюу хорьж хөдөлмөрлүүлэхээр шийтгэнэ” гэж хуульчилсан байгаа нь төсвийн хөрөнгийг түр хэрэглэсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцсон байгаа нь харагдаж байна. Энэ гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг: Үйл байдал нь хүнд ноцтой байвал 5 жилээс дээш хугацаатай хорихоор шийтгэнэ. Албаны зоосыг нүүлгэн хэрэглэсэн тоо нь лут их бөгөөд үл буцаасан байвал, арван жилээс дээш хугацаатай хорих буюу хугацаагүй хорихоор шийтгэнэ.⁶² гэж хуульчилсан байна.

Онц хүндрүүлэх бүрэлдэхүүнийг: Гамшигаас тэнхрүүлэх, аюулаас аврах, үерийг сэргийлэх, тэтгэн туслах, ядууг тэтгэх ардыг нүүлгэх, асран харгалзах зоос мөнгө эд барааг асиндаа нүүлгэн хэрэглэсэн байдал хүндээр шийтгэхээр хуульчилсан нь энэ гэмт хэргийн халдлагын зүйлээр нь хүндрүүлсэн байна.

Энэ мэтчилэн БНХАУ-ын Эрүүгийн хуульд төсвийн байгууллагын төсөв, улсын үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг тус бүрт нь эрүүгийн хуулиар хамгаалсан шинжтэй гэмт хэргүүдийг зааж өгсөн байдаг байна.

Бүгд Найрамдах Энэтхэг улсын /БНЭУ/ Эрүүгийн хууль: Тус улсын Эрүүгийн хуулийн 3-р бүлгийн 8-16-р зүйлүүдэд Хээл хахуулийн гэмт хэргийн талаар заасан дотор “Төрийн албан хаагч улсын төсвөөс болон гадаадын хөрөнгө оруулагч /хандивлагч/-аас нийгмийн үйл ажиллагаанд зориулсан хөрөнгөнөөс хувьдаа ашигласан тохиолдолд 6 сараас 5 жил хүртэл хорих ял шийтгэнэ.”⁶³ гэж хуульчилсан нь энэ гэмт хэргийн халдлагын зүйл нь төсвийн хөрөнгөөс гадна гадаадын хөрөнгө оруулагчаас тухайн улс оронд үзүүлж буй зээл, тусламжийн хөрөнгө байхаар зааж өгснөөрөө онцлог байна.

Хүснэгт №5

	БНЭУ-ын Эрүүгийн хуулийн 3 р бүлгийн 8-16-р зүйлүүдэд Хээл хахуулийн гэмт хэрэг	Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22.8-р зүйл Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
Объект	Улсын өмчийн компани, аж ахуйдал, ажил үйлсийн нэгжийн хэвийн үйл ажиллагаа, улс орны ашиг сонирхол, халдлагын зүйл нь улсын өмчлөлийн компани, аж ахуйдал, байгууллагын нэгжийн ажил, таваар	Төсвийн хөрөнгийг зарцуулах талаар хуулиар тогтоосон журам байна.
Халдлагын зүйл	Төсвийн хөрөнгөөс гадна гадаадын хөрөнгө оруулагчаас тухайн улс оронд үзүүлж буй зээл, тусламжийн хөрөнгө	Төсвийн хөрөнгө
Объектив тал	Улсын төсвөөс болон гадаадын хөрөнгө оруулагч /хандивлагч/-аас нийгмийн үйл ажиллагаанд зориулсан хөрөнгөнөөс хувьдаа ашигласан үйлдэл	- Зориулалтын бусаар зарцуулсан - Зах зээлийн дунджаас дээгүүр үнээр эд хөрөнгө худалдан авсан - Нөөцлөх нэрээр хэрэгцээнээс илүү хэмжээгээр бараа бүтээгдэхүүн худалдан авч, мөнгөний эрэлтийг саатуулсан - Зохиомол хомсдол бий болгох замаар бараа бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үнийг зориудаар өсгөсөн - Төрийн өмч болон төсөвт байгууллагын эд хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнээр борлуулсан

⁶² Мөн бүтээл 107 дахь тал

⁶³ CRIMINAL LAW IN INDIAN. ARTICLE 8-12

		- Улсын төсвийн болон өөрийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтад шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүн ашиглах замаар төсөвт өртгийг бүрдүүлж хөрөнгө завшсан идэвхитэй үйлдэл байна.
Хохирлын хэмжээ		300,000 төгрөгнөөс дээш хохирол учирсан байх
Субъектив тал	Гэм буруугийн санаатай хэлбэрээр, шунахайн сэдэлтэй үйлдэгдэнэ.	Гэм буруугийн санаатай хэлбэрээр, шунахайн сэдэлтэй үйлдэгдэнэ.
Субъект	Төрийн албан хаагч	Төсөв захирагч байна.
Санкц	6 сараас 5 жил хүртэл хорих ял шийтгэнэ	Нийтийн албанд томилогдох эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасаж 5400 нэгжээс 27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Хүндрүүлэх нөхцөл байдал		Их хэмжээний хохирол учирсан /50,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг/
Санкц		2-8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

Дүгнэлт. Судалгааны хүрээнд судалсан эрүүгийн хэргүүдийн халдлагын гол зүйл нь “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө”, “Нийгмийн халамжийн нөхөн олговрын хөрөнгө” зэрэг нийгмийн халамж буюу нийгэмд чиглэгдсэн хөрөнгө байгаа нь Энэтхэгийн Эрүүгийн хууль нь зөвхөн төсвийн хөрөнгийг гэж заагаагүй нийгмийн үйл ажиллагаанд чиглэгдсэн хөрөнгө гэж заасан оновчтой хуульчилсан байгааг харуулж байна гэж үзэж байна.

Субъектын хувьд Энэтхэг улсын Эрүүгийн хуульд “Төрийн албан хаагч” гэж тусгасан нь илүү өргөн хүрээтэй нь харагдаж байна. Объектив талын хувьд “хөрөнгөнөөс хувьдаа ашигласан бол” гэж үйлдлийн аргыг нь заагаагүйгээрээ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22.8-р зүйл, БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 166-р зүйлээр ялгагдаж байгаа нь дээрхи хуульд зааснаас өөр аргуудаар үйлдэгдэж болзошгүй байдалд хариуцлага хүлээлгэхээр давуу талтай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. "Монгол Улсын Үндсэн хууль".УБ., 1992
2. "Монгол Улсын Эрүүгийн хууль". УБ., 2002
3. "ОХУ-ын Эрүүгийн хууль". М., 1996
4. БНХАУ-ын Эрүүгийн хууль".1999
5. БНЭУ-ын Эрүүгийн хууль. 200 он
6. Эртний хууль цааз болон эрүүгийн хуулинд тусгаж ирсэн харьцуулалт
7. www.education.mn сайт
8. www.judcouncil.mn сайт
9. www.legalinfo.mn сайт
10. www.meds.gov.mn сайт
11. www.shuukh.mn
12. www.consultant.ru

**МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЯНАН
ШИЙДВЭРЛЭЖ БАЙГАА АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

(Монгол улс болон Казакстан улсын жишээн дээр)

Судлаач Батсайхан Эрдэнэбат

Товч агуулга. Зөвлөлт холбоот улсын бүрэлдэхүүн, түүний нөлөөллийн бүсэд байсан Монгол улс болон Казакстан улс нь эрх зүйн шинэтгэлийг үе шаттайгаар явуулж, Эрүүгийн багц хуулиудыг шинэчлэн (2014-2017 онд) найруулсан нь, өнөөдөр хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Уг шинэчлэлийн хүрээнд эрүүгийн процессын хуулиар⁶⁴ хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгон хуульчилсан дэвшилттэй зохицуулалт болсон. Энэхүү илтгэлийн зорилго нь авлига, мөнгө угаах гэмт хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байгаа Монгол, Казакстан улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлахад оршино.

Түлхүүр үг. Эрүүгийн хууль, эрүүгийн процессын хууль, гэмт хэрэг, ял шийтгэл, хохирогч, яллагдагч, өмгөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүх, нэмэлт өөрчлөлт, эрх зүйн байдал, авлига, мөнгө угаах гэмт хэрэг.

Нэг. Оршил. Өнөөгийн даяарчлагдсан ертөнцөд улс, үндэстнүүд хоорондоо улам өргөн харилцах болж, даяаршин эдийн засаг, нийгмийн нэгдмэл орчныг бий болгон, мэдээлэл, холбооны хэрэгслээр холбогдон, хил хязгааргүй мэт орчин бүрдүүлсэн ч олон төрлийн эрдлийг дагуулж байна. Үүний нэг нь мөнгө угаах гэмт хэрэг билээ. Мөнгө угаах гэмт хэргийн улмаас санхүүгийн системийн тогтвортой байдлыг эвдээд зогсохгүй эдийн засгийн хямралд хүргэдэг нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм.

Энэ хэргийн улмаас олон улсын тавцанд дотоодын банк, санхүүгийн байгууллагуудын нэр хүнд унах, банк, санхүүгийн байгууллагаар дамжин хийгдэж байгаа гадаад гүйлгээг саатуулан шалгах, тэдгээртэй харилцахаас татгалзах хүртэлх арга хэмжээ авагдаж, хөгжингүй буурай орнуудын хувьд гадаадын хөрөнгө оруулалт зогсож, эсвэл хууль бус хөрөнгө оруулалт цэцэглэн хөгжиж, авлига, хээл хахуулыг дэвэргэн, тэр ч бүү хэл тухайн орны хөгжлийг зогсонги байдалд оруулж байдаг

Мөнгө угаах нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг эвдээд зогсохгүй эдийн засгийн хямралд хүргэдэг нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм. Энэ хэргийн улмаас олон улсын тавцанд дотоодын банк, санхүүгийн байгууллагуудын нэр хүнд унах, банк, санхүүгийн байгууллагаар дамжин хийгдэж байгаа гадаад гүйлгээг саатуулан шалгах, тэдгээртэй харилцахаас татгалзах хүртэлх арга хэмжээ авдаг нь эдийн засагт сөрөг нөлөөтэй юм⁶⁵.

Энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүд нийгмийн хөгжилтэй зэрэгцэн бүлэг, зохион байгуулалтад орж үйлдлийн арга, хэлбэр улам боловсронгуй болж техник, технологийн дэвшлийг ашиглах, гэмт хэргийн улмаас олсон орлогыг улс, орон дамжуулж шилжүүлэх, цахим орчин, крипто валют ашиглан мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах зэргээр энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдлыг хүндрүүлж байна. Энэ судалгаагаар Монгол улстай газар нутаг, зан заншил, эрх зүйн зохицуулалт ижил төстэй пост социалист орон болох Казакстан улсад Мөнгө угаах гэмт хэргийг эрүүгийн хуулиар хуульчилсан байдал болон тухайн гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж байгаа ажиллагаанд харьцуулсан судалгаа хийлээ.

⁶⁴ Казакстан улсын ЭП-ийн хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, Монгол Улсын ЭП-ийн хуулийг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж байгаа болно.

⁶⁵ Б.Энхболд нар

Хоёр. Үндсэн хэсэг. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа нь дэлхий нийтийг түгшээж, улс орнуудын эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, ядуурлыг бууруулах, нийгэмд шударга ёсыг тогтооход саад бэрхшээл болж байна. Мөнгө угаах гэмт хэргийн эх үүсвэр нь ихэнхдээ хүний наймаа, хар тамхины худалдаа, хууль бус зэвсгийн наймаа, авлигал, хээл хахууль, хилээр хууль бусаар нэвтрүүлэх, байгаль орчны эсрэг, татвараас зайлсхийх гэмт хэрэг зэрэг хууль бус үйл ажиллагаанаас олж байгаа санхүүгийн урсгал болдог. Өөрөөр хэлбэл санхүүгийн салбарыг хууль бус эх сурвалжаас олсон мөнгийг хувиргах, шилжүүлэх, терроризмын санхүүжилтийг нэг бүс нутгаас нөгөө рүү бүс нутаг руу шуурхай илгээх хэрэгсэл болгон ашиглаж байна.

Сүүлийн жилүүдэд гэмт хэрэгтнүүд санхүүгийн тогтолцоо сул хөгжсөн болон хөгжиж буй орнуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааны транзит төв болгон ашиглаж байгаа явдал нь Монгол Улсын санхүүгийн салбарын энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна⁶⁶. Энэ эрсдэл мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалт сул, хөгжингүй орнуудад нэгэн адил байна.

Монгол улсын хувьд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас анх 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр баталсан бөгөөд Эрүүгийн хуулийн 166¹ дүгээр зүйлд Мөнгө угаах гэмт хэргийг хуульчлан, өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа 2015 оны Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд "Мөнгө угаах" гэмт хэргийг хуульчилсан бөгөөд гэмт хэргийн ангиллын хувьд үндсэн шинж нь хөнгөн, хүндрүүлэх шинж хүнд хэрэгт хамаарна.

Казакстан улс Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг 2009 оны 08 дугаар сарын 28-ны өдөр хуульчлан баталж, Мөнгө угаах гэмт хэргийг эрүүгийн хуульдаа зүйлчлэн, өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа 2014 оны Эрүүгийн хуулийн 218 дугаар зүйлд "Мөнгө угаах" гэмт хэргийг хуульчилсан. Уг гэмт хэрэг нь Казакстан улсын эрүүгийн хуульд ангиллын хувьд үндсэн болон хүндрүүлэх шинж нь хүндэвтэр гэмт, онц хүндрүүлэх бүрэлдэхүүн нь хүнд⁶⁷ хэрэгт хамаарна.

Монгол болон Казакстан улсын эрүүгийн хуулиар “Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлогыг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан” үйлдэл гэж нэгэн адил зүйлчилж, хүндрүүлэх бүрэлдэхүүнийг бүлэглэн, байнга, албан тушаалын байдлаа ашиглан, гэмт бүлэглэл үйлдсэн бол гэж нэгэн адил хуульчилсан байна.

Хүснэгт №1. Монгол болон Казакстан улсын эрүүгийн хуульд “Мөнгө угаах” гэмт хэргийг зүйлчилсэн байдал, түүнд оногдуулсан хариуцлагыг харьцуулсан байдал.

Аль улсын Эрүүгийн хууль болох	Монгол Улсын Эрүүгийн хууль	Казакстан Улсын Эрүүгийн хууль
Зүйл анги	18.6 дугаар зүйл. Мөнгө угаах	218 дугаар зүйл. Гэмт хэргийн аргаар олсон мөнгө болон (эсвэл) бусад эд хөрөнгийг хууль ёсны болгох (угаах)
Ердийн бүрэлдэхүүн	Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун	Гэмт хэргийн аргаар олсон орлогыг (эсвэл) бусад эд хөрөнгийг хөрвүүлэх, шилжүүлэх хэлбэрээр гүйлгээ хийх, хууль ёсны эргэлтэд оруулах, эсхүл уг эд

⁶⁶ Засгийн газрын 2017 оны 143 дугаар тогтоол “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”

⁶⁷ Казахстан улсын Эрүүгийн хуулиар гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилдаг. Монгол Улсын Эрүүгийн хуулиар хөнгөн, хүнд гэж ялгаатай ангилдаг.

	далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	хөрөнгийг эзэмших, ашиглах, түүний жинхэнэ мөн чанарыг нуун дарагдуулах, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах эрхийг хууль ёсны болгоход зуучилсан бол гурван мянга хүртэл хэмжээний “Тенге ⁶⁸ ”-ээр торгох, эсхүл найман зуун цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах, эсвэл эд хөрөнгө хурааж, гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Хүндрүүлэх бүрэлдэхүүн	2. Энэ гэмт хэргийг: 2.1.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого болохыг мэдсээр байж; 2.2.байнга тогтвортой үйлдэж; 2.3.албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	2. Энэ гэмт хэргийг: 1) урьдчилан тохиролцсоны дагуу бүлэглэн; 2) нэг бус удаа; 3) албан тушаалын байдлаа ашиглан хүн үйлдсэн бол таван мянга хүртэл хэмжээний “Тенге”-ээр торгох, эсхүл нэг мянга хоёр зуун цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах, эсвэл эд хөрөнгө хурааж, мөн хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Хүндрүүлэх бүрэлдэхүүн	3.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	3.Энэ зүйлийн нэг, хоёрдугаар хэсэгт заасан үйлдлийг: 1) төрийн чиг үүрэг гүйцэтгэх эрх бүхий этгээд, эсвэл түүнтэй адилтгах этгээд, албан тушаалтан, төрийн хариуцлагатай албан тушаал эрхэлж байгаа хүн албан тушаалын байдлаа ашигласан үйлдсэн; 2) гэмт бүлэглэл; 3) их хэмжээний хохирол учруулан үйлдсэн бол эд хөрөнгө хураах, 1-д заасан тохиолдолд тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг бүх насаар нь хасч гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Онц хүндрүүлэх бүрэлдэхүүн	4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгж ⁶⁹ -ээс дөрвөн зуун	Байхгүй

⁶⁸ Казахстан улсын мөнгөн тэмдэгт, 1 ам.доллар 426.99 тене-тэй тэнцүү

⁶⁹ Монгол Улсын Эрүүгийн хуулийн торгуулийн хэмжүүр, 1 нэгж 1 төгрөгтэй тэнцүү бөгөөд 1 ам.доллар 2789 төгрөгтэй тэнцүү

	мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	
--	---	--

Монгол болон Казакстан улсад шинээр хүчин төгөлдөрж хэрэгжиж байгаа Эрүүгийн процессын хуулийн зорилго нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх⁷⁰ явдал бөгөөд хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгон хуульчилсан.

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь олон улс төрийн тогтолцоо, иргэний харьяаллыг үл харгалзан иргэншил, соёл, мэдээлэл, эдийн засаг, санхүү, хуулийн бодлого, иргэний нийгмийн зарчим, ялангуяа эрх зүй нийтлэгших үзэгдэл зэрэг нь улам бүр дэлхий нийтийн шинжтэй болж тэр утгаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, ялангуяа эрүүгийн процессын ажиллагааг түргэн шуурхай үр нөлөөтэй явуулах, зөрчигдсөн эрхийг сэргээх шаардлагыг нэгэнт бий болгосон.

Тодруулбал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувьд хуульд зааснаас хөнгөн ял шийтгэл хүлээнэ, мөрдөн шалгах болон хянан шийдвэрлэх ердийн хугацаа буюу хэт урт хугацаанд бус, богино хугацаанд хэргээ шийдвэрлүүлнэ, хохирогчийн хувьд учирсан хохирлоо богино хугацаанд нөхөн төлүүлнэ, шүүх хуралдаанд мэдүүлэг өгөх, хохирол төлөгдөөгүй бол давж заалдах ажиллагаан дахь зардлаас чөлөөлөгдөнө, шүүх хуралдааны ихээр хойшилдог, хэрэг нэмэлт ажиллагаа хийгдэхээр буцаагдах, шүүхийн шийдвэрийн дагуу хохирол нөхөн төлөгдөхгүй байх, хөөн хэлэлцэх хугацаа дуусаж хэрэг хэрэгсэхгүй болох зэрэг эрсдэлүүд үүсэхгүй.

Гэрч, шинжээч нарын хувьд мөрдөн шалгах ажиллагааны явцад мэдүүлэг өгсөн бол дахин шүүх дээр мэдүүлэг өгөх, шүүхийн дуудсан цагт ажлаасаа чөлөө авах, хоол, унааны зардал гаргах, заналхийлэл, нөлөөлөлд өртөхгүй байх давуу талтай. Прокурор шүүх хуралдаанд бэлтгэх болон болзошгүй шүүн таслах ажиллагаанд цаг хугацаа, хөрөнгө зарцуулахаас зайлсхийж, ялыг тохиролцдог яллах ажиллагаа, шүүх хуралдааны явцад гарах зардал хэмнэгдэж төсвийн хөрөнгө үрэгдэхгүй, урт удаан хугацааны эрүүгийн шүүх хуралдаанаас зайлсхийх боломжийг олгодог. Нөгөө талдаа шат шатны шүүхийн ачаалал буурдаг сайн талтай⁷¹.

Хүснэгт №2. Монгол болон Казакстан улсын эрүүгийн процессын хуульд хялбаршуулсан журмаар шийдэгдэх боломжтой хэргийн ерөнхий нөхцөлийг харьцуулсан байдал.

№	Год	В Монголии ⁷²		В Казахстане ⁷³		
		Шүүхээр шийдсэн хэрэг	Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэсэг	Яллах дүгнэлт үйлдэх саналтай шүүхэд шилжүүлсэн хэрэг	Шүүхээр шийдсэн хэрэг	Шүүхээр шийдсэн хэрэг ⁷⁴
1	2017	3	-	56	1	-
2	2018	20	3	72	3	-
3	2019	34	1	26	2	-
4	2020	38	-	37	-	-
5	2021	36	5	23	-	-

⁷⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйл, 2017 он

⁷¹ [Ч.Жаргалбаатар: Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэнээр ял завиших явдлыг бууруулна | Авлигатай Тэмцэх Газар \(Iaac.Mn\)](#)

⁷² Монгол Улсын Шүүхийн албан ёсны тайл Shuukh.mn-ээс авсан сүүлийн 5 жилийн судалгаа

⁷³ Официальный сайт Комитета по правовой статистики и специальным учетам Генеральной прокуратуры Республики Казахстан сведения за 5 лет <https://qamgor.gov.kz/portal/page/portal/POPageGroup/Services/Pravstat>

⁷⁴ По ст.218 УК Казахстана статистика отдельно по упрощенному делопроизводству не ведется

Монгол Улсын Эрүүгийн процессын хуульд заасны дагуу мөнгө угаах гэмт хэргийн ердийн болон хүндрүүлэх бүрэлдэхүүн (ЭХТА-ийн 18.6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг), Казакстан Улсын Эрүүгийн процессын хуульд заасны дагуу мөнгө угаах гэмт хэрэг (ЭХТА-ийн 218 дугаар зүйл) бүхэлдээ хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдэх боломжтой байна. Тухайн гэмт хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдэхийг хуульд ямар нэгэн байдлаар хязгаарлаагүй байна.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 37 дугаар зүйлд “Гэмт хэргийг үйлдэхэд оролцсон хүмүүс мөрдөн шалгах ажиллагааны явцад баримт нотолгоо мэдээллийг гаргаж өгөх, хохирлыг нөхөн төлөх зэргээр мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн бол эрх бүхий байгууллага хөхиүлэн дэмжих талаар зохих арга хэмжээ авна”, “Оролцогч улс бүр энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргийг мөрдөн шалгах буюу яллахад идэвхтэй хамтран ажиллаж буй яллагдагч этгээдийн ялыг зохих тохиолдолд хөнгөрүүлэх боломжийг олгох асуудлыг авч үзнэ”, “Оролцогч улс бүр энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргийг мөрдөн шалгах буюу яллахад идэвхтэй хамтран ажиллаж буй этгээдэд яллагдахаас чөлөөлөгдөх дархан эрхийг олгох боломжийг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн олгох асуудлыг авч үзэхийг үүрэг болгосон” нь манай улсын Эрүүгийн хуулиар авлига, мөнгө угаах гэмт хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх ажиллагааг хуульчлах үндэслэл болсон.

Гурав. Дүгнэлт. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь цаг хугацаа, зардал хэмнэх төдийгүй бүхий л үе шатанд хялбарчилсан байдлаар, чирэгдэл багатай хэргийг шийдвэрлэдэг ололттой талуудтай бөгөөд авлига, мөнгө угаах гэмт хэрэгт хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ашиглах нь үр дүнтэй зохицуулалт болсон байна гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1. Эрүүгийн хууль. УБ., 2015 он.
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2017 он.
3. Авлигын эсрэг НҮБ-ын конвенц 2003 он
4. ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлал. 2015 он
1. Уголовный кодекс республики Казахстан (с изменениями и дополнениями по состоянию на 10.01.2022 г.)
2. Кодекс республики Казахстан уголовно-процессуальный кодекс республики казахстан (с изменениями и дополнениями по состоянию на 10.01.2022 г.)
3. Закон республики Казахстан о противодействии легализации (отмыванию) доходов, полученных преступным путем, и финансированию терроризма (с изменениями и дополнениями по состоянию на 19.01.2022 г.)

МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА: ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Н.Манлайбаатар –

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн
эрхлэгч, цагдаагийн дэд хурандаа*

Товч агуулга: Мөрдөн шалгах ажиллагаа нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны ерөнхий нэршил болон хэлбэржин тогтоод байгаа нь хүчин төгөлдөр ЭХХШ тухай хуулийн нэр томъёоны тайлбар, эрдэмтэн судлаачдын бүтээл, судалааны ажилд тусгалаа нэгэнт олжээ. Иймд мөрдөн шалгах ажиллагааны нэршил, томъёолол төдийгүй түүний дотоод ухагдахуун хэрхэн өөрчлөгдөж байгааг бид уг өгүүлэлээр авч үзсэн болно.

Түлхүүр үг: мөрдөн шалгах ажиллагаа, мөрдөн байцаалт, хэрэг бүртгэлт, мөрдөн мөшгих, мөрдөн нотлох, мөрдөн байцаах, шалган шийдвэрлэх, байцаан шийдвэрлэх.

Үндсэн хэсэг. Шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоо баяжин хөгжихөд хууль зүйн шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоо боловсронгуй болж, бидний судлан буй мөрдөн байцаалт ч шинэчлэгдэн, өөрчлөгдөж, шинэ чиг хандлагатайгаар хөгжих нөхцөл нэгэнт хэлбэржин тогтоод 30 гаруй жил болжээ.

Өөрөөр хэлбэл, 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуульд зааснаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан хуулиудыг тогтоосон хуваарийн дагуу 1993 онд багтаан батлан гаргах (Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг), мөн БНМАУ-ын олон улсын гэрээг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэх асуудлыг тухайн гэрээнд заасан болзол, журмын дагуу 1993 онд багтаан шийдвэрлэх, (Зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг), хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн бүрэн шинэчлэх ажлыг 1996 онд багтаан дуусгах (Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг) зорилтыг хуульчлан тодорхойлсон⁷⁵ бөгөөд 1992 оны VII дугаар сараас 1996 оны VII сар хүртэл хугацаанд 177 хууль баталж, 144 хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан⁷⁶ нь эрүүгийн процессыг өөрчлөх үндэслэл, хэрэгцээ, шаардлагыг нөхцөлдүүлсэн билээ.

Монгол Улсын Их хурлаас 1994 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж⁷⁷ мөн оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн⁷⁸ билээ. Уг өөрчлөлт нь нийгэм, эдийн засаг, улс төрийн тогтолцооны шинэчлэл, өөрчлөлттэй уялдаатайгаар хийгдсэн бөгөөд доктор, профессор Д.Зүмбэрэлхам “манай улсын байцаан шийтгэх ажиллагаа болон тогтолцоонд мэтгэлцэх зарчмын эзлэх байр суурь улам батжиж, энэ зарчмыг шүүн таслах ажиллагааны практикт хэрэгжүүлэх эрх зүйн орчин үндсэндээ бүрдлээ⁷⁹ гэж дүгнэсэнтэй нэг байна.

Мөн доктор, профессор Б.Бат-Эрдэнэ мэтгэлцээний сонгодог хэлбэр бол мэтгэлцээний эхлэл буюу гараа нь талуудад адил байх боломжийг хангаж өгөхийг ихээхэн чухал гэж үздэг⁸⁰ гэсэн нь манай улсад тэрхүү сонгодог хэлбэр төлөвших болоогүйг илэрхийлсэн. Нэгэнт мэтгэлцүүлэн шүүх тогтолцоо ийнхүү хэлбэржиж, бүрэлдэн төлөвшсөн нь мөрдөн байцаалт, түүний эрх зүйн зохицуулалт, зорилт, мөн чанарыг дахин авч үзэх шаардлагыг бий болгосон.

⁷⁵ Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээ. Тайлан. Захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам. Нэгдсэн тайлан бэлтгэсэн: Т.Мэндсайхан нар. Уб., 2008. 5-6 дугаар тал.

⁷⁶ Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо. Олон улсын симпозиум. Хууль зүйн яам, Улсын Их хурлын тамгын газар. Эмхэтгэн хэвлүүлсэн: Ханнс – Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар. 9 дэх тал.

⁷⁷ Төрийн мэдээлэл. 1994. №5

⁷⁸ Хууль зүйн үндэсний хүрээлэн. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал. (1911-2009 он) Уб., 2012. 318-364 дүгээр тал.

⁷⁹ Д.Зүмбэрэлхам. Шүүхийн мэтгэлцээн. Уб., 2002. 17 дахь тал.

⁸⁰ Хууль сахиулахуй. Онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл. №1. Уб., 2014. 34 дэх тал.

Нэгэнт хэргийн бодит байдлыг тогтоох, мэтгэлцүүлэн шүүх тогтолцооны холимог хэлбэр манай улсын эрүүгийн процесст нутагшиж буй нь мөрдөн байцаалтад гарах аливаа шийдвэрийг талууд мэтгэлцэх замаар шийдвэрлэх, улмаар тэрхүү шийдвэрийн үндэслэлийг шүүхээс хянах процесс одоогийн ЭХХШ тухай хуульд тусгалаа олоод байна. Тухайлбал: ЭХХШ тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.20 дахь заалтад “талууд гэж шүүх хуралдааны мэтгэлцээнд тэгш эрхтэй оролцож, яллах, өмгөөлөх чиг үүргийг хэрэгжүүлэгчийг”, 13.1 дүгээр зүйлд “Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах шүүхийн шийдвэр гаргах үндэслэл”-ийн 4 дэх хэсэгт “Шүүх энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан арга хэмжээг авахад яллах талд давуу байдал олгохгүй, эсхүл шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дордуулахгүй, талуудад мэтгэлцэх боломжийг тэгш хангана⁸¹” зэргээр хуульчилжээ. Энэ нь мөрдөн байцаалтыг илүү хариуцлагатай, нээлттэй, хүний эрхийг дээдэлсэн олон улсын чиг хандлагад нийцсэн хэлбэртэй явагдах суурь нөхцөлийг бүрдүүлж байна.

Мөрдөн байцаалт нь өөрийн зорилтоо хангах чиглэлээр тодорхой ажиллагаанаас бүрдсэн цогцолбор үе шат болохын хувьд бид эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн хэд хэдэн онцлог зүйлсийг авч үзэж байна.

Хүчин төгөлдөр ЭХХШ тухай хуулийн зорилт нь “...гэмт хэргийг шуурхай бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон⁸²...” гэсэн нь эрүүгийн процессын мөрдөх чиг үүргийг тодорхойлсон агуулга илэрхийлнэ. Харин мөрдөх чиг үүрэг нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанаас бүрдсэн цогц ажиллагаа бөгөөд эдгээр нь мөн өөр өөрийн зорилтыг хэрэгжүүлнэ. Тухайлбал, ЭХХШ тухай хуулийн Гучдугаар бүлэг: “Хэрэг бүртгэлт”-ийн талаар хуульчлан бэхжүүлсэн бөгөөд энэ бүлгийн 30.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: “Мөрдөгч гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авснаас эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах хүртэл явуулж буй ... ажиллагааг хэрэг бүртгэлт гэнэ⁸³” гэж тодорхойлжээ.

Харин мөрдөн байцаалтын ажиллагааны талаар ЭХХШ тухай хуулийн Гучин нэгдүгээр бүлэг: “Мөрдөн байцаалт”-ын талаар хуульчлан бэхжүүлсэн бөгөөд энэ бүлгийн 31.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдснээс хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл хэргийн талаар нотлогдвол зохих байдлыг тогтоох зорилгоор явуулж байгаа ... ажиллагааг мөрдөн байцаалт гэнэ⁸⁴” хэмээн тодорхойлсон бөгөөд шүүхийн өмнөх шатанд гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн хуулийн этгээдийг олж тогтоон, нотлогдвол зохих байдлыг тогтооход чиглэсэн ажиллагаа болохыг илэрхийлж байна.

Хэрэг бүртгэлтийн ажиллагааны талаар бид тусгайлан судлах шаардлагатайг дээр дурьдсан тул мөрдөн байцаалтын зорилт, хэм хэмжээний талаар хууль тогтоогчийн үзэл баримтлал, хүсэл зориг юунд чиглэж байсан талаар авч үзэх нь зүйтэй.

Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэн нь мөрдөн байцаалт эхлэж байгааг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, мөрдөн байцаалт нь гэмт хэрэг илэрсний дараа явагдах ажиллагаа болохын хувьд нотолгооны зүйлийг тогтооход чиглэсэн байдгаараа онцлогтой. Бид нотлогдвол зохих байдлын тухай авч үзсэн.

Уг үзэл баримтлал, хэм хэмжээ нь 2013 оноос эхлэсэн Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд боловсрогдсон бөгөөд “мөрдөн байцаалт”-ын агуулгыг өөрчлөх, уг ажиллагааг явуулах албан тушаалтныг “мөрдөгч” гэж нэрлэх, түүнчлэн “байцаах” гэдэг үгнээс татгалзах, улмаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах арга, хэлбэрийг нэмэгдүүлэх, мөрдөгч бие даан явуулах мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын зөвшөөрлөөр явуулах мөрдөн шалгах ажиллагааг тодорхойлох, прокурорын зөвшөөрлийг тогтолцоог нарийвчлан тусгах, мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн болох баримт, мэдээллийн

⁸¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694>

⁸² Төрийн мэдээлэл. 2017. №23. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. дугаарт хэвлэгдсэн.

⁸³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Дурьдсан бүтээл. Мөн тэнд.

⁸⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Дурьдсан бүтээл. Мөн тэнд.

талаар мөрдөгч магадлагаа үйлдэж мөрдөн шалгах ажиллагааны дүнг прокуророор баталгаажуулах⁸⁵ зэрэг үзэл санааг тууштай дэмжсэн билээ. Түүнчлэн, мөрдөн шалгах нууц ажиллагааг Улсын Ерөнхий прокурор, түүнээс эрх олгосон прокурор хяналт тавихаар хуульчилсан нь өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байна.

Хууль тогтоогчоос мөн гол анхаарлаа хандуулж байсан зүйл бол мөрдөн байцаалтыг явуулах албан тушаалтанд хялбар, амар байх нь зохисгүй гэж үзэж байсантай холбоотой асуудал бөгөөд энэ нь хуульд тусгалаа олсон билээ. Өөрөөр хэлбэл, мөрдөгч мөрдөн байцаалт явуулахад хүний эрхийг хязгаарлах буюу хүний халдашгүй эрхэд халдах тодорхой ажиллагаа явуулах бүрт прокурор, шүүхээс хянаж байхаар зохицуулсан явдал юм. Энэ нь тухайн үеийн улс төрийн нийтлэг хүсэл зориг болж байсан тул мөрдөх албадын төлөөлөл, эрдэмтэн судлаачид мөрдөн байцаалтыг бүхэлд нь прокурор чиглүүлж байх зохицуулалтыг тухайн үед төдий л эсэргүүцээгүй билээ.

Ийм ч учраас мөрдөн байцаалтын зорилтыг нотолбол зохих байдлыг тогтооход чиглэсэн ажиллагаа болгож, гэмт хэргийг ирлүүлэх зорилтыг уг ажиллагааны явцад мөрдөгч хэрэгжүүлэхгүй байхыг хуульчилсан байна. Энэ нь хэрэг бүртгэлт явуулах эрх бүхий мөрдөгч /хуучнаар эрүүгийн төлөөлөгч, хэсгийн төлөөлөгч/-ийг хэрэг бүртгэлтийн ажиллагааг хангалттай, бүрэн дүүрэн, шуурхай явуулах төдийгүй хэргийг илрүүлж, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг эргэлзээгүй тогтоох, хуульд заасан бүхий л арга хэрэгслээр тодорхой ажиллагаа явуулахыг илэрхийлсэн ойлголт билээ.

Нөгөөтэйгүүр, хэрэг бүртгэлт бүрэн дүүрэн, хангалттай, эргэлзээгүй явагдсан байх нь нотлогдвол зохих байдлыг эрх бүхий мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэн магадлах, шалгах, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах замаар нотлон тогтоох нөхцөлийг бүрдүүлсэн. Гэсэн хэдий ч өнөөгийн практикт үүссэн хүндрэл нь мөрдөгчийн бие даасан, хараат бусаар ажиллах нөхцөлийг үгүйсгэсэн⁸⁶ гэж үзэж байгаа нийтлэг хүсэл зориг илэрхийлэгджээ.

Мөрдөн байцаалтын зорилтыг хангахад мөрдөгчийн бие даасан хараат бусаар ажиллах нөхцөл боломж нь ажлын үр дүнд шууд нөлөөлнө. Энэ нь мөрдөгч бие даан шийдвэр гаргах боломжийг хуулиар олгох явдал юм. Гэтэл эрүүгийн процессын хөгжлийн нийтлэг чиг хандлагаас үзвэл *due process of law*⁸⁷ буюу зүй зохист эрх зүйн хөгжлийн баримжаатай хөгжих нь гарцаагүй болжээ. Өөрөөр хэлбэл, мөрдөн байцаалт хуульд заасан үндэслэл, журмын дагуу, аливаа зөрчилгүй, шударгаар явагдсан байх, түүнчлэн аливаа шийдвэрийг гаргахдаа талуудын оролцоонд үндэслэн гаргах, гарч буй аливаа шийдвэр хянагдах /шүүх, прокурор/, үе шатуудыг алгасахгүй байх зэрэг шинжээр илэрдэг.

Уг нөхцөл байдал нь нэгэнт мөрдөн байцаалтад нэвтрээд байгаа нь бидний судалгааны ажлаар бататгадаж байна. Тухайлбал, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн хөгжлийн замналаар үндсэндээ замнасан 1949 оны ЭБШ хуулиас 2017 оныг хүртэлх 70 орчим жилийн хугацаанд мөрдөн шүүх тогтолцоо давамгайлсан хэлбэртэй процесс хөгжсөн. Гэхдээ мэтгэлцүүлэн шүүх тогтолцоог огт үгүйсгэхгүй бөгөөд 1994 оны ЭБШ хуульд оруулсан нэмэлт нь хэлбэрийн хувьд мэтгэлцээний үндсэн дээр шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлсэн билээ.

Эрүүгийн процессын хөгжлийн чиг хандлага нь “байцаан шийтгэх” нэр томъёоноос татгалзаж “хянан шийдвэрлэх”, “мэтгэлцүүлэн шийдвэрлэх”, “шалган шийдвэрлэх” гэсэн чиг хандлагатай хөгжиж эхлээд байна.

“Байцаан шийтгэх” агуулга нь 1992 оноос өмнөх социалист нийгмийн тогтолцоонд тохирох шинжтэй буюу ардчилсан улсад уг нэр томъёог хэрэглэх нь төдий л зохимжтой биш гэж зарим улс төрч,

⁸⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулга. Хууль зүй, дотоод хэргийн яам. 2015. Монгол Улсын Засгийн газарт өргөн барьсан эх хувиас оруулсан болно.

⁸⁶ Хууль зүй, дотоод хэргийн яамнаас практик байгууллагуудаас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар авсан саналын материалаас. Ялангуяа Цагдаагийн байгууллагын Мөрдөн байцаах алба, Авлигтай тэмцэх газар, Тагнуулын Ерөнхий газар зэргээс ирүүлсэн саналуудаас үзвэл “мөрдөгч” тодорхой ажиллагааг бие даан явуулах, прокурорын зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх, бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх, тодорхой шийдвэрийг мөрдөгч өөрөө гаргаж, үүсэх эрх зүйн үр дагаврыг хариуцдаг байх зэргээр нийтлэг давтагдсан санал ирүүлсэн.

⁸⁷ *Зохист эрх зүйн* тухай үзэл санаа нь XIII зуунд Английн Магна Хартад бодитойгоор бэхжсэн гэж үздэг. Орчуулагч П.Амаржаргал. Магна Харт. Уб., 2016. 28 дахь талд 39 дүгээр зүйлийг үзнэ үү.

хууль зүйн эрдэмтэн, судлаачид үзэл санаагаа илэрхийлж байсан⁸⁸ нь эрүүгийн процессын суурь үзэл баримтлал, үнэт зүйлийг шинэчлэх эхлэл болсон билээ.

Бидний үзэж байгаагаар 2002 оны ЭБШ хууль нь хэдийгээр социалист агуулгатай биш боловч зорилго, үе шат, хэрэгжих аргын хувьд яллах процедур бүхий байцаалт, мөрдөлт шийтгэх үйл явцыг зохицуулсан гэж үзэх хандлага судлаачдын дунд давамгайлах болсон⁸⁹ гэсэнтэй санал нийлэхгүй байгаа билээ. Өөрөөр хэлбэл, 2002 оны ЭБШ хууль 15 жил үйлчлэхдээ мөрдөн байцаалтыг бүхэлд нь гагцхүү ЭБШ хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах зохицуулалтыг, мэтгэлцэх зарчимтай хамтатган хуульчилсан билээ.

Энэ нь мөрдөн байцаалтыг хууль ёсны төдийгүй, шударга ёсны тогтолцоонд шилжүүлсэн томоохон түлхэц болсон. Өөрөөр хэлбэл, 1963 оны эрүүгийн процесс нь хэдийгээр хүний халдашгүй эрхийг бататгасан, нотлох баримт, нотлох ажиллагааг хэлбэржүүлсэн, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхэд прокурорын хяналтанд хэрэглэх, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн ажиллагааг харилцан чиг үүргийн хувьд ялгаж өгсөн хэдий ч хорьж мөрдөх шинжтэй байжээ. Тухайлбал, 1963 оны ЭБШ хуулийн 94 дүгээр зүйлийн гарчиг “Цагдан хорих” гэсэн томъёололтой хэдий ч 95 дугаар зүйлийн гарчигт “Хорьж мөрдөх хугацаа⁹⁰” гэсэн томъёолол хэрэглэсэн нь бидний үзэж байгаагаар уг процесс “социалист эрх ашгийг хамгаалахын тулд мөрдөн байцаалтыг хорьж мөрдөх” гэсэн агуулгыг хуульчлан бэхжүүлсэн байжээ гэж үзэх үндэслэлийг бүрдүүлж байнса. Үүнийг 2002 оны ЭБШ хуулиар халж, сэжигтнийг баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг шүүгчийн зөвшөөрлөөр авдаг болжээ.

Мөрдөн байцаалтын агуулга нь яллах шинжтэй явагддаг ажиллагаа бөгөөд цаашид улам бүр эрх зүйн зохицуулалтын хувьд боловсронгуй болгох шаардлага түүхэн эх сурвалжаас тодорхой байна. Иймд үзэл сэтгэлгээний хувьд мөрдөн байцаалтыг яллах ажиллагаа бус төвийг сахисан /нейтраль/, идэвхитэй ажиллагаа болгохыг зорих шаардлагатай. Энэ нь хүчин төгөлдөр эрүүгийн ЭХХШ тухай хуульд тодорхой хэмжээнд тусгалаа олж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд мөрдөн байцаалт, мөрдөн байцаалтын ажиллагаа, мөрдөн шалгах ажиллагаа зэрэг нэр томъёогоор хуульчлагдсан боловч зарим судлаачдын дунд эдгээр нэр томъёог цэгцлэх шаардлагатай байгааг ном, бүтээлдээ дурьджээ. Тухайлбал, судлаач Х.Нямбаатар, доктор Т.Оюунчимэг нарын “Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаа⁹¹” бүтээл нь мөрдөн байцаалтад тулгуурласан процесс болохыг авч үзсэн байна.

Уг бүтээлд “эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа” гэсэн ойлголттой хамт “эрүүгийн хэрэг шүүхэд хянан хэлэлцэх ажиллагаа” хэмээх нэр томъёог хууль зүйн салбарт хэрэглэдэг гээд хэл зүйн үүднээс авч үзвэл, эдгээр нь ижил ойголт бус, учир нь “эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа” гэдэгт эрүүгийн хэрэг шалгах, хянах, шийдвэрлэх, шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаа бүхэлдээ багтана⁹² гэсэн нь бидний яллах шинжтэй процесс бөгөөд мөрдөн байцаалт голлох байр суурьтай гэсэн агуулгыг илтгэж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх гэсэн нэр томъёоны агуулга нь шүүхийн үе шатыг илэрхийлдэг, шүүхийн бүхий л үйл ажиллагаа гэсэн үндэслэл бүхий тайлбарыг бидэнд санал болгосон байна. Үүгээрээ эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа гэсэн гэвэл шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлдэг мөрдөн шалгах ажиллагаа мөн багтаж байгааг илэрхийлж байна⁹³ гэсэн дүгнэлт хийжээ. Бид уг дүгнэлттэй агуулгын хувьд санал нийлж, дэмжиж байгаа хэдий ч хууль

⁸⁸ Д.Баярсайхан. Эрүүгийн процессын эрх зүй. Уб., 2014. 17 дахь тал. Мөн 2012-2014 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллаж байсан Х.Тэмүүжин уг үзэл санааг тууштай дэмжиж, хууль зүйн шинжлэх ухааны нэр томъёонд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж улс төрийн хүсэл зоригоо тууштай илэрхийлж байсан билээ.

⁸⁹ Д.Баярсайхан. Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын шинэтгэлийн асуудлууд. Уб., 2019. 259-260 дахь тал.

⁹⁰ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал. (1911-2009 он) Хууль зүйн үндэсний хүрээлэн. Уб., 2012 он. 219-220 дугаар тал.

⁹¹ Т.Оюунчимэг нар. Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаа. Уб., 2020. 9 дэх тал.

⁹² Дурьдсан бүтээл. Мөн тэнд.

⁹³ Т.Оюунчимэг нар. Дурьдсан бүтээл. 10 дахь тал.

тогтоомжийг эрх зүйн эх сурвалжийн хувьд шууд утгаар хэрэглэх зүй ёсны шаардлагаар онолын хувьд гарцаагүй авч үзэх ёстой, судалгаа шинжилгээг эрүүгийн процессын тэр дундаа мөрдөн байцаалт дахь нэр томьёог боловсронгуй болгох чилэлээр эрчимжүүлэх шаардлагатайг илэрхийлнэ.

Дүгнэлт. Мөрдөн байцаалтын агуулга нь сүүлийн 100 гаран жилийн турш тодорхой төрлийн гэмт хэргийг илрүүлэх, нотлох, шүүхэд хэргийн гэрч, баримтыг бүрдүүлж өгөх, яллах болон цагаатгах нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх талаар хуульчлан бэхжүүлж ирсэн нь эрх зүйн зохицуулалтын хувьд дэлхий нийтийн чиг хандлагаас гажаагүйг илэрхийлэх онцлогтой юм байна.

Энэ нь монголчуудын хууль бүтээх өндөр соёлтойг илэрхийлэх хэдий ч хэрэглэх, хэрэгжүүлэх явцад алдаа, нуглаа гаргадаг байдлыг судалгааны ажлаар баталсан. Тийм ч учраас эрүүгийн хэрэгт хийж буй мөрдөн байцаалт нь эрх зүйн зохицуулалтын хувьд өнөөдөр ч нотолбол зохих байдлуудыг тогтооход чиглэсэн байгаагаараа уламжлал хадгалсан боловч, мөрдөн байцаалтын шатанд эрх зүйн хэм хэмжээний зөрчил гарч байгааг анхаарах шаардлага одоо ч байгаа нь илэрхий байна.

Мөрдөн шалгах ажиллааны хөгжлийн чиг хандлага нь түүхийн асар өргөн судлагдахуунтайг харгалзан цаашид судалгааг нарийвчлан тодорхойлох шаардлагатай болжээ. Мөрдөн шалгах ажиллагаанд үеэс үед хүний эрхийг хангах, баталгааг бүрдүүлэх, шинжлэх ухаанч байхыг аль болох нэвтрүүлж ирсэн хэдий ч хүн төрөлхтний өмнө тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд түүний хэм хэмжээ, чиг үүрэг тодорхой хэмжээнд хоцорч байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Мөрдөн байцаалтын агуулгын уламжлалт болон өнөөгийн тогтсон хандлагаас өөрөөр авч үзэх зүй ёсны шаардлага байна. Энэ нь амьдралд бататгагдсан бөгөөд яллах байр суурьтай мөрдөн шалгах ажиллагааг төвийн сахисан мөрдөн шалгах ажиллагаа болгох. Үүний тулд мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй өнөөгийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг авч үзэх замаар шүүхийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах нэгжийг байгуулах.

2. Үндэсний мөрдөх албыг байгуулахад чиглэсэн улс төрийн шийдлийг шуурхай бүрдүүлэхэд мөрдөх албадууд нэгдсэн байр суурьтай байж, үзэл санааны хувьд төдийгүй тус тусын байгууллагын эрх ашгаас улс үндэстний эрх ашгийг нэн түрүүнд авч үзэх замаар байгуулах талаар санаачлага гаргах шаардлагатай. Үүний тулд, Хууль зүй, дотоод хэргийн яамны ажлын хэсэг, Хууль зүйн байнгын хороо, УИХ-ын тодорхой гишүүдэд ойлгуулах замаар шуурхайлах нь зүйтэй.

3. Мөрдөгч бэлтгэх тогтолцооны хувьд багшийг бэлтгэх тухай дахин авч үзэх хэрэгцээ, шаардлага үүссэн нь илэрхий болжээ. Учир нь бидний бэлтгэсэн төгсөгчдийн мэдлэг, ур чадвар төдийгүй хандлага ч мөрдөн шалгах ажиллагааг яллахын тулд явуулдаг мэтээр ойлголцж байгаа нь /үе үеийн төгсөлтийн шалгалтуудын үнэлгээ/ анхаарал татаж байна. Иймд бид хөтөлбөрийн агуулгыг багшийн заах арга зүйд нийцүүлэх бус хөтөлбөрийн агуулгад багш өөрөө нийцэх тухай шаардлага тавих боломж бүрдэх юм.

4. Мөрдөн шалгах ажиллагааны хөгжлийн чиг хандлага нь улс дотохи асуудлыг шийдвэрлэх бус хүн төрөлхтний өмнө тулгамдсан асуудлыг зохицуулах, шийдвэрлэхэд онцгой учир холбогдолтой болон хөгжиж байгаа нь эрүүгийн процесс дахь шүүхийн өмнөх шатны тогтолцоог дахин боловсруулах шаардлагыг бүрдүүлсэн. Иймд судлаачид энэ чиглэлд анхаарлаа хандуулахыг санал болгож байна.

Ашигласан материал

1. Д.Баярсайхан. Эрүүгийн процессын эрх зүй. УБ., 2014.
2. Д.Баярсайхан. Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын шинэтгэлийн асуудлууд. УБ., 2019.
3. Д.Зүмбэрэлхам. Шүүхийн мэтгэлцээн. УБ., 2002.
4. Орчуулагч П.Амаржаргал. Магна Харт. УБ., 2016.
5. Т.Оюунчимэг нар. Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаа. УБ., 2020.

6. Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээ. Тайлан. Уб., 2008.
7. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал. (1911-2009 он) Хууль зүйн үндэсний хүрээлэн. Уб., 2012 он.
8. Төрийн мэдээлэл. 1994. №5
9. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал. (1911-2009 он) Уб., 2012.
10. Хууль сахиулахуй. 2014. №1.
11. Төрийн мэдээлэл. 2017. №23
12. Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо. Олон улсын симпозиум. Хууль зүйн яам, Улсын Их хурлын тамгын газар. Эмхэтгэн хэвлүүлсэн: Ханнс – Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар.
13. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулга. Хууль зүй, дотоод хэргийн яам. 2015.
14. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694>

МОНГОЛ УЛС ДАХ МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ КОНВЕНЦИ

Н.Бадраа

*Цагдаагийн сургуулийн
ЭПЭЗТ-ийн ахлах багш,
цагдаагийн дэд хурандаа*

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд Монгол Улс дахь мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, олон улсын гэрээ, конвенцид нийцүүлсэн байдал, мөн гадаадын зарим улс орнуудын эрх зүйн зохицуулалтад тусгагдсан байдлын талаар товч авч үзсэн болно.

Түлхүүр үг: Мөнгө угаах, хууль эрх зүйн зохицуулалт, олон улсын туршлага тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам.

Үндсэн хэсэг: Гэмт хэргийн улмаас олсон орлого, хөрөнгө мөнгийг мэдсээр байж авсан, ашигласан, эзэмшсэн үйлдлийг Монгол улсын эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлд “Мөнгө угаах” гэж томъёолсон байдаг.

Монгол Улсын Эрүүгийн хуульд “Мөнгө угаах” (ЭХ-ийн 18.6 дугаар зүйл) гэж ерөнхий оноосон нь учир дутагдалтай юм. Учир нь, уг зүйл ангийн агуулга хэсэгт: “Хууль бусаар олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан...” (ЭХ-ийн 18.6.1 18.6.2 дахь хэсэг)⁹⁴ гэж тухайн гэмт хэргийн үйлдлийн халдлагын зүйлийг тодорхой зааж өгсөн байгаа нь тухайн зүйл ангийн ерөнхий нэрийн оноолт болон агуулгатай зөрчилдөхөд хүргэж байна.

Мөн Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд хохирлын хэмжээг тодорхой зааж өгөөгүйгээс практикт хулгайн эд зүйл худалдан авсан этгээдийг мөнгө угаах гэмт хэргээр хуулийн хариуцлага хүлээлгэх нөхцөл байдал үүссэн байна.

Гэтэл энэ хэргийн онцлог нь бүлэг зохион байгуулалттайгаар их хэмжээний хууль бус хөрөнгө мөнгө, орлогыг хууль ёсны болгох ажиллагаа явуулж буй байдгаар илэрдэг онцлогтой.

Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг зөв тодорхойлсон байх ёстой. Гэтэл энэ гэмт хэргийн онцлог шинжийг зөв тодорхойлоогүй буюу ахуйн шинжтэй гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт хэргээс ялгаагүй зэрэг нь хууль эрх зүйн зохицуулалт болон зүйлчлэлийн хувьд асуудал тулгарч байгаа юм. Эрүүгийн хуульд бие хүн өөрөө мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага оногдуулах эсэхийг тодорхой зааж өгөөгүй байна.

Үүнээс үзэхэд энэ төрлийн гэмт хэргийн талаарх ойлголт, түүний мөн чанар нь онол, практикийн хүрээнд цогц судлагдаагүй байна гэж үзэж болохоор байна.

Иймд уг тулгамдсан асуудлыг гадаадын зарим орны хуримтлуулсан туршлага болон олон улсын эрх зүйн чиг хандлагатай уялдуулан судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Мөнгө угаах гэмт хэрэгтэй хийх тэмцлийн нэг хэлбэр нь эрүүгийн ялын бодлого юм. Энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах ял, хариуцлагын хувьд бусад улс оронтой харьцуулан авч үзэхэд ял шийтгэл хөнгөн байгаа бөгөөд уг гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинжид нийцсэн ялын бодлогыг хуульчлах шаардлагатай. Учир нь гэмт хэрэгт оногдуулах ял хариуцлагын төрөл, хэмжээ хязгаар олон улсын жишигтэй харьцуулахад харьцангуй хөнгөн байгаа юм.

2015 оны Эрүүгийн хуулиар хуулийн этгээдийг гэмт хэргийн субъектээр тооцож, оногдуулах ялыг чангатгасан нь олон улсын жишигт нийцсэн зохицуулалт болжээ. Одоогийн мөрдөж буй Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд ямар төрлийн үйл ажиллагаа явуулж байгаагаас үл хамааран тодорхой

⁹⁴ Төрийн мэдээлэл. 2016. №21. Монгол Улсын Эрүүгийн хууль.

төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж, торгох ял оногдуулж байна. Дан ганц хуулийн этгээдийг торгоод өнгөрөх бус тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтнуудад мөн ял оногдуулна.

Мөнгө угаах гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг дүгнэхэд 2014 онд Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр ердийн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнээр үйлдэгдэх тус гэмт хэрэгт торгох, хорих ялуудын аль нэгийг үндсэн ялаар, эд хөрөнгө хураахыг нэмэгдэл ялаар хэрэглэхээр зааж байсан бол 2015 оны Эрүүгийн хуулиар бие хүнд торгох ялыг хасаж, зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл мөн адил хугацааны хорих ялын аль нэгийг үндсэн ялаар, харин хуулийн этгээдэд торгох ял оногдуулахаар хуульчилжээ.

Мөнгө угаах гэмт хэргийн хорих ялын интервал 2014 оныг хүртэл 5-12 жил байсан бол одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулиар гэмт хэргийн ангиллаас хамаарч 6 сараас 12 жилийн хооронд буюу дээд доод ялын хэмжээ багасаж өөрчлөгдсөн байгаа.

Хүснэгт №1

Бүрэлдэхүүн	2008.02.01-нд Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 ¹ дугаар зүйл	2009.12.24-нд Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 ¹ дугаар зүйл	2014.01.16-нд Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 ¹ дугаар зүйл	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйл
Үндсэн бүрэлдэхүүн	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар хорих	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар хорих	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1-6 сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар хорих	6 сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих
Хүндрүүлэх бүрэлдэхүүн	Эд хөрөнгө хурааж, 5-10 жил хүртэл хугацаагаар хорих	Эд хөрөнгө хурааж, 5-10 жил хүртэл хугацаагаар хорих	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300-500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 5-12 жил хүртэл хугацаагаар хорих	1-5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих
Хүндрүүлэх бүрэлдэхүүн	Эд хөрөнгө хурааж, 10-15 жил хүртэл хугацаагаар хорих	Эд хөрөнгө хурааж, 10-15 жил хүртэл хугацаагаар хорих	Тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300-500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, (хуулийн этгээдэд хамааралтай)	5-12 жил хүртэл хугацаагаар хорих
Хүндрүүлэх бүрэлдэхүүн				Тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, 120.000-400.000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, (хуулийн этгээдэд хамраалтай)

FATF-аас гарсан зөвлөмжийн 3 дахь хэсгийн тайлбарт “Мөнгө угаах хэмт хэрэг үйлдсэн хувь хүнд үр дүнтэй, гаргасан үйлдэлд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан байдаг бөгөөд манай улсыг мөнгө угаах гэмт хэрэгт оногдуулж буй ялын хэмжээнд анхаарах шаардлагатайг удаа дараагийн зөвлөмждөө анхааруулсан байдаг.

Мөнгө угаах гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгаснаар мөнгө угаах гэмт хэргийн гаралт тодорхой хэмжээгээр буурах магадлалтайгаас гадна урьдчилан сэргийлэх дорвитой алхам болох, нөгөө талаас эрүүгийн хариуцлага гэм буруутай этгээдийн гэм буруу, бусдад учруулсан хохирлын хэр хэмжээнд тохирсон байх зарчимд нийцэх юм. Цаашлаад хөөн хэлэлцэх хугацаа урт болох, хүндрүүлэх бүрэлдэхүүний үед тэнсэх боломж хаагдах, улмаар ял завшихаас сэргийлэх ач холбогдолтой.

Нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн хүнд хуульд заасан хугацааны дотор хариуцлага хүлээлгээгүй өнгөрсний дараа дахин тэр хэрэгт нь хариуцлага хүлээлгэх нь ашиггүй байдаг нь судалгаагаар тогтоогдсон.

Энэ нь цаг хугацааны хувьд хууль зүйн үр дагавраа алдаж, гэмт хэрэг үйлдсэн хүн засарч хүмүүжсэн байж болох талтайгаас гадна үйлдэгдсэнээс хойш удаан хугацаа өнгөрсөн хэрэгт хариуцлага хүлээлгэх нь эрүүгийн хариуцлагын /ял/ урьдчилан сэргийлэх, цээрлүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх болон бусад зорилгыг бууруулахад хүргэдэг, мөн үйлдэгдсэнээс хойш удаан хугацаа өнгөрсний дараа илэрч байгаа гэмт хэргийн нотлох баримтууд зарим талаар баларч бодит үнэнийг тогтооход бэрхшээл учруулдаг тул шүүгдэгчийн эрх ашигт муугаар нөлөөлж болзошгүй зэрэг байдлыг харгалзан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг дэлхийн улс орнууд Эрүүгийн хуулиндаа хуульчлан тогтоодог.

Монгол Улсын хувьд 2002 оны Эрүүгийн хуульд хүндэвтэр, хүнд гэмт хэрэгт тооцож хөөн хэлэлцэх хугацааг хүндэвтэр гэмт хэрэгт 5 жил, хүнд гэмт хэрэгт 15 жилээр тогтоосон бол одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа 2015 оны Эрүүгийн хуулиар хөөн хэлэлцэх хугацааг 1, 5, 12 жилээр тогтоосон нь мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг илт багасгаж тогтоосон байх буюу олон улсын эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцэхгүй байдлаар буюу доорх байдлаар тогтоосон байдаг.

Хүснэгт №2

Бүрэлдэхүүн	2008.02.01-нд Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 ¹ дугаар зүйл	2009.12.24-нд Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 ¹ дугаар зүйл	2014.01.16-нд Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 ¹ дугаар зүйл	2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйл
Үндсэн бүрэлдэхүүн	5 жил өнгөрсөн	5 жил өнгөрсөн	5 жил өнгөрсөн	1 жил өнгөрсөн
Хүндрүүлэх бүрэлдэхүүн	15 жил өнгөрсөн	15 жил өнгөрсөн	15 жил өнгөрсөн	5 жил өнгөрсөн
Хүндрүүлэх бүрэлдэхүүн	25 жил өнгөрсөн	25 жил өнгөрсөн	15 жил өнгөрсөн	12 жил өнгөрсөн

Олон улсын гэрээ конвенц ба гадаадын зарим улс орны эрх зүйн зохицуулалт.

Олон улсын эрх зүйд мөнгө угаах үйлдлийг гэмт хэрэгт тооцох анхны оролдлого нь 1988 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын Конвенц⁹⁵ (цаашид Венийн Конвенц гэнэ) Тус Конвенцийн дагуу мансууруулах болон сэтгэц нөлөөт бодистой холбоотой

⁹⁵ Тус Конвенц нь 1988 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдаж, 1990 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хучин төгөлдөр болсон www.legalinfo.mn

олсон мөнгийг угаахыг хориглосон ба үүнээс хойш мөнгө угаах гэмт хэрэг нь ойлголтын хувьд улам боловсронгуй болсон байна.

1988 оны Венийн Конвенцийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (b)-ийн аливаа гэмт хэрэг болон энэ хэсгийн (a) дэд хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдсэний үр дүнд бий болсон, эсхүл дурдсан гэмт үйлдэлд оролцсоны үр дүнд бий болсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж, хөрөнгийн хууль бус эх үүсвэрийг халхавчлах, нуун дарагдуулах болон гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд гэмт үйлдлийнхээ эрх зүйн үр дагавраас нь зайлсхийхэд нь туслах зорилгоор уг хөрөнгийг хувиргах, шилжүүлэх;

энэ хэсгийн (a) дэд хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдсэний үр дүнд бий болсон, эсхүл тийм гэмт хэрэг үйлдэхэд оролцсоны үр дүнд бий болсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж түүний жинхэнэ мөн чанар, эх үүсвэр, байрлал, захиран зарцуулах арга, хөдөлгөөн, хөрөнгөтэй холбоотой жинхэнэ эрх эсхүл эзэмшигчийг халхавчлах, нуун дарагдуулахыг "мөнгө угаалт" байна гэж үзсэн.

Венийн Конвенцид мөнгө угаах гэмт хэргийг ийнхүү тусгах болсон хэд хэдэн үндэслэлтэй байсан. Энэ нь:

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтээс бий болсон хөрөнгийн хөдөлгөөнийг хянах үед энэ нь мөнгө угаах гэмт хэрэг болон өөрчлөгдөж байгаа нь тогтоогдсон; бөгөөд Монгол Улс 2003 оны 06 дугаар сарын 25-ны өдөр нэгдэн орсон байна.

Гэмт үйл ажиллагаанаас олсон орлогыг угаах, илрүүлэх, хураах тухай" Страсбургийн Конвенц 1990 онд батлагдаж, оролцогч улс орнуудад бохир мөнгө цэвэршүүлэхийг гэмт хэрэгт тооцох, хууль бусаар олж авсан эд хөрөнгийг эрэн сурвалжилж олж авах, хураах журмын тухай, банкны ажилтнуудаас үйлчлүүлэгчийн мөнгөн хадгаламжийн талаарх мэдээллийг задруулахтай холбогдсон хориг, хязгаарлалтыг хүчингүй болгож, эдгээр гэмт хэргүүдийг цаг тухайд нь илрүүлэх бололцоо олгох, банкны ажиллагаатай танилцах, хуулийн байгууллагын ажилтнуудын эрхийг бэхжүүлэх үүрэг хүлээжээ.⁹⁶

3. НҮБ-аас 1999 онд "Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Конвенц" батлагдсан бөгөөд уг Конвенцоор нэгдэн орсон улсыг мөнгө угаахын эсрэг улс хооронд мөрдөн шалгах, саатуулах, яллах ажиллагаанд хамтран ажиллахыг үүрэг болгосон. Уг үүргийг биелүүлэх хүрээнд нэгдэн орсон улсууд нь терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг мөнгө угаахтай тэмцэх арга хэмжээг авах дотоодын хэм хэмжээг боловсруулан батлах болсон.⁹⁷

4. 2000 оны Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын Конвенц (цаашид "Палермогийн Конвенц" гэнэ)-ийн 6 дугаар зүйлд: • Тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус үүсвэрийг нуух, далдлах, эсхүл эрх зүйн үндсэн зөрчлийг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд өөрийн үйлдлийн төлөө хүлээх хуулийн хариуцлагаас зайлсхийхэд нь туслах зорилгоор эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх;

- Тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч буюу эд хөрөнгийн эрхийг нуух буюу далдлах;

- Тухайн эд хөрөнгийг олж авах үед түүнийг гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийг олж авах, эзэмших буюу ашиглах;

- Мөнгө угаах гэмт хэргийг үйлдэхэд оролцох, хамтрах, угсэн тохиролцох, үйлдэхийг завдах болон хамжих, хатгах, туслах болон зөвлөгөө өгөх гэж тодорхойлсон байдаг.

Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг Палермогийн Конвенцийн 2 дугаар зүйлд "... үл хөдлөх, хөдлөх хөрөнгө, биет эсхүл биет бус бүх төрлийн хөрөнгө хамаарах болон тэдгээр эд хөрөнгийн эрх, ашиг сонирхлыг нотлох хууль зүйн баримт бичиг хэрэгсэл ..." гэж тодорхойлжээ.

⁹⁶ Эдийн засгийн гэмт хэрэг Шүүхийн ерөнхий зөвлөл. УБ., 2017. 205 дахь тал

⁹⁷ https://www.unodc.org/pdf/convention_1988_en.pdf

Олон улсын түвшинд "мөнгө угаах" гэсэн ойлголтыг Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын Конвенцид зааснаар өргөн хүрээнд хэрэглэдэг бөгөөд гэмт хэрэг үйлдэж олсон орлогоо нуусан, халхалсан, шилжүүлсэн үйлдэлд нь тухайн гэмт этгээдэд анх үйлдсэн гэмт хэрэг дээр нь давхардуулж ял, шийтгэл оноох, эсхүл гэмт хэрэгт биечлэн оролцоогүй ч түүнээс олсон орлогыг хууль бус гэдгийг нь мэдсээр байж хүлээн авч, нууж, шилжүүлсэн бусад этгээдийг яллан шийтгэхэд мөнгө угаах гэсэн томъёоллыг ашигладаг байна.

Дээрх тодорхойлолтуудаас үзвэл, мөнгө угаах гэдэг нь гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлс, ашиг, орлогын эх үүсвэрийг нуун далдалж, тэдгээрийг хууль ёсны мэтээр харагдуулах халхавчтайгаар эдийн засгийн эргэлтэнд оруулах, хэлбэр дүрсийг хувиргах бүхий л үйлдэл болон түүнд хамтран оролцохыг ойлгоно.

Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, Конвенцууд болоод холбогдох олон улсын тогтоол, дотоодын хууль эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэхээр Эрүүгийн хуульд оруулсан хэд хэдэн удаагийн өөрчлөлтөөр мөнгө угаах гэмт хэргийн ойлголт, шинж чанар, онцлог, хамрах хүрээ хязгаар, үйлдэгдэх арга хэлбэр, төрөл зэрэг мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой бүхий л ойлголтыг олон улсын түвшинд аль болох ойртуулах чигийг баримтлан хуульчилсан байх ба энэ нь нэг талаас манай улс бусад улс орнуудын өмнө хүлээж буй үүрэг хариуцлага боловч нөгөө талаас FATF-ын зүгээс бидэнд үзүүлсэн хатуу хяналт, манай улсын эсрэг авч хэрэгжүүлж болох санхүүгийн хориг арга хэмжээнээс сэргийлсэн алхам юм

Их долоо гэгдэх нөлөө бүхий дэлхийн улс орнуудын санаачилгаар 1989 онд /Financial Action Task Force / буюу Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх түр хороо-ны мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын хүчин зүтгэлийг нэгтгэн төвлөрүүлдэг. Олон улсын стандартыг боловсруулж гаргадаг бөгөөд тус байгууллагыг 1989 онд их долоогийн уулзалтын үеэр 26 улс нэгдэж НҮБ-ын конвенц, тогтоолуудыг хэрэгжүүлэх, олон улсын хүчин чармайлт, зүтгэлийг нэгтгэх, хууль бус аргаар орлого олох гэмт үйл ажиллагааг таслан зогсоох, эдийн засгийн хууль ёсны шударга ажиллагаанд тэдгээрийг нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэйгээр үүсгэн байгуулагдсан байдаг бөгөөд дэлхийн улс орнууд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй хэрхэн тэмцэж байгааг судлаж зөвлөмж өгч ажилладаг.

FATF 1990 онд 40 зөвлөмж-ийг гаргасан ба ингэхдээ 1988 оны Мансууруулах эм сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцийн 3 дугаар зүйлийг гол эх сурвалж болгон боловсруулсан ба энэ нь хар тамхины орлогын мөнгийг санхүүгийн салбарыг ашиглан угаах үйл ажиллагаанаас сэргийлэхэд чиглэгддэг. FATF-ын 40 зөвлөмж нь мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг улс орон бүрт нэг түвшинд хүргэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд улс орнуудын хамтын ажиллагаанд учирч болох хүндрэлүүдийг даван туулах зорилгоор гаргасан стандарт юм.

Өөрөөр хэлбэл улс орнуудын хууль эрх зүйн болон санхүүгийн салбар ялгаатай тул нийтлэг зорилгод хүрэх, ялангуяа тодорхой асуудлууд дээр нэг төрлийн ижил арга хэмжээ авах боломжгүй гэдгийг FATF хүлээн зөвшөөрдөг. Тиймээс зөвлөмж нь тухайн улс өөрийн хууль эрх зүйн хэм хэмжээнд болон нөхцөл байдалд тохируулан хэрэглэхэд зориулж хамгийн доод стандартыг тогтоосон байдаг. Энэ зөвлөмжид мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөх, шалгах, хууль бус гүйлгээ, орлогыг түдгэлзүүлэх, хураан авах эрх зүйн орчныг бүрдүүлэх, энэ ажлаар мэргэшсэн, төв байгууллагатай болох, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг банк санхүүгийн байгууллагаар авахуулах, сэжиг бүхий гүйлгээний талаар эрх бүхий байгууллагад мэдээлэх зэрэг цогц арга хэмжээ бүхий тогтолцоог бүрдүүлэхийг улс орнуудад зөвлөдөг.

FATF -ын “Нэмэлт тайлбар; хэсэгт илүү дэлгэрэнгүй, тодорхой тайлбаруудыг оруулжээ. Тодруулбал, 40 зөвлөмж -д мөнгө угаах гэмт хэргийг ямар хүрээ хязгаарын дотор авч үзэх, суурь гэмт хэргүүдэд хичнээн гэмт хэргүүдийг хамруулах мөнгө угаах гэмт хэргээс олсон орлогыг хэрхэх, түр зуурын арга хэмжээ гэж юу болох, хуулийн этгээд мөнгө угаах гэмт хэрэгт ямар хэлбэрээр оролцдог.

Хариуцлагыг ямар хэлбэрээр хүлээлгэх, харилцагчийг яаж таньж мэдэх, сэжигтэй гүйлгээнд ямар төрлийн гүйлгээ хамаарах, яаж хянах зэргээр мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой стандартуудыг тогтоож өгсөн.

Хэдийгээр албан ёсны нэршил нь “Зөвлөмж боловч эдгээр зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж байгаад мөнгө угаахтай тэмцэх бүсийн байгууллагуудын зүгээс үнэлгээ хийж, хангалтгүй үнэлгээ авсан улс орныг” саарал хар жагсаалтад оруулан бусад улс орнуудыг жагсаалтад орсон улстай санхүүгийн харилцаанд орохдоо өндөр сонор сэрэмжтэй байж, учирч болох эрсдэлээс өөрсдийгөө хамгаалахыг уриалдаг тул мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо нь Зөвлөмжид бүрэн нийцээгүй байх нь санхүү эдийн засгийн гадаад харилцаанд ихээхэн сөрөг үр дагавар бүхий асуудал үүсгэдэг.

Гадаадын зарим улс орнуудын Эрүүгийн хууль тогтоомж дахь мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт. Мөнгө угаах гэмт хэрэг нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн нэг төрөл болохын хувьд зайлшгүй харьцуулан судлах шаардлагатай гэмт хэргийн төрөл юм.

Дэлхийн улс орнуудад эрх зүйн тогтолцооны онцлогоос хамааран мөнгө угаах гэмт хэргийн талаарх ойлголтыг Эрүүгийн болон өөр бусад бие даасан хуулиудад нэг мөр болгож, бүрэлдэхүүний шинжийг тогтоосон байдаг. Жишээ нь .

ОХУ-ын 1996 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг буюу "Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын гэмт хэрэг" бүлгийн 174, 174-1 дугаар зүйлүүдэд мөнгө угаах гэмт хэргийн талаар хуульчилжээ .

Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг ОХУ - ын Эрүүгийн хуулийн 174 дүгээр зүйл болон 174-1 дүгээр зүйлүүдэд тодорхойлохдоо субъектын шинжээр буюу бусдын гэмт хэргийн замаар олж авсан мөнгөн хөрөнгө, эд зүйлийг хууль ёсны болгох (угаах), түүнчлэн гэмт хэргийн замаар олж авсан мөнгөн хөрөнгө, эд зүйлээ хууль ёсны болгох (угаах) гэсэн хоёр тусдаа гэмт хэрэг болгон заасан байна. Өөрөөр хэлбэл, бусдын хууль бус эд зүйлийг хувиргах, эсхүл өөрийн хууль бус аргаар олсон орлого, эд зүйлсийг хууль ёсны болгон хувиргах үйлдлийг зааглан авч үзсэн байна

Тодруулбал, Эрүүгийн хуулийн 174 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “ ... бусдын гэмт хэргийн замаар бий болсон мөнгө, бусад эд хөрөнгийг хууль ёсны болгох зорилгоор санхүүгийн гүйлгээ, бусад гүйлгээг хийсэн бол ...”, харин Эрүүгийн хуулийн 174-1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “гэмт хэргийн замаар олж авсан мөнгөн хөрөнгө , эд зүйлээ хууль ёсны болгох зорилгоор санхүүгийн гүйлгээ, бусад гүйлгээг хийсэн бол ...”⁹⁸ гэж тус тус тодорхойлжээ .

Харин Эрүүгийн хуулийн 174 болон 174-1 дүгээр зүйлүүдэд заасан хэргийг их хэмжээтэй, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, албан тушаалын байдлаа ашиглаж үйлдэх, зохион байгуулалттай бүлэг, онц их хэмжээтэй үйлдсэн тохиолдолд хүндрүүлэх нөхцөл байдалд хамаарахаар хуульчилсан байна .

ОХУ-ын Эрүүгийн хуульд мөнгө угаах гэмт хэрэгт торгох, албадан ажил хийлгэх, хорих ял оногдуулдаг байна. Тухайлбал, тус хуулийн 174 болон 174-1 дүгээр зүйлүүдийн ердийн бүрэлдэхүүнд нэг зуун хорин мянган рубль хүртэл, эсхүл бүтэн нэг жилийн хугацааны цалин хөлс болон бусад орлоготой дүйцэхүйц хэмжээгээр торгох ялаар; Эрүүгийн хуулийн 174 болон 174-1 дүгээр зүйлүүдийн 2 дахь хэсэгт хоёр зуун мянган рубль хүртэл, эсхүл нэгээс хоёр жил хүртэл авч байсан цалин хөлс болон бусад орлоготой дүйцэхүйц хэмжээгээр торгох, эсхүл нэгээс хоёр жилхүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялыг тавин мянган хүртэл рублээр торгох ялтай хамт, эсхүл ялтны гурван сар хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын дүйцэхүйц хэмжээгээр торгох ялаар, Эрүүгийн хуулийн 174 болон 174-1 дүгээр зүйлүүдийн 3 дахь хэсэгт хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах буюу хязгаарлахгүйгээр тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл

⁹⁸ Төрийн мэдээлэл. 2016. №21. Монгол Улсын Эрүүгийн хууль

хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах буюу хязгаарлахгүйгээр, эсхүл тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр таван зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгож таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар, Эрүүгийн хуулийн 174 болон 174-1 дүгээр зүйлүүдийн 4 дэх хэсэгт хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах буюу хязгаарлахгүйгээр тодорхой албан тушаал эрхлэх тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлаж тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр нэг сая хүртэл рубль, эсхүл ялтны таван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгож, долоон жил хүртэл хугацаагаар хорих ялаар тус тус шийтгэхээр заажээ .

БНХАУ - д мөнгө угаах гэмт хэргийг БНХАУ - ын 1997 оны Эрүүгийн хуулийн 4 дүгээр бүлгийн (Санхүү, мөнгөн гүйлгээний удирдлагын журмыг зөрчих гэмт хэрэг) 191 дүгээр зүйлд хуульчилсан байна .

Эрүүгийн хуулийн 191 дүгээр зүйлд зааснаар эх сурвалж, гарал үүслийг нь нуун дарагдуулах зорилгоор гэмт үйлдлийн замаар буюу хар тамхи, мансууруулах бодис, хууль бусаар эд зүйл хил нэвтрүүлэх, эсвэл ийм ажиллагааны үр дүнд олж авсан эд зүйл, хөрөнгө, орлого гэдгийг мэдсээр байж:

- Гэмт үйлдлийн замаар олж авсан хөрөнгө, орлогыг шилжүүлэхэд банкны (санхүүгийн) харилцах дансаа ашиглуулах ;

- Гэмт үйлдлийн замаар олж авсан эд хөрөнгийг биет хөрөнгө болон санхүүгийн хөрвөх чадвартай хөрөнгө бий болгоход ашиглах (бэлэн мөнгө, эсвэл мөнгөн дэвсгэрт болгон хөрвүүлэх);

- Хөрөнгийг хувиргах, данс руу шилжүүлэх, өр төлбөр барагдуулах, эсвэл төлбөрийн бусад аргыг ашиглан мөнгө шилжүүлэх;

- Гадаад орон руу мөнгө шилжүүлэх;

- Гэмт хэргийн орлогын эх үүсвэр, мөн чанарыг өөр хэлбэрээр нуун дарагдуулах зэрэг үйлдлүүдийн аль нэгийг хийсэн бол мөнгө угаах гэмт хэрэгт тооцогддог.

Эрүүгийн хариуцлагын хувьд гэмт үйлдлийн замаар олж авсан орлогыг хурааж 5 жил хүртэл хугацаагаар хорих , эсхүл богино хугацаагаар баривчлах , үүний зэрэгцээ мөнгө угаасан орлогын 5-20 хүртэлх хувьд нь торгууль оногдуулдаг. Хэрэв хэрэг нь хүндрүүлэх нөхцөл байдалтай байвал 5-10 жил хорьж, хууль бусаар олж авсан орлогын 5-20 хүртэлх хувьд нь торгууль оногдуулж, мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой бүх хөрөнгийг хураана

Хуулийн этгээд энэ гэмт хэргийг үйлдсэн бол торгууль төлнө. Харин хуулийн этгээдийн шийдвэр гаргах эрх мэдэл бүхий хүмүүс болон гэмт хэрэгт холбогдсон бусад хүмүүс нь 5 жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл богино хугацаагаар баривчлах ял шийтгүүлдэг байна.

ХБНГУ - ын одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хууль нь 1998 онд шинэчлэн батлагдсан ба мөнгө угаах гэмт хэргийг ХБНГУ - ын Эрүүгийн хуулийн "Гэмт хэргийн дараа туслах, хулгайлагдсан эд юмсыг ашиглах " гэсэн 21 дүгээр бүлгийн 261 дүгээр зүйлд хуульчлан заажээ .

Тус хуулийн 261 дүгээр зүйлд “Мөнгө угаах , хууль бусаар олж авсан эд хөрөнгийг нуух” гэж нэрлэн уг гэмт хэргийн үндсэн шинжийг нь тодорхойлохдоо тухайн зүйл ангид нэрлэн заасан хууль бус үйлдлийн улмаас бий болсон орлого, эд зүйлсийг нуун дарагдуулсан, түүний эх үүсвэрийг нь нуусан , эсвэл эх үүсвэрийг тодруулах, түүнийг эрх хайх, олж тогтоох, хураан авах эсвэл хамгаалалтад авах ажиллагаанд саад учруулсан, эсвэл аюул заналхийсэн бол гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байна .

ХБНГУ - ын Эрүүгийн хуулийн 261 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт өөрийн үйлдсэн гэмт хэргийн улмаас орлогыг тухайн хүн өөрөө " угаасан " үйлдлийг, харин уг зүйлийн 2 дахь хэсэгт гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж түүнийг худалдаж авах, хадгалах , ашиглах зэргээр бусдын орлого, эд хөрөнгийг “угаасан” хүний үйлдлийг ялган тодорхойлж өгчээ .

Мөнгө угаах гэмт хэргийн угтвар нөхцөл болж буй хууль бус үйлдэл гэдэгт Эрүүгийн хуульд заасан бүх төрлийн хүнд гэмт хэрэг, мөн түүнчлэн тухайн зүйл ангид нэрлэн заасан зарим хөнгөн хэргүүд хамаарахаар тусгаж өгсөн байна. Эдгээр хөнгөн гэмт хэрэгт гол төлөв хулгай, залилан мэхлэх, ашиглах зэрэг өмчийн эсрэг гэмт хэрэг багтаж байгаагаас гадна хүн худалдах, бие үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг мөн багтаасан байна.

Дүгнэлт. Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд хохирлын хэмжээг тодорхой зааж өгөөгүйгээс практикт хулгайн эд зүйл худалдан авсан этгээдийг мөнгө угаах гэмт хэргээр хуулийн хариуцлага хүлээлгэх нөхцөл байдал үүссэн байна.

Мөнгө угаах гэмт хэрэг нь бүлэг зохион байгуулалттайгаар их хэмжээний хууль бус хөрөнгө мөнгө, орлогыг хууль ёсны болгох ажиллагаа явуулж буй байдгаар илэрдэг онцлогтой.

Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг Эрүүгийн хуульд зөв тодорхойлсон байх ёстой. Гэтэл энэ гэмт хэргийн онцлог, бусад ижил төстэй гэмт хэргээс ялгагдах шинжийг зөв тодорхойлоогүйгээс хулгайн эд зүйлийг худалдан авсан этгээдэд дээрх зүйл ангид заасан эрүүгийн хариуцлага оногдуулж байгаа нь учир дутагдалтай байна.

Монгол улсын Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд “Бие хүн” өөрөө мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага оногдуулах эсэхийг тодорхой зааж өгөөгүй орхигдуулсан. Үүнтэй холбоотойгоор суурь гэмт хэргийг ч Эрүүгийн хуульд зөв тодорхойлох шаардлагатай болох нь харагдаж байна.

Олон улсын гэрээ конвенц болон FATF-ын зөвлөмж, гадаадын зарим улсын эрүүгийн хуульд мөнгө угаах гэмт хэргийг гардан үйлдсэн бие хүнд эрүүгийн хариуцлага ногдуулах тухай зүйл заалтууд байдаг. Үүнээс үзэхэд энэ төрлийн гэмт хэргийн талаарх ойлголт, түүний мөн чанар нь онол, практикийн хүрээнд цогц судлагдаагүй болохыг гэрчилж байна.

Иймд уг тулгамдсан асуудлыг гадаадын зарим орны хуримтлуулсан туршлага болон олон улсын эрх зүйн чиг хандлагатай уялдуулан нарийвчлан судлах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслээд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Монгол улсын Эрүүгийн хуульд Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг зөв тодорхойлох; /Ихэвчлэн бүлэг зохион байгуулалттайгаар үйлдэгддэг гэмт хэргийг ахуйн шинжтэй гэмт хэргээс ялгах/
2. Мөнгө угаах гэмт хэргийн улмаас учирсан хохиролын хэмжээг хуульд тодорхой тусгах;
3. Мөнгө угаах гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгаснаар мөнгө угаах гэмт хэргийн гаралт тодорхой хэмжээгээр буурахаас гадна урьдчилан сэргийлэх, нөгөө талаас эрүүгийн хариуцлага гэм буруутай этгээдийн гэм буруу, бусдад учруулсан хохирлын хэр хэмжээнд тохирсон байх зарчимд нийцэх юм.

Ашигласан материалын жагсаалт

Ном сурах бичиг

1. Хамтын бүтээл. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. Улсын дээд шүүх. Ханнс Зайделийн сан. УБ. 2013
2. Хамтын бүтээл. Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль. УБ. 2018
3. Эдийн засгийн гэмт хэрэг II. Монгол Улсын Ерөнхий прокурорын газар. УБ. 2018
4. “Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал” Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2018 он

2. Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл №1. УБ. 1992

2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль. Төрийн мэдээлэл №24 УБ. 2013

3. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. Төрийн мэдээлэл №3 УБ. 2002

4. Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл №6 УБ. 2002

3. Олон улсын эрх зүйн баримт бичиг:

1. 1988 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын Конвенц

2. 2000 оны Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын Конвенц

3. 2003 оны Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц

4. 2003 оны Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын Конвенц

4. Цахим эх сурвалж:

1. www.mongolbank.mn

2. www.legalinfo.mn

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
САЙЖРУУЛАХАД АНХААРАХУЙ

А.Амарсайхан
ЦЭЗТ-ийн эрхлэгч,
цагдаагийн хурандаа

Товч агуулга: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчин хангалттай бүрдсэн бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн талаарх олон улсын гэрээ, конвенцэд нийцсэн байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилтай нэгдмэл байдлаар, нэг адил арга, хүч хэрэгслийг ашиглан, нийтлэг зохицуулалтын хүрээнд авч үзсэн нь олон улсын жишигт нийцсэн шинэлэг зохицуулалт болсон гэж үзэж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилт зөрчигдсөн тохиолдолд хууль хэрэглэх, зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх ажлын үр нөлөө гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зорилгыг хангахад хамгийн тэргүүлэх чухал байр суурь эзлэж байгаа ба цагдаагийн байгууллагаас сүүлийн 5 жилд гэмт хэргийн гаралт буурсан үзүүлэлт нь эерэг сөрөг ямар талтайг тодруулахыг энэхүү илтгэлээр тодруулахыг зорив.

Түлхүүр үг: Урьдчилан сэргийлэх ажил,

Үндсэн хэсэг: Монгол Улсын төрт ёсны түүхэн уламжлалаас үзвэл улс орны дотоод аюулгүй байдлыг хангах, иргэдийн амгалан тайван, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх төрийн чиг үүргийн хэрэгжилт цагдаагийн албатай салшгүй холбоотой. Иргэдийнхээ аюулгүй байдлыг хэрхэн баталгаатай хангах вэ гэх амин чухал асуудлын гол зангилаа нь эрх зүйн эсрэг чиглэсэн аливаа сөрөг зан үйлээс урьдчилан сэргийлэх замаар учирч болох аюул занал, хор уршгийг бууруулах асуудал ямагт чухал байсаар ирсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”, 19 дүгээр зүйлийн 19.1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”⁹⁹ гэж заасан нь төрөөс иргэнийхээ өмнө хүлээх үүргийг баталгаажуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж өгсөн явдал юм.

Монгол Улсад сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтээс харахад эрүүгийн хууль тогтоомжид заасан 200 гаруй гэмт хэргээс цөөн хэдэн төрлийн гэмт хэрэг Монгол Улсад бүртгэгдэж буй нийт гэмт хэргийн 80 гаруй хувийг тогтмол эзэлж байна. Тухайлбал, хулгайлах гэмт хэрэг нийт бүртгэгдэж буй гэмт хэргийн 30 гаруй хувийг, бусдын бие махбодид гэмтэл учруулах төрлийн гэмт хэрэг 30 орчим хувийг, мөн залилах гэмт хэрэг, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг тус тус 10 орчим хувийг эзэлж, харин мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах болон цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн нийгэмд учруулах хор уршиг, аюул нэмэгдсээр байгаа бөгөөд гэмт үйлдлийн тоо хурдацтай өсөж байна.

Монгол Улсад гэмт хэргийн улмаас 2017 онд 198.1 тэрбум төгрөгийн хохирол учирч байсан бол 2021 онд 180.4 болж, 17.7 тэрбум төгрөгөөр буюу 9 хувиар, бүртгэгдсэн гэмт хэрэг 2017 онд 32259

⁹⁹ Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль

байсан бол 2021 онд 25429 болж 6830 буюу 21.1 хувиар тус тус буурсан байна. Гэмт хэргийн улмаас 2017 онд 37173 хүн хохирч байсан бол 2021 онд 24994 болж 12179 буюу 32.7 хувиар, 2017 онд гэмт хэргийн улмаас 10513 хүн гэмтсэн бол 2021 онд 8299 болж, 2214 буюу 21 хувиар, 2017 онд гэмт хэргийн улмаас 1129 хүн нас барсан бол 2021 онд 683 хүн нас барж, 446 буюу 39.5 хувиар тус тус буурчээ. Статистик¹⁰⁰-ийн эдгээр эерэг үзүүлэлт нь төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх болон эрүүгийн ялын бодлогод оруулсан өөрчлөлтийн үр дүн үү, эсхүл гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимтэй явуулсны үр дүн үү гэдэг асуулт зүй ёсоор тавигдаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/301 дүгээр тушаалаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийг байгуулан ажиллуулж эхэллээ¹⁰¹.

Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн 3 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/09, Цагдаагийн ерөнхий газрын даргын мөн оны нэгдүгээр сарын 14-ний өдрийн А/17 дугаар тушаалаар хүрээлэн байгаа орчныг хамгаалах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, байгаль экологид учрах хохирлыг бууруулах нэгдсэн бодлого хэрэгжүүлэх, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг ердийн болон онцгой нөхцөл байдал үүссэн үед шуурхай удирдлага, зохицуулалтад оруулах, хүрээлэн буй орчны хяналтын алба хаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар, дээд шатны байгууллага, албан тушаалтныг бодит мэдээ, мэдээллээр хангах нэгдмэл чиг үүргийг хариуцсан Экологийн цагдаагийн албыг байгуулжээ. Тус алба нь Захиргааны удирдлагын, Эрүүгийн цагдаагийн, Зөрчил шалган шийдвэрлэх, Урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааны, Мөрдөн шалгах, Дүн шинжилгээ, хяналт шалгалтын гэсэн 6 хэлтэс, 21 аймаг, 64 суманд экологийн асуудал хариуцсан алба хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна¹⁰².

2022 оны эхний улирлын байдлаар улсын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг 205 алба хаагч хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнээс Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс-14, Гэр бүлийн хүчирхийлэл, Хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс 11, Хар тамхитай тэмцэх хэлтэст 5, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын гэр бүлийн хүчирхийлэл, Хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст 9, дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсүүдэд нийт 67, орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтэст нийт 82, Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтэст 7, Эрүүгийн цагдаагийн алба 1, Мөрдөн байцаах алба 1, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба 3, Экологийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааны хэлтэст 5 алба хаагч хэрэгжүүлж байна. Тэдгээрийг мэргэжлийн хувьд авч үзэхэд, эрх зүйч 122, цагдаагийн ажил-эрх зүйч 51, гэмт явдалтай тэмцэх 3, хүний бага эмч-эрх зүйч 3, нягтлан бодогч-эрх зүйч 3, найруулагч-эрх зүйч 1, аюулгүй байдал-эрх зүйч 1, багш 3, авто инженер 1, бусад мэргэжилтэй 17 алба хаагч байна. Алба хаагчдын 121 буюу 59.0 хувь нь эмэгтэй, 84 буюу 40.9 хувь эрэгтэй алба хаагч байгаагаас насны хувьд 21-30 хүртэл насны 53, 31-40 насны 110, 41-50 насны 42 алба хаагч байна. Ажилласан жилийн байдлаар үзвэл, 1-10 жил 61, 11-15 жил 96, 16-20 жил 36, 21-25 жил 10, 27 жил 2 алба хаагч байна. Үүнээс тухайн чиглэлээр 61 алба хаагч 3 жил, 75 алба хаагч 2 жил, 69 алба хаагч 1 жил хүртэл хугацаанд ажиллаж байна¹⁰³.

Мэдээлэл судалгаа, дүн шинжилгээний чиглэлээр Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Дүн шинжилгээ, судалгааны хэлтэс, Статистикийн хэлтэст 13, бусад албанд 10, дүүрэг дэх цагдаагийн газарт 38, орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтэс 46 алба хаагч ажиллаж байна.

¹⁰⁰ www.1212.mn

¹⁰¹ ЦЕГ-ын тайлан мэдээлэл. /www.police.gov.mn/

¹⁰² Мөн тэнд

¹⁰³ Цагдаагийн Ерөнхий Газрын Хүний нөөцийн мэдээ. 2022 он

Алба хаагчдыг мэргэжлийн хувьд авч үзэхэд, эрх зүйч 93, эдийн засагч 2, хэрэглээний статистикч 1, багш 3, бизнесийн удирдлага, нягтлан бодогч 3, сэтгэл зүйч 2, санхүүгийн менежер 1, шинжээч 1, программ хангамж 1 алба хаагч байна. Алба хаагчдын 24 буюу 22.5 хувь нь эрэгтэй, 83 буюу 77.5 хувь эмэгтэй алба хаагч байгаагаас насны хувьд 23-30 хүртэл насны 22, 31-40 насны 51, 41-45 насны 20, 46-50 насны 13, 50-иас дээш насны 1 алба хаагч байна. Мэдээлэл судалгааны чиглэлээр ажилласан байдлаар үзвэл, 1-10 жил 94, 11-15 жил 11, 21-25 жил 2 алба хаагч байна. Үүнээс тухайн чиглэлээр 52 алба хаагч 3 жил, 41 алба хаагч 2 жил, 82 алба хаагч 1 жил хүртэл хугацаанд ажиллаж байна.¹⁰⁴

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүлээсэн үүргийн биелэлтийг үр нөлөөний талаар 2017 оноос 2021 оны байдлаар авч үзлээ. Монгол Улсад сүүлийн 5 жилд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, хөдөлгөөн, тархалт, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Гэмт хэрэг, шүүн таслах ажиллагааны статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”-ын дагуу тодорхойлж, цаашдын чиг хандлагыг нийгэм, эдийн засаг, эрүүгийн нөхцөл байдалтай уялдуулан авч үзэхэд жилд дунджаар 31 мянга гаруй гэмт хэрэг бүртгэгдэж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 184.8 тэрбум төгрөгийн эд материалын хохирол учирч, 981 хүн нас барж, 10351 хүн гэмтэж, эрүүл мэндээр хохирсон байна. Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлсэн хугацаанд буюу сүүлийн 5 жилийн байдлаар гэмт хэргийн илрүүлэлтийн хувийг авч үзэхэд 2017 онд 35.6, 2018 онд 36.0, 2019 онд 44.9 2020 онд 51.9, 2021 онд 52.7 хувьтай байна.

Дээрх тоо баримтаас дүгнэхэд манай улсад 5 жилийн дараа буюу 2024 онд гэмт хэрэг 41515 буюу 14.6, гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо 1135 буюу 21.5 хувиар, зам тээврийн осол 2.9 дахин, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 30.0, гэмт хэргийн улмаас нас баралт 10.0, бусдын бие махбодид гэмтэл учруулах зөрчил 15.0 хувиар тус тус өсөх хандлагатай гэж таамаглажээ.¹⁰⁵

Монгол Улсад гэмт хэргийн улмаас 2017 онд 198,1 тэрбум төгрөгийн хохирол учирч байсан бол 2020 онд 254.9 болж, 56,8 тэрбум төгрөгөөр буюу 28,6 хувиар өссөн, бүртгэгдсэн гэмт хэрэг 2017 онд 32259 байсан бол 2020 онд 23064 болж, 9195 буюу 28,5 хувиар буурсан байна. Гэмт хэргийн улмаас 2017 онд 37173 хүн хохирч байсан бол 2020 онд 23050 болж 14123 буюу 37.9 хувиар, 2017 онд гэмт хэргийн улмаас 10513 хүн гэмтсэн бол 2020 онд 8175 болж, 2338 буюу 22,2 хувиар, 2017 онд гэмт хэргийн улмаас 1129 хүн нас барсан бол 2020 онд 670 хүн нас барж, 459 буюу 40,6 хувиар тус тус буурчээ.

Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулсан байна.¹⁰⁶

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар цагдаагийн байгууллагын хүлээх үүрэг, энэ чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, түүний үр нөлөөг хэрхэн үнэлж дүгнэсэн талаар холбогдох хууль тогтоомж, албаны тайлан мэдээллийг эх сурвалж болгон өмнөх бүлэгт авч үзсэн.

Цагдаагийн байгууллагаас 2017 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх, 2018 онд ажлын хариуцлага, ёс зүйг дээшлүүлж, шуурхай байдлыг хэвшүүлэх, 2019 онд манлайлал, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх 2020 онд удирдлагын манлайлал, алба хаагчийн мэргэжлийн ур чадвар, харилцааны соёлыг дээшлүүлнэ, үйл ажиллагаанд техник технологийн дэвшлийг нэвтрүүлж, бүтээлч санал, санаачилгыг дэмжинэ. 2021 онд удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж, шуурхай байдлыг хангах зэрэг зорилт дэвшүүлэн ажиллаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндсэн үүрэг бүхий нэгжийн бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, үйл ажиллагааны журам, ажлын тайлан мэдээ гаргах, үнэлж дүгнэх

¹⁰⁴ Цагдаагийн Ерөнхий Газрын Хүний нөөцийн мэдээ. 2022 он

¹⁰⁵ Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр. Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоол.

<https://www.legalinfo.mn/annex/?lawid=15324>

¹⁰⁶ Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан. Цагдаагийн Ерөнхий Газар. 2019 он.

аргачлалуудыг сайжруулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг цагдаагийн албаны тэргүүлэх чиг үүрэг болгож, нийт алба, нэгж, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, алба хаагчдын нийтлэг үүрэг болгон хэвшүүлжээ.

Эдгээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнд эерэгээр нөлөөлж, уг ажлын хамрах хүрээ өргөжин бусад төрийн болон төрийн бус байгууллага, нийт иргэдийн оролцоонд тулгуурлан зохион байгуулах олон төрлийн арга хэлбэр тогтож хэвшсэнээр түгээмэл үйлдэгддэг гэмт хэргийн статистик сүүлийн хоёр жилд эерэг гарч, гэмт хэргийн тоо, хор уршиг буурахад нөлөөлжээ.

Цаашид цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх зарим хэрэгцээ, шаардлага, бодит нөхцөл байдалд тулгуурласан арга замыг тодорхойлоход чиглэсэн судалгаа, зохион байгуулалтын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь зүй ёсны асуудал юм. Хэдийгээр гэмт хэргийн нөхцөл байдал статистикийн хувьд эерэг байгаа боловч зарим төрлийн гэмт хэргийн тоо, хор уршиг өссөн, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамж өндөр биш, олон улсын төвшинтэй харьцуулахад нэг хүнд оногдох гэмт хэргийн тоо, осол хэргийн улмаас нас барсан хүний тоон үзүүлэлтүүд олон дунджаас өндөр байгаа зэрэг сөрөг үзүүлэлтүүд байгааг хайхрахгүй байж болохгүй юм. Энэ талаар Гэмт хэргийн цагаан ном-2016, 2017, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном-2018 болон гэмт хэргийн статистик, тодорхой төрлийн гэмт хэрэг, тодорхой нутаг дэвсгэрийн дэх гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд хийсэн судалгааны тайлангийн дүгнэлт, зөвлөмжүүдээс дэлгэрүүлэн үзэх боломжтой.

Цагдаагийн ерөнхий газрын захиалгаар 2012 оноос эхлэн жил бүр хөндлөнгийн судалгааны байгууллагууд Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээ хийж, үр дүнг танилцуулж ирсэн. Эдгээр судалгаагаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамж жил тутам бага хэмжээгээр аажим өсч байгаа боловч “дунд зэрэг” гэсэн төвшингээс ахиагүй байна. Цагдаагийн байгууллагын 2017 оны хэрэглэгчийн үнэлгээгээр иргэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хамгийн бага /3,11/ үнэлгээ өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, ялангуяа орон нутагт хангалтгүй байгаад анхаарч ажиллах талаар зөвлөсөн байна.¹⁰⁷

Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2017¹⁰⁸ судалгааны тайланд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын алдаа, дутагдал, анхаарах асуудлуудыг тусгасан байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрхэн үнэлэх, дүгнэх талаар үнэлэмж, хэмжүүр байхгүй байгаа, улсын хэмжээнд болон орон нутагт явуулж байгаа нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ хуучин практик, ажлын уламжлалт туршлага, арга барилд үндэслэн ерөнхий таамгаар төлөвлөж, зохион байгуулж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь зөвхөн цагдаагийн байгууллагын ажил гэж ойлгодог хэвшмэл хандлага хэвээрээ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлүүдийн ажлын тайланд зөвхөн цагдаагийн байгууллагаас явуулсан ажлыг дурдан ирүүлж байна гэжээ. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016¹⁰⁹ судалгааны тайланд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйлийг бодитой тогтоож, түүнд үндэслэн урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой, нэгдсэн зохион байгуулалттайгаар, тодорхой төсөв хөрөнгө төлөвлөн зарцуулж хэрэгжүүлснээр үр дүнд хүрэх боломжтой гэж дүгнэжээ.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд улс орны дотоод аюулгүй байдал, иргэд, олон нийтийн амар амгалан байдлыг хангах эрхэм зорилгыг хэрэгжүүлэх 2019, 2021 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийсэн тайлангийн үр дүнгээс үзвэл цагдаагийн

¹⁰⁷ Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээ-2017. Судалгааны тайлан. Нээлттэй нийгэм форум. УБ., 2018. 110-111 дэх тал

¹⁰⁸ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2017. Судалгааны тайлан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл. УБ., 2018. 227-228 дахь тал

¹⁰⁹ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016. Судалгааны тайлан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл. УБ., 2017. 660 дахь тал

байгууллагаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанарыг үнэлэхдээ нэн тэргүүнд үйлчилгээний орчин нөхцөл чухал юм байна. Энэ тухайд иргэд, хамтран ажиллагч байгууллагууд болоод цагдаагийн алба хаагчдын зүгээс алба хаагчдын техник хэрэгсэл, хангамжийн хүрэлцээт байдлыг санал нэгтгэйгээр "хангалтгүй" гэж дүгнэсэн. Хангалтгүй, хүрэлцээгүй байдал нь ажлын үр дүн, чанарыг буруулах, иргэд болон алба хаагчдад эрүүл мэнд, аюулгүй байдал, сэтгэл зүйд нь хохирол учруулдаг байна.

Дүгнэлт:

Нэг. Нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, нийтийн хэв журам хамгаалах нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэсэн ойлголтоос өргөн хүрээтэй бөгөөд агуулгын хувьд өөртөө багтаасан ойлголт юм. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнд нийгмийн дэг журмыг бэхжүүлэх зорилгыг хангах боломжгүй. Харин нийгмийн дэг журмыг бэхжүүлэх ажлын явцад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зорилго хангагдаж болно. Иргэний ухамсар, соёлыг төлөвшүүлэх нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндсэн чиглэл мөн боловч эцсийн зорилгод хамаарахгүй гэж үзэж байна.

Хоёр. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж түүний үр дүнг олон нийтийн хяналтын болон иргэний зөвлөлийн хурлаар тооцож байх нь үр дүнд хүрэх учиртай.

Гурав. Цагдаагийн байгууллагад урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ажилтны тоог нэмэгдүүлэх, цагдаагийн алба хаагчийн нийтлэх үүргийн дагуу гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил бүхий л шатны алба хаагчдын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байгааг нь тоон үзүүлэлтээс харагдаж байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараахь саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрт урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөлтийг тодотгох,
2. Иргэдийн ухамсарыг төлөвшүүлэхэд нөлөөллийн арга хэмжээг тогтоомол зохион байгуулах.
3. Урьдчилан сэргийлэх ажилд бүх шатны алба хаагч нарыг хамруулахын тул ажлын үзүүлэлтэд тусган оруулах.

Ашигласан материал

Монгол Улсын хууль:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
3. Цагдаагийн албаны тухай хууль

Сонин сэтгүүл:

4. Төрийн мэдээлэл. 1992. №1.
5. Төрийн мэдээлэл. 2017. №8
6. Төрийн мэдээлэл. 2019. 24.

Судалгааны тайлан:

7. Цагдаагийн Ерөнхий Газрын Хүний нөөцийн мэдээ. 2022
8. Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээ-2017. Судалгааны тайлан. У6.2018
9. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016. У6. 2017
10. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2017. У6. 2018
11. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан. У6.2019

Цахим эх сурвалж

12. www.1212.mn
13. www.police.gov.mn
14. www.legalinfo.mn

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ДУУДЛАГА, МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Г.Бямбадорж

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн ахлах багш, магистр,
цагдаагийн дэд хурандаа*

Товч агуулга: Цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн дуудлага мэдээллийг хүлээн авч шалгах ажиллагааны дэс дараалал, алхам, насанд хүрээгүй хүний аюулгүй байдлыг хангах, дуудлага мэдээлэл шалгахад үл хамаарах нөхцөл байдал зэргийг товч дурьдаж өөрийн санал, дүгнэлтээ дэвшүүлсэн.

Түлхүүр үгс: Баримт мэдээлэл, дуудлага, шийдвэрлэх, алхам, шалгах ажиллагаа

Үндсэн хэсэг. Сүүлийн жилүүдэд нийгмийн мэдээллийн хурдац өсөн нэмэгдэж, төрийн болон төрийн бус байгууллагуудаас хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх талаар сурталчилгааны ажлууд өргөнөөр хийгдсэнээр иргэдийн ойлголт мэдлэг, хандлага өөрчлөгдөж, цагдаагийн байгууллагаас тусламж үйлчилгээ хүсч, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл нэмэгдэж байна.

Энэ сэдвийн хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх, цагдаагийн байгууллагын мэдээллийн сан бүрдүүлэх, энэ төрлийн дуудлага мэдээллийн онцлог, шалгах ажиллагааны явцад анхаарах асуудлын талаар нэгдсэн ойлголттой болохыг чухалчилж байна.

Дуудлага мэдээлэл шалгах ажиллагаа

А. Дуудлага хүлээн авагчийн үүрэг:

- Дуудлага, мэдээлэл өгсөн иргэний аюулгүй байдлыг асууж, цагдаагийн ажилтан очих боломжит хугацааны талаар мэдэгдэнэ.
- Аюулгүй байдлыг хангах үүднээс цагдаагийн ажилтан хэргийн газар дээр очтол дуудлага өгсөн иргэнийг утсан дээр барьж байхыг эрмэлзэнэ.
- Мэдээллийн сангаас тухайн айл өрх, дуудлага өгөгч болон хүчирхийлэл үйлдэгчийн мэдээллийг шалгаж, дуудлага шалгах цагдаагийн ажилтанд өгнө.
- Дуудлага, мэдээлэл өгөгч дараагийн дуудлагаараа эхний дуудлагыг хүчингүй болгохыг хүссэн ч эхний дуудлагыг хүчингүй болгохгүй. Дуудлагыг үргэлжлүүлэн шалгаж, талууд аюулгүй байдлыг баталгаажуулна.
- Дуудлага, мэдээллийг цахим санд бүртгэн, дуудлагын бичлэгийг хадгална.
- Дуудлага өгсөн хүнтэй хүчирхийлэл үйлдэгчид оногдуулах хариуцлагын талаар урьдчилан ярилцах ёсгүй.

Б. Хариуцлагатай зохицуулагчийн үүрэг:

- Дуудлага мэдээллийн дагуу ажиллаж байгаа цагдаагийн ажилтнуудын шалгах ажиллагааг зааварчилж, шуурхай ажиллагааг удирдана.
- Утсаар дуудлага өгч байх явцад дуудлага тасарсан, эсхүл түүнийг үгүйсгэсэн шинжтэй мэдээллийг өөр хүн өгсөн тохиолдолд дуудлага хаанаас ирснийг тогтоох, хаягаар нь шалгуулах арга хэмжээг авна.
- Цагдаагийн ажилтны хүргэж ирсэн болон өөрөө хүрч ирсэн хүчирхийллийн хохирогч, хүчирхийлэл үйлдэгч нарын хэрэг, зөрчлийн асуудлыг шийдвэрлэнэ.
- Хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор шаардлагатай гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг шуурхай авна.

- Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл шалгасан байдал хангалтгүй бол шалгалтын дүнг хүлээн авалгүй буцааж, зөрчил дутагдлыг арилгуулна.

- Хүчирхийлэгч этгээд гараад зугтсан тохиолдолд албадын ажлыг уялдуулан зохицуулах, зарлан мэдээлэх, эрэн сурвалжлах үйл ажиллагааг ЦБҮАЖ-ын 228-т заасны дагуу цаг алдалгүй шуурхай зохион байгуулна.

В. Дуудлага шалгах цагдаагийн ажилтны үүрэг:

1 дүгээр алхам: (нэвтрэх)

- Дуудлагад хоёроос доошгүй цагдаагийн ажилтан очиж ажиллана.
- Цагдаагийн ажилтнууд өөрсдийн аюулгүй ажиллагааг хангана.
- Аюулын эрсдэлийн үнэлгээ, илтгэх хуудасны маягтыг авч очно.
- Тухайн айл болон иргэний талаарх мэдээллийг сангаас шалгасан байна.
- Хүчирхийлэгчийг зугтахаас сэргийлж тусгай дуут дохиог унтраана.
- Цагдаагийн автомашиныг тохиромжтой газар байрлуулна.
- Дуудлага өгсөн газар орчныг шалгана.
- Гүйцэтгэх үүргийг урьдчилан ярилцаж, ажил үүргээ хуваарилна.
- Хохирогчид аюул учрахаар бол хүч хэрэглэн дотогш нэвтэрнэ.
- Шаардлагатай тохиолдолд нэмэлт бүрэлдэхүүнийг дуудна.

2 дугаар алхам: (шалгах)

- Хойшлуулшгүй ажиллагаанаас бусад тохиолдолд өөрсдийгөө танилцуулна.

- Хүчирхийлэл үйлдэгчид хүчирхийлэл үйлдэх, согтууруулах ундаа хэрэглэхийг зогсоохыг шаардахдаа боломжит хэлбэрээр урьдчилан сануулна.

- Хохирогч, гэр бүлд хамт амьдарч байгаа бусад хүн, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, тодорхой шалтгаанаар гэр, орон байранд хамт амьдарч байгаа бусад хүнийг хохирсон эсэхийг шалгана.

- Хохирогчийн сэтгэл санааны байдлыг ойлгож, хүлээцтэй, итгэл төрүүлэхүйц хандана.

- Дуудлага шалгахдаа төвийг сахисан байр суурьнаас харилцаж, өөрийн хувийн үзэл бодол, аливаа дүгнэлт гаргахаас зайлсхийнэ.

- Хохирогч, хүчирхийлэл үйлдэгчийг талууд бие биенээ харахгүй, сонсохгүй, тухайн орчны хүмүүс, хөршүүдээс салангид газар орчинд байлцуулан болсон үйл явдал болон санал хүсэлтийг тодруулж, тэмдэглэнэ.

- Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй мөн эсэхийг тухайн нөхцөл байдалд хохирогчийн биед үүссэн гэмтэл, бэртэл, хувцасны урагдал зэргийг ажиглах, гомдол мэдээлэл гаргагчтай харилцан ярилцах, хэргийн газар орчныг шалгах зэрэг энгийн аргуудаар тогтооно.

- Монгол хэл, бичиг мэдэхгүй, хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хохирогчид орчуулагч, хэлмэрчээр дамжуулан харилцана.

- Хохирогчийн биед учирсан гэмтлийн ул мөр болон эд зүйлийн эвдрэл хэмхрэл бүрийг хуульд заасан журмын дагуу үзлэгийг хийж баримтжуулан, бодитойгоор үнэлнэ.

- Дүрс бичлэг, дуу хураагуур ашиглан үйл явдлыг давхар баримтжуулна.

- Гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд хэрэглэсэн эд зүйлсийг эд мөрийн баримтаар хураан авна.

- Шаардлагатай тохиолдолд хэргийн газрын хамгаалалтыг ЦБҮАЖурмын 205-т заасны дагуу авна.

3 дугаар алхам: (туслах)

- Хохирогч, хүчирхийлэл үйлдэгчид хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлаж, хохирогчид үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг бичгээр өгнө.

- Шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж үйлчилгээнд холбоно.

- Хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогчийг хамгаалах байранд хүргэнэ.

- Орон байрнаасаа хувцас, эм, эмчилгээний хэрэгсэл, баримт бичиг, хүүхдийн сургалтын хэрэгсэл зэрэг нэн шаардлагатай хэрэглээний эд зүйлээ авахад нь туслалцаа үзүүлж, хүчирхийлэл үйлдэгчээс шаардан гаргуулна.

4 Дүгээр алхам: (шийдвэрлэх)

- Гэмт хэргийн шинжтэйгээс бусад тохиолдолд холбогдогчид гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага ногдуулж болох тухай сануулна.

- Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлнэ.

5 дугаар алхам: (аюулын зэргийн үнэлгээ хийх)

- Хохирогчийн аюулын зэргийн үнэлгээг хийнэ. Аюулын зэргийн үнэлгээг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн болон үйлдэгдсэн байж болох орчинд эсхүл хохирогчийн байгаа газарт очиж хийнэ.

- Аюулын зэргийн үнэлгээг үндэслэн хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний төв, эсхүл түр хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садан, ойр дотных нь хүний хамгаалалтад өгөх, шаардлагатай бол хүчирхийлэл үйлдэгчийг баривчилна.

- Аюулын зэргийн үнэлгээгээр эрсдэл өндөртэй, эсхүл хүүхэд хүчирхийлэлд өртсөн бол тухайн хохирогч зөвшөөрөл өгсөн эсэхийг үл харгалзан харьяа нийгмийн ажилтанд мэдэгдэнэ.

- Галт зэвсэг, хүчирхийлэл үйлдэхэд ашигласан зэвсэг, зэвсгийн чанартай зүйлийг хураан авна.

- Шалгасан дуудлага, мэдээлэл гэмт хэргийн шинжтэй бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахаар цагдаагийн байгууллагад хүргэнэ.

- Цагдаагийн алба хаагч нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийг шалгахдаа холбогдох хууль тогтоомж болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 202, 212-219, 222, 224, 228, 244, 408-т заасныг баримтална.

- Дуудлага, мэдээлэл шалгасан талаар илтгэх хуудас бичнэ.

- Дуудлага, мэдээлэл шалгасан талаар санд мэдээлэл нэн даруй оруулна.

- Дуудлага, мэдээллийг хуулийн дагуу түргэн шуурхай шалгаж буй эсэхэд шууд удирдах дарга нь хяналт тавьж ажиллах үүрэгтэй.

Насанд хүрээгүй хүний аюулгүй байдлыг хангах ажиллагаа

- Дуудлага өгөгдсөн газарт насанд хүрээгүй хүүхэд байгаа эсэхийг тогтооно.

- Насанд хүрээгүй хүнд тусламж шаардлагатай эсэхийг тогтооно.

- Насанд хүрээгүй хүнд цагдаагийн байгууллагаас авах гэж байгаа арга хэмжээний талаар энгийн, ойлгомжтой байдлаар тайлбарлан, хүсэлтийг хүлээн авна.

- Шаардлагатайгаас бусад тохиолдолд цагдаагийн алба хаагчаас хүч хэрэглэсэн үйлдлийг насанд хүрээгүй хүнд харуулахгүй байхыг эрмэлзэнэ.

- Насанд хүрээгүй хүнийг хүчирхийлэл үйлдэгчтэй нэг орчинд үлдээхгүй.

Хэрэв хүүхэд өөрийн хууль ёсны төлөөлөгчийн хүчирхийлэлд өртсөн бөгөөд аюулын эрсдэлийн зэрэг дунд болон өндөр, эсхүл дараах нөхцөл тогтоогдвол эцэг эх, хууль ёсны төлөөлөгчийн саналыг харгалзахгүйгээр хамгаалах боломжтой хүн, гэр бүлд хүлээлгэн өгөх, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр, эсхүл асрамж, халамжийн үйлчилгээний байгууллагад хүргэх арга хэмжээг авна. Үүнд:

- хүчирхийллийг хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюултай аргаар үйлдсэн, эсхүл үйлдэж болзошгүй;

- хүүхдээ барьцаалсан, барьцаалж болзошгүй;

- хүүхдийн эмзэг байдлыг далимдуулан өөрт ашигтай шийдвэр гаргуулах, ашиг олоход ашигласан, ашиглаж болзошгүй;

- хүүхдийг айдас, сэтгэл санааны дарамтад оруулсан, оруулж болзошгүй;

- хүчирхийлэл үйлдэгч согтуурсан, мансуурсан байдалтай, эсхүл байнга согтуурдаг, мансуурдаг бол.

- Хүүхдийг хүнд хүлээлгэн өгөх бол түүнд эрх, үүргийг сануулж, бичгээр баталгаажуулна.

- Хохирогч хүүхэд долоо, түүнээс дээш настай бол хамгаалах боломжтой хүн, гэр бүлийг сонгохдоо түүний саналыг харгалзана.

Дуудлага мэдээлэл шалгасан тухай илтгэх хуудас, тэмдэглэл үйлдэх

Нөхцөл байдлыг сайтар нягталсны үндсэн дээр илтгэх хуудас бичнэ. Илтгэх хуудсанд дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:

Нэг дүгээрт: (нөхцөл байдал)

- дуудлага, мэдээлэл аваад очсон, шалгасан хугацаа;
- хохирогчийн болон хүчирхийлэгчийн анхны байр байдал сэтгэгдэл, тухайн орчин;
- хохирогчийн болон хүчирхийлэгчийн хамаарал;
- хохирогчийн болон хүчирхийлэгчийн бэртэл гэмтэл;
- эмнэлгийн тусламж авсан байдал;
- хүчирхийлэл үйлдэгдэх болсон шалтгаан;
- хүчирхийлэл үйлдсэн арга;
- хүчирхийлэгчийн заналхийлсэн байдал;
- зэвсэг хэрэглэсэн байдал, зэвсгийн төрөл;
- архи, согтууруулах ундаа хэрэглэсэн байдал;
- хохирогч болон хүчирхийлэгчийн хувийн мэдээлэл;
- хүчирхийллийн хэлбэр, үргэлжилсэн хугацаа, давтамж;

Хоёр дугаарт: (авсан арга хэмжээ)

- зураг авч, бичлэг хийсэн байдал; хохирогчийг хамгаалалтад авсан байдал;
- хүчирхийлэгчийг баривчилсан, саатуулсан байдал;
- хохирогчид шаардлагатай эд зүйл авч өгсөн байдал;
- хохирогчийг шаардлагатай байгууллагад холбон зуучилсан байдал;
- хохирогчид эрх зүйн зөвлөлгөө өгсөн байдал.

3 дугаарт: (шийдвэрлэлт)

- аюулын эрсдэлийн үнэлгээ;
- шийдвэрлэсэн байдал;
- илтгэх хуудас хүлээлгэж өгсөн цагдаагийн ажилтан.

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн дуудлага, мэдээллийн шалган шийдвэрлэхэд анхаарах асуудал

А. Дуудлага, мэдээлэл шалгах:

- Хүчирхийлэл үйлдэгч өөрийн гэр оронд хүч чадалдаа эрдсэн, дээд зэргийн сэтгэл хөдлөлд автсан байдгийг анхаарна
- Дуудлага нь хохирогч болон дуудлагаар очсон цагдаагийн ажилтны аюулгүй байдалд халдах магадлалтай байдаг.
- Хохирогч хүчирхийлэл үйлдэгчид арга хэмжээ тооцуулахыг хүсэж байвч хариуцлага хүлээлгэх болоход түүнийг өрөвдөх, өмөөрөх хандлага заримдаа гаргадаг.
- Хохирогчоос хүчирхийлэл үйлдэгчийн дэргэд тайлбар авч болохгүй. Учир нь хүчирхийлэл үйлдэгч хохирогчийн хүсэл зоригийг өөрийн дохио зангаа, харц, харилцаагаар хорьж, шахалт үзүүлдэг.
- Гэр бүлийн хүчирхийллийн хэргийн онцлогоос үзэхэд хүчирхийлэл нь анхных ч биш, эцсийнх ч биш байдаг бөгөөд хохирогч болоод гэр бүлийн бусад гишүүд хэзээд ч хүчирхийлэлд дахин өртөх эрсдэлтэй байдаг.
- Хохирогч өөрөө хүсэхгүй байсан ч гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг шүүхээр орж, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох ёстой.
- Хохирогчийн амьдралын хэв маяг, хандлага үйлдлийг шүүмжлэх, буруутгасан, мохоосон үг хэрэглэх, үйлдэл гаргаж болохгүй.

- Хохирогчийг үл хүндэтгэсэн, буруутгасан, бодит байдлыг гуйвуулсан, үл итгэсэн, цаашид гаргах хүсэлтийг няцаасан байр сууринаас хандаж болохгүй.

- Хохирогчийг хамгаалах байранд хүргэх тохиолдолд очихоосоо өмнө түр хамгаалах байрны ажилтанд урьдчилан мэдэгдэх нь зүйтэй.

Б. Хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажиллахад анхаарах асуудал:

- Эцэг эхийн хооронд болж байгаа хүчирхийллийн зөрчил хүүхдийн сэтгэл зүйд хүндээр тусдаг

- Эцэг эхийнх нь нэгний эсрэг явуулж буй цагдаагийн шуурхай ажиллагаа хүүхдэд айдас төрүүлсэн явдал байдаг

- Хүүхэд болж буй явдлыг хэд дахин илүүгээр хүлээж авдаг

- Хүүхэд эцэг, эхийнхээ талд байж гэр бүлийн нууцыг задруулахыг хүсдэггүй

- Насанд хүрэгчдийн хооронд, тэр дундаа эцэг, эхийн хоорондох хүчирхийллийг харсан хүүхэд айж почирддог

- Хүчирхийлэл хүүхдийн эрх дураараа байдаг, байх дуртай гэр оронд нь явагддаг.

- Хүүхэд эцэг, эхийнхээ аль алинд нь хандаж чадахаа болиод айдсын мэдрэмжүүдтэйгээ ганцаараа үлддэг

- Өөрөө байнгын айдас, эргэлзсэн дунд амьдарч буй эцэг эхийн аль нэг нь хүүхдийнхээ сэтгэл санааны байдалд анхаарал хандуулж чаддаггүй

- Хүчирхийлэл харсан хүүхдүүд үгүйсгэх, зайгаа авах, уурлаж бухимдах зэрэг өөрийн аргаар айдсаа дарж сурсан байдаг

В. Хохирогчийн хандлага:

- Идэвхгүй байдалтай. Дуу гарахгүй, биеэ барьсан, хүчирхийллийн талаарх асуултад хариулах дургүй.

- Үгүйсгэх байр суурьтай. Болсон явдлыг үгүйсгэнэ, хариугүй жаахан зүйл гэж үзэх ба хүчирхийлэгчийг цагдаагаас өмөөрнө, цагдаад уурлана.

- Ууртай. Өмнө нь гомдол гаргасаар байтал цагдаагийн байгууллага хамгаалж чадалгүй ийм байдалд хүргэсэн, хүчирхийлэл болоод дууссаны дараа ирсэн, цаг тухайд нь хамгаалж чадаагүй гэх мэт шалтгаанаас хохирогч ууртай байж болно.

- Айдаст автсан. Цагдаа дуудсандаа хүчирхийлэл үйлдэгчээс айх, цагдаа ирлээ гээд хүчирхийлэл зогсохгүй байх гэж айх, цагдаа хүчирхийлэл үйлдэгчид итгээд өөрт нь итгэхгүй байх гэж айх, хүчирхийлэл үйлдэгч хүүхдүүдийг айлган сүрдүүлсэн учир хууль цагдаа хүүхдүүдийг нь аваад явчих вий гэж айх, хүчирхийлэл үйлдэгчийг баривчлаад явахад гарч ирээд үйлдэх хүчирхийллээс айх.

Дуудлага мэдээлэл, гомдол шалгахад үл хамаарах нөхцөл байдал:

- хохирогч хүчирхийлэгч этгээд гэр бүлийн харилцаатай эсэх;
- хохирогч хүчирхийлэгч этгээдтэй нэг дор амьдардаг эсэх;
- хохирогчийн биед нүдэнд харагдах гэмтэл бэртэлгүй;
- ажил, нийгмийн байдал болон баривчлан саатуулахад гарах үр дагаврууд;
- хүчирхийлэл үйлдэгчийн урьдчилсан амлалт, харилцан тохиролцсон байдал;
- хүчирхийлэл үйлдэгчийн хүчирхийллийг зогсооно гэсэн аман баталгаа;
- эрүүгийн хариуцлага ноогдуулахаар хэрэг биш юм шиг санагдах гэх мэт.

Дүгнэлт. Гэр бүлийн хүчирхийллийн аливаа гэмт хэрэг, зөрчлийн талаарх нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх ажиллагаа нь анхан шатны ажиллагаа буюу гомдол, мэдээллийг хүлээн авч шалгах ажиллагаанаас хамааралтай байна.

Гэр бүлийн хүчирхийллийн талаарх гомдол, мэдээлэл нь бусад төрлийн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллээс гэр бүлийн харилцаанд үүссэн, нэн даруй арга хэмжээ авах шаардлагатай маш өндөр эрсдэлийг дагуулсан байдгаараа онцлог юм. Энэ төрлийн хэрэг, зөрчлийг шалгаж эхлэх үед гэмт үйл явдал болоод өнгөрсөн байдгаас түүнийг судлан шинжилж, танин мэдсэнээр өнгөрсөн үйл явдлыг сэргээн тогтоох зорилгыг хангахад гомдол мэдээллийг шалгах ажиллагаа чиглэгдэж байна.

Мөн дуудлага мэдээллийг шалгахдаа тухайн үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн онцлог, мэдээллийг хүлээн авсан цаг хугацаа, хэргийг шалгаж эхлэх үеийн нөхцөл байдал зэргийг харгалзан мөрдөн шалгах ажиллагааны дарааллыг тогтоох ач холбогдолтой байна.

Санал

- Дуудлага, мэдээллийг хүлээн авах, шалгаж шийдвэрлэх үйл ажиллагааны журмын дарааллыг дээр дурьдсан таван алхамын дагуу нэг бүрчлэн гүйцэтгэх;
- Дуудлага, мэдээлэл шалган шийдвэрлэх явцад цугуулж бэхжүүлсэн баримт, холбогдох мэдээллийг нотлох баримтын хэмжээнд үнэлэх;
- Дуудлага мэдээллийн аудио бичлэгийг хуулбарлаж, шалгаж буй эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн авч, гэмт хэрэг, зөрчлийн материалд хавсаргаж хэвших;
- Прокурор гомдол мэдээллийг хүлээн авмагц эрх бүхий ажилтан зайлшгүй хийж гүйцэтгэвэл зохих ажиллагаанууд бүрэн хийгдсэн эсэх, тухайн хэргийн нөхцөл байдалд тохируулан хариу арга хэмжээ авах талаар заавар, чиглэл өгч тодорхой ажиллагааг түргэн шуурхай хангуулахад хяналтаа чиглүүлж ажиллах;

**ЦАГДАН СЭРГИЙЛЭХ БАЙГУУЛЛАГААС 1980-ААД ОНУУДАД
ХАР ТАМХИТАЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ
БАЙСАН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ**

Г.Өлзийбуян

*ДХИС-ийн магистрант,
цагдаагийн хошууч*

Товчлол. Хар тамхи гэдэг бол хүний уураг тархи, мэдрэлийн систем, оюун ухаанд бодитоор нөлөөлөхүйц хүчтэй байгалийн болон химийн гаралтай мансууруулах үйлчилгээтэй ургамал юм.

Мансууруулах бодис нь каннабиноид, марихуан, гашиш гэх мэт олон төрөл, хэлбэртэй байдаг бөгөөд сүүлийн үед мансууруулах бодис хэрэглэгчдийн нас улам залуужиж, хамгийн бага нас нь манай улсын хувьд 13 болсон гэх харамсалтай мэдээлэл байгаа нь өнөөдрийн тулгамдсан асуудал болоод байна.

Энэхүү өгүүлэлд хар тамхи, мансууруулах бодисны тухай ойлголт, шинж, төрөл, хэлбэр болон Цагдан сэргийлэх байгууллагаас 1980-аад оны сүүлээр авч хэрэгжүүлж байсан ажил, арга хэмжээний талаар товч авч үзсэн болно.

Түлхүүр үг. Цагдан сэргийлэх байгууллага, мансууруулагч бодис, хорын дон, насанд хүрээгүй хүмүүс, наркотик, албадан эмчлэх, сэтгэл мэдрэлийн өвчин, зарлиг

Үндсэн хэсэг. Монгол Улсад үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу хориглосон мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын агууламжтай ургамал, бэлдмэл, бодисыг энгийн ярианд “хар тамхи” гэж хэлж нэршсэн байдаг.

Анагаахын шинжлэх ухаанд “мансууруулах сэтгэцэд нөлөөт бодис” гэдэг нь тухайн бодисыг хэрэглэсэн хүн болон амьд организмын уураг тархи буюу төв мэдрэлийн системд дарангуйлал үүсгэн үйлчилж, мансуурал гэж нэрлэх сэтгэцийн тогтворгүй байдлыг үүсгэх чадвартай эм бэлдмэл бодисуудыг хэлнэ.

Нийгмийн шинжлэх ухаанд аливаа мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, бодисыг хэрэглэсэн этгээдийг зан үйлийн болон ёс суртахууны зөрчил рүү түлхэн, гэмт хэрэг үйлдэх нөхцөл бололцоог бий болгож, улмаар нийгэмд хор хохирол учруулах чадвар бүхий бодис, түүнийг агуулсан эм бэлдмэлийг хэлнэ гэж тус тодорхойлсон байдаг.

Хууль, эрх зүйн салбарт Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын 1961 оны “мансууруулах эмийн тухай”, 1971 оны “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай”, 1988 оны “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодисын хууль бус эргэлтийн эсрэг” конвенцын жагсаалтад орсон байгалийн гаралтай, мөн нийлэгжүүлсэн бодисуудын хэрэглээнээс бий болох эрүүл мэндийн болон нийгмийн сөрөг үр дагаврыг нь харгалзан мансууруулах сэтгэцэд нөлөөт бодис болохыг нь тогтоож хяналтаас гадуур /эрүүл мэндийн салбар, судалгаа шинжилгээний бус зорилгоор/ хэрэглэхийг хориглон, тусгай жагсаалтад оруулсан бодис, эм бэлдмэлийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис гэж тайлбарладаг.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 3.1.1-д “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис”¹¹⁰ гэж донтуулах болон сэтгэцэд бусад хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, "Мансууруулах эмийн тухай" 1961 оны НҮБ-ын Конвенци¹¹¹, "Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай" 1971 оны НҮБ-ын Конвенцийн жагсаалтад заасан, хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад хяналтад байлгавал зохих эм, байгалийн болон нийлэгжүүлсэн бэлдмэлийг¹¹² гэж тодорхойлсон.

¹¹⁰ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002, №46. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль

¹¹¹ <https://legalinfo.mn/mn/detail/1206>

¹¹² Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002, №46. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль

Хар тамхи нь хүний бие организмд тайвшруулах “саатуулах” үйлчлэл үзүүлдэг сэтгэцэд хүчтэй нөлөөлдөг бодис юм. Хар тамхины бүлэгт морфин төст нэгдэл агуулсан байгалийн гаралтай болон нийлэг бодисууд хамаардаг. Ихэнх тохиолдолд судсаар тарьж хэрэглэдэг нь түгээмэл юм.

Мансууруулах бодис гэдэг нь 1961 оны Мансууруулах бодисын тухай нэгдсэн конвенцийн дагуу тус улсын нутагт хяналтанд байдгавал зохих байгалийн болон нийлэгжүүлсэн бодис, бэлдмэлийг хэлдэг.¹¹³

Хар тамхи нь хүний бие, эрүүл мэндэд дараах сөрөг үр дагавар, нөлөөллийг үзүүлдэг байна. Тухайлбал:

- Ганц удаа хэрэглээд давтан хэрэглэж эхэлдэг. Хар тамхийг анх хэрэглэж эхэлсэн хүн “Ганц удаа татлаа гээд орчихгүй” хэмээн найдаж, түүндээ лавшран, дараа дараагийн удаа хэрэглэсээр нэг мэдэхэд бүр мөсөн орж, бие сэтгэлээ захирч чадахгүй болсон байдаг.

Хар тамхины найрлага нь хүний цусыг бохирдуулснаар донтуулдаг. THC (tetrahydrocannabinol) хэмээх бодис нь уураг тархинд шууд нөлөөлж, дофамины (адреналинийг ихэсгэж, донтох эмгэгийг үүсгэдэг) хэмжээг эрс нэмэгдүүлж, биеэ барих чадварыг алдагдуулдаг. Ингэснээр хүн өөрийн мэдэлгүй амиа хорлох, бэлгийн харьцаанд орох, бие эрхтнээ гэмтээх зэрэг үйлдлийг хийдэг.

- Тархины эд эсийг эргэж сэргэхгүйгээр үхүүлдэг. Нисэж байгаа мэт мэдрэмж төрж, сэтгэл санаа огцом дээшилж, эсвэл огцом сэтгэл санаагаар унаж, үхэх хүсэл төрнө. Энэ нь тархин дахь дааврын хэмжээ өөрчлөгдөж байгаагаар холбоотой. Цаагуураа тархины эдийг үхжүүлж, хэвийн сэтгэх үйл ажиллагааг доголдуулж байдаг.

- Сэтгэцийн эмгэг үүснэ. Хар тамхийг хэр их хэрэглэнэ тэр хэмжээгээрээ донтох үйлчилгээ тэлж, биемахабодийг хамрах хүрээ нь өргөжиж байдаг. Тархины мэдээлэл хадгалах, санах ойд нөлөөлж, сэтгэцийн эмгэг үүсгэх аюултай.

- Өөрийгөө удирдаж чадахаа болино. Цусны судсыг тэлснээс болж нүд улайн, аргадаг. Тархинд шууд нөлөөлдөг гэж дээр дурьдсан даа. Ингэснээр сэтгэл санаа тогтворгүйжиж, өөрийгөө удирдаж, захирч чадахаа байна. Энэ нь өөртөө болон орчин тойрондоо муу нөлөө үзүүлэх эх үндэс болдог. Шим тэжээлийн дутагдалд орж, турж эцнэ

- Харах, үнэрлэх, сонсох мэдрэхүйд шууд нөлөөлж, хий юм харах, чих шуугих шинж тэмдгүүд илэрнэ. Түүнчлэн ходоод гэдэсний хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, хоолны дуршлыг бууруулна. Яваандаа мансууруулах бодисноос өөр зүйл хүсэхээ болин, шим тэжээлийн дутагдалд орж, турж эцнэ. Эрт хөгширч, үс унаж өнгө чанараа алдана

- Нүүрэн дээр юм гарч, арьсны эд үхжиж, арьс харлаж, өтлөх шинж харьцангуй хурдсана. Үс унаж, өнгөлөг чанараа алдана. Зүрхний хэм өөрчлөгдөж үхэх аюултай.

- Хар тамхи татсанаас нэг минутын дотор зүрхний хэмнэлд өөрчлөлт гарч, зүрхний цохилт минутанд 20-50-аар нэмэгддэг. Тус шинж 20 минутаас 3 цаг үргэлжилж эцэстээ үхэх аюултай. Сэтгэлд гутралд орно.

- Мансууруулах бодисны үйлчилгээ гарсны дараа толгой хүчтэй эргэх, харааны фокус алдагдах, маш ихээр сульдаж ядрах, нойргүйдэх, сэтгэл гутралд автах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг.¹¹⁴

Дашрамд дурьдахад хар тамхи хэрэглэдэг хүмүүсийн 20 хувь нь өөрийн санаачилгаар гарах тухай боддог бол үлдсэн 80 хувь нь эмч болон тусгай мэргэжилтний тусламжтайгаар гарах шаардлагатай байдаг байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/16 дугаар тушаалаар тус газрын орон тоог 46 аар нэмэгдүүлж, бүтцийг шинэчлэн хар тамхины гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, төрийн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэйгээр ажиллаж байна.

¹¹³ <http://criminology.mn/wp-content/uploads/2020/11/2019-%E2%84%962.pdf>

¹¹⁴ <http://www.oloo.mn/n/64818.html>

Үүнтэй холбогдуулан олон төрлийн материал, архивын нэгж тус газарт шилжин ирсэний дотор тухайн үеийн төр засгийн зүгээс хар тамхитай /хорын дон/ тэмцэх чиглэлээр 1988 онд авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, тоо мэдээ, танилцуулга бүхий 297 хуудас материалыг түүвэрлэн 28 хуудас материалыг судалсанаа танилцуулж байна.

Зарим бүртгэл судалгаа, танилцуулгад хүний овог нэр, нас, сургууль, анги удирдсан баг, эцэг эхийн нэр хаяг, эрхэлсэн ажил, сурагчийн анги, бүлэг, гэрийн хаяг, мансуурдаг хэлбэр, хэрэглэдэг бодис, үйлдсэн гэмт хэргийн талаар тодорхой дурьдсан тул энд дэлгэрэнгүй бичээгүй, материалыг хавсаргаагүй болно.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Нийгмийн аюулаас хамгаалах яамны нэгдүгээр орлогч сайд, Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын дарга, хошууч генерал С.Дамдинсүрэн Монгол Ардын Хувьсгалт намын Төв хорооны Захиргааны байгууллагын хэлтсийн эрхлэгч Л.Моломжамц, Нийгмийн аюулаас хамгаалах яамны сайд, дэслэгч генерал А.Жамсранжав нарт 1987 оны 3 дугаар сарын 27-ны өдөр “Мансууруулагч бодис хэрэглэж байгаа насанд хүрээгүй хүмүүсийн тухай”¹¹⁵ танилцуулгыг хүргүүлсэн байна.

Уг танилцуулгад Улаанбаатар, Дархан /тухайн үеийн/ хотод химийн зарим төрлийн мансууруулагч бодисыг насанд хүрээгүй хүмүүсээс хэрэглэх явдал цөөн тоотойгоор бүртгэгдэж, тэдэнд чиглэсэн үйл ажиллагааг 1983, 1985 онд улс, олон нийт, хууль хяналтын байгууллагууд зохион байгуулсан боловч тодорхой үр дүн хүрээгүй, энэ явдлыг таслан зогсоож чадаагүй, насанд хүрээгүй хүмүүсээс энэ төрлийн өвчнөөс буюу хорын донгоос шалтгаалсан нас баралт 1988 онд анх бүртгэгдэж эхэлсэн талаар дурдаж доорх ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

1. Эрүүлийн хамгаалах яамтай хамтран гутлын цавуу үнэрлэх, демодрол ууж мансуурахын хор холбогдлыг сурталчлах сарын зохистой ажил зохиох, */энэ ажлыг цаг үеэ олоогүй гэх шалтгаанаар хойшлуулсан/*

2. ХХҮЯ-тай хамтран гутлын цавууны хадгалалт, хамгаалалтад шалгалт хийх, гутлын цавууг үйлдвэр, гутал засварын газраас гадагш гаргахгүй байх арга хэмжээ авах, */нийт 12 удаагийн шалгалт хийж, дүн танилцуулсан/*

3. Гутлын цавуу үнэрлэх, демодрол ууж мансуурах явдал анх хаанаас гарсан, хэн хэн хэрэглэж байгааг нэгбүрчлэн тогтоож, хараа хяналтадаа бүрэн авч урьдчилан сэргийлж, таслан зогсоох саналтай байгааг илтгэн танилцуулсан байна¹¹⁶.

Дээрх танилцуулгаас харахад 1983-1985 оны хооронд насанд хүрээгүй хүмүүс тухайн үед ашиглаж байсан “Уколет PS”, “Уколет КМ-1” цавуу, бензин зэргийг үнэрлэж бодисыг үнэрлэх хэлбэрээр хэрэглэн мансуурч, ургамлын болон синтетик гаралтай мансууруулах бодисыг хэрэглээ дэлгэрээгүй байжээ.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын боловсролын яам, Эрүүлийг хамгаалах яамны коллег, Улсын Цагдан Сэргийлэх Ерөнхий газрын зөвлөлд 1988 оны 10 дугаар сарын 07-ны өдөр танилцуулсан танилцуулгад улсын хэмжээнд бүртгэгдсэн хорын донтой 112 хүний 78 нь, мансууруулах төрлийн бодис хэрэглэдэг 215 хүний 155 нь Улаанбаатар хотод амьдардаг насанд хүрээгүй хүмүүс бүртгэгдсэн, ялангуяа нийслэл хотод бүртгэгдсэн 232 хүүхдийн 54 хувь нь Октябрийн районд, 46 хувь нь Ажилчны районд тус тус бүртгэгдсэн, нийслэл хотод зохион байгуулсан мансуурлын эсрэг арга хэмжээний дүнд 131 хүүхэд мансууруулах бодис хэрэглэхээ больж, 101 хүүхэдийн эмчилгээ үр дүнгээ өгсөн талаар дурьджээ¹¹⁷.

Мөн Улсын Цагдан Сэргийлэх Ерөнхий газар, Улсын прокурорын газар, Эрүүлийн хамгаалах яам, Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн Төв хорооноос 1987-1988 оны 1-9 сард химийн төрөл

¹¹⁵ Хар тамхитай тэмцэх газрын архив ХНЗ.1987-2011 оны хууль эрх зүйн акт. Уб. 2013. 294 дэх тал

¹¹⁶ Хар тамхитай тэмцэх газрын архив ХНЗ.1987-2011 оны хууль эрх зүйн акт. Уб. 2013. 296 дахь тал

¹¹⁷ С.Бүдрагчаа. Манай орны зарим аймаг, хотод гарч байгаа мансуурах үзэгдлийн шинж байдал, хандлага илтгэл. Уб. 1987.3 дахь тал.

бүрийн хорт бодис хэрэглэдэг насанд хүрээгүй хүмүүсийг илрүүлэх, эмчлэх зорилгоор 4 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, 327 хүүхдийг илрүүлэн, наркологийн эмчийн үзлэгт оруулж, 122 хүүхдийг сэтгэл мэдрэлийн өвчнийг анагаах больницод хэвтэн эмчлүүлсэн байна. Үүнээс 8 хүүхэд хоёрдахь удаагаа, 104 хүн анхны эмчилгээнд хамрагдсан байна.¹¹⁸

Гэвч Дархан, Эрдэнэт хот, Дорнод, Дорноговь, Хөвсгөл, Сэлэнгэ, Баянхонгор, Төв аймаг, Тусгай техник мэргэжлийн сургууль, Дарьтын хүмүүжил, хөдөлмөрийн колонид насанд хүрээгүй хүмүүс химийн мансууруулах төрлийн бодис хэрэглэж мансуурах байдал харьцангуй их бүртгэгдэж, таслан зогсоогдоогүй тул “Мансууруулах зүйл хэрэглэх явдалтай хийх тэмцлийг хүчтэй болгох арга хэмжээний тухай” Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн Зарлиг гаргуулах зорилгоор тодорхой судалгаа хийх, тандалт явуулах, нөхцөл байдлыг судлах, зарим аймагт уулзалт зохион байгуулж, “Мансуурах үзэгдэлтэй хүчтэй тэмцье” сэдэвт семинарыг зохион байгуулсан байна.¹¹⁹

Мөн гадаад улсуудад энэ чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ, хууль тогтоомж, нөхцөл байдлыг судалж, Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх тасгаас “Химийн зарим бодисыг үнэртэж, мансуурч байгаа тухай”¹²⁰ мэдээллийг бэлтгэн хүүхэд залуучуудын дунд цаашид тархаж болох химийн төрөл бүрийн бодис үнэртэж мансуурдаг үзэгдлийг урьдчилан сэргийлж, таслан зогсооход БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг гаргах нь өнөөгийн шаардлагын үүднээс тавигдаж байгааг дурьджээ.

Улаанбаатар хотоос гадна Дархан хот, Сэлэнгэ, Баянхонгор, Дорноговь аймаг, Сэлэнгэ аймгийн Ерөө дахь Техник мэргэжлийн тусгай сургууль, Дарьт дахь хөдөлмөр хүмүүжлийн колонид химийн янз бүрийн бодис үнэртэж мансуурах сонирхолтой, хорын дон өвчтэй хүүхдүүд бүртгэгдсэнийг тодорхой дурьдаж, ерөнхий боловсролын дунд сургуулийн 3-8 дугаар ангийн, ТМС-ийн 1-3 дугаар ангийн 10-17 насны хүүхдүүдийн дунд токсикоманитай /цавуу, бензин үнэрлэх дон/ болсониог бүртгэсэн байна.¹²¹

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Намын төв хороо, Ардын боловсролын яам, Ниймгийн аюулаас хамгаалах яам, Эрүүлийг хамгаалах яамны оролцоотой Мансуурлаас урьдчилан сэргийлэх салбар комисс байгуулагдаж Улаанбаатар хот, Дархан хот, Сэлэнгэ, Баянхонгор, Дорноговь аймаг, Сэлэнгэ аймгийн Ерөө дахь Техник мэргэжлийн тусгай сургууль, Дарьт дахь хөдөлмөр хүмүүжлийн колонид ажиллаж, хурлын протокол,байгууллага, албан хаагч нарт өгсөн хугацаатай үүрэг, үүргийн биелэлтийг тус тус танилцуулж, биелэлтийг тооцжээ.¹²²

Монголын Хувьсгалт Залуучуудын эвлэлийн Төв хороо, Ардын боловсролын яам, Эрүүлийг хамгаалах яам, Улсын Прокурорын газар, Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын хамтарсан албан даалгаврын төсөл 1988 оны 10 дугаар сарын 19-нд төсөл хэлбэрээр боловсруулагдсан боловч албан ёсоор батлагдсан эсэх нь одоогоор тодорхойгүй байна.¹²³

Хар тамхитай тэмцэх ажлын эрх зүйн эх сурвалжийг судлах хугацаанд зөвхөн батлагдсан хууль, дүрэм, журам, он, сарыг дурьдагддаг боловч тухайн эрх зүйн баримт бичиг батлагдан гарах хүртэл хугацаанд судалгаа танилцуулга бэлтгэх, нөхцөл байдлыг дүгнэх зэрэг урт хугацааны цаг, хүч, хөдөлмөр шаардсан ажлуудыг судлаж, үнэлэлт, дүгнэлт өгөлгүй орхигдуулж байжээ.

Дүгнэлт. Төр засаг, залуучууд, эрүүл мэнд, төрийн хяналтын байгууллагуудаас насанд хүрээгүй хүмүүсийн дунд химийн бодис хэрэглэж мансуурдаг, хорын донтой болсон хүмүүсийн талаар жил бүр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байжээ.

Насанд хүрээгүй хүмүүсийг зөвхөн мансуурах, хорын донгоос бус бүх төрлийн гэмт хэргээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажил нь зөвхөн цагдаагийн байгууллагын ажил байсангүй. Энэ ажилд

¹¹⁸ Мөн илтгэл. Уб. 1987.4 дэх тал.

¹¹⁹ Хар тамхитай тэмцэх газрын архив ХНЗ.1987-2011 оны хууль эрх зүйн акт. Уб. 2013. 158 дахь тал

¹²⁰ Мөн материал. 206 дахь тал

¹²¹ Мөн материал. 295 дахь тал

¹²² Мөн материал. 270 дахь тал

¹²³ Хар тамхитай тэмцэх газрын архив ХНЗ.1987-2011 оны хууль эрх зүйн акт. Уб. 2013. 193 дахь тал

эцэг эх, сургуулийн багш удирдлага, залуучуудын байгууллага, эрүүл мэнд, цагдаагийн ажлыг хослуулан бодит, үр дүнтэй ажлыг хийж иржээ.

Богино хугацаанд хэрэгжүүлсэн арга хэмжээг тухай бүр нь дүгнэж, хоцорсон, тасарсан арга хэмжээг тусгайлан авч үзэж, хэрэгжилтийг 85 хувиас буулгахгүй тооцохоор ажиллаж байв.

Мөн мансууруулах бодис хэрэглэдэг хүнийг илрүүлэх ажилд онцгойлон анхаарч, энэ ажилд нэргүй судалгаа авах, байнгын үзлэгт хамруулах, иргэн бүрийг татан оролцуулж байсан нь анхаарал татаж байна. Дээрх ажлыг өнөөгийн нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлэх шаардлагатай байна гэж харж байна. Ялангуяа цагдаа-олон нийтийн хамтын ажиллагааг гэмт хэрэгт өртөж болзошгүй эмзэг цэг, эмзэг бүлгийг илрүүлэхэд ашиглах нь ямар ач холбогдолтой байдгыг энэ өгүүллийг бичиж явцад судалсан материалаас харж болно.

Мөн эмзэг бүлэг болон мансууралд өртөж болзошгүй этгээдүүдийг гэр бүл хамт олны хяналтад байлгах, эрүүл мэндийн байгууллагын түлхүү оролцоотойгоор, хамт олны дэмжлэгтэйгээр илрүүлэх, эмчлэх ажлыг богино хугацаагаар хэсэгчилсэн байдлаар зохион байгуулж, тухай бүр үр дүнг дүгнэж байх нь шаардлага байна гэж үзэж байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна.

1. Анх удаа мансууруулах төрлийн бодис хэрэглэж баригдсан өсвөр насны хүүхдүүдтэй цагдаагийн байгууллага дангаараа бус, харин эцэг эх, сургуулийн багш, удирдлага болон эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2. Мансууруулах бодистой тэмцэх ажлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн дор идэвхижүүлэх

3. Эрүүлийн хамгаалах яамтай хамтран гутлын цавуу үнэрлэх, демодрол ууж мансуурахын хор холбогдлыг сурталчлах сарын зохистой ажил зохиох

4. Сургуулийн сурагчдын дунд гутлын цавуу үнэрлэх, демодрол ууж мансуурах зэргээр хэн хэн хэрэглэж байгааг нэг бүрчлэн тогтоож, хараа хяналтадаа бүрэн авч урьдчилан сэргийлж, таслан зогсоох ажлыг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагаас зохион байгуулж хэрэгжүүлэх зэрэг болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль
2. С.Бүдрагчаа. Манай орны зарим аймаг, хотод гарч байгаа мансуурах үзэгдлийн шинж байдал, хандлага илтгэл. УБ. 1987
3. Хар тамхитай тэмцэх газрын архив ХНЗ.1987-2011 оны хууль эрх зүйн акт. УБ. 2013.
4. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002, №46.
5. <https://legalinfo.mn/mn>
6. <http://criminology.mn>
7. <http://www.olloo.mn>

ЖАГСААЛ ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Б.Сүхбат

“Цагдаа судлал”-ын магистрант,
цагдаагийн ахмад

Товч агуулга. Монгол Улсад Ардчилсан хувьсгал гарснаар иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон төдийгүй Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, пактуудаар энэхүү эрх баталгаажиг уг эрхийн хүрээнд 1994 онд Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль батлагдан гарч уул арга хэмжээний үед нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулж байна. Иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлэх эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлыг судлаж, цаашид боловсронгуй болгох талаар авч үзлээ.

Түлхүүр үг. Жагсаал цуглаан, хүний эрх, үзэл бодол, эвлэлдэн нэгдэх, жагсаал, цуглаан

Үндсэн хэсэг. Монгол Улс дах “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, түүний эрх зүйн зохицуулалт Үндсэн хуулийн 16.16-д “Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх”¹²⁴ эрхийг хүний эрх, эрх чөлөөний гол цөм нь гэж үзэж болох бөгөөд итгэл үнэмшилтэй байж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн арга нь үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөө юм.

Монгол Улсын Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйл Энэ хуулийн зорилт нь тайван жагсаал, цуглаан хийх иргэдийн Үндсэн хуулийн эрх чөлөөг баталгаажуулах, жагсаал цуглаан хийх журмыг тогтоох, уул арга хэмжээний үед нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино¹²⁵ гэж хуульчилсан байна.

Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19.3-т “Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарах ёстой:

1-рт, бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх,

2-рт, Үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах үүднээс хязгаарлалтыг зөвхөн хуулийн дагуу хийж болно. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний нэг хэлбэр нь хэвлэн нийтлэх эрх юм¹²⁶.

Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль 1994 онд батлагдсан цагаас хойш нийт 5 удаа нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд эдгээр нэмэлт өөрчлөлтүүд нийгэм эдийн засаг, цаг үеэ олсон эсэхэд дүгнэлт хийх шаардлага тулгарч байна.

Монгол услад жагсаал цуглаан зохион байгуулахад хаярьяа нутаг дэвсгэрийн засаг даргад бүртгүүлж байгаа нь Үндсэн хууль, Жагсаал цуглаан хийх журмын хуулийн зохицуулалтыг гажуудуулсаар байна.

Хүний эрхийн үндэсний комиссоос Монгол Улсад тайван жагсах, хуран чуулах эрх чөлөөгөө эдлэх баталгаа хэврэг, энэ орон зай цаашид улам хумигдах эрсдэлтэй гэж дүгнэжээ.

Тогтолцооны талаас авч үзвэл энэ байдалд нэг суурь шалтгаан, суурь шалтгааныг дагасан хоёр үндсэн шалтгаан нөлөөлж байна гэж үзэж байна. Тухайлбал, Тайван жагсаал зохион байгуулах ялангуяа

¹²⁴ "Төрийн мэдээлэл. 1993. №1. Монгол Улсын Үндсэн хууль

¹²⁵ Legalingo.mn Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль

¹²⁶ Ханнс-Зайделийн сан болон Эрх зүйн боловсролын академиас гаргасан “Үндсэн хуулийн тайлбар”, УБ, 2009, 98-р тал

улс төрийн өнгө аястай, төрийн бодлого үйл ажиллагааг шүүмжилсэн үзэл бодлоо илэрхийлэх жагсаж, цуглахад айж цэрвэх, хачирхах, хардах төрийн албан хаагчийн хандлагатай холбоотой. Зүй нь тайван жагсаал бол ардчилсан улсын хэвийн амьдралын нэг хэсэг байх учиртай.

Энэ нь төрийн эрх мэдлийг хянах, бодлого үйл ажиллагаагаа сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэх учиртай. Шүүмжлэлт үзэл бодол үүнийгээ илэрхийлэх жагсаал цуглаан зэрэг арга хэмжээг хэвийн зүйл гэж үзэх нийгмийн хандлага, төрийн албан хаагчдын хандлага тогтоогүй байна. Энэ нь хүчирхийллийн бус тайван жагсаал цуглааныг дэмжих бус хязгаарлах, зогсоох, намжаахад чиглэж байна. Түүнчлэн 1994 онд бичигдсэн Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль ерөнхий бичигдсэн төдийгүй цаг үеэсээ хоцорсон байна.

Цар тахлын үеэр Засаг даргын захирамжаар бүх жагсаал цуглааныг нийтлэг байдлаар хязгаарлах журмыг авч хэрэгжүүлсэн нь хүний эрхийн зарчимд нийцэхгүй бөгөөд мэдэгдэх, бүртгэх гэж нэрлэсэн боловч үнэн хэрэгтээ зөвшөөрөл авах механизм үйлчилж байна гэж үзэж болохоор байна.

Энэ байдал нь иргэд, төрийн байгуулагуудын хоорондын таарамжгүй харилцаа, зөрчилдөөн үүсгэх боломж бүрдсэн гэж хэлхэд хэлсдэхгүй юм. Энэ бүхний хамгийн тод жишээ “No Naadam” хөдөлгөөнийг зохицуулагч иргэн Д.Монголхүүгийн цагдаагийн алба хаагчдын хууль ёсны шаардлага эсэргүүцэх, биед халдах үйлдэл олон нийтийн цахим сүлжээгээр цацагдаж иргэдийг багагүй бухимдуулсан явдал юм. Энэ асуудалтай холбоотойгоор Улсын их хурлын гишүүн Н.Учрал "Жагсаал, цуглаан хийх журмын тухай" хуулийн талаар мэдээлэл хийж "Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачиллаа. Жагсаал, цуглаан хийх журмын тухай 1994 онд батлагдсан хуулийн 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан тодорхой зохицуулалтыг өөрчилж өнөөдрөөс хэлэлцүүлэг явуулж байна. 14 хоногийн дотор ЗГ-аас ирсэн саналыг УИХ-д өргөн барина.

Сүүлийн үед хүний эрхэд халдах үзэгдлүүд ажиглагдаж байна. Үндсэн хуульд зааснаар бид үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал хийх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно гэж Үндсэн хуульд заасан. Гэтэл өнөөдөр жагсаал, цуглаан хийх, үзэл бодлоо илэрхийлэх, үгээ хэлэхдээ заавал тухайн орон нутгийн Засаг даргаас бүртгэл нэртэй зөвшөөрөл авч байна.

Иргэд жагсаал, цуглаан хийх, үг хэлэх эрхээ эдэлж чадахгүй байдалд хүрээд байна. Иймээс "Жагсаал, цуглаан хийх журмын тухай" хуулийг өөрчлөх 10 дугаар зүйлийг бүхэлд нь хасах хуулийн төслийг санаачилж байна. Ингэснээр ард иргэдийн зүгээс жагсаал, цуглаан хийхдээ Засаг даргаасаа зөвшөөрөл авах биш бүртгүүлдэг байх зохицуулалтыг тусгаж өгсөн" гэж олон нийтэд мэдээлсэн юм.

Одоогийн эрх зүйн зохицуулалтаар жагсаал цуглаан хийх эрхийг зайлшгүй үндэслэл гарвал хязгаарлаж болдог. Гэхдээ энэ эрх чөлөөг хязгаарлахад, Үндсэн хууль, Иргэний болон улс төрийн тухай олон улсын фактаар дараах шаардлага тавьдаг.

Эрхийг ийнхүү хязгаарлахад заавал хангах дараах нөхцөлийг Үндсэн хуульд заасан:

1-рт Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2-т зааснаар төрийн үйл ажиллагааны нэг үндсэн зарчим бол хууль дээдлэх ёс учраас ийм нөхцөл тавигддаг. Мөн, Үндсэн хуулийн 19-р зүйлийн 2 дахь хэсэгт “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно.

Ийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө” гэж заасан. Энэ заалтад онц болон дайны байдал зарласан үед хязгаарлаж үл болох салшгүй эрхийг заахын зэрэгцээ эдгээрээс бусад эрхийг хязгаарлах бол заавал хуулиар хязгаарлах ёстой гэжээ. Онц болон дайны байдал зарласан үед хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуулиар хязгаарлана гэж байгаа нь ийм байдал үүсээгүй ердийн үед хүний эрх, эрх чөлөөг бас зөвхөн хуулиар хязгаарлах гэсэн санааг өөртөө багтаадаг. Өөрөөр хэлбэл, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуулиар

хязгаарлах гэсэн шаардлагыг онцгой үед тавьж байгаа бол ердийн үед үүнээс доогуур шаардлага тавьж болохгүй.

Хуулиар хязгаарлах зарчим нь зөвхөн хуульд заасан байхаас гадна тодорхой үндэслэл, журам, нарийвчилсан зохицуулалт хийх гэсэн санааг агуулдаг. Үндсэн хуульд хувийн өмчийг хураах, дайчлан авах, албадан хөдөлмөрлүүлэх, нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг хязгаарлах, жагсаал, цуглаан хийх (16-р зүйлийн 3, 4, 13, 16) зэргийг хуулиар зохицуулахаар заасан нь төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны зүгээс дур зоргоор авирлахаас хувь хүнийг хамгаалдаг¹²⁷.

2-рт Хязгаарлалт нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн дэг журам гэсэн ашиг сонирхлыг хамгаалах. "...Тодорхой хүний эрх бусад хүмүүсийн мөн тийм эрхээр харьцангуй хэмжигдэн зохицуулагдах нь нийгмийн шударга ёсонд бүрэн нийцнэ"⁷ хэмээн АИХ-ын гишүүд үзэж байсан тул Үндсэн хуулийн 19-р зүйлийн 3-т "Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй" гэж оруулсан. Эндээс хүний эрх, эрх чөлөөг зөвхөн эдгээр чухал ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор л хязгаарлаж болно гэсэн санаа харагддаг.

3-рт Хязгаарлалт нь тохирсон (зайлшгүй) байх. Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар төрийн үйл ажиллагааны үндсэн зарчимд "шударга ёс" багтдаг. Шударга ёс бол өргөн агуулгатай зарчим. Жишээлбэл, шударга ёсны нэг чухал хэсэг бол тохирсон байх явдал. Тохирсон байх гэдэг нь аливаа арга хэмжээ, ял шийтгэл зайлшгүй шаардлагатайгаас илүү хүнд, хатуу байж болохгүй гэсэн үг. Ял шийтгэл нь гэмт хэргийн шинж чанар, хэр хэмжээнд тохирсон байхыг шударга ёсны зарчим гэж Монгол Улсын Эрүүгийн хуулиудад тусгаж ирсэн байдаг. Үүнтэй адилхан үндсэн эрхийг хязгаарлах арга хэмжээ нь Үндсэн хуулийн 19-р зүйлийн 3 дахь хэсэгт заасан чухал ашиг сонирхлыг хамгаалахад тохирсон байх ёстой.

4-рт Үндсэн эрхийг аль болох эдлүүлэх. Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны нэг үндсэн зарчим бол "эрх чөлөө" гэж заасан. Эрх чөлөөний зарчим бол үндсэн эрхийг аль болох эдлүүлэх, үндсэн эрхийг зайлшгүй тохиолдолд хязгаарлаж болох ч тэрхүү хязгаарлалт нь тухайн эрхийг агуулгыг бүрэн үгүйсгэхгүй байх, хуулийн талаарх өөр өөр тайлбаруудаас үндсэн эрхэд илүү нийцсэнийг нь хэрэглэх зэрэг олон утгыг багтаадаг¹²⁸.

Харин Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулинд байгаа мэдэгдэл нэртэй зөвшөөрлийн тогтолцоо нь дээрх шаардлагыг хангаж чадахгүй хэмээн дүгнэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, зүй ёсны ашиг сонирхлыг хамгаалахын тулд жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлаж болох ч тэр хязгаарлалт нь жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хамгийн багаар хязгаарласан, зөвхөн зайлшгүй хэмжээнд л байх ёстой. Тухайлбал, Уг хуулийн 10-р зүйлд "дайн сурталчлах, үндэстэн, ястныг хооронд хагаргах, ялгаварлан гадуурхах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журамд хохирол учруулах", "эмх замбараагүй явдал бий болгох" зэрэг хууль бус зорилгоор, эсхүл албан ёсны бүртгэлгүй нам, ТББ-аас санаачилсан, мөн нисэх онгоцны буудал, эмнэлэг зэрэг хориглосон газарт жагсаал, цуглаан зохион байгуулах бол бүртгэхээс татгалзана гэж заасан байдаг. Гэвч Засаг дарга иргэдийн жагсаал, цуглаан хийх мэдэгдлийг "өөр үйл ажиллагаатай давхацсан", "автомашин хөдөлгөөнд саад учруулна", "иргэдийг бухимдуулна" гэсэн хуульд заагаагүй шалтгаанаар жагсаал цуглаан хийх хүсэлтийг бүртгэхээс татгалзсан татгалзаж байсан нь Үндсэн хуульд заасан эрхийг Засаг дарга хууль бусаар боогдуулж байна. Сүүлийн 5 жилийн нийтийг хамарсан арга хэмжээний судалгаагаар авч үзвэл сүүлийн 2 жил буюу 2020, 2021 онуудад жагсаал, цуглаан болон бусад нийтийг хамарсан арга хэмжээ буурсан үзүүлэлтэй байна.

¹²⁷ О.Мөнхсайхан "Жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт", Ардчиллын хөгжил-Иргэдийн оролцоо ЭШБХ-ын илтгэлийн эмхтгэл, УБ., 2017, 91-108 дахь тал

¹²⁸ Хүний эрх онол арга зүйн сэтгүүлийн 2017 оны №1 дугаар 20 дахь тал

Энэ нь дэлхий нийтэд учирсан цар тахал Коронавируст халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчлийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 сарын 21-ний өдрийн 45 дугаар тогтоолоор баталсан “Коронавируст халдварын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам” уг эрх зүйн актуудтай уялдуулан Нийслэлийн засаг даргын хорио цээрийн дэглэмтэй холбоотой хэд хэдэн удаагийн захирамжуудаар жагсаал, цуглаан хийхийг хориглосон шийдвэртэй холбоотой гэж дүгнэж болох юм.

Дээрх судалгаанаас үзэхэд дэлхий нийтийг хамарсан цар тахал буюу Корона вирусн халдвараас шалтгаалан дараах хууль тогтоомжуудаар нийтийг хамарсан арга хэмжээ тэр дундаа жагсаал цуглааныг хориглосон нь үүнд нөлөөтэй гэж үзэж байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулиар гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан.

№	Хамгаалалтын төрөл	2017	2018	2019	2020	2021
1	Жагсаал, цуглаан	174	139	152	50	93
2	Арга хэмжээ	154	1	138	24	73
3	Ажил хаялт	0	5	0	0	1
4	Суулт	5	16	3	1	12
5	Бусад баяр	10	3	18	2	
6	Бөхийн барилдаан	3	0	1		8
7	Салют	2	0			1
8	Үзэсгэлэн	3	12			
9	Хөшөөнд хүндэтгэл үзүүлэх	17	3	12	1	6
10	Баяр, наадам	3	12	1	1	
11	Шоу тоглолт	20	9	18	2	
12	Шүүх хурал	9	11	4	11	9
13	Газрын маргаан	4	37	2	5	39
14	Тэмцээн	45	0	36	1	4
15	Өлсгөлөн	3	7	4	3	8
16	Гадаадын хурал	5	15	7		1
17	Гадаадын зочин	10	6	17	2	7
18	Итгэмжлэх жуух барих	9	3	10	1	3
19	Санал асуулга	4	2	2	1	3
20	ХГХамгаалалт	6	0	4	1	
21	Албадан тараах	0	3			
22	Морины уралдаан	11	0	4		
23	Нөхөн сонгууль, сонгууль	2	0		2	2
24	Объектийн хамгаалалт	16	10	7	15	9
25	Сургалт	7	0	1	1	
26	УИХ, ЗГ гишүүн	11	6	5	1	1
27	Цэрэг татлага	2	2	2	1	1
28	Ном хурах	7	7	5		
29	Гэр барих	0	0			
30	Бусад сонгууль	11	5	2	1	
31	Хурал, уулзалт	55	21	51	54	107
32	Нийт	890	1256	456	181	427
	Алба хаагч	38063	30371	24474	24792	13431
	Авто машин	2824	2715	2014	1993	3442

Харин Коронавируст халдвар цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулиар цар тахалаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах харилцааг зохицуулж ирсэн. нь дээр дурьдсан Үндсэн хуулийн шаардлагатай зөрчилдөж байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулиар гамшгаас хамгаалах, Коронавируст халдвар цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Засгийн газрын 2021 оны 02 сарын 21-ний өдрийн 45 дугаар тогтоолоор баталсан “Коронавируст халдварын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам” зэрэг хууль тогтоомж, эрх зүйн актаар жагсаал цуглаан хийхийг хориглосон нь дээр дурьдсан Үндсэн хуулийн шаардлагатай зөрчилдөж байна.

Гамшиг, аюулт үзэгдэл, хорио цээрийн дэглэмийн үед иргэдийн дуу хоолойг хорьж болохгүй талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрс шүүмжилсэн бөгөөд энэ талаар Монгол Улсын засгийн газар, Улсын их хуралд хэд хэдэн удаагийн шаардлага хүргүүлсний үр дүнд нээлттэй сонголт хийж “Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг гаргаж, боловсруулж байгаа төслийн хүрээнд 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан нь иргэний жагсаал цуглаан хийх эрхийг хангах, зөвшөөрөл авах бус бүртгэлийн системийг хэрэгжүүлэх зөв зүйтэй алхам болсон байна. Үүнд:

1 дүгээр зүйл.¹²⁹ Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.3 дах хэсэг:

“3.3. Тодорхой үйл явдалтай холбоотойгоор иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэн цуглаж, тайван замаар үзэл бодлоо илэрхийлэх жагсаалыг аяндаа үүссэн цуглаан гэнэ.

2/10 дугаар зүйлийн 1 дах хэсэг:

10’ дугаар зүйл. Аяндаа үүссэн жагсаал, цуглааныг зохицуулах нь

“10’.1. Аяндаа үүссэн цуглааныг мэдэгдэх шаардлагагүй.

“10’.2. Мэдэгдээгүй нь түүний аюулгүй байдлыг хангуулахаас зайлсхийх нөхцөл болохгүй.

2 дугаар зүйл. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/6 дугаар зүйлийн 6.7 дэх хэсэг:

“6.7 Төрийн ордон, Сүхбаатарын талбайг иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх хэсгийг хориглосон зурвасыг хэсэгчлэн тогтоохдоо Үндсэн хуульд заасан чиг үүргийг мөрдөх ба Төрийн ордон болон тусгай хамгаалалтын газрын талбайн зөвшөөрөгдөх хэсгийг иргэдэд нээлттэй индэр байдлаар ашиглахыг хориглохгүй байж болно”

2/9 дугаар зүйлийн 9 дах хэсэг:

9.3. Засаг дарга жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 1 өдрийн дотор түүний бэлтгэл ажлыг бүрэн хангуулах үүрэгтэй.

9.4. Жагсаал, цуглааны бэлтгэлийг хангах хүрээнд нэмж тодруулах буюу зохицуулбал зохих асуудал гарвал Засаг дарга энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацааны дотор зохион байгуулагчтай харилцаж зохицуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд жагсан явах чиглэлийн асуудлаар зөвшилцөж болно.

9.5. Жагсаал, цуглаан зохион байгуулах тухай мэдэгдлийг Засаг даргад хүргүүлснээр зохион байгуулах эрх нээгдэнэ хэмээн нэмэлт өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсруулсан нь жагсаал цуглаан хийх бүртгэлийн систем бий болгох шинэ алхам болжээ гэж үзэж байна.

¹²⁹ Төрийн мэдээлэл. 1994. №9. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль

Дүгнэлт. Дээрх бүхнээс дүгнэхэд “Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах нь зайлшгүй асуудал бөгөөд нийгэм цаг үеэ дагаж Үндсэн хуулиар олгогдсон иргэдийн эрх, эрх чөлөөг хангах чиглэлээр хориглосон заалтыг өөрчлөх нь зүйтэй гэж дүгнэлээ.

Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хуулиар гамшгаас хамгаалах, Коронавируст халдвар цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Коронавируст халдварын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам” зэрэг хууль тогтоомж, эрх зүйн акт нь Үндсэн хуулийн 2-р бүлийн 16-р зүйлд заасан иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхтэй зөрчилдөж байна.

Жагсаал цуглаан зохион байгуулахад засаг даргад бүртгүүлэх үйл ажиллагаа нь бүхэлдээ зөвшөөрлийн систем болж хувирсан нь нийтийн эрх ашиг сонирхолд үл нийцнэ.

Жагсаал цуглаан зохион байгуулах, Аяандаа үүссэн жагсаал цуглаан гэсэн нэр томъёог Жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд тусгаж, хууль бусаар жагсаал цуглаан зохион байгуулах үйлдлээс ялгаж тогтоох.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслээд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Үндсэн хуулийн 2-р бүлийн 16-р зүйлд заасан иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхтэй зөрчилдөж байгаа Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хуулиар гамшгаас хамгаалах, Коронавируст халдвар цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн зохицуулалтанд нэмэлт өөрчлөлт оруулж зөрчилдсөн хэм хэмжээг арилгах. Тухайлбал “Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль”-д оруулах дээр дурьдсан нэмэлт өөрчлөлтийг тусгах замаар бүртгэлийн системийг бий болгох;

2. Аяандаа үүссэн жагсаал цуглаан, Хууль бусаар жагсаал цуглаан зохион байгуулах үйлдэлд хүлээлгэх шийтгэлийн төрөл хэмжээг ялгамжтай тогтоох;

Ашигласан материалын эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль
3. Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1966
4. Donald P.Kommers , “The Constitutional Jurisprudence of the Federal Republic of Germany”, 2nd edition, January 1997,
5. ХЗҮХ-н Судалгааны тайлангийн эмхэтгэл, 2010-2011/II/
6. Төрийн мэдээлэл. 1993. №1.
7. Төрийн мэдээлэл. 1994. №9.
8. <http://www.sejm.gov.pl>
9. <http://en.poland.gov.pl>

**ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ
ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

**ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ**

Д.Булган.

*Доктор (Ph.D), дэд профессор
цагдаагийн дэд хурандаа*

Г.Ариунгэрэл.

Магистр, судлаач

Товчлол. Өнөөгийн нийгэмд хамгийн их эрсдэл учруулж байгаа зүйл бол авто машины осол, аваар бөгөөд зөрчил гарахад согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, хамгаалалтын бүс, малгай, аюулгүйн бүс хэрэглэхгүй байх, хурд хэтрүүлэх, гар утсаар ярих, нүүрээ будах /эмэгтэйчүүд/, тамхи асаах, хүүхэдтэйгээ зууралдах зэргээр анхаарал сарнихад жолоочийн хөдөлгөөн удаашрах, гэрэл дохио анхаарахгүй, эгнээ байр эзлэхдээ бусдыг анзаарахгүй байх, хажуу хоорондын зайг тохируулахгүй байх нь жолоочийн ур чадварт шууд нөлөөлж, зам тээврийн осол гардаг.

Мөн зам тээврийн ослын шалтгаан нь замын нөхцөл байдал, тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтэл, жолоочийн буруугаас, орчны нөлөөлөл гэсэн зүйлүүдээс хамааралтай. Ийнхүү шалтгаан хүчин зүйлийг нь оновчтой тодорхойлсноор энэ төрлийн үзэгдэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга замыг зөв тодорхойлох, зам тээврийн осол, хэргийн гаралтыг тогтоон барих, бууруулах арга хэмжээг төлөвлөн авах боломжтой болох юм.

Энэхүү сэдвийн хүрээнд нэг-т; Тээврийн цагдаагийн албаны урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нэгжийн зохион байгуулалтын бүтцийн өнөөгийн байдал, хоёрт; хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээний өнөөгийн байдал, гуравт; урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж буй алба хаагчдын дунд хэлэлцүүлэг хийж, өнөөгийн байдлыг тодорхойлж, үр дүнг тус тус судалж үзлээ.

Түлхүүр үг. Зам тээврийн осол, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил, тээврийн цагдаагийн алба, урьдчилан сэргийлэх хэлтэс.

Үндсэн хэсэг. Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “цагдаагийн байгууллага нь нийтийн хэв журмыг хамгаалах чиг үүргийн хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан. Энэ чиг үүргийн хүрээнд тус хуулийн 11.1.3-т “замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах” талаар заасан. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн нэг чиглэл нь зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа юм.

Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн сүүлийн 5 жилийн нөхцөл байдлыг судлахад иргэдийн аюулгүй, амар тайван амьдралын баталгааг хангахын тулд урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэх, боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байгаа нь харагдаж байна. Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг зөв тодорхойлж, хэрэгжилтийг амжилттай зохион явуулах нь өнөөгийн тулгамдаж буй асуудлын нэг юм.

Энэ асуудлыг шийдвэрлэхээр Тээврийн цагдаагийн албаны урьдчилан сэргийлэх хэлтэс нь зам тээврийн болон төмөр замын аюултай бүс, иргэний агаарын тээврийн аюулгүйн зурваст үйлдэгдэх гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд төлөвлөн зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үндсэн чиг үүрэгтэйгээр ажилладаг. Орон нутгийн авто замд

зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн аймаг, орон нутгийн цагдаагийн байгууллагын замын цагдаагийн нэгжийн алба хаагчдтай хамтран зохион байгуулж байна.

Зам тээврийн осол 2016 онд 46712, 2017 онд 36591, 2018 онд 29474, 2019 онд 25302, 2020 онд 21768, 2021 онд 22482 тус тус бүртгэгдсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 3.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Орон нутагт үйлдэгдсэн зам тээврийн ослын 3122 буюу 95.9 хувь нь жолоочийн буруугаас, 115 буюу 3.5 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, 18 буюу 0.6 хувь нь замын нөхцөлөөс шалтгаалж бүртгэгджээ. Зам тээврийн ослын шалтгаан нөхцөлийг жолоочийн буруутай үйлдэл, явган зорчигчийн буруутай үйлдэл, замын нөхцөл байдал, техникийн гэмтлийн улмаас гарсан осол хэмээн бүлэглэн авч үзэж байна.

Харин зөрчлийн хувьд улсын хэмжээнд 2016 онд 1328560 зөрчил бүртгэгдсэн бол 2020 онд 2058347, 2021 онд 1921887 зөрчил бүртгэгдсэний 1489089 буюу 77.5 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөн зөрчил өнгөрсөн оны үеийнхээс 136460 нэгж буюу 6.6%-иар буурсан. Үүнээс орон нутагт гарч байгаа замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийг графикаар авч үзвэл:

Зураг №01. ЗХАБ-ын эсрэг зөрчлийн сүүлийн 5 жилийн үзүүлэлт



Графикаас харахад 2016 онд нийслэлд 1080168 зөрчил бүртгэгдсэн бол 2021 онд 1489089 зөрчил бүртгэгдсэн нь 46 хувиар өссөн үзүүлэлт харагдаж байна. Харин 2020 оноос зөрчлийн үзүүлэлт буурсан нь ковид цар тахлын хорио цээрийн дэглэмтэй холбоотой буурсан байх магадлалтай юм.

Сүүлийн жилүүдэд зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх маш олон арга хэмжээг эрчимтэй авч хэрэгжүүлсэн нь зөрчийн гаралтад нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй. Тухайлбал, “Дураараа биш дүрмээрээ”, “Яараад яахав дээ” зэрэг зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Эдгээр арга хэмжээ нь орон нутгийн иргэд, жолооч нарт хэр хүртээмжтэй, үр нөлөөлтэй байгааг судлах хэрэгцээ шаардлага байсаар байна.

Дээр дурдсанаас дүгнэхэд зам тээврийн осол, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, хэрэгжилтийг сайжруулах, оновчтой арга зүйд үндэслэн боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байсаар байна. Тиймээс зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажил, арга хэмжээний өнөөгийн байдал, хэрэгжүүлж буй зохион байгуулалтын бүтэц, алба хаагчдын чиг үүрэг, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх замаар өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, цаашид сайжруулах арга замыг тодорхойлохоор энэхүү сэдвийг сонгон авч судаллаа.

Нэг. Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээний өнөөгийн байдал. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр дэлхий нийтийн өмнөө тавьсан зорилт, зарим улсын¹³⁰ туршлагаас үзвэл урьдчилан сэргийлэх ажлын үр дүн нь ослын гаралтын өсөлт,

¹³⁰ Швед Улсын “Алсын хараа-Тэг” стратегийн хөтөлбөр.

бууралтаас илүү ослын шалтгаанаар нас барсан, гэмтсэн хүний тоог бууруулсан байх нь хамгийн гол үзүүлэлт болж байна. Түүнчлэн зам тээврийн осол, зөрчлийг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь зөвхөн цагдаагийн байгууллагын үүрэг биш бөгөөд авто тээвэр, эрүүл мэнд, хот төлөвлөлт, орон нутгийн захиргаа, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн өргөн оролцоог хангасан хамтын үйл ажиллагааны үр дүн болохыг Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейн 2010 оны 64/255 дугаар тогтоолоор баталсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөр”-т онцолжээ.

“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 3.1-т “гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний нийлбэр цогц мөн¹³¹” гэж тодорхойлоод гэмт хэрэг, зөрчлөөс (зам тээврийн осол, зөрчил) урьдчилан сэргийлэх ажлын зарчим, үндсэн чиглэл, зохион байгуулалт, байгууллага, олон нийтийн оролцоог тус тус тодорхойлж, нийгэмд аюултай үзэгдэл болохын хувьд түүний хор аюулаас иргэдийг хамгаалах хууль зүйн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлсэн байна.

Мөн хуулийн 6 дугаар зүйлд “гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэл”-ийг ерөнхий, тсгай, нэг бүрчилсэн, соён гэгээрүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэхээр тодорхойлж, зохицуулсан байна.

Зам тээврийн осол, зөрчил гарахад “нэг хүний хүчин зүйлийн нөлөө” онцгой үүрэг гүйцэтгэдэг тул жолоочийн болон тээврийн хэрэгслийн тоон үзүүлэлт нэмэгдэх тусам зам тээврийн осол, зөрчил нэмэгдэх магадлал нэмэгдэнэ. Тухайлбал, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил, хурд хэтрүүлэх, суудлын бүс хэрэглэхгүй замын хөдөлгөөнд оролцох гэх мэт жолоочийн буруутай үйлдлээс үүдэлтэй зам тээврийн осол гарч, түүнээс учрах хохирол нэмэгдсээр байна.

Зам тээврийн осол, зөрчил гарах шалтгааны 95-аас дээш хувь нь жолоочийн буруутай үйлдэл гэж Тээврийн цагдаагийн албанаас эрхлэн гаргаж буй зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэлд дурдсан байна. Энэхүү шалтгааны дийлэнх хувийг согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, анхаарал болгоомжгүй жолоодох, хурд хэтрүүлэх, зогсоох арга хэмжээ авахгүй байх нь зам тээврийн осол гарахад нөлөөлжээ¹³². Эндээс харахад зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ нь шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглэгдэж үү, үр нөлөөтэй үзүүлж байна уу гэсэн асуулт гарч ирж байна. Тиймээс одоогийн хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны өнөөгийн байдал, хэрэгжилтийн талаар судлан авч үзье.

Монгол Улсад 1949 оноос Улсын авто техникийн шалган байцаах газрын дотоод орон тоонд “Ухуулах ажлын байцаагч”-ийн 1 орон тоотой анхны үйл ажиллагаа эхэлсэн бөгөөд урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд нь 1960.12 сард иргэд, олон нийтэд урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн тайлангаа танилцуулж, санамж бүхий өврийн дэвтэр 10.000 ширхэг, замын хөдөлгөөний дүрэм 100.000 ширхэг, явган зорчигч ба дугуйтай хүнд зориулсан дүрмийн брошюр 50.000 ширхэг, авто хөсгийн жолооч нар ба явган зорчигчдод зориулсан санамж 25.000 ширхэг, хөдөлгөөний дүрмийн зөрчилд аваарын байдлыг харуулсан 3 төрлийн 25.000-30.000 ширхэг, зурагт самбар 50-200 хувь хэвлэн олон нийтэд тарааж байв.

Үүнээс хойш 2000 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн №354 дүгээр тушаалаар Замын цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх хэсэг, 2009 онд Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар Олон нийттэй харилцах тасаг, 2012 оны 12 дугаар сарын 28-наас Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар Шинжилгээ үнэлгээ, захиргааны газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, 2014 оны 06 дугаар сард Цагдаагийн ерөнхий газрын №71 тоот тушаалаар Нийслэлийн Замын цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/159 дүгээр тушаалаар

¹³¹ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль.

¹³² Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик, үзүүлэлтийн эмхэтгэл. Уб., 2018, 2019, 2020, 2021 оны эмхэтгэл.

Тээврийн цагдаагийн албыг байгуулсантай холбогдуулан албаны бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр Захиргааны удирдлагын газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс байгуулагдаж байв. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар Тээврийн цагдаагийн албаны бүтэц, орон тоо, цол цалингийн зэрэглэлийг шинэчлэн баталж, Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтэс нэртэйгээр тус тус батлагдаж үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлээ.

Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтэс нь хэлтсийн дарга 1, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах зохицуулагч 2, Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн 2, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан зохицуулагч 2, цахим хуудас хариуцсан мэргэжилтэн 1, зураглаач цагдаа 1, нийт 9 орон тоотойгоор ажиллаж байна. Энэхүү хэлтэс нь зам тээврийн болон төмөр замын аюултай бүс, иргэний агаарын тээврийн аюулгүйн зурваст үйлдэгдэх гэмт хэрэг, осол, зөрчлийн шалтгааныг судлах, зам тээврийн осол, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажил, арга хэмжээг харьяа нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг хамруулан зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, иргэд олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулан, үр дүнг тооцон ажилладаг.

Хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх арга хэмжээг тоймлон авч үзвэл¹³³:

1. Өнөөдрийн байдлаар зам тээврийн осол, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнд оролцогчдын сахилга, батыг өндөржүүлэх, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ая тухтай аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор олон нийтийг хамарсан аян, арга хэмжээг тогтмол зохион байгуулж ирсэн. Тухайлбал, “Дураараа биш дүрмээрээ”, “Яараад яахав дээ”, “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл”, “Ирээдүйгээ хамгаалъя” уриатай арга хэмжээнүүдийг үе шаттай зохион байгуулснаар зам тээврийн осол 12.8, гэмт хэрэг 45.2, гэмтсэн 32.8 хувиар тус тус бууруулсан гэж тус хэлтсийн тайланд дурдагджээ.¹³⁴ Мөн явган зорчигчийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, явган хүний гарцаар гарах үеийн аюулгүй байдлыг хангах зорилгоор “1 хором хүлээ”, “Гарцаар гарцгаа”, “Бяцхан зорчигч”, Хүүхдэд ээлтэй жолооч”, “Шар дарцаг” зэрэг зорилтот арга хэмжээг зохион байгуулжээ.

2. Хэвлэл мэдээллийн байгууллага, мэдээллийн олон урсгалаар дамжуулан иргэд олон нийтэд нөлөөлөх мэдээлэл сурталчилгааны ажил тул энэ чиглэлд түлхүү үйл ажиллагааг чиглүүлж ирсэн. Энэ ажлын хүрээнд улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн осол, хэргийн товч мэдээлэл, шалтгаан, нөхцөл, хор уршгийг таниулах, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор долоо хоног, амралтын өдрүүдийн нөхцөл байдлын мэдээ, сэрэмжлүүлэг зэргийг бэлтгэн өргөн нэвтрүүлгийн 28 телевизэд 124 төрлийн мэдээллийг 558 удаа, богино долгионы 4 Fm радиод 70 төрлийн мэдээллийг 242 удаа, албаны болон бусад цахим 56 сайтад 62 төрлийн мэдээллийг 310 удаа, Сонинд 3 төрлийн мэдээллийг 3 удаа тус тус өгч ажиллажээ.

3. Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, сургалт зохион байгуулах зэрэг олон төрлийн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, зөвлөмж өгч ажиллаж байна.

4. Цагдаагийн ерөнхий газар болон Тээврийн цагдаагийн албанаас хурдаас шалтгаалсан ослын бууруулах зорилгоор хатуу хучилттай улсын чанартай авто замд байрлах цагдаагийн байнгын хяналтын дундаж хурдыг хэмжих хяналтын камерыг 2019 оны 10 дугаар сард байрлуулан ашиглаж байна.

5. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын 2020 оны 102 тогтоол, Ерөнхий сайдын 2020 оны 99 дүгээр захирамж, Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн

¹³³ Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх 2020, 2021 оны үйл ажиллагааны тайлангаас харьцуулан судлав.

¹³⁴ ТЦА-ны Урьдчилан сэргийлэх хэлтсийн 2021 оны үйл ажиллагааны тайлан.

2020 оны 26/16 зөвлөмж гэх мэт нийт 13 хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт үр дүн, хэрэгжилтийг хариуцан ажиллажээ.

Дээрх арга хэмжээнүүдийг харахад зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа боловч энэ нь зам тээврийн ослын шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглэсэн, оновчтой, үр дүнтэй байгаа эсэх нь эргэлзээтэй, цаашид энэ талаар судалгаа шинжилгээ хийж, бодиттой үр дүнтэй арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагатай гэж судлаачийн хувьд үзэж байна.

Цагдаагийн байгууллагын урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж буй алба хаагчдаас “зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн байдал¹³⁵-ыг тодорхойлохоор фокус ярилцлага хийлээ. Энэхүү хэлэлцүүлэгт Цагдаагийн Ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн алба хаагчид, Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн сургагч багш нар болон бусад төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий хүмүүс хамрагдсан.

Энд “зам тээврийн осол, зөрчлийн өнөөгийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад анхаарах асуудал”, “байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, PR хийх”, “зам тээврийн осолд өртсөн иргэнд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж” зэрэг сэдвээр хэлэлцэж, алба хаагчдад хариуцсан нутаг дэвсгэртээ зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах, хамтын ажиллагааг сайжруулах бодлого чиглэлийг тодорхойлох, хил залгаа, оролцогч аймаг, дүүргийнхээ хэрэгжүүлсэн ажлын туршлагыг судалж, сайн туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр харилцан санал бодлоо солилцсон.

Хэлэлцүүлэгт оролцсон алба хаагчдаас дараах саналуудыг гаргасан. Үүнд:

- Албан тушаалын тодорхойлолтыг судалж, зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тусгах,
- Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан алба хаагчдын ажил дүгнэх шалгуур үзүүлэлтэд зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлыг нэмэх,
- “Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажил хариуцсан алба хаагч”-ийн орон тоог албан тушаалын тодорхойлтын чиг үүрэгт тусгуулах
- Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын урьдчилан сэргийлэх ажил хариуцсан алба хаагчдын оролцоог нэмэгдүүлэх;
- Орон нутгийн замд үйлдэгдэж буй зам тээврийн осол, зөрчил, гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, хэрэгжүүлэх арга хэмжээг авдаггүй;
- Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг судалгаа, дүн шинжилгээгүйгээр зохион байгуулдаг, гарсан үр дүнг үнэлж тооцдоггүй зэргийг сайжруулах талаар тус тус санал, хүсэлтийг ирүүлсэн.

Хоёр. Зам тээврийн осол, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг бууруулахад чиглэсэн ажлын үр нөлөөг дээшлүүлэх ажлын хүрээнд. Монгол Улсад зам тээврийн осол гарахад нөлөөлж буй хүчин зүйл¹³⁶-д замын хөдөлгөөнд оролцогчдын эрх үүрэг, эрх зүйн ухамсар муу, жолоочийн соёл, ур чадвар дутмаг, жолооч бэлтгэх сургалтын багш, сургалтын хөтөлбөр хэрэгжилт хангалтгүй байгаа нь нөлөөлж байна. Үүнд хяналт тавих, хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой зохицуулалтыг нэмж тусгах. Тухайлбал, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд “замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх бүх нийтийн тасралтгүй боловсрол олгох” талаар нарийвчлан зааж өгөх;

Монгол Улсад одоогийн байдлаар 367 аж ахуйн нэгж байгууллага жолооч бэлтгэх сургалт явуулж байгаагаас нийслэлд 180 орчим нь үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр жолооны курсийн сургалтад дүрмийн мэдлэг, хотын болон талбайн жолоодлогоор мэдлэг, ур чадварыг олгож байгаа нь өнөөгийн шаардлагыг хангахгүй, хоцрогдсон хөтөлбөр байна.

¹³⁵ “Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааг сайжруулах” сэдэвт хэлэлцүүлэг.

¹³⁶ Судалгаагаар 95-аас дээш хувь нь жолоочийн буруутай үйлдэл байгаа талаар бид өмнө дурдсан. Тиймээс жолоочид чиглэсэн арга хэмжээг бодиттой төлөвлөж, хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Жолооч бэлтгэх сургалтын чанарыг сайжруулахад боловсролын онолын үндэслэлтэй цогц чадамж, мэдлэг, ур чадвар, хандлагын суралцахуйн үр дүнг тодорхойлж, түүнд хүрэх сургалтын арга замуудыг боловсруулах нь зүйтэй юм.

Жолооны “В” ангиллын тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх модульд суурилсан сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийлээ. Энэхүү хөтөлбөрөөр чадамжийн нэр¹³⁷, сургалтын төрөл¹³⁸, сургалтын цаг¹³⁹, жолоодлогын дадлагын тусгай талбай, сургалтын хэлбэр зэргийг тус тус тусгажээ. Эндээс харахад тус сургалтын хөтөлбөр нь мэдлэг, чадвар олгож байгаа боловч хандлага төлөвшүүлэхээр тусгаагүй байна.

Онолын мэдлэгийн хүрээнд замын хөдөлгөөний дүрэм, тээврийн хэрэгслийг аюулгүй жолоодох онол зүй, техникийн анхны мэдэгдэхүүн, авто техникийн ашиглалт, хууль тогтоомж, эмнэлгийн анхны тусламж зэрэг хичээлийн агуулгыг тусгажээ. Дээрх хөтөлбөрийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийснээр дараах агуулгыг жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөрт тусгах талаар санал болгож байна. Үүнд:

Хүснэгт №1. Жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөрт тусгах санал

	Хичээлийн хөтөлбөрийн нэр	Цаг, багтаамж	Хүрэх үр дүн
1	Дүрмийн мэдлэг олгох хөтөлбөр;	60 цаг	Жолоочийн ур чадвар, соёл, сахилга бат дээшилж, жолоочоос шалтгаалах осол буурна.
2	Жолоодох ур чадвар олгох хичээлийн хөтөлбөр;	32 цаг	
3	Жолоочийн соёл хандлагыг төлөвшүүлэх хичээлийн хөтөлбөр;	10 цаг	
4	Жолоочийн эрх зүйн мэдлэг олгох хичээлийн хөтөлбөр	10 цаг	
5	Зам тээврийн осолд өртөгсдөд үзүүлэх анхны тусламж	10 цаг	

Дээрх хичээлүүдийг судалснаар жолооч нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт, дүрмийн мэдлэг эзэмшиж, жолоодох ур чадвартай, хөдөлгөөний соёлтой байх хандлага төлөвшсөн байхаар төлөвлөгдсөн байна. Ийнхүү замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бүх нийтийн боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага, агуулгыг сайжруулснаар зам тээврийн осол, зөрчил буурах нөхцөл бүрдэнэ гэж судлаачийн хувьд үзэж байна.

Мөн зам тээврийн осол, зөрчлийн шалтгаан нөхцөлд “замын нөхцөл” хамгийн бага буюу нийт осолд 0.2 хувийг эзэлж байгаа нь эргэлзээтэй байна. Учир нь Монгол Улсын Авто замын тухай хууль¹⁴⁰-д заасны дагуу Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үндэсний авто замын сүлжээ нь олон улс, улс, нийслэл, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто замаас бүрдэнэ. Монгол Улс 1990-ээд онд ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжихдээ Монгол Улс үйл ажиллагааны үр ашгийн түвшин доогуур, удирдлага нь шууд удирдан өргөжүүлдэг тун жижиг авто замын сүлжээг хүлээн авсан.¹⁴¹

Үндэсний авто замын сүлжээний нийт урт 2019 оны жилийн эцсээр 111916,7 км байгаагийн 100323,28 км нь буюу 89,6% нь ердийн хөрсөн, 11593,42 км буюу 10,4% нь сайжруулсан зам байна. Нийт сайжруулсан замын 9781 км буюу 84,4%-ийг хатуу хучилттай, 1207.9 км буюу 10,4%-ийг хайрган хучилттай, 604.9 км буюу 5,2%-ийг сайжруулсан хөрсөн зам эзэлж байна. Цаашид Монгол Улсын Засгийн газар тус салбарыг хөгжүүлэх, замын сүлжээг өргөтгөх стратеги боловсруулан мөрдөж, замын

¹³⁷ “Жолоочоос гадна наймаас илүүгүй хүний суудалтай, бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй автомашин (бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй)-ы жолооч” гэж тодорхойлсон.

¹³⁸ Мэдлэг, дадлага олгох.

¹³⁹ Онол 76 цаг, дадлага 32 цаг.

¹⁴⁰ “Авто замын тухай хууль”¹⁴⁰-ийн 14 дүгээр зүйлийн 14.1-т “Монгол Улсын үндэсний авто замын сүлжээ нь олон улс, улс, нийслэл, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто замаас бүрдэнэ” гэж заасан.

¹⁴¹ Монгол Улс Авто замын салбар -2016. Азийн хөгжлийн банк. УБ., 2011.

барилгын аж үйлдвэрлэл, үйл ажиллагааг сайжруулах хэрэгцээ шаардлага байгаа нь бидний тулгамдсан асуудал болсоор байна.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хууль”-ийн 19.2-т “Зам, замын байгууламжийг төлөвлөх, барих, өргөтгөх, засварлах, арчлан хамгаалах ажил нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хууль, техникийн норм, дүрэм, стандартад нийцэж байгаа эсэхэд тухайн холбогдох хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина” гэж заасан. Эндээс харахад авто зам, замын байгууламжийг барих, арчлах, засварлах, хамгаалах, ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг төрийн байгууллага, бүх шатны Засаг дарга, холбогдох албан тушаалтан эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлж байна.

Гэхдээ замын байгууламжийг барих, арчлах, засварлахад холбогдох байгууллагууд хяналт тавьж байгаа боловч хэрхэн хяналт тавих, засаж сайжруулах шаардлагатай бол хэрхэн ажиллах талаар тусгаагүй буюу хэрэгжүүлэх механизмыг тусгаагүй байна. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн өндөр чадвар бүхий туршлагатай зам тээврийн ослын шинжээч болон замын хөдөлгөөний аюулгүй байдал, хөдөлгөөн зохион байгуулалтын инженерүүдээс бүрдсэн баг замын хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх талаар тусгаж өгөх нь зүйтэй юм.

Мөн энэхүү аудитын багийн гишүүд нь зам тээврийн ослын шинжээч, замын хөдөлгөөний аюулгүй байдал, хөдөлгөөн зохион байгуулалтын инженерүүд байх бөгөөд авто замын төлөвлөлт болон хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр мэргэжил эзэмшиж, аудитын чиглэлээр суралцаж, мэргэшсэн, энэ чиглэлээр туршлагатай аж ахуйн нэгж байгууллагын зөвшөөрөлтэй хуулийн этгээд байх шаардлагатай юм.

Дүгнэлт. Монгол Улсад зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн зохион байгуулалтын бүтэц 1949 оноос бий болж, өнөөг хүртэл үйл ажиллагаа нь тогтмол хэрэгжсээр байна.

Гэхдээ зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэлтсийн үйл ажиллагаа нь соён гэгээрүүлэх, аян, хэсэгчилсэн арга хэмжээ хэрэгжүүлэх, судалгаа шинжилгээ хийх, хамтын ажиллагааны хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна.

Дээрх хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг харахад замын дэд бүтцийг судалж, замын нөхцөл байдлаас үүдэлтэй шалтгаан нөхцөлийг буурахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлдэггүй, жолоочоос үүдэлтэй зам тээврийн осол, зөрчлийн шалтгаан нөхцөлд чиглэсэн оновчтой арга хэмжээг авч төлөвлөдөггүй болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, замын хөдөлгөөний аюулгүй байдал, шуурхай байх үндсэн нөхцөлийн нэг нь замын дэд бүтэц, жолоочийн хариуцлага байдаг.

Замын эвдрэл, гэмтэл нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж, зам тээврийн осол, хэрэг гарах шалтгаан нөхцөлүүдийн нэг болдог байна.

Өнөөг хүртэл замын эвдрэл гэмтэл, онгорхой нүх, овоолсон шороо, зузаан мөстсөн замын хэсэг, замын бусад хангалтгүй нөхцөлийг тойрох гэсэн автомашины жолооч хөдөлгөөний чиглэлээ гэнэт өөрчлөх, тойрч эсрэг урсгалд орсноос гарсан тохиолдлыг осол гарсан актад тусгахгүй, ихэнх тохиолдолд бурууг жолооч, бусад хөдөлгөөнд оролцогчдод хариуцуулж байна. Манай орны замын байхад замын нөхцөл гэсэн хүснэгтэд байгаа тоон үзүүлэлт маш бага байгаа нь шалтгаан нөхцөлийг зөв тогтоохгүй байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Замын байгууламж хариуцсан албадад хариуцлага хүлээлгэвэл зам, замын нөхцөл чанарын өндөр түвшинд хүрэх нэг механизм болно гэсэн үг юм. Замын хөдөлгөөнд оролцогчдод сайхан зам, аюулгүй зам хэрэгтэй байдаг учир замын байгууламж хариуцсан албад, гадна талбай, зогсоолын талбай зэрэг нийтэд үйлчлэх эзэмшлийн зам, талбайгаа цэвэрлээгүйгээс уг байгууллагын эзэмшлийн газарт замын нөхцөлөөс үүдэлтэй осолд аж ахуйн нэгж байгууллагад хариуцлага хүлээлгэвэл зам, замын нөхцөл нь чанарын өндөр түвшинд хүрэх нэг механизм болно гэж үзэж байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслээд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Жолооч бэлтгэх сургалтын чанарыг тодорхойлох судалгаа хийж, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэх, сайжруулах;
2. Зам тээврийн ослыг бүх талаас нь шинжлэн шалгах, судлах хараат бус албыг байгуулан, зам тээврийн осол ихээр гардаг, гарах өндөр эрсдэлтэй замын хэсэгт аюултай байдлын үнэлгээ, аудит хийлгэн, зам тээврийн ослын шалтгаан нөхцөлийг тогтоолгон, үр дагаврыг бууруулах бодлого чиглэл боловсруулан, үр дүнтэй арга авч хэрэгжүүлэх;
3. Жолоочоос үүдэлтэй зам тээврийн осол, зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглэсэн “хөтөлбөр, төлөвлөгөө” боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх.
4. Улсын чанартай орон нутгийн автозамд байрлах цагдаагийн 12 хяналтын цэгт алба хаагчдыг ажиллуулах.

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАХ ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ҮНДЭС

Б.Эрхэмбаяр
ДХИС-ийн магистрант,
цагдаагийн ахмад

Товч агуулга. Монгол Улсын анхны замын хөдөлгөөний дүрэм 1925 оны тавдугаар сарын 22-ны өдрийн Засгийн газрын 18 дугаар хуралдаанаар батлагдсанаас хойш 12 удаа шинэчлэн батлагдаж, таван удаа нэмэлт өөрчлөлт орж, 2018 оны наймдугаар сарын 08-ны өдөр Замын хөдөлгөөний дүрмийг 27 бүлэг, 224 зүйл, 4 хавсралттайгаар шинэчлэн баталж, 2018 оны арваннэгдүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхлээд 97 жилийн хугацаа өнгөрөөд байна.

Энэхүү өгүүлэлд цагдаагийн алба хаагч замын хөдөлгөөн зохицуулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт тун тутмаг, эрх зүйн зохицуулалтгүй үйл ажиллагаа явуулж байгаа учир Замын хөдөлгөөн зохицуулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байгаа, цагдаагийн байгууллага болон төрийн бусад чиг үүрэг бүхий байгууллагын хамтын ажиллагаа арга хэлбэр, эрх зүйн орчинд үнэлэлт өгч, энэ нь ямар түвшинд байгааг тусгасан болно.

Түлхүүр үг: Тээврийн хэрэгсэл, зам, замын хөдөлгөөн, тээврийн осол, зөрчил, зохицуулагч, хөдөлгөөн зохицуулалт.

Үндсэн хэсэг: Монгол улсын Авто тээвэр, Цагдаагийн байгууллагын үүсэл, хөгжилтэй холбоотой юм. Хорьдугаар зууны эхэн үеэс Орос, Хятад улсаар дамжин наймаа эрхэлдэг, Монгол улсаас түүхий эд авдаг Орос, Хятад, Европ, Франц, Америкийн пүүс, хоршоодын цөөн тооны автомашин нэвтэрч байсны гадна Богд хаан, Сайн ноён хаан, Түшээ гүн Лувсан, Бэйс Лувсанцэрэн зэрэг хаад, ноёд 1-10 машинтай байсан гэх мэдээ баримт байдаг. Монгол улсад худалдаа наймааны харилцаатай гадаад орнуудын зүгээс механикжсан тээврийг нэвтрүүлэх санал тавьж, 1913 онд Чита хотод байсан Германы худалдаачин Вейнерман Нийслэл хүрээ-Хиагтын хооронд хувийн шуудан тээвэр хийж эхэлжээ.

1921 онд Монгол оронд үндэсний ардчилсан хувьсгал ялснаар хувьсгалт ардчилсан арга хэмжээнүүд хэрэгжиж, хувьсгалт хэв журам тогтоож эхэлсний дотор Нийслэл хүрээнд 1910-аад оноос цагаан хаант орос, хятад америк, английн худалдаачны цөөн тооны пүүсийн автомашин нэвтэрч, авто тээврийн хөдөлгөөн түүний зөрчил, аваарь цөөнгүй гарах болсноор гудамж замын хөдөлгөөнийг зохицуулах ажил эхэлсэн байна. Жишээлбэл: 1923 онд хятад пүүсийн жолооч Бронштейн согтуугаар машин жолоодож яваад Дамчаа гэдэг цэргийг дайрч амь насыг бүрэлгэжээ.

1925 онд хятад Далайн пүүсийн жолооч Ты Явон Бику Маймаа хотын гудамжинд Пунцаг овогтой Дуламсүрэн гэдэг охиныг дайрч амь насыг хохироосон. 1925 оны 7-р сард Рос центсоюз хоршоо, шавь яамны хоёр тэрэг мөргөлдөж, шавь яамны жолооч Загдын буруу болж байсан зэрэг хөдөлгөөний зөрчлүүд гарах болсон байна¹⁴².

Авто хөсөг нэмэгдэж тэдгээрээс гудамж замаар эмх замбараагүй явж байгаа тухай асуудлыг Ардын засгийн газрын 1924 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 6 дугаар хурлаар хэлэлцэн “Уурын тэргийг товчлон эрхлэх газар”-ыг байгуулах, цахилгаан тэргийг хэрхэн явуулах дүрэм хэмжээг боловсруулах комиссыг томилж, мөн оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 7 дугаар хурлын тогтоолоор Цэргийн яамны дэргэд “Уурын тэргийг товчлон эрхлэх газар”-ыг байгуулснаар энэ газар нь ачаа, зорчигчдын тээврийг зохион байгуулах, автомашин, түүний хөдөлгөөнд хяналт тавих ажлыг хариуцаж эхэлсэн байна.

¹⁴²А.Думбурай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт, УБ 1995. 106 дах тал

Ардын засгийн газрын 1924 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 6 дугаар хурлаар байгуулсан дүрэм, хэмжээ боловсруулах комисс нь тухайн үеийн төв, суурин газрын гудамж, зах зээлээр зорчиж байгаа автомашин, ердийн хөсөг, явган явагчдын хөдөлгөөнийг журамлах явдлын чухлыг харгалдан “Аливаа гал, усны уурын хүчээр явах тэрэг зэргийг БНМАУ-ын хязгаарын дотор хэрхэн хэрэглэхийн түр дүрэм”-ийн төслийг боловсруулж, Засгийн газрын 1925 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 18 дугаар хурлаар хэлэлцүүлэн батлуулсан нь өнөөгийн Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийн анхдагч суурь нь болж хөгжлийн түүхэн үеүүдэд улам бүр боловсронгуй болж иржээ.

Засгийн газрын 1924 оны 2-р сарын 15-ны 6 дугаар хурлаар уг асуудлыг авч хэлэлцэн “Уурын тэргийг товчлон эрхлэх газар”-ыг байгуулах, цахилгаан тэргийг хэрхэн явуулах дүрэм хэмжээг боловсруулах тусгай комисс томилжээ. Эл 6-р хурлын тогтоолоор Товчлон эрхлэх газрын комиссын бүрэлдэхүүнд Засгийн газрын жинхэнэ орлогч сайд С.Данзан, засгийн газрын нарийн бичгийн дарга Баваасан, гадаад яамны эрхэлсэн түшмэл Довчин нар оролцжээ¹⁴³.

Зам тээврийн осол, зөрчил, гэмт хэрэг гарахад жолоочийн мэдлэг ур чадвар муу, замын нөхцөл байдал, халтиргаа, гулгаа, явган зорчигчийн буруутай үйл ажиллагаа, техникийн бүрэн бус шаардлага хангахгүй, хуучирч муудсан авто машинууд, шаардлага хангахгүй гэрлэн дохио, тэмдэг, тэмдэглэлгүй уулзвар гарц, зам, авто замын эвдрэл гэмтэл, алдаатай зохион байгуулат, гэрэлтүүлэггүй зам орчин, эрх зүйн зохицуулалтын хийдэл зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна.

Харин цагдаагийн байгууллагаас Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчилд гудамж замын хяналт, шалгалтаас гадна замын хяналтын камер болон цахим дүрс бичлэг ашиглан замын хөдөлгөөнд оролцогчийн хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг хангах, гарч болзошгүй осол, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж өдөр тутмын хяналтыг тавьж ажиллаж байна.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот өдгөө 1 сая 200 мянган давсан хүнтэй болж дэлхийн саятан хотуудын эгнээнд зүй ёсоор орсон билээ.Энэ их хотын хүн амын өдөр тутмын зорчилт, ачаа тээврийн хөдөлгөөнийг үндсэндээ авто замаар, авто машинаар хэрэгжүүлдэг юм. Улаанбаатар хотын 839 км авто замаар, өдөр бүр 420-450 мянган тээврийн хэрэгсэл, түүний дотор 2000 том, дунд, бага оврын нийтийн тээврийн хэрэгсэл зогсоо зайгүй зорчиж байна.

Цагдаагийн алба хаагчаас замын хөдөлгөөн зохицуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах олон улсын гэрээ, конвенцуудаас гадна үндэсний хууль тогтоомж, эрх зүйн актуудыг мөрдлөгө болгон ажилладаг байна.

Монгол Улсын нэгдэн орсон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаарх олон улсын гэрээ, конвенц -д Замын хөдөлгөөний тухай 1968 оны Венийн Конвенц¹⁴⁴, Замын дохио, тэмдгийн тухай 1968 оны Венийн Конвенц, Замын хөдөлгөөний тухай 1968 оны Конвенцын нэмэлт болох 1971 оны Европын хэлэлцээр, Замын дохио, тэмдгийн тухай 1968 оны Конвенцын нэмэлт болох 1971 оны Европын хэлэлцээрүүд болно.

Дотоодын хууль тогтоомжийн хүрээнд цагдаагийн алба хаагч дараах хууль, эрх зүйн актуудыг мөрдлөг болгон ажилладаг байна. Тухайлбал:

- “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай”¹⁴⁵,
- “Автозамын тухай”¹⁴⁶,
- “Авто тээврийн тухай”¹⁴⁷,
- “Зөрчлийн тухай”¹⁴⁸,

¹⁴³ А.Думбурай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт, УБ 1995. 107 дах тал

¹⁴⁴ Замын хөдөлгөөний тухай болон замын дохио, тэмдгийн тухай конвенц. Эмхэтгэсэн Хурцбилэг А, Мөнхжаргал Я. Замын хөдөлгөөн судлалын хүрээлэн. УБ., 2004 он.

¹⁴⁵ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль (шинэчилсэн найруулга). 2015. www.legalinfo.mn

¹⁴⁶ Автозамын тухай хууль. 1998. Төрийн мэдээлэл. № 2.

¹⁴⁷ Авто тээврийн тухай. 1999 он.

- “Эрүүгийн хууль”¹⁴⁹,
- “Цагдаагийн албаны тухай”¹⁵⁰ зэрэг хуулиудыг мөрдлөг болгодог.

Түүнчлэн “Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм” болон Монгол Улсын Засгийн газар, яам, тамгын газруудаас батлан гаргасан “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх”¹⁵¹, “Тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн шалгалт авах, үнэмлэх олгох”¹⁵², “Автотээврийн хэрэгслийн тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох”¹⁵³, “Тээврийн хэрэгслийн тооллого, техникийн хяналтын үзлэг явуулах”¹⁵⁴, “Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх”¹⁵⁵ зэрэг 30 шахам журам автозам, автотээврийн салбарын тогтолцооны стандартуудыг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын 9 дүгээр зүйлийн 9.4.5-д “харьяа нутаг дэвсгэрийнхээ зам, замын байгууламж гэрэлтүүлэг, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдалд хяналт тавьж, илэрсэн зөрчил, иргэдийн санал, гомдлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг авахуулах”¹⁵⁶-аар заасан цагдаагийн алба хаагчаас замын хөдөлгөөн зохицуулахтай холбоотой чухал эрх зүйн зохицуулалт болж байна.

Хотын түгжрэл нь цагдаагийн алба хаагчаас замын хөдөлгөөн зохицуулах үйл ажиллагаанд сөрөг нөлөө ихээр үзүүлж байна. Тухайлбал, Улаанбаатар хотын иргэн өдөрт нэг цагийг замын түгжрэлд зарцуулбал жилд зам дээр 15 өдөртэй тэнцэх хугацааг зарцуулдаг гэсэн тооцоог гаргажээ.

Нийслэлийн замын хөдөлгөөн зохицуулах хэлтсийн одоогийн байдлаар үүрэг гүйцэтгэж байгаа 62 уулзвар гарцуудад ажиллаж байгаа алба хаагчид нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, замын хөдөлгөөний хууль дүрэм, холбогдох стандарт, заавар журмуудыг мөрдүүлэх, замын хөдөлгөөн зохицуулах үед шаардлагын түвшинд хүрэлцэхгүй байгаа нь алба хаагч, хүн хүч нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага бий болж байгааг харуулж байна.

Нийслэлд одоо үүрэг гүйцэтгэж байгаа уулзвараас гадна тогтмол алба хаагч ажиллуулах шаардлагатай уулзвар, гарц /Зайсангийн зүүн уулзвар, Токио тауэрын гарц, Ази фармын гарц, 120-н автобусны буудал, Сандэй плазагийн гарц, Шөнийн захын гарц, Хавдрын автобусны буудал, Халдвартын эцэс, 84-р сургуулийн урд уулзвар, Нарантуул захын далангын буцаж эргэдэг, Ориантал буудлын буцаж эргэдэг, Алтжин бөмбөгөрийн гарц, Найман шаргын зам, Хархорин захын ордог гарц, Мах импексын уулзвар/ зэрэг 45 уулзвар, гарц байна. Эдгээр цэгүүдэд 2 ээлжээр алба хаагч ажиллуулана гэж тооцвол бүгд 90 алба хаагч нэмэлтээр ажиллуулах хэрэгтэй болж байна.

Гэтэл 168 алба хаагч 86 уулзвар гарцанд 2 ээлжээр 1 ээлжэнд 1 алба хаагч 8-9 цагийн хугацаанд үүрэг гүйцэтгэх боловч зочины хамгаалалт болон чиглэлийн хамгаалалт, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, нэгдсэн хяналт шалгалтын хүрээнд 10-12 цагийн хугацаад үүрэг гүйцэтгэж байна. Өнөөдөр замын цагдаагийн алба хаагч 7 хоногт дунджаар 60 цаг үүрэг гүйцэтгэж байна,

Өнөөдөр замын цагдаагийн алба хаагчид “Замын хөдөлгөөн зохицуулах хянан шалгах журам”-д заасан эрх зүйн зохицуулалтаар замын хөдөлгөөний биет зохицуулалтыг явуулж байна. өөрөөр хэлбэл уг журмын 2.16-д заасан гэрлэн дохиогоор зохицуулдаг уулзвар, гарц, явган хүний гарц, төмөр замын гарам дээр дараахь тохиолдолд замын хөдөлгөөнийг биечлэн зохицуулж байна. Үүнд:

¹⁴⁸ Зөрчлийн тухай хууль. (шинэчилсэн найруулга). Төрийн мэдээлэл. 2016., № 08.

¹⁴⁹ Эрүүгийн хууль. (шинэчилсэн найруулга) 2015. Төрийн мэдээлэл 2016., № 07.

¹⁵⁰ Цагдаагийн албаны тухай хууль. (шинэчилсэн найруулга) 2013. Төрийн мэдээлэл. № 29.

¹⁵¹ Хөдөлмөрийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/171, А/496 дугаар тушаал. Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам.

¹⁵² Хууль зүйн сайдын 2014 оны А/158 дугаар тушаал. Тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн шалгалт авах

¹⁵³ Зам, тээврийн сайдын 2012 оны 59 дүгээр тушаал. Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам.

¹⁵⁴ Дэд бүтцийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 235/209 дугаар хамтарсан тушаал. Тээврийн хэрэгслийн тооллого, техникийн хяналтын үзлэг явуулах журам

¹⁵⁵ Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 201 дүгээр тушаал. Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм

¹⁵⁶ Төрийн мэдээлэл. 2015. №28. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль

1. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд заасан төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэн замын хөдөлгөөнд оролцоход;

2. замын хөдөлгөөнд оролцогчдод аюултай нөхцөл байдал /зам, замын байгууламж эвдэрсэн, байгалийн гамшиг, гал түймэр, халдварт өвчин гэх мэт/ үүсэхэд;

3. эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийн дагуу нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахад;

4. зам тээврийн осол, гэмт хэрэг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, байгалийн гамшиг, гал түймэр зэрэг шаардлагатай үед;

5. тусгай дуут болон гэрлэн дохио ажиллуулан хойшлуулшгүй албан үүргээ гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгсэл буюу цуваа өнгөрөхөд¹⁵⁷ гэж заасан байна.

Дээрх дурдсан эдгээр 5 дохиолдолд биет зохицуулалт хийнэ гэсэн боловч өнөөгийн нөхцөл байдалд цагдаагийн алба хаагч өдөр тутамдаа биет зохицуулалт хийхээс өөр аргагүй болсон байна. Энэ нь замын цагдаагийн алба хаагчдаас эрх зүйн үндэслэлд багтаагүй түгжрэлийн үед биет хөдөлгөөн зохицуулалт хийж байгаа нь тулгамдсан асуудал болж байна.

Тээврийн цагдаагийн алба иргэд, байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 24352 дуудлага, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 8281 нь зам тээврийн осол, хэргийн, 130 нь төмөр замын аюултай бүс, зурвас газар болон төмөр замын байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт, 10 нь нисэх онгоцны буудлын аюултай бүс, зурвас газар болон харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй дуудлага, мэдээлэл байна.

Дээрх дуудлага, мэдээллээс цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 314, зөрчлийн шинжтэй осол 7941, төмөр замын аюултай бүс, зурвас газар болон төмөр замын байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт 12, нисэх онгоцны буудлын аюултай бүс, зурвас газар болон харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт 4 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас 80 хүн нас барж, 268 хүн гэмтэж, зам тээврийн ослын улмаас иргэд, байгууллагад 8.0 тэрбум 330.5 сая төгрөгийн хохирол учирсан.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож гудамж замын хөдөлгөөнд оролцсон 14609, замын хөдөлгөөнд оролцох шаардлага хангаагүй журамлагдсан 11100 зөрчил, бусад 1595 хэрэг, зөрчил, цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ASAP санд эрэн сурвалжлагдаж байгаа 594 хүн, эд зүйлийг олж тогтоон илрүүлж, санд бүртгэн холбогдох албадад харьяаллын дагуу шилжүүлсэн.

Мөн нийт 642587 зөрчил илрүүлснээс замын цагдаагийн чиглэлээр 628991, төмөр замын байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт 5179, нисэх онгоцны буудлын аюултай бүс, зурвас газар болон харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн 8417 зөрчлийг илрүүлэн шалгаж шийдвэрлэсэн.

Нийслэл хотын гудамж замд байрлах замын хөдөлгөөний хяналтын төхөөрөмжөөр нийт 161020 зөрчил илрүүлснээс хурдны зөрчил 58295, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээний зөрчил 71211, түр зогсох журам зөрчсөн зөрчил 29748, үзлэг оношилгоонд ороогүй 511 зөрчлийг баталгаажуулан, арга хэмжээ тооцож тээврийн хэрэгслийн эзэмшигчийн хаягаар хүргүүлсэн¹⁵⁸

Нийслэл хотод орох, гарах хөдөлгөөнд хяналт тавих 7 постоос Эмээлт, Гүнтийн давааны 2 постод 3, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Цэргийн төв эмнэлэг, Амар, Наранбулаг, Парк, Дреам, Корпорейт, Кентавор, Тоёоко-Иинн, Туушин зочид буудлууд, Жаргалант сургалтын нэгдсэн төв зэрэг тусгаарлан ажиглах байрууд, Замын хөдөлгөөний удирдлагын төвийн 48, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн 63, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул дүүрэг дэх гудамж, талбайн

¹⁵⁷ <https://legalinfo.mn/mn/detail/14469>

¹⁵⁸ ЦЕГ-ын 2021 оны хагас жилийн тайлангаас хэсэгчилэн авав.

телехяналтын камерын дүрсийг Шуурхай удирдлагын штабт холбож, хяналт тавих боломжийг бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлсэн байна.

Шинээр батлагдсан журам бол “жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журам¹⁵⁹” юм. Тус журам нь Хууль зүйн сайдын 2015 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдаж, мөн оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж ирсэн.

Журмын зорилго нь тээврийн хэрэгслийн жолоочид замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх, тэдний сахилга, хариуцлагыг сайжруулах, гаргасан зөрчилд оноо тооцох, зөрчил гаргаагүй тохиолдолд урамшуулах асуудлыг зохицуулахад оршино.

Тус журмын 2.1-т “Жолооч замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомж,” дүрэм, журам, стандарт зөрчсөн үйлдэлд нийгэмд учирч болзошгүй хор, уршгаас шалтгаалан зөрчлийн 1-5 оноо хасна”, 2.2-т “жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо дууссан тохиолдолд тухайн жолоочийг тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүйд тооцно” гэж тус тус заажээ.

Жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох нь зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлж, учрах хохирлыг багасгах, жолооч нарын сахилга хариуцлагыг дээшлүүлж, замын хөдөлгөөнд соёлтой оролцуулахад чиглэгдэнэ.

Улсын хэмжээнд 2020 оны байдлаар 1335000 жолооч бүртгэлтэй байгаагаас замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчиж 249592 жолоочийн зөрчлийн оноо хасагдаж, жолоочийн бүртгэлийн системд 4419 жолоочийн оноо тэглэгдэж тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болжээ. Жолооч замын хөдөлгөөнд оролцохдоо хамгаалах бүс, хамгаалалтын малгай хэрэглээгүй зөрчлийн улмаас оноо хасагдсан тохиолдол нийт оноо хасуулсан зөрчлийн 99387 буюу 39.8%-ийг эзэлж байна¹⁶⁰.

Дээрхи бүх ажил, арга хэмжээнүүд нь замын хөдөлгөөн зохицуулах цагдаагийн алба хаагчдын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт зохих хэмжээгээр бүрэн хангагдсаныг харуулж болохоор байна.

Дүгнэлт. Цагдаагийн алба хаагчаас замын хөдөлгөөн зохицуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалт бүрэн хангагдсан гэж үзэж болохоор боловч нийслэлийн түгжрэлтэй холбоотой зохицуулалт учир дутагдалтай байна.

Тухайлбал, “Замын хөдөлгөөн зохицуулах хянан шалгах журам”-ын 2.16-д заасан гэрлэн дохиогоор зохицуулдаг уулзвар, гарц, явган хүний гарц, төмөр замын гарам дээр замын хөдөлгөөнийг биечлэн зохицуулах үндэслэл дээр түгжрэлтэй холбоотойгоор биет зохицуулалт хийх заалт байхгүй байгаа нь тулгамдсан асуудал болсон байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. “Замын хөдөлгөөн зохицуулах хянан шалгах журам”-ын 2.16.6-д шинээр “Замын түгжрэлтэй холбоотойгоор замын цагдаагийн алба хаагч өөрийн санаачлагаар биет зохицуулалт хийж болно” гэж заалтыг шинээр нэмж тусгах

2. Замын цагдаагийн алба хаагчаас түгжрэлтэй холбоотой явуулж буй үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтаас хүндрэл үүсгэж байгаа зүйл, заалтуудын талаар Тээврийн цагдаагийн албанаас ажлын хэсэг гаргаж, судалгаа хийлгүүлэх

3. Цагдаагийн албаны тухай хуульд заасан олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд биет зохицуулалт хийхтэй холбоотой эрх зүйн актын практикт хэрэгжилтийн талаар алба хаагчдаас судалгаа авах зэрэг болно.

¹⁵⁹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11296> Жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журам. Хууль зүйн сайдын 2015 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/187 дугаар тушаалын хавсралт

¹⁶⁰ Жолоочийн бүртгэл, мэдээллийн сан.

Ашигласан материалын жагсаалт

Монгол Улсын хууль тогтоомж:

1. Автозамын тухай хууль. 1998 он
2. Авто тээврийн тухай. 1999 он.
3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль. 2015 он
4. Зөрчлийн тухай хууль
5. Эрүүгийн хууль
6. Цагдаагийн албаны тухай хууль.

Ном, сурах бичиг, гарын авлага:

7. А.Думбурай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт, УБ 1995
8. Хурцбилэг А, Мөнхжаргал Я. Замын хөдөлгөөний тухай болон замын дохио, тэмдгийн тухай конвенц. УБ. 2004

Сонин, сэтгүүл.

9. Төрийн мэдээлэл. 1998.№ 2.
10. Төрийн мэдээлэл. 2016., № 08.
11. Төрийн мэдээлэл 2016., № 07.
12. Төрийн мэдээлэл. 2013. № 29.
13. Төрийн мэдээлэл. 2015. №28.

Цахим эх сурвалж

14. www.legalinfo.mn
15. www.Police.mn

АМИНД ХАЛГҮЙ ЗЭВСГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХЭРЭГЛЭХ
ҮНДЭСЛЭЛ ЖУРАМ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Ш.Чулуун

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Дотоодын цэргийн албаны тэнхимийн
дэд профессор, цагдаагийн дэд хурандаа*

Товч агуулга: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны үйл ажиллагаанд цагдаагийн алба хаагч аминд халгүй зэвсгийг хэрэглэхдээ гэмт этгээд, зөрчил гаргагчид хэрхэн ямар байдлаар хэрэглэх, энэ талаар дотоодын хууль тогтоомжинд хэрхэн тусгасан эсэх, гадны улс орны цагдаа болон хүчний байгууллагын албанд хэрэглэж буй зарим нэр төрлийн аминд халгүй зэвсгийг хэрэглэх аргачлал, анхаарах асуудал, ач холбогдол, үр дүнгийн талаар өөрийн саналыг дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг. Аминд халгүй зэвсэг, цагдаа, хүч хэрэглэх, эрхзүйн зохицуулалт, эрх зүйн зохицуулалт

Үндсэн хэсэг. Цагдаагийн хүч хэрэглэх явдал нь хүний төрөлхөөс заяагдсан нэр төртэй байх, амьд явах, аюул заналхийллээс ангид, эрх чөлөөтэй байх эрхийг хөндөж байдаг.

Тиймээс хүн бүр хуулиар адил тэгш үндсэн дээр хамгаалуулах эрхтэйг санаж хүний эрх, эрх чөлөөг үргэлж хамгаалах, хүндэтгэх, хөхүүлэн дэмжих зарчмыг баримтлах нь зүйтэй юм.

Түүнчлэн Нэгдсэн Үндэсний Байгууллагаас батлан гаргасан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт” болон бусад барим бичиг, дотоодын “Үндсэн хууль” болон бусад холбогдох хууль эрх зүйн баримт бичгүүдэд тунхагласан хүний эрхийн талаар тодорхой мэдлэгтэй байх шаардлагатай байна.

Өнөөдөр цагдаагийн байгууллага, алба хаагч нь хуулинд заасан үндэсэл журмын дагуу хүч хэрэглэхдээ галт зэвсэг хэрэглэхээс аль болох зайлсхийж тусгай хэрэгсэл, биеийн хүч буюу аминд халгүй зэвсэг хэрэглэхийг чухалчлан авч үзэж байна.

Хөгжингүй болон өндөр хөгжилтэй орны цагдаагийн байгууллага албаны үйл ажиллагаандаа ашиглаж байгаа тусгай хэрэгслийг аминд халгүй зэвсэг гэж нэрлэдэг байна. Үүнийг тодруулбал:

Хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хүн, амьтанд нөлөөлөх, хүний бие болон зэвсэг, техник хэрэгслийг чадамжгүй болгох зорилгоор бүтээгдсэн хэрэгслийг аминд халгүй зэвсэг гэнэ¹⁶¹ гэж тодорхойлжээ.

Аминд халгүй зэвсгийг хэрэглэснээр огт хүний амь насыг хохироох, биед гэмтэл учруулахгүй гэсэн баталгаа байхгүй юм. Зөв зохистой заавар, журмын дагуу хэрэглэснээр амь насаа алдах, бэртэл гэмтэл учрах эрсдлийг бууруулах ба сэтгэл зүйн хувьд тухайн байг устгаж буй хэрэг юм.

Тусгай ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд аминд үл хүрэх зэвсгийг үхэлд хүргэх зэвсэгтэй цуг ашиглаж болно.

Аминд халгүй зэвсгийг албаны үйл ажиллагаанд эсрэг талын үйл ажиллагааг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах, нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох,

¹⁶¹ “Аминд халгүй зэвсэг-2010” АНУ-ын сургагч багш нарын сургалт

үхэлд хүргэх хүчийг хэрэглэх нь зохистой шийдвэр биш үед, бие бүрэлдэхүүнийг хамгаалах, техник, тоног төхөөрөмжийг түр ажиллагаагаагүй болгох гэсэн үндсэн зорилгоор хэрэглэдэг байна.

Аминд халгүй зэвсэг нь дараах шинж чанартай байна.

- ✚ Бие хүнд болон материалд нөлөөлөл үзүүлэх чадвартай байх.
- ✚ Тухайн бүсэд харилцан адилгүй нөлөөлөл, үйлчилгээ үзүүлдэг.
- ✚ Уг зэвсгийг хэрэглэхдээ үхэлд хүргэх хүчийг ашиглахаас өмнө ашиглах хэрэгтэй.
- ✚ Аминд үл хүрэх зэвсгийн чадавхи нь өргөн хэмжээнд хэрэглэх боломжийг олгодог боловч уламжлалт үхэлд хүргэх хүчийг ашиглахгүй байх гэсэн үг биш юм.
- ✚ Хүчийг шат дараатайгаар хэрэглэх замаар энгийн иргэд болон бие бүрэлдэхүүний амь насаа алдах, бэртэл гэмтэл авах эрсдлийг бууруулна.

Аминд үл хүрэх хүч хэрэглэх үе шатууд нь дараах байдлаар ангилагдсан байна.

- ✚ Анхааруулах командыг амаар өгөх
- ✚ Бие хамгаалах техникүүдийг ашиглах
- ✚ Бороохой болон бусад техникийг ашиглах
- ✚ Нулимс асгаруулагч хий ашиглах
- ✚ Аминд халгүй зэвсэг, сум галт хэрэглэлийг ашиглах
- ✚ Үхэлд хүргэх хүч ашиглах

Аминд халгүй зэвсэг хэрэглэх ажиллагаа нь нэг талаас эерэг нөлөөтэй боловч нөгөө талаас сөрөг үр дагаврыг бий болгодог байна.¹⁶²

Эерэг байдал нь:

- ✚ Хүний амь нас, эд хөрөнгийг хамгаалдаг.
- ✚ Олон төрлийн сонголт хийх боломжийг бүрдүүлж өгдөг.
- ✚ Хүчийг шат дараалсан замаар хэрэглэх боломж олгодог.
- ✚ Байдлыг хурцатгахгүй намжаах боломж олгодог.
- ✚ Бие бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангахад нөлөө үзүүлнэ.

Сөрөг байдал нь:


- ✚ Хүний биед сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.
- ✚ Бие бүрэлдэхүүний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
- ✚ Хүний амь хохироохгүй гэсэн баталгаа байхгүй.
- ✚ Буруу хэрэглэснээр гарах үр дүн тухайн ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй нөхцлийг тус тус бий болгодог байна.

Хүний амь нас, эрүүл мэндэд шууд хохирол учруулахгүй аминд халгүй зэвсгүүдийг дэлхийн хөгжингүй болон өндөр хөгжилтэй орнуудын хууль, хүчний байгууллагууд үйл ажиллагаандаа түгээмэл ашиглаж байна.

Тухайлбал манай хойд хөрш болох ОХУ, урд хөрш болох БНХАУ, АНУ, Англи, Израль, Энэтхэг гэх зэрэг улс орны цэрэг, цагдаа болон хууль сахиулах салбарын алба хаагч нь гэмт этгээд болон зөрчил гаргасан хүний хууль бус үйлдлийг таслан зогсоох, саатуулах, баривчлах, аюулгүй байдлыг хангах үедээ аминд халгүй зэвсгийн ангилал, төрөлд хамаарах “Taser X-26” загварын цахилгаан гүйдлээр цохигч бууг түгээмэл ашигладаг бөгөөд энэхүү бууны талаархи ерөнхий мэдээлэл болон хэрэглэх аргачлалын талаар товчхон та бүгдэд танилцуулъя.

Энэхүү цахилгаан гүйдлээр цохигч буу нь цахилгаанаар цочрол өгөх замаар төв мэдрэлийн системд нөлөөлж, ингэснээр булчингийн үйл ажиллагааг түр зогсоох үйлчлэл үзүүлнэ. Тус цахилгаан гүйдлээр цохигч буугаар буудуулсан этгээд нь ямар нэгэн үйлдэл хийх чадамжгүй, өөрийн биеийг хянаж чадахгүй болж, газарт шууд унадаг байна. Цахилгаан үйлчлэл нь тухайн хүнд үйлчлэхээс өөр хүнд үйлчилдэггүй байна.

¹⁶² “Аминд халгүй зэвсэг-2010” АНУ-ын сургагч багш нарын сургалт



Цахилгаан гүйдлээр цохигч буу нь хүний биед дараах нөлөөллүүд үзүүлнэ.¹⁶⁴

- ✚ Буудуулсан даруйд газарт унана. /Хөдөлгөөн хязгаарлана. Явах чадваргүй болгоно./
- ✚ Хашгирна, орилно. /Бие организмд тодорхой өөрчлөлт орж өвдөлт мэдрэнэ./
- ✚ Булчингуудыг хүчээр зангируулна. /Хүний биеийн булчингийн үйл ажиллагааг саармагжуулж зогсооно./
- ✚ Байсан газар дээрээ хөдөлгөөнгүй болно. /Эсэргүүцэл үзүүлэх чадваргүй болгож илүү хөдөлгөөн хийхгүй байх нөхцлийг бүрдүүлнэ./
- ✚ Хэдэн секунд/минут толгой эргэнэ. /Тодорхой хугацаанд толгой эргэх, дотор муухай оргих, огиулах шинж тэмдэг илэрнэ./

Цахилгаан гүйдлээр цохигч буу нь хүний биед дараах сөрөг нөлөөлөлийг үзүүлнэ.

- ✚ Арьсанд гүнзгий орсноос арьсанд шархлаа үүсгэж, удаан эдгэхгүй байх боломжтой. /Гоо сайхан, гадаад үзэмжинд нөлөөлөх, шарх сорвитой болох/
- ✚ Нүдэнд гэмтэл учруулж болзошгүй. /Хараа муудах, нүд сохрох, бусад эрсдэл дагуулах/
- ✚ Шатамхай шингэнд гал авалцуулна. /Бензин, шатахуун болон шатах тослох материалтай газар орчин нөхцөлд аль болох хэрэглэхгүй байх, шаардлагатай тохиолдолд аюулгүй ажиллагааны дүрэм журмыг нарийн чанд мөрдөж ажиллах/
- ✚ Унаснаас болж дагалдах гэмтэл учруулж болзошгүй. /Хүний биеийн хүндийн төв хаашаа хазайна тэр талруу буудуулсан этгээд унадаг тул тухайн унаж байгаа газар, орчин нөхцөлд хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах магадлал өндөр байна. Жишээ нь: Хурц ирмэгтэй эд зүйл, хутга мэс гэх мэт/
- ✚ Өвдөлт үүсгэж, стрессд оруулж болзошгүй. /Тухайн этгээд цахилгаан буугаар буудуулснаар бие организм тодорхой өвдөлт мэдрэх, сэтгэл санаа цочирдох ингэснээр айдас хүйдэст автагдах/

¹⁶³ www.taser.com

¹⁶⁴ Чулуун.Ш., “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл”, УБ хот., 2019 он., 162 дахь тал

Харин дотоодын хууль тогтоомжинд аминд халгүй зэвсгийн талаархи ерөнхий ойлголт, нэр томъёоны тодорхойлолт, болон хэрэглэх аргачлалын талаар дараах агуулгаар тусган өгчээ. Үүнд:

Монгол улсын шинэчлэн баталсан “Галт зэвсэг”-ийн тухай хуулинд галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн жагсаалт, түүнийг ашиглах журмыг цагдаагийн төв байгууллагын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална¹⁶⁵ гэж тусгаж өгсөн байна.

Энэхүү ажлын хүрээнд Хууль зүйн сайдын А/249 тоот тушаал¹⁶⁶ батлагдан гарсан бөгөөд түүнд галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн жагсаалт болон ойлголтыг дараах байдлаар тусган өгчээ. Үүнд:

- Шахагдсан хийн даралтын хүчээр хошуу буюу үрлийг гол төмрөөс шидэх зориулалттай гадаад хэлбэр хийц, ажиллах зарчмын хувьд галт зэвсэгтэй төсөөтэй хийн буу;

- Амьсгал боогдуулах, нулимс асгаруулах, почироох үйлчилгээ бүхий химийн бодис ашиглах зориулалттай гадаад хэлбэр хийц, ажиллах зарчмын хувьд галт зэвсэгтэй төсөөтэй тусгай хэрэгслүүд;

Тайлбар: “Тусгай хэрэгсэл” гэж хүний аминд үл хүрэх гэмтэл бэртэл учруулах, амьсгал боогдуулах, нулимс асгаруулах, почироох зэвсгийг ойлгоно. Тухайлбал:

- Чанга дуу чимээ, гэрэл гаргах зориулалттай гадаад хэлбэр хийц, ажиллах зарчмын хувьд галт зэвсэгтэй төсөөтэй дохионы хэрэгслүүд;

- Сумны хошуу нь дангаараа буюу утсаар дамжуулан цахилгаанаар цохих үйлчилгээ үзүүлэх зориулалттай гадаад хэлбэр хийц, ажиллах зарчмын хувьд галт зэвсэгтэй төсөөтэй тусгай хэрэгслүүд;

- Сумны хошуу нь резинэн, хуванцар, даавуу болон бусад төрлийн материалаар хийгдсэн цохих /гэмтээх, бэртээх/ зориулалттай гадаад хэлбэр хийц, ажиллах зарчмын хувьд галт зэвсэгтэй төсөөтэй тусгай хэрэгслүүд;

- Зэвт хошуу бүхий сумаар харвах зориулалттай хавчаахай /нумт буу/ гэж тус тус тодорхойлжээ.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын 2017.09.06-ны өдрийн А/224, А/102 тоот хамтарсан тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-т цахилгаан гүйдлээр цохигч бууг /аминд халгүй зэвсэг/ хэрэглэх аргачлалын талаар тусгажээ. Үүнийг тодруулбал:

- Цагдаагийн алба хаагч цахилгаан гүйдлээр цохигч бууг хэрэглэх зорилгоо тодорхойлж, цахилгаан гүйдлээр цохигч бууг 4-5 метрийн зайд байгаа хүний биед хэрэглэх бөгөөд нэг газар 3 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар чиглүүлэн, байрлалыг сольж хэрэглэх ба энэ хугацаа нь араатан амьманд 5 секундээс илүүгүй байхаар тооцох;

- Цахилгаан гүйдлээр цохигч болон цахилгаан гүйдлээр цохигч бууг хүний биеийн цээж, нуруу, гар, хөл, гуяны хэсэгт хэрэглэх бөгөөд боломжтой бүх тохиолдолд хүний биеийн ил харагдах хэсэгт хэрэглэхгүй байх;

- Цахилгаан гүйдлээр цохигч болон цахилгаан гүйдлээр цохигч бууны үйлчлэл нь хүний биеийн булчинлаг хэсэг зангирах өвдөлт өгөх, мэдрэлийн систем түр сарних хэлбэрээр 5 минут үйлчлэх бөгөөд 20 минутын дараа үйлчлэл бүрэн арилна.

- Цахилгаан гүйдлээр цохигч болон цахилгаан гүйдлээр цохигч бууны хэвийн ажиллагаа, унтраалгыг шалгаж, ажиллуулах бөгөөд бороо, устай газарт хэрэглэхээс зайлсхийх, чийгтэй газарт хадгалахгүй байх;

- Цахилгаан гүйдлээр цохигчийн дуу, чимээг ашиглаж болох бөгөөд нэг дор 1-5 секундээс илүү хугацаагаар ажиллуулахаас татгалзах нь зүйтэй гэжээ.¹⁶⁷

¹⁶⁵ Галт зэвсгийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.5 дахь заалт

¹⁶⁶ Хууль зүйн сайдын 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/249 дүгээр тушаалын 1-р хавсралт “Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн жагсаалт”

¹⁶⁷ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан 2017.09.06-ны өдрийн А-224/А-102 тоот тушаалын 1-р хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 3-р зүйлийн 3.14 дэх заалт

Өөрөөр хэлбэл дотоодын хууль тогтоомжинд аминд халгүй зэвсгийн ойлголт, хэрэглэх үндэслэл, журмын талаархи онолын асуудлыг тодорхой хэмжээнд тусгаж өгчээ.

Гэсэн хэдий ч аминд халгүй зэвсгийг /цахилгаан гүйдлээр цохигч бууг/ нэгдсэн бүртгэл, судалгаанд оруулж албаны үйл ажиллагаанд нэвтрүүлэх, цагдаагийн алба хаагчдад энэ чиглэлийн сургалтыг зохион байгуулж хэрэглэх ур чадвар суулгах, тэдний биеийн болон сэтгэл зүйн бэлтгэлийг хангах зэрэг цогц арга хэмжээг эрх бүхий цагдаагийн алба нэгж, албан тушаалтан бодлогын хэмжээнд авч хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага үүсэн бий болж байна.

Дүгнэлт:

Дэлхийн хөгжингүй болон өндөр хөгжилтэй орнуудын цагдаа болон хүчний байгууллагууд нь албаны үйл ажиллагаандаа олон нэр төрөл, загварын аминд халгүй зэвсгийн шинэ технологийг хэрэглэж байна.

Цагдаагийн алба хаагч нь галт зэвсэг хэрэглэх эрх нээлттэй байгаа боловч үүнээс аль болох түтгэлзэх, боломжтой бүх тохиолдолд аминд халгүй зэвсгийг албаны үйл ажиллагаандаа ашиглах хэрэгцээ, шаардлага байна.

Дотоодын эрх зүйн актанд тусгагдсан “Taser X-26” загварын цахилгаан гүйдлээр цохигч бууг цагдаагийн албанд нэвтрүүлж, алба хаагчдад сургалт зохион байгуулж онолын мэдлэг олгох, практик ур чадвар суулгахад эрх бүхий алба, нэгж, албан тушаалтан анхаарч ажиллах шаардлагатай байна.

Санал:

- ✓ Дэлхийн хөгжингүй болон өндөр хөгжилтэй орнуудын цагдаа болон хүчний байгууллагад хэрэглэж буй аминд халгүй зэвсгийн төрөл, ангилалын талаар нэгдсэн судалгаа хийх
- ✓ Гадны улс орнуудад зохион байгуулж буй төрөл бүрийн аминд халгүй зэвсгийн сургалтанд алба хаагчийг хамруулж мэдлэг, ур чадварыг нь нэмэгдүүлэх
- ✓ Дотоодын хууль тогтоомжинд тусгагдсан аминд халгүй зэвсгийн ангилалд хамаарах “Taser X-26” загварын цахилгаан гүйдлээр цохигч бууг авах талаар зохих судалгаа хийн албанд хүлээн авах, нэгдсэн хангалт хийх
- ✓ Гадаад улсаас аминд халгүй зэвсгийн чиглэлээр дагнан эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийдэг, дадлага, туршлагатай эрдэмтэн, сургагч багш нарыг урьж авчран нийт бие бүрэлдэхүүнд нэгдсэн сургалт зохион байгуулах

Ашигласан материал

Нэг. Хууль тогтоомж:

1. Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017.02.09
2. Галт зэвсгийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2015.08.07
3. ХЗДХС, УЕП-ын хамтарсан 2017.09.06-ны өдрийн А-224/А-102 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”
4. Хууль зүйн сайдын 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/249 дүгээр тушаалын 1-р хавсралт “Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн жагсаалт”

Хоёр. Сурах бичиг, гарын авлага

5. Ш.Чулуун. “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл”. УБ хот., 2019 он

Гурав. Цахим эх сурвалж

6. www.taser.com

Дөрөв. Бусад

7. Аминд үл хүрэх зэвсэг-2010” сургалт /Зэвсэгт хүчний 150, 084, 032-р анги болон Цагдаа, дотоодын цэргийн төлөөлөл болон оролцсон нийт 162 цагдаа, цэргийн алба хаагчдад ”Таван толгой” сургалтын төвд зохион байгуулсан АНУ-ын сургагч багш нарын сургалт/

АРДЧИЛАЛД УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

А.Мөнхцэцэг,
ДХИС-ийн ЭЗНУС-ийн
НУТ-ийн багш, магистр

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд ардчилсан нийгэмд улс төрийн боловсрол, түүний үнэт зүйлс хэрхэн төлөвшиж буйд дүн шинжилгээ хийх замаар гадаадын зарим орны давуу ба сул тал, ялгаа онцлогийг тодруулж харьцуулсан талаар товч авч үзсэн болно.

Түлхүүр үг:

Ардчилал, Улс төр, боловсрол, МАХН, ҮЭ, Марксист-ленинист,

Үндсэн хэсэг. Ардчилсан нийгэм нь онолын төвшинд ч олон нийтийн санаа бодлын хүрээнд ч үндэслэл муутай ойлгож, буруу төсөөлж ирсэн. Үнэн хэрэгтээ ардчилсан нийгэм гэдэг нь иргэн өөрийнхөө төлөө амьдарч, төр болон нийгмийн оролцоогүйгээр бие даан амьдрах ур чадвар билээ. Ардчилсан нийгэмд улс төрийн мэдлэг, боловсролын гүйцэтгэх үүрэг тулгамдсан асуудал болж байна.

Америкийн прагматик философич, боловсролын онолч Ж.Дьюи-н тэмдэглэснээр боловсрол, мэдлэг түгээх нийгмийн байгууллагуудыг чухалчилж, нийгмийн оюун санаа бол хувь хүмүүсийн мэдлэгийн нийлбэр биш, харин нийгмийн асуудал шийдэх чадварын нөөц баялгийг улам олон талтай болгож, тэрхүү нөөц баялгийг нийгмийн бүх гишүүдэд хүртээмжтэй зохион байгуулах ёстой гэж үзэж байв. Хэрэв нийгмийн гишүүдэд мэдлэг, технологи, соёл эзэмших бололцоо байхгүй бол нийгэм нь түүгээр тодорхойлогдож, нийгмийн хуваагдал үүсэх эрсдэлтэй¹⁶⁸ гэжээ.

Ардчиллын замаар замнасан 30 гаруй жилд ардчилсан нийгмийн тулгуур институтууд хэлбэржин тогтсон боловч тэдгээрийн нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа, нийгмийн төлөөллийг хэрхэн хангах асуудал биелэлээ олохгүй удааширалтай байгааг иргэдийн улс төрийн оролцоо, түүнийг нөхцөлдүүлэгч иргэдийн гэгээрэл, боловсрол хангалтгүй байгаатай холбож үзэх бүрэн үндэстэй.

Ардчилсан нийгэм нь өөрийн амьдралын ачааг дааж чадах, улмаар бусдын төлөө нийгмийн хариуцлага хүлээх чадвартай, ухаалаг мэдээлэлтэй иргэдтэй байж л бодитой бий болно. Одоогоор манай нийгмийн харилцаанд бүх түвшний шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн зохистой оролцоо, улс төрийн соёл ба зан суртахууны төлөвшил, түүгээр дамжсан нийгмийн хяналт дутагдаж байна.

Нүдэнд үл үзэгдэх боловч сөрөг үр дагавар ихтэй энэ байдлаас гарах гарц нь иргэдийн улс төрийн боловсрол юм. Улс төрийн мэдлэг олгох, иргэд, сонгогчдын боловсролд чухал нөлөө үзүүлэх, шинжлэх ухаан танин мэдэхүйн ач холбогдол бүхий мэдээ, мэдээлэл, нийтлэл, өгүүлэл, нэвтрүүлгүүд цөөн тоогоор гарах болсон нь иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх үйл явцад суралцах, боломж, бололцоог хязгаарлаж байна.

Дийлэнх иргэдийн хувьд улс төрийн шинжлэх ухааны онолын үндэстэй мэдээ мэдээллийг бус, өдөр тутмын эмх замбараа муутай, мэдээллийг ердийн ухамсрын түвшинд хүлээн авч түүгээрээ нийгмийн амьдралд оролцох боллоо. Өөрөөр хэлбэл, төрийн удирдлагад оролцох иргэдийн оролцоо, сонгуулийн компанит ажил, сонгуульд санал өгөх, ямар нам, улс төрийн бүлэглэлд элсэх, төрийн бус байгууллага байгуулах зэрэгт улс төрийн мэдлэг боловсрол нэн чухал ач холбогдолтой болов. Иймд улс

¹⁶⁸ Монгол дахь иргэний нийгмийн төлөвшлийн философи, улс төр, эрх зүйн асуудал. УБ., 2014, 40 дэх тал

төрийг нийгмийн гишүүдийн амьдралын тулгамдсан асуудалд ойртуулах, илүү үр дүнтэй, хариуцлагатай болгох нь ардчилсан нийгмийн хөгжлийн нэг шаардлага болоод байна.

1980-аад оны эхний хагас гэхэд “хүйтэн дайн”-ы илт сөргөлдөөн зөөлөрч, намжмал байдал руу хэвийж, их гүрнүүдийн гадаад бодлогод шинэ сэтгэлгээ давамгайлах хандлагатай болж иржээ. Энэ үед ЗСБНХУ болон социалист орнуудад хямралт шинж байдал ил болж, социализмын хөгжлийг бодитойгоор үнэлэн дүгнэх түүхэн шаардлага тулгарав.

Улсын аюулаас хамгаалах байгууллагын олон жил толгойлж байсан Ю.В.Андропов бээр Л.И.Брежневийн оронд 1982 онд Зөвлөлтийн нам, төрийн толгойд гарч ирж, зөвлөлт нийгэмд бугшсан хоосон сайрхал, магтаал, хээл хахуул, ёс суртахууны ялзралд идэгдэж байгаатай захиргааны аргаар тэмцэж эхэлжээ. 1982 оны 11 дүгээр сарын дундаас 18 сайд, муж, хязгаарын болон Бүгд Найрамдах Улсуудын Намын Төв Хорооны 37 нарийн бичгийн дарга нарыг өөрчилж, удирдах албан тушаалын олигархи хэсгийг тэвдүүлсэн билээ¹⁶⁹.

Ю.В.Андропов 1983 онд “Карл Марксын сургаал ЗСБНХУ-ын социалист байгуулалтын зарим асуудал” өгүүлэл бичиж, социалист нийгмийн тухай сайрхаж байсан олон асуудлыг дахин эргэцүүлэхийг сануулсан байна. Тухайлбал, өмчийн харилцааны талаар “миний” гэсэн хувийн өмчийн үзлийг “манай”, нийтийн гэсэн үзэл болгон хувиргах нь амаргүй хэрэг гэдгийг бодит социализмын түүхэн туршлага харуулж байна.

Өмчийн харилцаанд эргэлт хийх нь үйлдвэрлэлийн үндсэн хэрэгслийг нийт ард түмний хүртээл болгочихдог ганц удаагийн үйл ажиллагаа биш ээ. Эзний эрх олж авах, ухаалаг, арвич хямгач, жинхэнэ эзэн болох хоёр бол адилхан зүйл огт биш ээ. Социалист хувьсгал хийсэн ард түмэн нийгмийн бүх баялгийг дангаараа гол өмчлөгч байх шинэ байдалдаа дадаж занших, эдийн засгийн хувьд ч, улс төрийн хувьд ч, цаашилбал хамтач ухамсар, зан харилцаа эзэмшин сэтгэл санааны хувьд ч дасч дадахад нэлээд их цаг хугацаа орно.

“Миний” гэдгийг “манай” болгох тухай ярихдаа энэ бол хялбарчилж үл болох олон талтай, урт удаан процесс гэдгийг мартаж болохгүй. Социалист үйлдвэрлэлийн харилцаа бүрмөсөн тогтсон үед ч хувиа хичээх заншил, бусдын хүчээр, нийгмийн хүчээр амьдрах эрмэлзэл зарим нэг хүнд байсаар байдаг, тэр ч байтугай сэргэн гарч ирдэг юм.

Энэ бүхэн нь Марксын нэр томъёог хэрэглэн өгүүлбэл, хөдөлмөрийг хүнийсгэхийн уршиг бөгөөд хэдийгээр хүнийсгэлийг нэгэнт устгасан ч гэсэн энэ уршиг хүний ухамсраас гэнэт, аяндаа арилчихгүй юм”^{170 171} хэмээн нийгмийн өмч бүрэлдэх нь тун амаргүй урт удаан хугацааны үйл явц гэдгийг сануулсан байна.

Зөвлөлт нийгмийн хүрсэн төвшинг хэт дэвэргэн магтаж байсанд шүүмжлэлтэй хандан, “Ямар шатанд явж байгаагаа бид ухаалгаар үнэлэх хэрэгтэй. Урагш хэт яарвал биелэшгүй зорилт дэвшүүлэхэд хүрнэ гэсэн үг. Хүрсэндээ тайвшран зогсвол байгаа бүхнээ ашиглаж чадахгүйд хүрнэ гэсэн үг. Манай нийгмийг бодит хөдөлгөөн дунд нь, байгаа бүх боломж, эрэлт хэрэгцээний нь хамт авч үзэх нь өнөөгийн шаардлага болж байна¹⁷²” дүгнэлт хийсэн юм.

Ю.В.Андроповыг насан өөд болсны дараа ЗСБНХУ-ын нам, төрийн жолоон дээр М.С.Горбачев гарч иржээ. ЗХУКН-ын 1985 оны IV сарын бүгд хурал, улс орны улс төр, нийгэм-эдийн засгийг шинэчлэх хурдасгах зорилт дэвшүүлсэнээр ЗХУ-д шинэчлэлтийн үе эхлүүлсэн юм. Тус бүгд хурал дээр М.С.Горбачев: “Манай орны түүхэн хувь заяа өнөөгийн ертөнцөд социализмын эзлэх байр суурь нь бид цаашид ажил төрлөө хэрхэн явуулахаас олон талаар хамаарна.

¹⁶⁹ Содномбалжир Д. XX зууны дэлхийн түүх. УБ., 2001, 69 дахь тал

¹⁷⁰ Андропов В.Ю. Карл Марксын сургаал ЗСБНХУ-ын социалист байгуулалтын зарим асуудал. УБ.,

¹⁷¹ , 8,9 дэх тал

¹⁷² Мөн тэнд, 25 дахь тал

Бид шинжлэх ухаантехникийн хувьсгалын ололтыг өргөн ашиглаж, аж ахуйг социалист ёсоор эрхлэн хөтлөх хэлбэрүүдийг өнөөгийн нөхцөл, хэрэгцээ шаардлагатай нийцүүлэн, нийгэмэдийн засгийн дэвшлийг ихээхэн түргэтгэх ёстой. Өөр зам ерөөсөө байхгүй¹⁷³” хэмээн онцлон тэмдэглэсэн юм.

Энэ нь хөгжлийн хурдыг жирийн нэг түргэсгэх биш, хөдөлгөөнийг зүгээр нэг хурдасгах биш, харин социалист нийгмийг чанарын шинэ заагт гаргах асуудлыг дэвшүүлсэн хэрэг байлаа. Энэ нь арай хожуухан “өөрчлөн байгуулалт” хэмээх стратегийн ухагдахуунаар солигджээ. М.С.Горбачев: “Өөрчлөн байгуулалт бол тулгамдсан хэрэгцээ”, “Өөрчлөн байгуулалт бол хувьсгал мөн” гэж томъёолж байлаа.

Үүний хамт “Ил тод байдал” хэмээх ухагдахуун, “Гласность” хэмээх орос үг улс төрийн хэллэгт баттай орж иржээ. Ил тод байх нь нэг талаас ардчиллын үр дүн, нөгөө талаас түүний хөгжин дэвших нөхцөл, хөрс дэвсгэр гэдгийг зөвлөлтийн удирдагч бүх талаас нь нотолж байсан юм. Өөрчлөн байгуулалтын нэг гол үзэл сурталч А.Н.Яковлев: “Ил тод байдал бол нийгмийг ардчилах хэлбэр, арга хэрэгсэл, ирээдүйн нийгмийн зэвсэг” хэмээн тэмдэглэж байлаа. М.С.Горбачев хүн төрөлхтний үнэт зүйлийг ангийн эрх ашгаас дээгүүр тавих өмнөх сэтгэгчдийн үзэл санааг өөрийнхөө гадаад бодлогын албан ёсны үзэл баримтлалын гүн ухааны үндэс болгосон юм. Энэ нь “Улс төрийн шинэ сэтгэлгээ” хэмээн алдаршсан билээ.

М.С.Горбачев: “Өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээ” номондоо: “Бид цөмөөрөө шавь нар, харин амьдрал цаг хугацаа бол багш юм. Өөрчлөн байгуулалтыг үгийн өргөн утгаар хийсний үр дүнд дэлхий ертөнц ойртон нягтарна гэсэн ойлголт өсөн өрнөнө гэдэгт би итгэж байна. Бид манай гол багш болсон амьдралаас нааштай үнэлэлт олж аваад нүдээ тайлсан бөгөөд дэвшил хөгжил үргэлжлэнэ гэсэн итгэлтэйгээр XXI зуунд орно¹⁷⁴” гэсэн ирээдүйдээ бат итгэсэн үгээ хэлжээ.

Өөрчлөн байгуулалт нь ЗХУ-ын “дагуул” орон гэж нэрлэгдэж байсан БНМАУд шууд нөлөөлж эхэлжээ. МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж.Батмөнх МАХН-ын XIX их хуралд тавьсан Намын Төв Хорооны тайлан илтгэлдээ: “Намын Төв Хороо тус улсын эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх явдлыг чиг баримжаа болгож байна” гэж тэмдэглэсэн нь дэлхийн социализмын өмнө тулгарсан зорилтыг тодорхой хэмжээнд мэдэрч, тус улсын эдийн засгийг эрчимжүүлэх асуудлыг дэвшүүлсэн хэрэг байлаа. Тус их хурал “... улс төрийн сургуулийг улам боловсронгуй болгох, улс төр, олон түмний ажлын үр нөлөөг дээшлүүлэх ..., гадаад улс төрийн суртал нэвтрүүлгийг хүчтэй болгох¹⁷⁵” шийдвэр гаргажээ.

МҮЭ-ийн XIII их хурал (1987) дээр Ж.Батмөнх “Өөрчлөн байгуулалт бол манай чиг баримжаа мөн” гэсэн өмнөхөөс илүү тодорхой томъёолол хэлсэн байна. Энэ нь өөрчлөн байгуулалтыг анх удаа албан ёсоор хүлээн зөвшөөрсний хувьд онцгой ач холбогдолтой байлаа. Гэвч социалист нийгмийн зогсонги байдлын шалтгаан, үндсийг, түүнчлэн нийгмийн амьдралын бүх хүрээнд бий болсон саатуулагч механизмыг бүх талаас нь задлан шинжлэх чадвар, шинэ сэтгэлгээ, улс төрийн зориг тэр үеийн монголын удирдагчдад дутаж байсан билээ.

Энэ үед хуучныг баримталсан зан төрх, хөшүүн хойрго араншин, үзэл бодлынхоо бүдүүвчинд таараагүй бүхнийг үл тоомсорлон ихэмсэглэх авир, нийгэм-эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хойргоших, хүрсэн үр дүнгээ тоон үзүүлэлтээр дөвийлгөн магтах хандлага давамгайлсаар байв.

Харин олон түмэн улс төрийн шинэ сэтгэлгээг талархан хүлээж авч, дэвшилтэт сэхээтэн, эрдэмтэд дэлхий дахины болон социализмын улс төрийн мөн чанарыг танин мэдэх эрмэлзэл эрс өсжээ. Өөрөөр хэлбэл, олон түмний нийгэм-улс төрийн идэвхи хүчтэй өрнөх болсон байна. Төр засгийн зүгээс “Өөрчлөн байгуулалт”, “Ил тод байдал”, “Улс төрийн шинэ сэтгэлгээ” зэрэг асуудалд зохих ёсоор анхаарч, “Үнэн” сониноор дамжуулан сурталчилгаа хийж, улс төрийн амьдралын шинэ соргог өөрчлөлтийг ухуулан таниулж байв.

¹⁷³ Горбачев С.М. Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг. УБ., 1986, 2 дахь тал

¹⁷⁴ Горбачев С.М. Өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээ. Манай оронд болон дэлхий дахинд. УБ., 1988, 315 дахь тал

¹⁷⁵ МАХН-ын XIX их хурал, (Дэлгэрэнгүй тайлан), УБ., 1986, 73 дахь тал

Энэ марксизм-ленинизмын эх зохиолуудыг сталинчлагдсан агуулгаар тайлбарлаж байсныг засах залруулах зарим нэг оролдлого хийх болов. Тухайлбал, В.И.Лениний “Сүүлчийн өгүүллүүд”-ийг шинэлэг байдлаар тайлбарласан өгүүллүүд “Үнэн” сонин, “Намын амьдрал”, “Залуу үе” сэтгүүлд гарч байв. Мөн эрх баригч нам Үндсэн хуулийн шинэ төсөл боловсруулах, намын мөрийн хөтөлбөрийг шинэчлэх ажилд оржээ.

1988 оны 12 дугаар сард МАХН-ын V бүгд хурал хуралдаж “... эдийн засаг, улс төрийн систем, нийгэм, оюун санааны хүрээг бүхэлд нь хамарсан өөрчлөн байгуулалт хийх нь манай ард түмний хойшлуулшгүй зорилт болж байна” хэмээн дүгнэж, улс төрийн системийг ардчилах, нийгмийн удирдлагын захиран тушаах арга барилыг арилгах, хэт төвлөрлийг задлах, эдийн засгийн механизмыг боловсронгуй болгох, өмчийн үр өгөөжтэй хэлбэрүүдийг оновчтой хослуулах, хоршооллын хэлбэрүүдийг дэмжих зэрэг асуудлыг дэвшүүлэн тавьжээ. Намын Төв Хорооны V бүгд хурлын үзэл санаа олон түмний улс төрийн идэвхийг эрс өрнүүлжээ.

Монголын нийгэмд өөрчлөн байгуулалтын үзэл санаа соёолох хөрс бэлэн, түүнийг тарьж ургуулах олон нийтийн тэмцэл өрнөж, эсвэл, холбоод байгуулагдан, зорилтоо тодорхойлж, хэрэгжүүлэх алхмаа хийж эхэлсэн юм. Өөрчлөн байгуулалтын үзэл санаа, олон нийтийн тэмцэл хөдөлгөөн хоёр хамтдаа өсч, үйл ажиллагаа, үзэл бодлын цэгцрэл, нэгдэл зэрэгцэн бүрэлдэж байв.

Ардчилсан хүчнээс олон түмэнд хандан гаргаж байсан уриалга, лоозон, төр засагт тавьж байсан шаардлагын агуулга нь эхэн үедээ тухайн үеийн төр засгийн эрх баригчдын үйл ажиллагааг шүүмжлэх, өнгөрсөн түүхэн замналаа үнэлж дүгнэхдээ бодитой хандах, хөрш орнуудтай харилцах тэгш бус харилцааг засаж залруулах, улмаар нам, төрийн удирдлагыг огцруулах зэргээр нийгмийн тоталитари тогтолцооны эсрэг чиглэсэн хандлагатай байв.

Социалист орнуудын хэмжээнд улс төр-онолын сэтгэлгээнд ч өөрчлөлт гарч эхлэв. Тухайлбал, Шинжлэх ухааны коммунизмын онолын зарим асуудлыг эргэн харж, хөрөнгөтөн орнуудад хөгжсөн улс төр судлалын зарим ойлголт, категориудыг уг онолын хүрээнд судлах, хэрэглэх болсон байна. 1980-аад оны II хагаст ардчилал, улс төрийн систем, улс төрийн соёл, улс төрийн хүмүүжил, улс төрийн хошуучлал зэрэг асуудлыг илүү сонирхон судалж, эрдмийн зэрэг хамгаалж, ном, өгүүлэл бичиж эхэлсэн юм. МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Д.Сүхбаатарын нэрэмжит Намын дээд сургуульд 1989-1990 оны хичээлийн жилд Улс төр судлалын төвийг байгуулан, “Улс төр судлал” хэмээх хичээлийг зааж эхэлжээ. Академич Ж.Болдбаатар тэмдэглэхдээ: “... Би ЗХУКН-ын Төв Хорооны дэргэдэх Нийгмийн ухааны академиас зохион байгуулсан нэгэн эрдэм шинжилгээний хуралд (1988) оролцож, тус академийн Олон улсын харилцааны төвийн захирал, профессор Ю.Красин, профессор Ю.Н.Гаврилов, ШУКО-ын тэнхимийн удирдагч, профессор Халипов нартай уулзахад улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх шаардлага тулгарч байгааг тайлбарлаад, ШУКО-ын тэнхимээ Улс төр судлалын тэнхим болгон өөрчлөн зохион байгуулж байгаа тухай ярьсан юм. Танайх ч ийм чиглэл барих нь зүйтэй хэмээн зөвлөжээ.

Ирээд Намын Төв Хороо, сургуулийн удирдлагад танилцуулахад дэмжсэн. Ингэж Монголд анх удаа Улс төр судлалын төвийг байгуулж, би эрхлэх болсон билээ. Манай төвд А.Цанжид, Ч.Ган-Өлзий, Д.Ганбат, П.Доржсүрэн, Г.Чулуунбат, А.Пагма зэрэг залуус ажиллаж байв” гэжээ.

Монголд 1990 оны ардчилсан хувьсгалаар улс төр, нийгмийн байгуулалт өөрчлөгдөж, 1992 оны шинэ үндсэн хуулиар улс төрийн ардчилсан дэглэм, парламентын засаглалыг тунхагласан билээ. Ардчилсан улс төрийн систем, институцийг төлөвшүүлэх нь урт удаан хугацаа шаардсан амаргүй ажил билээ. К.Поппер “Тоталитаризмаас ардчилалд шилжих шилжилт бол хамгийн хүнд бэрх шилжилт юм” хэмээн хэлсэн нь санамсаргүй үг биш гэдгийг бидний амьдрал батлан харуулж байгаа билээ. Ардчилал бэхжсэн хөгжингүй орнуудын иргэдэд улс төрийн боловсрол олгох үйл явцад дараах байгууллагууд идэвхитэй ажилладаг байна. Үүнд:

“Улс төрийн шинжлэх ухааны үндэс” номонд: “Улс төрийн шинжлэх ухаан нь бусад шинжлэх ухааны нэгэн адил өөрийн үндсэн ойлголтуудтай. Тэдгээрт нийгмийн бүлэг, нийгмийн бүлгийн

хэрэгцээ, сонирхол, улс төрийн үнэт зүйлс, улс төрийн хэм хэмжээ, улс төрийн үйл ажиллагаа, улс төрийн байгууллага, улс төрийн засаглал, улс төрийн бүрдэл, үзэл суртал, улс төрийн харилцаа, улс төрийн соёл, улс төрийн субъект ба субьектлэг чанар, бие хүний улс төрийн нийгэмжилт, улс төрийн үйл явц, улс төрийн систем зэрэг ойлголтууд багтдаг.

Эдгээр ойлголтын нэлээд нь нийгмийн тухай бусад шинжлэх ухаанд бас бий. Гэхдээ шинжлэх ухаан тус бүрт эл ойлголтын утга, агуулгад зохих өвөрмөц онцлог байдаг нь ойлгомжтой. Улс төрийн шинжлэх ухааны ойлголтын нь бодит байдлын тусгал болохын хувьд нэг нь нөгөөтэйгээ харилцан холбоотой, нэг нь нөгөөгөөсөө урган гардаг учир тэдгээрийг тодорхойлох, ухаж ойлгоход нарийн дэс дарааг харгалзах шаардлага багагүй гардаг”¹⁷⁶ хэмээн тодорхойлжээ.

Мөн улс төрийн шинжлэх ухааны өвөрмөц аргууд-системийн арга, бихевиорист арга, жишилтийн арга, шийдвэрийн арга зэргийг тайлбарласан байна.

Тэр үеийн Намын дээд сургуульд философи, улс төрийн эдийн засаг, социологи, социалист сургаалын түүх, ЗХУКН-ын түүх, Олон улсын коммунист ажилчны хөдөлгөөний түүх, Коммунист хүмүүжил зэрэг хичээлүүдээр улс төрийн шинжлэх ухааны зарим ойлголтуудыг өгч байсан билээ. Ялангуяа коммунист хүмүүжлийн хичээлийн дотор улс төрийн хүмүүжил хэмээх ухагдахуунийг нэлээд өргөн хүрээтэй зааж байсан юм.

1990-ээд оны эхнээс их, дээд сургуулийн марксизмын гурван бүрэлдэхүүнийг заахаас татгалзаж эхэлжээ. Тухайлбал, 1990-1991 оны хичээлийн жилээс МАХН-ын түүх, ЗХУКН-ын түүх, Улс төрийн эдийн засгийн ухаан, ШУКО-ын хичээлийг их, дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөнөөс хасч, оронд нь орох шинэ хичээлүүдийн бэлтгэлийг хийж эхэлсэн байна. Энэ нь нэгдүгээрт, Монгол Улс шинэ сонголт хийж, ардчилалын замд шилжсэн, хоёрдугаарт, олон нийт, ялангуяа оюутан залуус айсуй цагийн өнгө аяст тохирсон хичээлүүдийг судлах санал гаргаж эхэлсэн явдал юм.

Сургалтын шинэ хөтөлбөрт шилжих бэлтгэлийг хангахын тулд Польш, ЗХУ-д илгээж, мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах ажил хийжээ. Чингээд МУИС-ийн ШУКО-ын тэнхимийн суурин дээр Улс төр судлалын тэнхимийг байгуулах бэлтгэл ажил 1990 онд хийсэн байна. Багш нар нэг хичээлийн жил хичээлийн төлөвлөгөө, программ боловсруулж, лекц, семинар хийх бэлтгэлээ хангажээ.

1992 онд эдүгээгийн Удирдлагын тэнхимд их, дээд сургуульд улс төр судлал заах багш нарт зориулан тусгай курс зохион байгуулжээ. Гэгээрлийн сайдын тушаалаар 1991-1992 оны хичээлийн жилд ШУКО-ын оронд Улс төр судлал, УТЭЗУны оронд Эдийн засгийн онол, Марксист-ленинист философийн оронд гүн ухаан, МАХН-ын түүхийн оронд Монголын түүхийн хичээлүүдийг заах нь зүйтэй гэсэн шийдвэр гарчээ.

1991 онд МУИС-ийн захирлын тушаалаар ШУКО-ын тэнхимийн суурин дээр Улс төр судлалын тэнхим байгуулагджээ. Тухайн үед Политехникийн дээд сургууль, УБДС, АУДС, ЦДС, ХААДС зэрэг дээд сургууль, зарим техникумын улс төр судлалын багш нар МУИС-ийн Улс төр судлалын тэнхим дээр төвлөрч, сургалт, эрдэм шинжилгээн, онол-заах аргын семинар хийж, улс төрийн шинжлэх ухааны сургалт-судалгааны тулгамдсан асуудлыг хэлэлцэж, санал бодлоо солилцож байлаа.

Улс оронд өрнөж буй өөрчлөлт шинэчлэлийг улс төрийн шинжлэх ухааны үүднээс дүгнэж цэгнэх шаардлага улам өсөн нэмэгдсээр байв. Ялангуяа 1992 онд Ардын Их Хурлын чуулганаар шинэ Үндсэн хууль баталснаар хүний эрх, эрх чөлөөг олон улсын эрх зүйн хэмжээнд зөвшөөрөгдсөн хэм хэмжээгээр тунхаглаж, төрийн эрх мэдлийг “засаглал хуваах онол”-ын дагуу хуваарилан, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын асуудлыг нутгийн өөрөө удирдах ёстой холбон тавьсан юм¹⁷⁷.

Мөн “Улс төрийн намуудын” тухай хууль батлагдан гарч, олон намын тогтолцоо төлөвших эрх зүйн үндэс бүрэлджээ. 1994 онд “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал”, 1995 онд “Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого” болон боловсролын багц

¹⁷⁶ Цанжид А. Улс төрийн шинжлэх ухааны үндэс. УБ., 1992, 15 дахь тал

¹⁷⁷ Үндсэн хууль. УБ., 1992. 16 дугаар зүйл

хуулиуд батлагдсан билээ. Иймээс Үндсэн хуулиар тунхагласан улс төрийн шинэ тогтолцоо, үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлал, боловсролын талаар баримтлах бодлогоор тавигдсан зорилт, шинэлэг ойлголтуудыг улс төрийн шинжлэх ухааны үүднээс тайлбарлах, хэрэгжүүлэх арга замыг шинжлэх ухааныг үндэстэй боловсруулахад улс төр судлаачдын гүйцэтгэх үүрэг эрс өссөн байна.

Энэхүү тавигдаж байгаа шаардлага, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн санаачлагаар 1993 онд улс төр судлалын анги нээх шийдвэр, улс төр судлалаар мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх эх суурийг тавьжээ. Тус тэнхим БНСУ, Герман, Польшийн сургуулиудын сургалтын төлөвлөгөөг үндэслэн, анхны сургалтын төлөвлөгөөг боловсруулжээ. Чингээд 1993-1994 оны хичээлийн жилд анхны элсэлтээ авчээ. Эхлээд 18-хан хүүхэд элсчээ. Энэ үед Цэргийн нэгдсэн дээд сургууль улс төрийн ажилтны анги нээсэн боловч элсэлт гүйцээгүй учир тэндээс хэдэн хүүхэд шилжиж ирсэн байна. Ингээд МУИС-ийн ректор 1994 оны 11 дүгээр сарын 14-ний тушаалаар улс төр судлаач мэргэжлээр бакалаврын сургалтын төлөвлөгөөг баталж, амьдралд хэрэгжүүлж эхэлсэн байна. Эл төлөвлөгөөгөөр ерөнхий суурь боловсрол олгох хичээлүүдээс гадна I ангид Улс төр судлалын удиртгал, Улс төрийн сэтгэлгээний түүх, Төр, эрхийн онол, угсаатны зүй, Нийгмийн антропологи, II ангид Улс төрийн сэтгэлгээний түүх, Монголын нийгэм, Улс төрийн сэтгэлгээний түүх, Социологийн онол, сэтгэл судлал, III курст Монголын улс төрийн түүх, харьцуулсан улс төр судлал, Төрийн гадаад бодлого, олон улсын харилцаа, Улс төрийн сэтгэл зүй, Сурган хүмүүжүүлэх ухаан, Нийгэм судлал заах арга зүй, Хүн ам зүй, IV курсэд Харьцуулсан улс төр судлал II, Олон улсын харилцааны эрх зүй, Улс төрийн анализ хэмээх мэргэжлийн суурь мэдлэг олгох хичээлүүдийг орох болсон байна.

1997 онд улс төр судлалын оройн анги нээн хичээллүүлжээ. Улс төр судлаачийн анги анх элсэлт авснаас хойш 18 удаа төгсөлт хийж, 1000 гаруй бакалавр зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэжээ.

Улс төрийн шинжлэх ухааны сургалт судалгааны ажил өргөжин тэлж, боловсролын тогтолцоонд зохих байр сууриа эзэлж байгаагийн нэг жишээ бол МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн “Улс төр судлал” бакалаврын мэргэжлийн хөтөлбөр Боловсролын магадлан итгэмжлэх Үндэсний зөвлөлийн 2012 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны шийдвэрээр магадлан итгэмжлэгдсэн явдал юм. Ийнхүү нийгмийн ухааны хичээлүүдээс Монгол Улсад анх удаа магадлан итгэмжлэгдэж байгаа хөтөлбөрүүдийн нэг боллоо.

Улс төр судлалыг янз бүрийн мэргэжлийн хүмүүс сонирхон суралцах болж, чамгүй олон магистр төрж гарч судалгаа өргөжиж эхэлжээ. Ийм үед 1999 онд тус тэнхим анхны докторын шатны сургалтыг эхлүүлсэн байна.

Улс төр судлаач мэргэжилтэн бэлтгэх ажил МУИС-ийн хүрээнээс хальж, 1999 оноос Улсын боловсролын их сургууль дээр философи-улс төр судлалын анги, 2000 онд Шинжээч-21 дээд сургуульд социологич-улс төр судлаачийн анги, 2003 оноос Ховд их сургуульд улс төр судлаачийн анги нээжээ. Түүнчлэн Соёмбо, Чингис хаан, Их засаг зэрэг сургуулиудад ижил төрлийн мэргэжилтэн бэлтгэх болов. Ийнхүү манай улсад улс төрийн шинжлэх ухааны чиглэлээр бакалавр, магистр, докторын шаталсан сургалт бодит биелэлээ олж, төлөвшиж байна.

Улс төр судлалын салбар, тэнхимийн гадаад харилцаа өргөжиж ирсэн нь Монгол оронд улс төрийн шинжлэх ухаан өрнөн хөгжих нөхцөлийг бүрэлдүүлсэн юм. Тус салбар өсөн бэхжихэд Соросын сан, СЕР, ТЕИС, Конрад-Аденаурын сан, Ханс Зайдлын сан, Эйбертийн сан, Азийн сан зэрэг олон улсын байгууллагууд туслалцаа дэмжлэг үзүүлж ирэв.

Эдгээр байгууллага улс төр судлаачдыг гадаадын мэргэжил нэг байгууллага, судлаач эрдэмтэдтэй холбоо тогтооход чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Улс төр судлалын салбарыг профессор, багш нар, судлаачид АНУ, Канад, Герман, Англи, Унгар, Польш, Литва, Казахстан, Киргизстан, Узбекистан, Япон, Солонгос, Хятад, Сингапур зэрэг Ази, Европ, Америк зэрэг олон оронд суралцаж, мэргэжил дээшлүүлэн, эрдмийн зэрэг хамгаалж иржээ.

Сүүлийн жилүүдэд улс төр судлаачдын хамтын ажиллагаа өргөжиж, мэргэжлийн холбоонд нэгдэх болов. 2003 онд Монголын Улс төр судлалын холбоог байгуулжээ. Тус холбооны дүрэмд: “Холбоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Төр бус байгууллагын тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон энэ дүрмийн хүрээнд Улс төрийн шинжлэх ухааныг судалдаг сонирхдог иргэдийг нэгтгэн үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус, аль нэг улс төрийн хүчин, нэр дэвшигчийг дэмжихгүй, улс төрийн хүчнээс хараат бус нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага мөн¹⁷⁸” гэж тодорхойлжээ.

ШУА-ийн улс төр судлалын салбарын үндэс анх 1978 онд Шинжлэх ухааны социализмын онолын сектор нэртэйгээр тавигджээ. Марксизмын улс төрийн сургаал хэмээгдэж байсан ШУКО-ын Монгол дахь хэрэгжилт, түүнтэй холбогдон тавигдаж байсан онолын зарим асуудлыг тус орны онцлогт нийцүүлэн судлах ажлыг тус сектор 1990 он хүртэл гүйцэтгэжээ.

Улс төр судлалын салбар нь 1990 оноос эхлэн өнөөг хүртэл Монголын нийгмийн хөгжил, өөрчлөлтийн асуудал, олон нийтийн санаа бодлын өөрчлөлт, монголын улс төрийн тогтолцооны онцлог, ардчиллын төлөвшлийн асуудлыг судалгааныхаа үндсэн чиглэл болгон судлахын зэрэгцээ нийгэм улс төрийн харилцааны чухал асуудлууд болох сонгууль, сонгуулийн тогтолцоо, үйл явц, монголын улс төрийн сэтгэлгээний түүх, монголын улс төрийн ардчилсан өөрчлөлтийн онолын асуудал, улс төрийн нам, түүний дотоод ардчилал, иргэний нийгмийн төлөвшил, төлөөллийн ба иргэдийн улс төрийн оролцооны онолын асуудлуудыг суурь судалгааны сэдвийн түвшинд нарийвчлан судалдаг.

МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, түүний дэргэдэх төв, ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэн салбаруудаас гадна Улс төрийн боловсролын академи, Төрийн Удирдлагын Академи, УИХ-ын дэргэдэх судалгааны төв, Улс төрийн намуудын дэргэдэх судалгааны байгууллагууд, МЗХ-ны дэргэдэх Полис төв, Зориг сан, Сант Марал сан, Зотол, Социологийн Академи, Сонгогчдын боловсрол төв, Сивикус, Зөгий, Жинлүүр, Монголын Лектор төв зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд улс төрийн ШУ-ны тодорхой чиглэлүүдээр судалгаа шинжилгээний ажлууд хийж ирсэн нь энэ салбарын институционал бүтцийн нэг бүрдэл хэсэг болон төлөвшиж байна. Энэхүү бүтцийн хөгжилд Соросын сан, АНУ-ын БНОУХ, Азийн сан, Конрод-Адэнаурын сан зэрэг гадаад орнуудын болон олон улсын байгууллагуудын дэмжлэг, туслалцаа хамтын ажиллагаа чухал нөлөө үзүүлсэн билээ.

Манай улсад иргэдэд суурь боловсролыг олгох сургууль 10 жилийн сургалттай ерөнхий боловсролын сургуулиудыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх ажил янз бүрийн үе шаттайгаар 20 гаруй жил үргэлжилсэний эцэст 2012 онд бүрэн шилжсэн байна. Энэ хугацаанд ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт тухайлбал, “Нийгмийн тухай мэдлэг” хичээлийн хөтөлбөр агуулгын хувьд олон дахин өөрчлөгдөж иржээ.

Өнөөгийн ерөнхий боловсролын “нийгмийн тухай мэдлэг” хичээл тодорхой шүүмжлэлтэй байгаа хэдий ч ардчилсан нийгмийн иргэдийн наад захын мэдлэг болох улс төр, социологи, философи, түүх, эрх зүй, эдийн засаг, олон улсын харилцааны наад захын мэдлэгийг албан ёсны сургалтын системээр дамжуулан ахлах ангийн сурагч хүүхдүүдэд олгодог болсон ажээ. Үүнээс гадна тусгай сургалттай хувийн сургуулиудад зарим хичээлийг илүү түлхүү оруулах хэлбэрээр хүүхэд, залуучуудын нийгмийн тухай мэдлэгийг дээшлүүлж байна. Мөн их дээд сургуульд элсэн ороход нийгмийн тухай мэдлэг болон түүхийн хичээлээр элсэлтийн шалгалт авч байна.

Төрөөс мэргэжлийн боловсролын тогтолцооны “дуал буюу хосолсон систем” байгуулах зорилт тавьж “Мэргэжлийн үйлдвэр сургалтын төв”-үүд байгуулахыг дэмжсэн бодлого хэрэгжүүлж байгаа хэдий ч энэ тодорхой үр дүнд хүрэхгүй байна. Уг системийн онцлог нь үйлдвэрлэлийн практик мэргэжлийн сургалтыг хослуулдаг онцлогтой.

¹⁷⁸ Ганболд Ц. ШУКО-оос Улс төр судлал хүртэл. 2012, 81 дэх тал

Гадаад орнуудын туршлагаас харахад мэргэжлийн боловсрол олгох нь үйлдвэрлэгч эдийн засгийн салбарын үүрэг байсан бөгөөд нэн ялангуяа үйлдвэр, худалдааныханы өөрсдийнх нь үр ашиг, хөгжлийн бодлоготой илүү холбогддог байна. Тухайлбал, АНУ-ын боловсролын салбарын үсрэнгүй хөгжил нь Америкийн нийгэмд нийгмийн гарлын хувьд харилцан адилгүй өргөн хүрээтэй дундаж давхарга бүрэлдэн тогтоход чухал хувь нэмрээ оруулсан байдаг.

Мөн Улс төрийн институцийн үүрэг хариуцлагыг авч үзэхэд Парламентын ардчилал зүй зохисоороо хөгжихөд иргэд сонгогчдын сонголтод улс төрийн мэдлэг, боловсрол өндөр ач холбогдолтой. УИХ-ын сонгуульд оролцож буй иргэдийн багагүй хувь нь саналаа мөнгөөр худалдах, туйлшрах хандлага өргөн байгаа нь нэг талаар иргэдийн улс төрийн боловсрол мэдлэг бага байгаатай, нөгөө талаар хүмүүсийн амьдралын түвшин муу байгаатай холбоотой гэж үздэг. Гэхдээ сүүлийн үед хувийн ашиг сонирхлын төлөө төрийн эрх мэдлийг авах гэсэн талцсан улс төржилт сонгогчдын тавны нэгийг хамарсан (Монгол улс 2 сая сонгогчидтой, 400 мянган намын гишүүнтэй байна¹⁷⁹) нь улс төрийн тогтолцоог гажуудуулж байна.

Нөгөөтэйгүүр, сонгогчдын улс төрийн боловсрол өндөр байгаа нөхцөлд парламентын гишүүдийн амлалт, үйл ажиллагаа, ёс зүйн түвшин өндөрсдөг нь Европын орнуудын болон Евро парламентын үйл ажиллагаанаас харагддаг. Парламентын үйл ажиллагаа олон нийтэд нээлттэйгээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжин хүрч байгаа нь иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх нэг гол эх сурвалж болж байгаа хэдий ч манай улс төрчдийн улс төрийн мэдлэг боловсролын түвшин доогуур байгаа болон зориуд “буруу”⁹⁷¹⁸⁰ мэдээлэл өгөх хандлага нь иргэдийг төөрөгдөлд оруулж байна.

Үүнээс үзэхэд Улс төрийн намуудын үйл ажиллагаа шударга бус байгаа нь нэг талаар сонгогчдын улс төрийн мэдлэг боловсрол бага байгаатай холбоотой юм. Тэд “Ямар ард түмэн байна, тийм засаглал байдаг” гэсэн хэлц үгээр өөрсдийгөө зөвтгөдөг. Нөгөө талаар улс төрийн намууд бодлогын институц болж чадаагүй нь сонгогчдын улс төрийн мэдлэг боловсрол бага, амьжиргааны түвшин муу байгаатай холбоотой. Ардчилал бэхжсэн орнуудад намууд манайх шиг мөрийн хөтөлбөртэй сонгуульд оролцвол ялахгүй нь тодорхой. Энэ нь нэг талаар сонгогчдын улс төрийн мэдлэг боловсролын түвшинтэй холбоотой юм.

Нэр дэвшигчид сонгогчдын саналын төлөө өрсөлдөхдөө иргэдийг мэдээллээр хангах ёстой. Энэхүү мэдээллийн үндсэн дээр иргэд улс төр, намууд болон тэдгээрээс нэр дэвшигчдийн дэвшүүлж буй хөтөлбөр, саналын талаар, түүнчлэн эдгээр намын манлайлагчдад итгэл хүлээлгэж болох эсэх, тэд хэр зэрэг шударга, ажил хэргээ мэдэж байгаа талаар ухамсартай сонголт хийж чадахуйц байх ёстой. Иргэд ийм хэмжээний мэдээлэлтэй болохоор дараагийн сонгуулийн босгон дээр улс төрчид буюу намуудаас үйл ажиллагааных нь тайланг шаардаж чаддаг байна. Улс төрийн зүтгэлтнүүд үйл ажиллагаагаа тайлагнах учраас сонгуулийн өмнөх амлалтаа амьдралд хэрэгжүүлэхийг эрмэлзэх болно. Гэвч энэ зарчим хэрэгжиж чадахгүй байгаа нь сонгогчдын улс төрийн мэдлэг боловсролтой ямар нэг хэмжээгээр холбогдоно.

Барууны орнуудын улс төрийн намуудын өрсөлдөөн, тэдгээрийн бодлогын мэтгэлцээн, шүүмжлэлүүд нь иргэд, сонгогчдод улс төрийн утга учрыг гүнзгий ойлгох боломжийг олгодог байна. Энэ утгаараа парламентын мэтгэлцээн, улс төрийн намуудын “шударга” өрсөлдөөн нь иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх хамгийн гол эх сурвалж болдог ажээ.

Ардчилал бэхжсэн орнуудад сонгуулийн пропорциональ болон холимог тогтолцоо давамгайлж байгаа нь сонгогчдын улс төрийн мэдлэг боловсрол өндөр байгаатай холбоотой юм. Учир нь сонгуулийн пропорциональ тогтолцооны онцлог нь сонгогчид нам дугуйлдагт оршдог бөгөөд сонгогчид улс төрийн намуудын бодлого, мөрийн хөтөлбөрт үнэлэлт, дүгнэлт өгч сонгохыг илүүд үзэх

¹⁷⁹ Батболд Ц. Улс төрийн намын хатуу гишүүнчлэл, түүний нийгэм улс төрийн амьдралд гүйцэтгэх үүрэг. Улс төрийн нам: эрэл, шийдэл, №05, 2014

¹⁸⁰ Тухайлбал, хууль, шүүхийн байгууллагаар батлагдаагүй мэдээллээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан гүтгэх гэх мэт

болсонтой нэг талаар холбоотой юм. Нөгөө талаар тэдгээр орнуудын сонгогчид хэн нэгэн хувь улс төрч буюу төлөөлөгчөөс илүүтэй улс төрийн намын бодлого хөтөлбөр өөрсдийнх нь амьдралд илүү нөлөөлж чадна гэдгийг ойлгох чадвартай болсонд оршино.

Өндөр хөгжилтэй орнуудаас зөвхөн АНУ, Их Британид сонгуулийн мажоритар тогтолцоо ноёрхож байгаа нь тэдгээр орнуудын сургалтын тогтолцоотой холбоотой байна. Учир нь тэдгээр орнуудад далайн орнуудын либерал уламжлалаар элит сургалтад илүү анхаарч, бүх нийтийн сургалтын хөтөлбөрийн чанар муу байгаатай холбоотой юм. Тиймээс сонгогчдын олонхийн улс төрийн боловсролын түвшин логикийн хувьд өндөр хөгжилтэй Европын орнуудаас доогуур байна гэж үзэж болно.

Парламентын ардчилалын хууль ёсны үйл ажиллагааг иж бүрэн хангахад хэрэгтэй гэж үзвэл улс төрийн намуудын чадавхи, оршин байгаа нөхцөл, үйл ажиллагааны нь шинж чанар зэргээс гадна тэдэнд шаардлага тавьж буй иргэд, сонгогчдын улс төрийн мэдлэг боловсролоос их зүйл хамаарч байна.

Ардчилсан нийгэм дэх ТББ, ИНБ-ийн үйл ажиллагаа. Ардчиллыг бататгахад иргэний нийгмийн бүтцүүд, иргэдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх замаар хямралаас ангид байх нөхцөлийг хангах нь зайлшгүй зүйлийн нэг юм. Үүнд хүрэхийн тулд хүн амын зохих хэмжээний улс төрийн боловсролыг хангах, түүнийг дэмжин хөгжүүлэх нь чухал. Учир нь зөвхөн сайн боловсролтой иргэд л улс төрийн болон нийгмийн үйл явцад идэвхитэй оролцож чадна. Энэ үүднээс иргэдийн улс төрийн боловсрол, соёл, оролцооны ач холбогдол нь ардчилсан улс төрийн системийн эргэх холбооны үндсийг бүрдүүлдэг.

Барууны иргэний нийгмийн байгууллагууд нь бидэнд хүний эрхийг хангах, төр засаглалыг хянах зорилгоор засгийн газраас хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрүүдэд мониторинг хийх замаар үүрэг хүлээгчдэд нөлөөлөл, лобби хийх, хариуцлагатай, ил тод байдлыг баталгаажуулах үйл ажиллагаа явуулдаг. Манайд ийм чиглэлээр ажиллаж буй ТББ-ууд цөөн боловч ажиллаж байгаа нь УИХ, Ерөнхийлөгчийн сонгуулиудад хийж буй аудитаар харагдаж байна.

Иргэний нийгмийн байгууллагууд, ТББ-ын улс төрийн үүргийн нэг бол төр, засаг захиргаанд өөрчлөлт гарсан ч тэдгээрийн хөтөлбөрүүдийн тогтвортой, үргэлжлэн хэрэгжих баталгааг хангахад чиглэсэн шаардлага, шүүмжлэл, хяналт юм. Иргэний нийгмийн байгууллагууд, ТББ-ууд нь сургалт хийх, мэдлэг ойлголт өгөх замаар иргэд, олон нийтийг нийгмийн үйл хэрэгт татан оролцуулах тал дээр улс төрийн намуудаас дутуугүй үйл ажиллагаа явуулдаг болсон бөгөөд мөн төрийн үйлчилгээнд мониторинг хийх замаар нийгмийн өөрчлөлт хийх үйл явцад хувь нэмэр оруулдаг байна.

Энэ тал дээр манай иргэний нийгмийн байгууллагууд, ТББ-ууд үнэхээр чадваргүй байгаа нь мэдлэг боловсролоос гадна санхүүгийн чадавхгүй байдалтай илүү холбоотой юм. Нөгөө талаар хөгжиж байгаа орнуудад тусалж буй гадны ТББ-ын тусламжийг үр дүнтэй ашиглаж чадахгүй байгаа байдал ажиглагдаж байна. Тэдний үйл ажиллагаа хамгийн ядуу, нийгмээс тусгаарлагдсан, эмзэг бүлгийн гишүүдтэй ажиллаж, тэдний хөгжлийг хангахад нь тусалж дэмжих, мөн эрхийг нь хангах үүрэг хүлээгчдийг идэвхижүүлэхэд нөлөөлөл үзүүлэхэд чиглэх нь ховор байна.

Нийгмийг ардчилах нь иргэний нийгмийн чадавхийн асуудал юм. Барууны орнуудад иргэний нийгэм үүргээ хэрхэн гүйцэтгэж байгаагаар тэдгээрийн ардчилах чадавхийг хэмждэг. Үүнийг харьцуулан авч үзье.

Иргэний нийгмийн байгууллагуудын гүйцэтгэх үүргийн харьцуулалт

№	Ардчилал бэхжсэн барууны орнуудад	Өнөөгийн Монголд
1	Иргэний нийгмийн эхний бөгөөд хамгийн чухал үүрэг нь төрийн зүгээс хувийн амьдралд халдахаас хамгаалах, ингэснээр хувийн болон нийгмийн хүрээг зааглан баталгаажуулахад оршино. Бүх либерал ардчилсан системд энэ зарчим үйлчилдэг.	Төрийн зүгээс хувийн амьдралд халдахаас хамгаалах үүрэг төлөвшөөгүй. Хувийн болон нийгмийн хүрээ нь холилдсон

2	Төрийн эрх мэдэлд иргэний нийгмийн зүгээс ажиглалт хийн, хяналт тавих явдал. Иргэний нийгмийн чадал, чадавхиас хамааран энэхүү "иргэний нийгмийн ажиглалт"-аар төрийг хариуцлагад татаж болно.	Төрийн эрх мэдэлд иргэний нийгмийн зүгээс ажиглалт хийн, хяналт тавих явдал төлөвшөөгүй. Иргэний нийгэмд төрийг хариуцлагад татах хэмжээний чадавхи бүрдээгүй.
3	Иргэдийг ардчилсан оролцооны чиглэлээр нийгэмшүүлэн, төрийн шийдвэр гаргадаг байгууллагуудад ардчилсан элитийг дайчлан оролцуулах буюу нийгмийн капиталыг хуримтлуулах, ардчиллын сургууль болох үүрэг.	Энэ үүрэг төлөвшөөгүй.
4	Иргэний нийгэм нь улс төрийн нам болон парламентаас гадна нийтлэг үнэт зүйлс, нийгмийн эрх ашиг бүрэлдэх, нягтрах үр өгөөжтэй арга замыг нээж өгдөг. Ялангуяа угсаатан, арьсны болон шашны цөөнх зэрэг хавчигдмал, эсвэл эмзэг бүлгүүдийн хувьд энэхүү үүрэг нэн чухал.	Иргэний нийгмийн байгууллагууд эмзэг бүлгүүдтэй ажиллах явдал гадны санхүүжүүлэгчдээс хамааралтай эхэлсэн.
5	Иргэний нийгэм нь ялангуяа шинэ тулгар ардчилсан тогтолцоонд үндэсний хэмжээний ардчиллын хөгжлөөс хоцронгүй байдаг хөдөө орон нутгийг ардчилахад чухал үүрэг гүйцэтгэдэг.	Иргэний нийгэм нь хөдөө орон нутагт идэвхитэй бус, ардчилахад гүйцэтгэх үүрэг төлөвшөөгүй.
6	Иргэний нийгэм нь эвсэл холбоо, үүсгэл санаачлагын хөдөлгөөн, сүлжээгээрээ дамжуулан нийгмийн зөрчлийг намжаахад хувь нэмрээ оруулдаг.	Нийгмийн зөрчлийг дэврээдэг.
7	Иргэдийн улс төрийн боловсрол мэдлэгийг дээшлүүлэхэд нөлөө үзүүлэхүйц “Education Voting” буюу “Сонгогчдын боловсрол”, “Democratic Education” буюу “Ардчилсан боловсрол” гэх мэт олон үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.	Хувийн шинжтэй “Сонгогчдын боловсрол төв” гэх мэт байгууллагуудын үйл ажиллагаа нь гадны ивээн тэтгэгч болон нэг хүнээс хамааралтай. Иргэдийн улс төрийн боловсрол мэдлэгийг дээшлүүлэхэд нөлөө үзүүлж чадахгүй.

Үүнээс үзэхэд манай улсад улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд “Улс төрийн боловсролын академи” багагүй үүрэг гүйцэтгэж байна. Тус академи улс төр судлалын цуврал лекцүүд гаргаж, улс төр судлалын гарын авлагууд хэвлүүлжээ. Мөн “Шинэ толь” сэтгүүл гаргаж, улс төрийн амьдралын амин чухал асуудлаар онолпрактикийн өгүүлүүд нийтэлсээр байна.

Дүгнэлт: Ардчиллыг бататгахад иргэний нийгмийн бүтцүүд, иргэдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх замаар хямралаас ангид байх нөхцөлийг хангах нь зайлшгүй зүйлийн нэг. Үүнд хүрэхийн тулд хүн амд зохих хэмжээний улс төрийн мэдлэг, боловсролоор хангах, түүнийг дэмжин хөгжүүлэх нь чухал. Энэ үүднээс иргэдийн улс төрийн боловсрол сайн байх нь ардчилсан нийгэм дэх төлөөллийн ардчилал зүй зохисоороо хөгжих, улс төрийн намуудын үйл ажиллагаа нийгэмд үр нөлөөтэй байхад зайлшгүй чухал ач холбогдолтой. Улс төрийн намуудын амлалт, мөрийн хөтөлбөрийн биелэгдэх магадлал, боломж нь сонгогчдын улс төрийн боловсролтой шууд хамааралтай. Сонгогчдын боловсрол бага байх тусам намуудын амлалтууд хариуцлагагүй, утопи, популист шинжтэй болж байна. Ийнхүү Монголд улс төрийн шинжлэх ухааны хөгжил хүчээ авч, хүн ардыг улс төрийн талаар нийгэмшүүлэх, хүн төрөлхтний улс төрийн амьдралын жам ёсны гольдролоор хөгжих онол, практикийн хүчирхэг хүчин зүйл болон өсөн дэвшиж байна.

Санал. Монгол оронд улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлж, улс төрийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлэхийн тулд дараах саналыг дэвшүүлж байна.

1. Бүх нийтэд улс төрийн боловсрол олгох улсын хэмжээнд шинжлэх ухааны үндэстэй нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх,
2. Улс төрийн шинжлэх ухааны бакалавр, магистр, доктор бэлтгэх сургалтыг олон улсын жишигт хүргэх,
3. Улс төрийн шинжлэх ухааны ойлголт, ухагдахууныг монгол хөрсөн улам нарийн буулган, судалгааг гүнзгийрүүлэх,
4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд улс төрийн бодлогод дүн шинжилгээ хийж, холбогдох өндөр дээд албан тушаалтанд ажил хэрэгч зөвлөмж өгөх улс төрийн анализын орон тооны хамтлаг (төв) байгуулах,
5. Улс төр судлаачид УИХ-ын болон Засгийн газрын гишүүдийн улс төрийн хэм хэмжээнээс хэтэрсэн үйлдлийг онолын үндэслэгээтэй няцаасан өгүүлэл нийтэлж байх,

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. Болд-Эрдэнэ Д. Улс төрийн философи. УБ., 2015
2. Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь. УБ., 2006
3. Монгол дахь иргэний нийгмийн төлөвшлийн философи, улс төр, эрх зүйн асуудал. УБ., 2014
4. Чулуунбаатар Г. XX-XXI зууны зааг үеийн Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил хөгжил. УБ., 1999
5. Тамир Э. Монголын сэхээтний улс төрийн ухамсар соёлын төлөвшлийн зарим асуудал. УБ., 1993
6. Аристотель. Улс төр. УБ., 2006
7. Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг. УБ., 2010
8. Цанжид А. Монгол Улсын хөгжлийн бодлогын зарим асуудалд. УБ., 2006
9. Хүний эрхийн комиссын эмхэтгэл, УБ., 2014

ДОТООДЫН ЦЭРЭГ СУДЛАЛЫН СУДАЛГААНЫ
НЭГЖ БАЙГУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Э.Рэгдэндагва

*Цагдаагийн сургуулийн дотоодын
цэргийн албаны тэнхимийн эрхлэгч,
цагдаагийн дэд хурандаа*

Товч агуулга. Монгол Улсад дотоодын цэрэг анх 1922 онд үүсгэн байгуулагдаж улсын чухал объектын харуул хамгаалалт, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олзлогсад болон хоригдлыг хуяглан хүргэх, төр засгийн шийдвэрээр улс оронд гарсан үймээн самууныг таслан зогсоох үүргийг голчлон гүйцэтгэж иржээ. Дотоодын цэрэг нь НАХЯ-ны /хуучин нэрээр/ Хилийн ба Дотоодын цэргийн удирдлагад, 1990 оноос 2014 онд татан буугдах хугацааг хүртэл цагдаагийн төв байгууллагын удирдлагад чиг үүргээ хэрэгжүүлж байжээ.

Улсын онц чухал объектыг хамгаалах, шаардлагатай үед нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, дотоодын бусад үймээн самууны үед иргэн, байгууллагын аюулгүй байдал, өмч хөрөнгийг хамгаалах, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг гүйцэтгүүлэх, гамшиг, аюулт үзэгдэл, техникийн осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан үед аврах болон хорио цээрийн дэглэмийг сахиулахад оролцох хэрэгцээ шаардлага нь Дотоодын цэргийн үүрэг оролцооны ач холбогдлыг илэрхийлж байна.

Энэхүү өгүүлэлд Дотоод цэргийн гүйцэтгэх үүрэг, түүхэн хөгжил болон тусгайлсан Дотоодын цэрэг судлалын нэгж байгуулах хэрэгцээ шаардлага, ач холбогдлын талаар товч өгүүлсэн болно.

Түлхүүр үг. Дотоод цэрэг, улсын онц чухал объект, чиг үүрэг, түүхэн хөгжил

Үндсэн хэсэг. Жанжин Д.Сүхбаатарын санаачлага, Ардын түр засгийн газар, Бүх цэргийн зөвлөлийн шийдвэрээр 1922 оны 07 дугаар сарын 16 ны өдөр Дотоодыг хамгаалах газрыг анх байгуулахад тус газрын дэргэд дотоодын харуул хамгаалалтын үүргийг дагнан гүйцэтгүүлэх зорилгоор цөөн хүний бүрэлдэхүүнтэй нэгэн тасаг цэргийг байгуулжээ.

Энэхүү тасаг цэрэг нь байгуулагдсан цаг үеэс эхлэн улсын чухал албан газрыг манаж хамгаалах, алслагдсан нутаг хошуудад нууц бичиг баримтыг хүргэх, оргон нуугдсан гэмт хэрэгтнүүдийг баривчлах, хоригдол ялтныг хуяглан хүргэх, цагдан харгалзах зэрэг үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ хувьсгалын эсэргүү бослого хөдөлгөөн, үймээн самууныг дарахад Дотоодыг хамгаалах газрын ажилтануудтай хүч хавсран оролцож байжээ.

Түүхэн баримт бичиг болон эрдэмтэн, судлаач, түүхчдийн бичиж тэмдэглэснээс үзвэл тус тасаг цэрэг нь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй тайван цагт мэргэжлийн бие даасан үйл ажиллагаа явуулдаг, орчин цагийн төрийн цэргийн байгууллага болох Дотоодын цэргийн эх үүсвэр үндэс суурь нь болон хөгжижээ.

Түүхэн хөгжлийн явцаас нь үзэхэд Дотоодын цэрэг нь;

1. 1922-1936 онд Дотоодыг хамгаалах газрын ерөнхий хэлтэс, цэргийн ба хязгаарын хэлтсийн шууд удирдлагад,
2. 1936-1955 онд Дотоод явдлын яамны хязгаарын ба цэргийн хэлтсийн шууд удирдлагад,
3. 1955-1959 онд Цэргийн ба Нийгмийг хамгаалах хэрэг эрхлэх яамны Ардын цэргийн командлалын Ерөнхий цэргийн штабын шууд удирдлагад,
4. 1959-1990 онд Нийгмийг аюулаас хамгаалах яамны Хязгаарын ба дотоодын цэргийн хэрэг

эрхлэх хэлтэс, газар, Хилийн ба Дотоодын цэргийг удирдах ерөнхий газрын шууд удирдлагад,

5. 1990-1995 онд Цагдан сэргийлэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын шууд удирдлагад,

6. 1995 онд "Дотоодын цэрэг"-ийн тухай хууль батлагдаж, 1995-2014 онд Дотоодын цэргийн даргын шууд удирдлагад ажиллаж, алба-ажиллагаагаа Цагдаагийн байгууллагатай хамтран явуулж байв.

7. 2016 оны Улсын Их Хурлаар "Дотоодын цэргийн тухай хууль"- батлагдаж, 2017 оны 09 дүгээр сараас мэргэжлийн штаб, анги байгууллагыг Засгийн газрын шийдвэрээр дахин байгуулагдаж, одоо Дотоодын цэргийн командлагчийн шууд удирдлагад алба ажиллагаагаа явуулж байна.

Дээрхи хугацаанд Дотоодын цэрэг нь 1953 -1959 онд болон 2014 -2017 онуудад хоёр удаа төр, засгийн шийдвэрээр татан буугдаж байсан байна. Үүний гол шалтгааныг судлаач миний зүгээс төр засгийн удирдлагад Дотоодын цэргийн байгууллагын чиг үүрэг, алба үйл ажиллагааны үндсэн чиглэл, төрөөс баримтлах бодлого хангалтгүй, Дотоодын цэрэг гэдэг байгууллагын хөгжлийн чиг хандлага, төрөөс баримтлах бодлого, цаашдын чиг хандлагыг шинжлэх ухааны үүднээс судлан шинжилсэн судалгааны ажил байхгүй, боловсон хүчнээ бэлтгэх, цаашид мэргэшүүлэх бодлого хангалтгүй байсантай холбон үзэж байна.

Дотоодын цэргийн чиг үүрэг түүний хэрэгжилтэнд дараах судалгааг хийв.

Дотоодын цэрэг нь Монгол улсын “Дотоодын цэргийн тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлд¹⁸¹ заасан улс орны дотоод аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн дараах чиг үүргүүдийг хэрэгжүүлэн алба ажиллагаагаа зохион байгуулж байна.Үүнд:

1. Улсын онц чухал объектыг хамгаалах
2. Нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсооход дэмжлэг үзүүлэх
3. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул тохиолдсон үед болон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
4. Шаардлагатай үед зарим объектыг түр хугацаагаар хамгаалах
5. Террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагаанд оролцох
6. Хуулиар тогтоосон бусад чиг үүргүүдийг Дотоодын цэргийн командлагчийн өдөр тутмын шууд удирдлаганд мэргэжлийн штаб, анги, тусгай салбарын бүтэц зохион байгуулалтайгаар цагдаагийн байгууллага, бусад төрийн тусгай чиг үүргийн байгууллагууд, хамгаалж байгаа байгууллагын захиргаатай харилцан ажиллаж, хуулиар хүлээсэн чиг үүргийн биелэлтийг хангаж байна.

Сүүлийн үед улс орны гадаад, дотоод нөхцөл байдлын өөрчлөлтөөс хамаарч дотоодын цэргийн гүйцэтгэх чиг үүрэг нэмэгдэж, Засгийн газрын 2021 оны 356 дугаар тогтоолоор "Өмнөговь аймаг дахь Таван толгойн нүүрсний уурхайг хамгаалах анги", "Говь-Алтай аймаг дахь Тайширын усан цахилгаан станцыг хамгаалах тусгай салбар" шинээр байгуулагдаж, Дотоодын цэргийн командлагчийн 2022 оны 04 дүгээр сарын шийдвэрээр "Чойбалсан, Дархан хотууд, Өмнөговь аймаг дахь, Нийслэлийн Багахангай, Багануур дүүрэг дэхь салаадыг тусгай салбар болгон өргөтгөн зохион байгуулаад байна. Энэ байдалд дүгнэлт хийж үзэхэд Дотоодын цэргийн гүйцэтгэх улс орны аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээрх үүрэг цаашид нэмэгдэх чиг хандлагатай байна гэж үзэж байна.

Дотоодын цэрэг бусад төрийн цэргийн байгууллага, цагдаагийн байгууллагаас ялгаатай онцлог байдал: Дотоодын цэргийг Монгол улсын "Үндэсний аюулгүй байдлын тухай хууль"-ийн 7.1.6-д "Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага"¹⁸², “Зэвсэгт хүчний тухай хууль”-ийн 7.2-д зааснаар “Дайны байдал зарламагц хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага зэвсэгт хүчний бүтцэд шилжиж, үүрэг гүйцэтгэнэ.”¹⁸³, "Монгол улсын батлан хамгаалах

¹⁸¹ Төрийн мэдээлэл. 2017. №14. Дотоодын цэргийн тухай хууль

¹⁸² Төрийн мэдээлэл. 2002. №03

¹⁸³ Төрийн мэдээлэл. 2016. №31

бодлогын үндэс"-ийн 7.1-д зүйлд зааснаар “Төрийн цэргийн байгууллага”¹⁸⁴-гэж тус тус заасанаас үзэхэд Дотоодын цэрэг нь **Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэгтэй, тайван цагт мэргэжлийн бие даасан үйл ажиллагаа явуулдаг, төрийн цэргийн байгууллага юм.**

Дотоодын цэрэг нь гэмт хэргийг таслан зогсоох, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлэх, гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул тохиолдсон үед болон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, террорист сөрөг тусгай ажиллагаанд оролцох чиг үүргүүдийг цагдаагийн байгууллага, бусад төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудтай хамтран Дотоодын цэргийн командлагчийн шийдвэрээр шууд хэрэгжүүлдэгээрэй **төрийн цэргийн байгууллагуудаас ялгаатай** боловч эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, хуулийн байгууллагын шинжийг агуулдаггүйгээрэй **Цагдаагийн байгууллагаас ялгаатай** байгууллага билээ.

Дотоодын цэргийн хуульд заасан улс орны дотоод аюулгүй байдлыг хангахад нэн чухал ач холбогдолтой Засгийн газраас тогтоосон "Улсын онц чухал объектыг хамгаалах", "Цагдаагийн байгууллагын хуч хэрэгсэл хүрэлцэхгүй үед гэмт хэргийг таслан зогсоох, нийгмийн хэв журмыг сахиулахад оролцох"- талаархи чиг үүргүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17 ны өдрийн 152 дугаар тогтоолоор “Хууль сахиулахын их сургууль”-ийг, “Дотоод хэргийн их сургууль”-болгон өөрчлөн зохион байгуулахад Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/126 дугаар тушаалаар “Дотоодын цэргийн албаны танхим”-ийг байгуулж, “Аюулгүй байдал-Дотоодын цэрэг” мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн дөрвөн удаагийн элсэлт авч, одоо 62 сонсогч, суралцагчийг дээрхи хөтөлбөрөөр суралцуулж байна.

Тус тэнхим нь дотоодын цэргийн боловсон хүчнийг бэлтгэх сургалтын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн зэрэгцээ дотоодын цэрэг судлал, албаны тактик, тусгай бэлтгэл зэрэг хэд хэдэн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг явуулж байна.

Дэлхийн цаг уурын дулаарал, байгалийн гамшигт үзэгдэл, эко системийн алдагдал, хүн амьдрах орчны бохирдол, халдварт өвчний тархалт, эдийн засгийн тогтворгүй байдал, хүн амын ядуурал, хүнсний хомсдол, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, мансуулах бодис, галт зэвсгийн хууль бус худалдаа, хүний наймаа зэрэг “уламжлалт бус” аюулын хамрах хүрээ өргөжин тэлж байгаа даяарчлалын өнөө цагт Дотоодын цэргийн алба-үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, түүнд тулгуурлан мэргэшүүлэх сургалт, албаны сургалтыг зохион байгуулах, Дотоодын цэргийн түүхэн уламжлалыг судлаж хөгжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн шинэ мэдлэг мэдээлэл, бүтээлч санааг эрэлхийлэх, нээн гаргах, нэвтрүүлэх зорилгоор Дотоодын цэрэг судлалын судалгааны нэгжийг байгуулах хэрэгцээ шаардлага бий болж байна.

Судалгааны нэгж байгуулах дараах үндэслэл, шаардлагууд амьдралаас урган гарч байна. Үүнд:

1. Улс орны нийгэм, эдийн засаг, стратегийн ач холбогдолтой "Онц чухал объект, байгууламж"-ийн аюулгүй байдлыг найдвартай хангах шаардлага гадаад, дотоод нөхцөл байдалтай холбогдон өөрчлөгдөж, дотоодын цэргийн гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэх чиг хандлагатай болж байна.

2. Дотоодын цэргийн судлалын ажлыг үр дүнтэй явуулж, "Аюулгүй байдал- Дотоодын цэрэг" мэргэжлийн офицер, "Дотоодын цэргийн харуулчин" ахлагч нарыг бэлтгэж байгаа мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт болон анги салбар мөрдөгдөж байгаа албаны сургалтын хөтөлбөр, стандарт, нормативт өнөө цагийн тавигдаж байгаа бодлого зорилтод нийцсэн зохих өөрчлөлтүүдийг оруулж, мэдлэг, дадлага, чадвартай офицер, ахлагчийг сургаж бэлтгэх хэрэгцээ шаардлага бий болж байна.

3. Дотоодын цэргийн түүхэн уламжлал, алба үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй судлаж, эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулж, цаашдын хөгжлийн чиг баримжаа, мэргэжлийн чиг хандлагыг зөв тодорхойлох шаардлага тавигдаж байна.

¹⁸⁴ Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт

4. Дотоодын цэргийн байгуулалт, дотоодын цэргийн хамгаалалтын албаны урлагийг түүхийн суурь судалгааны сурвалжуудаас нэгтгэн судлаж, хэрэглээний эргэлтэд оруулж, нийтийн хүртээл болгох шаардлага тулгарч байна.

5. Гадаад орнуудын ижил төстэй байгууллагуудын гүйцэтгэж байгаа чиг үүрэг, үйл ажиллагаа, ажлын дэвшилтэт арга хэрэгслийг судлах, алба үйл ажиллагаанд нэвтрүүлэх хэрэгцээтэй байна.

6. Цагдаагийн сургууль, Дотоодын цэргийн албаны тэнхимээс жил бүр Дотоодын цэргийн алба үйл ажиллагааны чиглэлээр уламжлал болгон зохион байгуулдаг эрдэм шинжилгээний хуралд оролцсон эрдэмтэн, багш, судлаачид, ахмад ажилтнууд дотоодын цэргийн чиглэлээр судалгааны нэгж байхгүй байгаад удаа дараа шүүмжлэлтэй хандаж, санаачлага гарган ажиллахыг онцлон тэмдэглэж байгаа болно.

Цаашид Дотоодын цэргийн түүхэн уламжлал, цэргийн байгуулалт, дотоодын цэргийн хамгаалалтын албаны удирдлага зохион байгуулалт, стратеги тактикийг суурь судалгааны эх сурвалжуудаас нэгтгэн шинжлэх ухааны үндэслэлтэй судлаж, эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулж, эрх зүйн орчинг сайжруулах, хөгжлийн бодлого боловсруулах шаардлагын үүднээс энэ чиглэлийн судалгааны төв (нэгж)-ийг байгуулах хэрэгцээ шаардлага бий болсоныг илтгэн харуулж байна.

Дүгнэлт: Дотоодын цэрэг судлалын төвийг Дотоод хэргийн их сургуульд ажиллуулснаар дотоодын цэргийн чиглэлээр магистр, докторантад суралцагч нарт өгөх арга зүйн зөвлөмж дээшилж, багш, судлаач нарын туурвисан ном, гарын авлагад хийх редакц сайжирч, багш судлаач нарын ур чадвар, дотоодын цэргийн цаашдын хөгжлийн чиг хандлага, төрөөс баримтлах бодлого үйл ажиллагааны чиглэлд тодорхой ахиц гарч төрийн цэргийн нэг байгууллага Дотоодын цэрэг хөгжин дэвших үндэс суурь болно гэж үзэж байна.

Санал: Их сургуулийн эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн дэргэд бусад хүрээлэн, төвийн жишгийг харгалзан, “Дотоодын цэрэг судлалын төв”-ийг байгуулж ажиллуулах, тус их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Гамшиг судлал болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвүүдийг байгуулахад харьяа агентлагуудаас орон тоо, хүний нөөцийн дэмжлэг авч байсан жишиг бий.

Иймд Дотоодын цэрэг судлалын төв-ийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хэвийн явуулахад хэрэгцээтэй байгаа орон тоог Дотоодын цэргийн байгууллагаар шийдвэрлүүлж, хамтран ажиллах боломжтой гэж үзэж байна.

Ашигласан материал

1. Дотоодын цэргийн тухай хууль
2. Төрийн мэдээлэл. 2017. №14.
3. Төрийн мэдээлэл. 2002. №03
4. Төрийн мэдээлэл. 2016. №31
5. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛД /НИСГЭГЧГҮЙ ОНГОЦНЫ СИСТЕМ/ ДРОН НӨЛӨӨЛӨХ НЬ

Б.Энхжин
ДХИС-ийн магистрант,
хошууч

Товчлол: Дэлхийн улс орнууд нисгэгчгүй онгоцны систем /Дрон/-ыг цэрэг-тагнуулын зориулалтаар өргөн хүрээтэйгээр ашиглаж байна. Технологийн шинэ эрин үеийн нөлөөгөөр виртуал бодит байдал, хиймэл оюун ухаан, роботын хөгжил хүний ажиллах, амьдрах дадал төдийгүй хүн хоорондын харилцааг өөрчилж байна.

Энэхүү өгүүлэлд Улсын онц чухал объект, төрийн хамгаалалтад байх онцгой дэд бүтцүүдийн аюулгүй байдалд нисгэгчгүй онгоцны систем /дрон/ нөлөөлж болзошгүй асуудлын талаар авч үзсэн болно.

Түлхүүр үг: Улсын онц чухал объект, дэд бүтэц, нисгэгчгүй онгоцны систем, дрон, цэрэг-тагнуул, терроризм, террорист үйлдэл.

Үндсэн хэсэг. Анхны нисгэгчгүй онгоцны системийг Дэлхийн нэгдүгээр дайны үед Их Британи, АНУ-д тус тус бүтээжээ. Британийн агаарын зорилтот жижиг онгоцыг 1917 оны 3-р сард “Кеттеринг” баг гэгддэг Америкийн агаарын “Торпедо”-г анх 1918 оны 10-р сард нисч туршсан. Хэдийгээр нислэгийн туршилтаар хоёр улс амжилтад хүрнэ гэж амлалт өгсөн ч дайны үед аль алиныг нь ажиллагаанд ашиглаж чадаагүй.

Дайны хоорондох хугацаанд нисгэгчгүй онгоцны системийг хөгжүүлэх, турших ажил үргэлжилж байв. 1935 онд Британичууд сургалтын зориулалтаар ашиглах зорилгоор радио удирдлагатай хэд хэдэн онгоц үйлдвэрлэжээ. Эдгээр загваруудын нэг болох “DH.82B Queen Bee”-ийн нэрнээс санаа авсан “Drone” гэсэн нэр томъёог яг одоо хэрэглэж эхэлсэн гэж үздэг. Радио удирдлагатай дроннуудыг мөн АНУ-д үйлдвэрлэж, зорилтот дадлага, сургалтад ашиглаж байжээ.

Тагнуулын нисгэгчгүй нисэх онгоцуудыг Вьетнамын дайнд анх өргөн цар хүрээтэй ашигласан. Нисгэгчгүй онгоцыг мөн дайн тулалдаанд төөрөгдүүлэх үүрэг гүйцэтгэх, тогтсон байны эсрэг пуужин харвах, сэтгэл зүйн үйл ажиллагаанд нөлөөлөхөд зориулж ухуулах хуудас хаях зэрэг олон төрлийн шинэ үүрэг гүйцэтгүүлэхэд ашиглаж эхэлсэн.

Өнөөгийн цаг үед нисгэгчгүй онгоцны төхөөрөмжийн шинэ загварууд илүү боловсронгуй илүү хүчин чадалтай, дэвшилтэт, өндөрт нисэх чадвартай болсон. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийг хянахаас, байгалийн гамшгийн дараа эрлийн ажиллагаа явуулах, гал унтраах, гэрэл зураг авах, бичлэг хийх баримтжуулах, бараа бүтээгдэхүүн хүргэх зэрэг олон үүрэг гүйцэтгэдэг болж, үйлчлэх цар хүрээг нь тооцоолоход бэрхшээлтэй болсон.

Нийгмийн салбар бүрт чанарын өндөр өөрчлөлт гаргасан эерэг нөлөө байгаа хэдий ч нөгөөтэйгүүр нисгэгчгүй онгоцны системийн хөгжлийн сөрөг нөлөө, үр дагавар нь улс төр, шашин, үзэл суртал, эдгээртэй адилтгах бусад зорилгодоо хүрэхийн тулд төрийн байгуулал, нийгэм, эсхүл түүний тодорхой хэсэгт нөлөөлөн айдаст автуулахаар хүчирхийлэл үйлдэх, хүчирхийлэл үйлдэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх, улсын онц чухал объектод халдах, нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг алдагдуулах нөхцлийг бүрдүүлэхээс урьдчилан сэргийлж, хариу арга хэмжээ нэн шаардлага тулгарч байна.

Орос-Украины дайн нь [2022 оны 2 сарын 24](#)-ний өдрийн 05:00 цагт (орон нутгийн) ОХУ, Украин улсын хооронд эхэлсэн дайн. [ОХУ](#)-ын ерөнхийлөгч [В.Путины](#) зарлигаар үүнийг дайн биш [Украин](#)

улсад "цэргийн тусгай ажиллагаа" /специальная военная операция/ эхлүүлж байгаа гэж онцолж байгаа юм. Тус цэргийн ажиллагаа нь Киев, Харьков, Крым, Донецк-Луганский чиглэлээр давшиж эхэлсэн.

Энэ дайны үйл явцын талаар дэлхийн улс орнуудын цэргийн эрдэмтэн судлаачид цахилгаан дайн, гибрид буюу хосолмол дайн гэх мэтээр тус тусдаа дүгнэж байна. Орос-Украины дайны энэ байдлыг ОХУ-аас /цэргийн тусгай ажиллагаа/ гэж нэрлэж байгаа бөгөөд Украин улсын цэргийн дэд бүтцийг агаараас цохилт өгч байна. Тус дайны үйл явцад нисгэгчгүй онгоцны систем /дрон/-ыг хүртэл их хэмжээгээр ашиглан хор хохирлыг учруулж байгааг судлаачын хувьд уншиж, судлахад бид дотоодын аюулгүй байдлаа хэрхэн хангах вэ? гэсэн асуулт тулгарч байна.

Хүснэгт №1

№	Цагдаагийн албаны тухай хууль	Дотоодын цэргийн тухай хууль
1	2	3
1	Цагдаагийн албаны тухай хуулийн 12.1.5-т “шаардлагатай тохиолдолд улсын онц чухал болон хүний амь нас, эрүүл мэнд, байгаль экологийн тэнцвэрт байдалд шууд хохирол учруулах эрсдэлтэй болон гэмт халдлагад өртөж болзошгүй бусад объект, ачаа тээшийг түр хугацаагаар хамгаалах” ¹⁸⁵ гэж заасан байдаг;	Дотоодын цэргийн тухай хуулийн 4.1.3-т "Улсын онц чухал объект" гэж Монгол Улсын Засгийн газраас тогтоосон онцгой ач холбогдол бүхий байгууллага, үйлдвэр, барилга байгууламжийг; ¹⁸⁶ заасан байдаг.
Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал объектын жагсаалт		
1	Цагдаагийн байгууллагын төсөвт хамгаалалтад байх объект.	
1.1	1. Гадаадын дипломат төлөөлөгчийн газар; 2. НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар; 3. Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв; 4. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын төв болон үйлчилгээний байрууд, иргэний цахим үнэмлэхийн үйлдвэр; 5. Аймаг, нийслэл, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн байр ¹⁸⁷ .)	
2	Цагдаагийн байгууллагын гэрээт хамгаалалтад байх объект	
2.2	1. Монголбанкны төв байр, орон нутаг дахь хэлтэс, салбарын байр; 2. Монгол Улсын Хөгжлийн банкны байр; 3. Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлагын төв (Нийслэлийн замын хөдөлгөөн зохицуулах нэгж); (Засгийн газрын 2021 оны 101 дүгээр тогтоолоор нэмэлт орсон) 4. “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэг; 5. “Чингис хаан” олон улсын нисэх буудал; 6. Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумаас Гашуунсухайт дахь хилийн боомт хүртэлх 247 км, мөн аймгийн Гурвантэс сумаас Шивээхүрэн дэх хилийн боомт хүртэлх 112 км хатуу хучилттай болон засч сайжруулсан авто зам; 7. “Эрдэнэт үйлдвэр” ХХК.	
3	Дотоодын цэргийн төсөвт хамгаалалтад байх объект	
3.1	1. Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн төв байр, радио, телевизийн эфирин студи;	

¹⁸⁵ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

¹⁸⁶ Төрийн мэдээлэл. 2017. №12. Дотоодын цэргийн тухай хууль

¹⁸⁷ Энэ заалтыг Засгийн газрын 2018 оны 142 дугаар тогтоолоор нэмсэн

	2.“Изотоп” төв; 3.Улаанбаатар, Чойбалсан, Дархан, Эрдэнэт, Ховд, Даланзадгад хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж; 4.“Дулааны II цахилгаан станц”, “Дулааны III цахилгаан станц”, “Дулааны IV цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компаниуд; (Энэ заалтад Засгийн газрын 2021 оны 318 дугаар тогтоолоор нэмэлт орсон бөгөөд үүнийг 2022-1-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө) 5.Дөргөний усан цахилгаан станц; 6.Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн төв лаборатори; 7.Халдварт өвчин судлалын үндэсний төвийн лаборатори; 8.Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори; 9.Зоонозын өвчин судлалын үндэсний төв; 10.“Биокомбинат” төрийн өмчит үйлдвэрийн газар; 11.Стандарт, хэмжил зүйн газрын төв байр болон Үнэт металлын сорьцын хяналтын газрын байр; 12.Гадаадын иргэн, харьяатын газрын төв байр; (Засгийн газрын 2018 оны 368 дугаар тогтоолоор нэмсэн) 13.Тайширын усан цахилгаан станц; (Засгийн газрын 2019 оны 444 дүгээр тогтоолоор нэмсэн бөгөөд үүнийг 2021-1-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө) 14. Үндэсний дата төвийн нөөц төв. (Засгийн газрын 2020 оны 153 дугаар тогтоолоор нэмсэн)
4	Дотоодын цэргийн гэрээт хамгаалалтад байх объект ¹⁸⁸
4.1	1.“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн үйлдвэрийн гадна талбай дахь тэсэрч дэлбэрэх бодисын үйлдвэр, тэсэрч дэлбэрэх бодисын агуулах; 2.”Цагааннуур” худалдааны чөлөөт бүс; 3. “Таван толгой түлш” ХХК-ийн үйлдвэрийн I, II, III, IV объект; (Засгийн газрын 2020 оны 2 дугаар тогтоолоор нэмсэн) 4.“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Тавантолгой нүүрсний уурхай. (Засгийн газрын 2020 оны 201 дүгээр тогтоолоор нэмсэн).

1990-ээд оны үеэс цэрэг-тагнуулын зориулалтаар ашигладаг байсан нисгэгчгүй онгоцны систем нь 2000 оноос хойш техник технологийн үсрэнгүй хөгжлийн нөлөөгөөр ХАА, үйлдвэрлэл, үйлчилгээ зэрэг аж үйлдвэр, эрэн сурвалжлах, аврах ажиллагаа зэрэг тусгай зориулалтаар төдийгүй чөлөөт цагаа өнгөрөөх арга хэрэгсэл болон өргөн хүрээнд тархаж байна.

Дэлхийн дроны зэх зээлийн судалгаа эрхэлдэг DRONII (Drone Industry Insights)-ийн дүгнэлтэд тулгуурлавал дэлхийн дроны зах зээлийн дүн 2020 онд 22.5 тэрбум ам.доллар байсан бөгөөд жилийн дундаж өсөлт 13.8% гэж тооцоход 2025 онд хоёр дахин буюу 42.8 тэрбум ам.долларт хүрнэ гэж үзэж байна. Ялангуяа дрон ашигладаг хүргэлтийн үйлчилгээний салбар маш хурдацтай өргөжих бөгөөд Азийн бүс нутаг дэлхийн хамгийн том дроны зах зээл болно хэмээн таамаглаж байна. Өнөөдрийн байдлаар АНУ, БНХАУ дангаар дроны зах зээлийн 2/3 хувийг эзлэж байна. Үүний дараа Япон, Энэтхэг (2018 онд хуулиар зөвшөөрсөн)-ийн дроны зах зээл өсөн нэмэгдэх хандлагатай байна. Ковид-19 цар тахлын улмаас дэлхийн эдийн засаг бүхэлдээ хямралд орсон ч дроны зах зээл эсрэгээрээ тэлсэн үзүүлэлттэй байгаа бөгөөд өндөр үр ашигтай ажилласан байна.

¹⁸⁸ Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2017.№281. Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал объектын жагсаалт

Энэхүү технологийн хөгжил нь нөгөө талаас дрон ашиглан хүний хувийн амьдралд халдахаас эхлээд тагнан турших, хорлон сүйтгэх ажиллагаа, терроризмын аюул занал өсөн нэмэгдэхэд нөлөөлөх нэг хүчин зүйл болдог. Иймд дроны хөгжилтэй зэрэгцэн дронуос хамгаалах тогтолцоог хэрхэн шийдвэрлэх асуудал тусгай албадад томоохон сорилт учруулж байна.

Дрон ашиглан халдлага үйлдсэн олон арван жишээний заримыг дурдвал 2021 оны 6 дугаар сард Багдад хотын олон улсын нисэх онгоцны буудал руу дронуор халдлага үйлдсэн, 2019 оны 9 дүгээр сард Саудын Арабын газрын тос олборлогч компани Арамко-гийн дэлхийд хамгийн томд тооцогдох газрын тос боловсруулах үйлдвэр дээр дрон ашиглан тэсрэх бөмбөг хаясан бол 2018 оны 12-р сард Лондон хотын Гэтвик олон улсын нисэх буудал руу дрон нисэж ирснээс болж онгоцны буудлыг хаах хүртэл арга хэмжээ авч байжээ. БНСУ-д Умард Солонгосын талаас удаа дараа дрон нисэж ирснийг илрүүлсэн бөгөөд атомын цахилгаан станц зэрэг улсын онц чухал объектын ойролцоо хууль бусаар нисгэгчгүй онгоцны систем нисэж байсан хэд хэдэн тохиолдлыг илрүүлсэн байна.

Дроныг хэлбэр, хэмжээ, жин, хурд, нислэгийн өндөр, даац, хүчин чадал гэх зэрэг олон төрлөөр ангилж болох боловч аюулгүй байдалд учруулж болзошгүй эрсдлээр нь гурван хэмжээст дроныг хамгийн аюултайд тооцдог байна. Үүнд:

1. Туулах чадварын хувьд холын зайд нисэх боломжтой. Энэ нь ихэвчлэн дунд ба том оврын дрон байх ба хэдэн арван километр зайг туулах хүчин чадалтай.

- Даацын хувьд хэдэн килограмм хүртэл ачааг зөөвөрлөх боломжтой тул тэсрэх бөмбөг, хар тамхи, мансууруулах бодис, зэвсэг тээвэрлэх эрсдэлтэй.
- Цаг агаарын хүнд нөхцөлд нислэг хийх буюу хүчтэй салхи эсэргүүцэж, нислэгийн чиглэлээ алдахгүй байхаар бүтээгдсэн байдаг.

Ийм төрлийн дроны аюул заналыг 4 ангилан үзэж болно. Үүнд:

- Халдлага (Attack)

Дрон нь тэсрэх бодис, хими, биологийн зэвсэг зөөвөрлөх боломжтой тул дронуор улсын онц чухал объект, төрийн өндөр албан тушаалтан, олон нийтийг чиглэсэн халдлага хийх эрсдэл өндөр.

- Мөргөлдөөн (Collision)

Дрон нь агаарын тээврийн хөлөг болон хүмүүст их хэмжээний хохирол учруулах эрсдэлтэй. Дроныг алсаас удирдаж, санаатай болон болгоомжгүйгээр нисэх онгоцны ойролцоо эсвэл нислэгийн зам руу илгээвэл энэ нь нисэх багийн гишүүд, зорчигчдыг эрсдэлд оруулна.

- Хувийн орон зайд халдах болон тагнан турших (Invasion of privacy or espionage)

Ихэнх дронууд өндөр хүчин чадалтай камераар тоноглогдсон байдаг тул хаалттай мэдээлэлд нэвтрэх боломжтой байдаг. Түүнчлэн дрон ашиглан хувь хүн, ААН, засгийн газрын байгууллагуудын эсрэг тагнан турших ажиллагаагд ашиглах боломжтой. Ийм төрлийн дронууд холын зайд нислэг үйлдэхээс гадна, дроныг хаанаас удирдаж байгааг олж тогтоох боломж нэн хязгаарлагдмал байдаг.

- Хууль бусаар хил давуулах (Smuggling)

Дрон ашиглан хар тамхи, мансууруулах бодис, зэвсэг болон бусад эд зүйлийг хилээр хууль бусаар нэвтрүүлэх тохиолдол нэмэгдэж байгаа нь хилийн хамгаалалтад тулгамдсан асуудлын нэг болж байна. Гадаадын зарим оронд дрон ашиглан хоригдлуудад бараа бүтээгдэхүүн нууцаар хүргүүлэх явдал ихээхэн гардаг тул харгалзагч нар энэ тал дээр анхаарал хандуулдаг байна.

Mavic 3 загварыг ямар камертай гарах бол гэсэн хүлээлт өндөр байсан. 4/3 инч хэмжээтэй буюу өмнөх загвараас 33% өргөн CMOS сенсортой, зөвхөн Mavic 3 загварт зориулан олон жил хөгжүүлсэн Шведийн алдарт Hasselblad-ийн L2D-20c камертайгаас гадна 1/2 инчийн 28x hybrid zoom хийх чадвартай теле камерын хослолоор тоноглогджээ.

Mavic 3 нь өндөр нягтаршил, фрэймийн хурдаар агаарын видео бичлэг хийхээс гадна 10 битийн D-Log өнгөний профайлаар 1 тэрбум хүртэл өнгийг ялган дүрслэх чадвартай болсон байна.

Техникийн үзүүлэлт:

- ➔ □ Удирдах зай: 15 км
- ➔ □ Өндрийн хязгаар 500 метр
- ➔ □ Нисэх хугацаа: 46 минут
- ➔ □ Дээд хурд: 68 км/цаг
- ➔ □ Саад мэдрэгч: Бүх талдаа
- ➔ □ Салхинд тэсвэр: 12 метр/секунд
- ➔ □ Бичлэгийн чанар: 5.1K, 4K, FHD
- ➔ □ Видео формат: MP4, MOV
- ➔ □ Зургийн чанар: 20MP, 4/3 CMOS
- ➔ □ Зургийн формат: JPEG, DNG, RAW


Mavic 3 Fly More Combo багцад: Нисдэг камер, RC-N1 удирдлага, 3 батарэй, 6 хос сэнс, 65W зөөврийн цэнэглэгч, удирдлаганы хос joystick, хөдөлгөөнт орчинд зөөвөрлөхөд сэнс болон хөлийг хөдөлгөөнгүй барих cover, 3 батарэй цуваа цэнэглэгч, ND 4/8/16/32 филтер, 2 мөрнөөс үүрэх үүргэвч болж хувирдаг 16 инчийн лаптоп багтах цүнх, кабелууд багтсан.¹⁸⁹

Дүгнэлт. Технологийн дэвшлээр шинэ тутам хөгжиж буй дроныг ахуй амьдралд хэрэглэхээс гадна түүнийг ашиглан халдлага үйлдэх, нийтийн аюулгүй байдалд заналхийлэх явдал гарч буй тул дроны хэрэглээг зохистой дэмжихийн хажуугаар аюулгүй байдлын цогц арга хэмжээ авах шаардлага тулгарч байна. Дрон ашиглан үйлдэж буй гэмт үйлдлийн онцлог нь хотын их хөдөлгөөн, цахилгаан долгионы торон сүлжээн дунд дроныг удирдаж буй байршлыг илрүүлэх болон дрон ашиглан үйлдсэн гэмт хэргийн захиалагч, операторыг хэрэгт холбоотой эсэхийг тогтоох боломж нэн хомс байдагт оршино. Иймд манай орны хувьд дроноос хамгаалах системийг бий болгох үүднээс хууль, эрх зүй, зохион байгуулалт, технологийн шийдлийг хослуулах шаардлага тулгарч байна. Түүнчлэн аюултай дроныг хянах, бүртгэлжүүлэх, хилээр нэвтрүүлэхэд олон улсын баталгаажуулалтын гэрчилгээ шаардах болон тодорхой хязгаарлалт тавих механизмыг бүрдүүлэх нь зүйтэй.

Монгол улсын хувьд өргөн уудам газар нутагтай тул үндэсний хэмжээний дроноос хамгаалах системийг байгуулах нь цаг хугацаа, хөрөнгө их зарцуулах тул нэн тэргүүнд хилийн хамгаалалт, улсын онц чухал объект, дэд бүтэц, төрийн тусгай хамгаалалтын объект, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явагдаж буй газруудад дроноос хамгаалах тогтолцоог бүрдүүлэх нь цаашид гарч болзошгүй эрсдэл, түүнээс гарах хохирлыг бууруулахад ихээхэн ач холбогдолтой гэж үзнэ.

Санал:


1. Улсын онц чухал объектуудын орчинд тус таних тэмдэгийг байрлуулах.



Дрон хориотой

2. Цагдаа, Дотоодын цэргийн байгууллага даргын ажлын байр зүйн зураг үйлдэхдээ таних доорх таних тэмдэгийг ашиглах.

¹⁸⁹ <http://dji.mn/products/681/>



3. DJI Mavic 3 загварын нисгэгчгүй онгоцны системийг улсын онц чухал объектын хамгаалалтад хэрэглэж, алба хаагч нарыг сургаж бэлтгэх.
4. Дрон ашиглах сургалтыг үнэгүй зохион байгуулах.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1. Цагдаагийн албаны тухай хууль;
2. Дотоодын цэргийн тухай хууль;
3. Төрийн мэдээлэл 2017.№08.
4. Төрийн мэдээлэл 2017.№12.
5. Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2017.№281. Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал объектын жагсаалт;
6. <http://dji.mn/products/681/>

